- Нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх замаар компанийг өөрчлөн байгуулах;
- Компанийн өрийг хувьцаагаар солих, хувьцаа нэмж гаргах, түүний тоог тогтоох;

- Компанийн хэлбэрийг өөрчлөх, төлөөлөн удирдах зөвлөлийг өөрчлөн зохион байгуулах төслийг батлах, шийдвэр гаргах;
- Компанийг татан буулгах, татан буулгах комиссыг томилох;
- Компанийн хувьцааг хуваах буюу нэгтгэх;
- ТУЗ-ийн гишүүнийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох, эрх хэмжээг тогтоох;
- ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох;
- Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөх;
- Компаниас хууль ёсоор зарлан мэдэгдсэний дагуу ногдол ашиг авах;
- Компанийг татан буулгаж, эд хөрөнгийг нь хуваарилах тохиолдолд түүний үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос эзэмшиж буй хувьцааныхаа тоотой хувь тэнцүүлэн хувь хүртэх;
- Компаниас нэмж гаргасан хувьцаа, хувьцаанд хөрвөх үнэт цаасыг тэргүүн ээлжинд худалдан авах;
- ТУЗ болон Гүйцэтгэх захирлын шийдвэрлүүлэхээр оруулсан бусад асуудлууд;
- Хууль тогтоомжийн актад заасан бусад эрх, үүрэг.

### 2.3.3 ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

**Үнэт цаас гаргагчийн төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрх**

Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэгт Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь Төлөөлөн удирдах зөвлөл байна гэж заасан бөгөөд Төлөөлөн удирдах зөвлөл нь тус хуулийн 76 дугаар зүйлд заасан бүрэн эрхийг эдэлнэ.

Үнэт цаас гаргагчийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэгт заасанаар ТУЗ нь Компанийн тухай хууль, Хувьцаа эзэмшигчдийн гэрээ эсхүл дүрэмд тусгайлан заасан Хувьцаа эзэмшигчдийн бүрэн эрхэд хамаарах асуудлаас бусад доор дурдсан асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх бүрэн эрхтэй байна. Үүнд:

- Компанийн эрхлэх үйл ажиллагааны чиглэлийг тогтох, өөрчлөх;
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах;
- Компанийн зарласан хувьцааны төрөл болон тоонд багтах хувьцаа гаргах;
- Үнэт цаас гаргах;
- Компанийн стратеги болон дунд хугацаа, жилийн бизнес төлөвлөгөө, төсөв, үйл ажиллагааны бодлогыг батлах;
- Компанийн бүтэц, зохион байгуулалт, орон тоог батлах;
- Компанийн бүх төрлийн бодлогын баримт бичгийг батлах;
- Компанийн Гүйцэтгэх захирлыг сонгох, түүний бүрэн эрхийг тогтоох, бүрэн эрхийг хугацаанаас өмнө дуусгавар болгох, тусгайлсан асуудлаар түүнд итгэмжлэл олгох;
- Гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээний нөхцөлийг батлах, өөрчлөлт оруулах, түүнд олгох, шагнал, урамшуулал, цалингийн хэмжээг тогтоох;
- Компанийн жилийн бизнес төлөвлөгөөний гүйцэтгэл, үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаар Гүйцэтгэх захирлаас гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;
- Компанийн аудитын байгууллагыг сонгож, гэрээ байгуулах;
- Компанийн тухай хуулийн 11 дүгээр бүлэгт заасны дагуу их хэмжээний хэлцлийг батлах;
- Компанийн тухай хуулийн 12 дугаар бүлэгт заасан сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах;
- Ногдол ашиг хуваарилах эсэх талаар шийдвэр гаргаж, ногдол ашгийн хэмжээ, хуваарилах журам, бодлого тодорхойлох;

- Компанийн эрхэлж буй үндсэн болон туслах үйл ажиллагаатай холбоотойгоос бусад 1,000,000,001 (нэг тэрбум нэг) төгрөгөөс дээш зах зээлийн үнэтэй үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, барьцаалах, барьцаалуулах болон бусад хэлбэрээр захиран зарцуулах шийдвэр гаргах, түүнтэй холбогдсон гэрээ, хэлцэл эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн гэрээ, хэлцлийг батлах, гэрээ, хэлцэл хийх зөвшөөрөл олгох;
- Хараат болон охин компани, салбар, төлөөлөгчийн газар байгуулах, тэдгээрийн эрх хэмжээ, үйл ажиллагааны чиглэлийг тогтоох;
- Компанийн дүрмээр болон хууль тогтоомжийн актад заасан бусад эрх;
- Гүйцэтгэх захирлын шийдвэрлүүлэхээр оруулсан бусад асуудал.

**ТУЗ-ийн үйл ажиллагааны журам**

Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2019 оны 02 дугаар сарын 04-ны өдрийн А/07-Т тоот тогтоолоор батлагдсан "Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам"-аар ТУЗ-ийн үндсэн чиг үүрэг, бүрэн эрх, ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх этгээдэд тавигдах шаардлага, гишүүдийг сонгох журам, дахин нэр дэвших болзол, хараат бус гишүүний шалгуур үзүүлэлт, ТУЗ-ийн хурлын зарыг хүргэх, хуралд оролцох, санал өгөх, ТУЗ-ийн гишүүдийг мэдээллээр хангах журам, үүргээ зохих түвшинд хэрэгжүүлээгүй гишүүнд хүлээлгэх хариуцлага болон ТУЗ-ийн бусад үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулсан байна.

**Үнэт цаас гаргагчийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд**

Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн гишүүдийг Компанийн ХЭХ-ын 2018 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн А/24 тоот шийдвэр болон 2018 оны 10 дугаар сарын 5-ны өдрийн А/26 тоот шийдвэрээр тус тус томилсон байна.

Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь 5 гишүүнтэй бөгөөд тэдгээрийн 1 нь хараат бус гишүүн байна. ТУЗ нь тус бүр 3 хүний бүрэлдэхүүнтэй Аудитын хороо, Цалин, урамшууллын хороо, Нэр дэвшүүлэх хороо болон Эрсдэлийн удирдлагын хороодтой байна.

ТУЗ-ийн ээлжит хурлыг улирал нэг удаа хуралдуулах бөгөөд шаардлагатай гэж үзвэл тухайн улиралд ТУЗ-ийн ээлжит бус хурлыг ТУЗ-ийн дарга, түүний гишүүд, гүйцэтгэх захирал болон компанийн дүрэмд заасан бусад этгээдийн санаачилга, шаардлагаар хэдийд ч зарлан хуралдуулж болно. ТУЗ нь жилийн ажлын тайлангаа хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж хэлэлцүүлэн үнэлэлт, дүгнэлт гаргуулдаг.

**Хүснэгт 6: Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд**

| № | ТУЗ-ийн гишүүдийн нэр | Албан тушаал |
|---|---|---|
| 1 | Б.Анхболд | ТУЗ-ийн дарга |
| 2 | Д.Баясгалан | ТУЗ-ийн гишүүн |
| 3 | Р.Мөнхтөр | ТУЗ-ийн гишүүн |
| 5 | Намики Хирохито | ТУЗ-ийн гишүүн |
| 4 | Ч.Хашчулуун | ТУЗ-ийн хараат бус гишүүн |
| 6 | О.Уянга | ТУЗ-ийн нарийн бичгийн дарга |

**Үнэт цаас гаргагчийн охин компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд**

Үнэт цаас гаргагчийн охин компани болох "Инвескор Эй Ай Лаб" ХХК нь төлөөлөн удирдах зөвлөлгүй болно.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2019-03-26
БҮРТГЭВ 02

СЗХ 2019 04 сар 24 өдөр БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2019-03-26 БҮРТГЭВ-02

## 2.3.4 ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД

**ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг**

“Инвескор ББСБ” ХХК-ийн ТУЗ-ийн дэргэд дараах байнгын үйл ажиллагаатай хороод байна. Үүнд:

- ✓ Аудитын хороо
- ✓ Цалин урамшууллын хороо
- ✓ Нэр дэвшүүлэх хороо
- ✓ Эрсдэлийн удирдлагын хороо

### Аудитын хороо

ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооны журам нь Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2019 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн А/07-Т тоот тогтоолоор батлагдсан бөгөөд уг журмаар компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх, дотоод хяналт, үйл ажиллагаа болон эрсдэлийн удирдлага, санхүүгийн тайлан, санхүү, эдийн засгийн байдалд хяналт тавих үйл ажиллагааг зохицуулна.

Аудитын хорооноос чиг үүргийнхээ хүрээнд тодорхой асуудлаар дүгнэлт гаргах, санал, зөвлөмж боловсруулах, шаардлагатай бусад асуудлыг ТУЗ-д танилцуулж шийдвэрлүүлнэ.

Аудитын хороо нь дараах чиглэлээр дүгнэлт гаргаж ТУЗ-д танилцуулна. Үүнд:

- Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх бодлого, заавар, зөвлөмж гаргах;
- Санхүүгийн тайлан, санхүү, эдийн засгийн бусад мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавих;
- Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэлд хяналт тавих, дүгнэлт гаргах;
- Аудитын шалгалтаар тогтоогдсон зайлшгүй шаардлагатай томоохон залруулга;
- Бизнесийн үйл ажиллагаа тасралтгүй байх зарчим;
- Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой бусад хууль, тогтоомжийг мөрдөж ажилласан байдал;
- ТУЗ-ийн тодорхойлсон бусад асуудал.

Аудитын хороо нь Компанийн дотоод хяналт болон эрсдэлийн удирдлагын тогтолцоонд дараах байдлаар хяналт тавьж ажиллана. Үүнд:

- Мөнгө угаах, авилга, луйвар, залилангийн шинжтэй зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, түүний талаар мэдээлэл өгөх, өргөдөл, гомдлын талаарх Компанийн журмууд, түүний хэрэгжилтийг шалгаж, санхүүгийн тайлан, санхүүгийн хяналт болон бусад асуудалтай холбоотой зөрчлийн талаар ажилтнууд өөрт аюулгүйгээр санал гомдол гаргах боломжийг хангасан байхыг шалган баталгаажуулах;
- Компанийн үйл ажиллагаа, санхүү, хууль эрхзүйн гол эрсдэлүүдийг тодорхойлох болон хянах, Компанийн удирдлагын зүгээс эрсдэлийг тодорхойлох, үнэлгээ хийх, эрсдэлийг бууруулах, тодорхой хугацаанд хянах явцад баримтлах удирдамж, бодлогыг боловсруулах;
- Дотоод хяналт, санхүүгийн тайлан, эрсдэлийн удирдлагын системийн үр дүнгийн талаарх удирдлагын болон дотоод аудиторын тайланг хянан шалгах;
- Компанийн санхүүгийн дотоод хяналтын зөв зохистой байдлыг хянах;
- Компанийн дотоод хяналт болон эрсдэлийн удирдлагын талаар жилийн тайланд оруулсан тайлбарыг хянах;
- Компанийн хяналтын үйл ажиллагааг сайжруулах, боловсронгуй болгох, цар хүрээг нь өргөжүүлэх асуудлаар зөвлөмж боловсруулах;

TDB CAPITAL LLC



“ИНВЕСКОР ББСБ” ХХК InvesCore УЛААНБААТАР ХОТ

СЗХ 2019 04 24 он сар өдөр

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2019-03-26 БҮРТГЭВ 02

- Санхүүгийн болон санхүүгийн бус эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, удирдах, шалгах зорилго бүхий удирдлагаас тогтоосон системийн далайц, үр дүнг үнэлж, дүгнэх;
- Дотоод хяналт шалгалтын явц, санхүүгийн нягтлан бодох бүртгэл болон тайлан, эсхүл хөндлөнгийн аудиттай холбоотой асуудлаар Компанийн хүлээн авсан гомдол саналыг хянах журмыг боловсруулан мөрдөх.

Аудитын хороо нь Компанийн санхүүгийн тайлангийн хөндлөнгийн аудит, түүний бие даасан байдлыг дараах горимоор хянан шалгана. Үүнд:

- Аудитын хороо нь ТУЗ-өөр хэлэлцүүлж батлуулахаас өмнө хөндлөнгийн аудитын үйлчилгээний цар хүрээ, үнэ хөлсийг хянан шалгаж, аудитын шалгалт чанарын өндөр түвшинд хийгдэхэд хангалттай хэмжээнд байгааг баталгаажуулах;
- Аудитын агуулга, цар хүрээний талаар хөндлөнгийн аудитортай зөвшилцөх;
- Хөндлөнгийн аудитортай хамтран хийгдсэн ажлын үр дүнд дүн шинжилгээ хийх;
- Хөндлөнгийн аудиторын ажлыг хугацааны эцэст үнэлж дүгнэх, ХЭХ-д хөндлөнгийн аудиторын томилгоо, дахин томилох эсвэл гэрээг цуцлах асуудлаар мэдээлэл зөвлөмж бэлтгэх ба хөндлөнгийн аудитын томилготтой холбогдуулан хөндлөнгийн аудиторыг дүгнэсэн, сонгон шалгаруулсан байдлыг ХЭХ-д танилцуулах;
- Хөндлөнгийн аудиторын шалгалтын явцад илэрсэн зөрчил, түүний гаргасан зөвлөмж болон гүйцэтгэх захирлын зүгээс тухайн зөвлөмжийн дагуу авсан арга хэмжээний талаар хэлэлцэх;
- Хөндлөнгийн аудитын компани болон бусад компанид зөвлөх үүрэг гүйцэтгэж байсан этгээд уг ажлаасаа гарч Компанид ажилд орохыг хүссэн тохиолдолд компанийн зүгээс баримтлах бодлогыг тодорхойлох.

### Цалин, урамшууллын хороо

ТУЗ-ийн дэргэдэх цалин, урамшууллын хорооны журам нь Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2019 оны 02 дугаар сарын 04-ны өдрийн А/07-Т тоот тогтоолоор батлагдсан бөгөөд уг журмаар Компанийн ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх захирал, эрх бүхий албан тушаалтан, ажилтнуудын цалин, урамшууллын талаар баримтлах бодлогыг боловсруулах, ТУЗ-ийн гишүүд болон гүйцэтгэх захирал, эрх бүхий албан тушаалтанд олгох цалин, урамшууллын дээд хязгаарыг тогтоох, тогтоосон хэмжээнд багтаан цалин, урамшуулал олгох санал боловсруулах үйл ажиллагааг зохицуулна.

Цалин, урамшууллын хорооноос чиг үүргийнхээ хүрээнд тодорхой асуудлаар дүгнэлт гаргах, санал, зөвлөмж боловсруулах, шаардлагатай бусад асуудлыг ТУЗ-д танилцуулж шийдвэрлүүлнэ.

Цалин, урамшууллын хороо нь дараах чиглэлээр дүгнэлт гаргаж, ТУЗ-д танилцуулна. Үүнд:

- Компанийн ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлагын эрх бүхий албан тушаалтан, ажилтнуудын цалин, урамшууллын талаар баримтлах бодлогыг боловсруулж, ТУЗ-ийн гишүүд болон гүйцэтгэх захирал, эрх бүхий албан тушаалтанд олгох цалин, урамшууллын дээд хязгаарыг тогтоох, тогтоосон хэмжээнд багтаан цалин, урамшуулал олгох санал боловсруулж, ТУЗ-д оруулах;
- ТУЗ-ийн дарга, хорооны гишүүн болон бусад зөвлөлийн гишүүдэд Компаниас олгох цалин, урамшууллын шалгуурыг гишүүдийн хараат бус байдалд нөлөөлөхгүй, өрсөлдөх чадвартай байлгахаар боловсруулах;
- Гүйцэтгэх захирал, Компанийн эрх бүхий албан тушаалтны санхүүгийн болон бусад ажлын гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлтэд суурилсан жилийн хувьсах урамшууллын систем, менежерүүдийн ашиг сонирхлыг Компанийн хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхолтой нийцүүлэх урт хугацааны урамшууллын систем, мөн тэтгэвэр, тэтгэмж болон бусад нэмэлт орлогыг тогтоож, тогтмол хяналт тавих;

TDB CAPITAL LLC

"ИНВЕСКОР ББСБ" ХХК InvesCore УЛААНБААТАР ХОТ

- Компанийн цалин, урамшууллын шалгуурыг Компанийн хөгжлийн стратеги санхүүгийн нөхцөл байдал болон хөдөлмөрийн зах зээлийн давамгай хандлага зэрэгт үндэслэн тохиромжтой эсэхийг тогтмол хянах;
- ТУЗ-өөс гаргасан гүйцэтгэх захирал, удирдах албан тушаалтны цалин урамшуулалтай холбоотой шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих, түүнчлэн, захиралуудын цалин урамшууллын талаарх мэдээллийн нууцлалтын хэрэгжилтийг хянах;
- Бүх ажилчдын цалин, урамшууллын бодлого боловсруулах чиглэлээр Компанийн удирдлага болон хүний нөөцийн боловсруулсан төсөлд санал өгөх.

Хороо нь цалин, урамшууллын бодлогыг тодорхойлохдоо холбогдох дүрэм, журмыг харгалзан дараах хүчин зүйлсийг анхаарна. Үүнд:

- Мэргэжлийн шаардлага хангахуйц ур чадвартай ТУЗ-ийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын мэргэжилтнийг татах, тогтвор суурьшилтай ажиллуулах, идэвхжүүлэхэд хангалттай цалин, урамшууллын хэмжээг тогтоох;
- Гүйцэтгэх захиралд ажлын гүйцэтгэлтэй нь уялдуулан олгох урамшуулал нь нийт цалин урамшууллын санд багтаж, Компанийн ашигт ажиллагаатай шууд уялдсан байх.

### Нэр дэвшүүлэх хороо

ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хорооны журам нь Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2019 оны 02 дугаар сарын 04-ны өдрийн А/07-Т тоот тогтоолоор батлагдсан бөгөөд уг журмаар ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүн, гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчид тавих шаардлагыг тодорхойлох, тухайн шаардлагад нийцэж байгаа эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгөх, ТУЗ болон гүйцэтгэх удирдлагыг сонгохтой холбоотой үйл ажиллагааг зохицуулна.

Нэр дэвшүүлэх хорооноос чиг үүргийнхээ хүрээнд тодорхой асуудлаар дүгнэлт гаргах, санал, зөвлөмж боловсруулах, шаардлагатай бусад асуудлыг ТУЗ-д танилцуулж шийдвэрлүүлнэ.

Нэр дэвшүүлэх хороо нь дараах чиг үүрэгтэй байна. Үүнд:

- Хороо нь ТУЗ-д нэр дэвшүүлэх эрх бүхий Компанийн хувьцаа эзэмшигчдээс нэр дэвшүүлэх тухай санал, нэр дэвшүүлж буй этгээдийн тухай мэдээллийг хүлээн авч, тухайн этгээд нь Компанийн тухай хууль, Компанийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар тогтоосон шалгуурыг хангаж байгаа эсэхийг хянаад, шалгуур хангахгүй байгаа бол энэ тухай нэр дэвшүүлсэн этгээдэд бичгээр мэдэгдэл хүргүүлнэ. Хараат бус гишүүнд нэр дэвшүүлж байгаа бол хараат бус гэдгийг нотлох мэдээлэл, уг мэдээлэл үнэн зөв болох тухай нэр дэвшигчийн баталгаа зэргийг гаргуулсан байна.
- ТУЗ-ийн гишүүн нас барсан, удаан хугацаагаар үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд ТУЗ-ийн ээлжит хурал хүртэлх хугацаагаар нөхөн сонгох гишүүний нэрийг дэвшүүлэх асуудлыг Хороо хариуцан гүйцэтгэх;
- Хороо нь ТУЗ-ийн бүрэн эрх дуусгавар болсон үед ТУЗ-ийн гишүүд үүргээ хэрхэн хэрэгжүүлсэн тухай ТУЗ-ийн гишүүн тус бүрээр дүгнэлт гаргаж, ХЭХ-д танилцуулна. Уг танилцуулгад ТУЗ-ийн гишүүн бүр нийт хэдэн удаагийн хуралд оролцохоос хэдэн удаагийн хуралд оролцсон тухай мэдээлэл заавал байх ёстой. Гүйцэтгэх удирдлагын эрх бүхий албан тушаалтанд нэр дэвшүүлэх, нэр дэвшигчдийн талаар мэдээлэл бэлдэн ТУЗ-ийн хуралд оруулах, үүргийн гүйцэтгэлийн талаар дүгнэлт гаргах.

### Эрсдэлийн удирдлагын хороо

ТУЗ-ийн дэргэдэх эрсдэлийн удирдлагын хорооны журам нь Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2019 оны 02 дугаар сарын 04-ны өдрийн А/07-Т тоот тогтоолоор батлагдсан бөгөөд уг журмаар Компанийн эрсдэлийн удирдлагыг тодорхойлох, эрсдэлийг тодорхойлох, эрсдэлийн хяналтын тогтолцоо, үйл ажиллагаанд хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулна.

Эрсдэлийн удирдлагын хорооноос чиг үүргийнхээ хүрээнд тодорхой асуудлаар дүгнэлт гаргах, санал, зөвлөмж боловсруулах, шаардлагатай бусад асуудлыг ТУЗ-д танилцуулж шийдвэрлүүлнэ.

Эрсдэлийн удирдлагын хороо нь дараах чиг үүрэгтэй байна. Үүнд:

- Компанийн үйл ажиллагаа, санхүү, хууль эрх зүйн гол эрсдэлүүдийг тодорхойлох болон хянах ба Компанийн удирдлагын зүгээс эрсдэлийг тодорхойлох, үнэлгээ хийх, эрсдэлийг бууруулах, тодорхой хугацаанд хянах явцад баримтлах удирдамж, бодлогыг боловсруулах;
- Дотоод хяналт, санхүүгийн тайлан, эрсдэлийн удирдлагын системийн үр дүнгийн талаарх удирдлагын болон дотоод аудиторын тайланд үнэлэлт, дүгнэлт хийх;
- Компанийн дотоод хяналт болон эрсдэлийн удирдлагын талаар жилийн тайланд оруулсан тайлбарыг хянах;
- Компанийн эрсдэлийн хяналтын үйл ажиллагааг сайжруулах, боловсронгуй болгох, цар хүрээг нь өргөжүүлэх асуудлаар зөвлөмж боловсруулах;
- Санхүүгийн болон санхүүгийн бус эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, удирдах, шалгах, зорилго бүхий удирдлагаас тогтоосон системийн далайц, үр дүнг үнэлж дүгнэх;
- Эрсдэлийн удирдлагын бодлого, журамд тодорхойлсон эрсдэлийн төрлүүдээр алдагдал, хохирлын түвшинг хянах, Компанийн эрсдэл даах чадварыг үнэлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах, хяналтын тогтолцооны найдвартай байдалд хяналт тавих;
- Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын тогтолцоо болон үйл ажиллагааны эрсдэлийн зөвшөөрөх хэмжээнд хяналт тавьж ажиллах;
- Зээлийн эрсдэлийг хамгийн бага түвшинд барьж ажиллах.

### ТУЗ-ийн дэргэдэх хороодын гишүүд

Үнэт цаасны танилцуулга бэлтгэх өдрийн байдлаар Компанийн ТУЗ-ийн дэргэдэх хороодын гишүүд дараах байдалтай байна.

**Хүснэгт 7: Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн дэргэдэх хороодын гишүүд**

| № | Хорооны нэр | Гишүүдийн тоо | Гишүүдийн нэрс | Албан тушаал |
|---|---|---|---|---|
| 1 | Аудитын хороо | 3 | Намики Хирохито | Дарга |
| | | | Ч.Хашчулуун | Гишүүн |
| | | | Б.Анхболд | Гишүүн |
| 2 | Цалин, урамшууллын хороо | 3 | Б.Анхболд | Дарга |
| | | | Намики Хирохито | Гишүүн |
| | | | Д.Баясгалан | Гишүүн |
| 3 | Нэр дэвшүүлэх хороо | 3 | Ч.Хашчулуун | Дарга |
| | | | Б.Анхболд | Гишүүн |
| | | | Р.Мөнхтөр | Гишүүн |
| 4 | Эрсдэлийн удирдлагын хороо | 3 | Б.Анхболд | Дарга |
| | | | Д.Баясгалан | Гишүүн |
| | | | Р.Мөнхтөр | Гишүүн |

СЗХ 2019.04.24 өдөр Б ЭЗ Б № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2019-03-26 БҮРТГЭВ-02

### 2.3.5 УДИРДЛАГЫН БАГ

#### ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА

Үнэт цаас гаргагчийн гүйцэтгэх удирдлагыг ТУЗ-ийн сонгосон гүйцэтгэх захирал хэрэгжүүлэх ба Гүйцэтгэх захирал нь Компанийн дүрэм болон ТУЗ-тэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах бөгөөд Компанийн эрх бүхий төлөөлөгч байна.

"Инвескор ББСБ" ХХК-ийн Гүйцэтгэх захирал Д.Баясгалан нь Компанийн ХЭХ-ын 2016 оны 3 дугаар сарын 29-ны өдрийн 01 тоот шийдвэрээр томилогдсон бөгөөд 2019 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн гүйцэтгэх захиралтай байгуулсан "Хөдөлмөрийн контракт"-ын дагуу ажиллаж байна.

**Гүйцэтгэх захирлын эрх үүрэг**

Компанийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсэгт заасны дагуу гүйцэтгэх захирал нь дор дурдсан эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Компанийн стратегийн бодлого, дунд хугацаа болон жилийн бизнес төлөвлөгөө, төсвийг Компанийн зорилго, зорилтод нийцүүлэн боловсруулж, ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн батлуулах;
- Компанийн бүтэц, орон тоо, цалингийн систем зэргийг батлагдсан хүрээнд удирдан зохион байгуулах;
- Компанийн үйл ажиллагааг тухайн жилийн батлагдсан бизнес төлөвлөгөө, төсвийн хүрээнд эрхлэн явуулах, захиран зарцуулах;
- Хувьцаа эзэмшигчийн болон ТУЗ-ийн шийдвэр, тогтоол, Компанийн бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах;
- Компанийн эрхэлж буй үндсэн болон туслах үйл ажиллагаатай холбоотойгоос бусад 0-1,000,000,000 (нэг тэрбум) төгрөг хүртэлх зах зээлийн үнэтэй үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, барьцаалах, барьцаалуулах болон бусад хэлбэрээр захиран зарцуулах шийдвэр гаргах, түүнтэй холбогдсон гэрээ, хэлцэл эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн гэрээ, хэлцлийг байгуулах, гэрээ, хэлцэл хийх зөвшөөрөл олгох;
- Зээлийн хорооны гишүүдийг томилох, чөлөөлөх;
- Өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой заавар, дүрэм, журам батлан мөрдүүлэх;
- ТУЗ-өөс олгосон эрх хэмжээний хүрээнд итгэмжлэлгүйгээр Компанийн нэрийн өмнөөс аж ахуйн шинжтэй, үндсэн үйл ажиллагаатай холбогдсон бүх төрлийн гэрээ, хэлцэл байгуулах, хэлэлцээр хийх, гарын үсэг зурах, төлөөлөх, бусад этгээдэд эрх олгох;
- Компанийн эрхэлж буй үйл ажиллагаа болон эд хөрөнгөтэй холбогдсон бүх татвар, хураамж, түүнтэй адилтгах төлбөрийг төлөх, төрийн эрх бүхий байгууллагатай тохиролцсоны дагуу компани хооронд дамжуулан тооцуулах шийдвэр гаргах, бусад зайлшгүй гарах зардлыг зохих журмын дагуу шийдвэрлэж, төлж барагдуулах;
- Монгол Улсын хууль, Компанийн бизнес төлөвлөгөө, төсөв, Компанийн дүрэм болон гадаад харилцааны ёс зүйд Компанийн үйл ажиллагааг нийцүүлэн явуулах, аливаа зөрчил гарсан тохиолдолд зөрчлийг арилгах, хуульд нийцүүлэх арга хэмжээ авах, энэ тухай Дүрэмд заасны дагуу ТУЗ эсхүл Хувьцаа эзэмшигчид мэдэгдэж, шийдвэрлүүлэх;
- Хувьцаа эзэмшигч болон ТУЗ-өөс шаардсан тайлан, мэдээлэл, баримт бичгийг тухай бүр бэлтгэн гаргаж өгөх;
- Компанийн үйл ажиллагаатай холбогдон үүссэн шүүхийн маргаан, өр барагдуулах үйл ажиллагаа, хэрэг хянан шийдвэрлэх болон захиргааны журмаар шийдвэрлүүлэх, аливаа ажиллагаанд Компанийг төлөөлөн оролцож, асуудлыг шийдвэрлүүлэх, энэ

TDB CAPITAL LLC



"ИНВЕСКОР ББСБ" ХХК InvesCore 1115224289 ∙ 6060854 УЛААНБААТАР ХОТ

талаар өмгөөлөгч болон бусад тусгайлан эрх авсан холбогдох этгээдүүдтэй гэрээ байгуулах, Компанийг төлөөлөх этгээдэд итгэмжлэл олгох, эрх ашгийг хамгаалах холбогдох арга хэмжээ авах;

- Компанийн ажиллагсдыг ажилд авах, чөлөөлөх, хөдөлмөрийн гэрээ байгуулах, цуцлах, дуусгавар болгох, тэдгээрийн ажлын гүйцэтгэлд хяналт тавих, урамшуулах, Хөдөлмөрийн тухай хууль болон компанийн Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу ажилтанд хөдөлмөрийн сахилгын арга хэмжээ авах;
- Хувьцаа эзэмшигч, ТУЗ-ийн бүрэн эрхэд хамаарахаас бусад Компанийн удирдах албан тушаалтнууд, салбар нэгжийн гүйцэтгэх удирдлагыг бие даан томилох, чөлөөлөх, бүрэн эрхийг тогтоох, шаардлагатай тохиолдолд хугацаанаас нь өмнө чөлөөлөх, тэдгээрийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх.

## ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН НЭГЖҮҮД

### Зээлийн хороо

"Инвескор ББСБ" ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2016 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн В/02 дугаар тушаал болон 2018 оны 9 дүгээр сарын 29-ны өдрийн В/140 дугаар тушаалаар Компанийн Зээлийн хорооны гишүүдийг томилсон бөгөөд 2019 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн В/186 дугаар тушаалаар зээлийн хорооны үйл ажиллагааны журмыг шинэчлэн баталсан байна.

Хүснэгт 8: Үнэт цаас гаргагчийн Зээлийн хорооны гишүүд

| № | Нэр | Зээлийн хорооны үүрэг | Албан тушаал | Томилогдсон огноо |
|---|---|---|---|---|
| 1 | Д.Баясгалан | Дарга | Гүйцэтгэх захирал | 2016.03.29 |
| 2 | Р.Мөнхтөр | Нарийн бичгийн дарга | Дэд захирал, Байгууллагын банк хариуцсан захирал | 2016.05.23 |
| 3 | Р.Пүрэв | Гишүүн | Санхүү эрхэлсэн захирал | 2016.05.23 |
| 4 | Ш.Эрдэнэбилэг | Гишүүн | Салбарын захирал | 2016.05.23 |
| 5 | Н.Арсланбаатар | Гишүүн | Салбарын удирдлага хариуцсан захирал | 2018.09.29 |

## ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН

Компанийн дүрмийн 12 дугаар зүйлийн 12.1-т зааснаар Компанийн албан ёсны шийдвэрийг гаргахад болон гэрээ, хэлцэл хийхэд шууд болон шууд бусаар оролцдог ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх захирал, дэд захирал, газрын захирал болон ТУЗ-ийн нарийн бичгийн даргыг Компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно

СЭХ 2019 04 24 өдөр БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2019-03-26 БП-ТЭВ-02
ТИ ДИ БИ КАПИТАЛ ҮЦК ХХК TDB CAPITAL TDB CAPITAL LLC
"ИНВЕСКОР ББСБ" ХХК InvesCore УЛААНБААТАР ХОТ

Хүснэгт 9: Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтнууд

| № | Нэр | Албан тушаал | Томилогдсон огноо |
|---|---|---|---|
| 1 | Б.Анхболд | ТУЗ-ийн дарга | 2018.10.01 |
| 2 | Д.Баясгалан | ТУЗ-ийн гишүүн<br>Гүйцэтгэх захирал | 2018.10.01<br>2016.03.29 |
| 3 | Р.Мөнхтөр | ТУЗ-ийн гишүүн<br>Дэд захирал, байгууллагын банк хариуцсан захирал | 2018.10.01<br>2018.09.28 |
| 4 | Намики Хирохито | ТУЗ-ийн гишүүн | 2018.10.05 |
| 5 | Ч.Хашчулуун | ТУЗ-ийн хараат бус гишүүн | 2018.10.01 |
| 6 | О.Уянга | ТУЗ-ийн нарийн бичгийн дарга | 2018.10.02 |
| 7 | Р. Пүрэв | Санхүү эрхэлсэн захирал | 2017.01.02 |

## Эрх бүхий албан тушаалтнуудын товч танилцуулга

### ТУЗ-ийн дарга Б.Анхболд



Б.Анхболд нь Япон Улсын Рицүмейкан Ази Номхон далайн Их Сургуульд бизнесийн удирдлагын бакалавр болон бизнесийн удирдлагын магистрын зэрэг хамгаалсан. Тэрээр Япон Улсын Abeam Consulting компанид бизнесийн ахлах зөвлөх, "Шунхлай Групп" ХХК-д хүний нөөц, карьер төлөвлөлт хариуцсан захирал, дэд ерөнхийлөгчөөр ажиллаж байсан. Б.Анхболд нь маркетинг, компанийн засаглал, төлөвлөлт болон стратегийн чиглэлээр мэргэшсэн, туршлагатай.

### ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал Д.Баясгалан



Д.Баясгалан нь МУИС-ийн Эдийн Засгийн Сургуулийг эдийн засагч, эдийн засгийн онолын багш мэргэжлээр бакалаврын зэрэгтэй төгссөн. Тэрээр банк, санхүүгийн салбарт 18 жил ажилласан туршлагатай бөгөөд Монголбанкны төслийн зохицуулагч, Худалдаа, хөгжлийн банкны санхүүгийн хэлтсийн ахлах мэргэжилтнээр тус тус ажиллаж байсан. Д. Баясгалан нь санхүүгийн бүртгэл, удирдлагын бүртгэл, хөрөнгийн удирдлага болон нөөцийн удирдлагын чиглэлээр мэргэшсэн, туршлагатай.

### ТУЗ-ийн гишүүн, Дэд захирал, Байгууллагын банк хариуцсан захирал Р.Мөнхтөр



Р.Мөнхтөр нь МУИС-ийн Эдийн Засгийн Сургуульд эдийн засагч, эдийн засгийн онолын багш мэргэжлээр бакалаврын зэрэг, эдийн засгийн ухааны магистрын зэрэг хамгаалсан. Тэрээр Сэрүүлэг дээд сургууль, Худалдаа, үйлдвэрлэлийн дээд сургууль, Шинжлэх ухаан технологийн их сургууль болон МУИС-ийн Эдийн Засгийн Сургуульд 16 жил багшилсан бөгөөд Монгол Улсын Хөгжлийн банкны ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар ажиллаж байсан. Р.Мөнхтөр нь макро эдийн засаг, олон улсын эдийн засаг, хөдөлмөрийн эдийн засаг, компанийн засаглал болон хөрөнгийн зах зээлийн чиглэлээр мэргэшсэн, туршлагатай.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
2019 -03- 26
БҮРТГЭВ-02

**ТУЗ-ийн гишүүн Намики Хирохито**



Япон Улсын иргэн Намики Хирохито нь Япон Улсын Кейо Их Сургуульд эдийн засагч мэргэжлээр бакалаврын зэрэг, АНУ-ын Рочестерийн Их Сургуульд эдийн засаг болон бизнесийн стратеги чиглэлээр магистрын зэрэг тус тус хамгаалсан. Тэрээр Япон Улсын Mitsubishi UFJ Trust and Bank-нд санхүүгийн зөвлөх, компанийн стратеги төлөвлөлтийн чиглэлээр ажиллаж байсан. Намики Хирохито нь олон улсын хөрөнгө оруулалтын чиглэлээр мэргэшсэн, туршлагатай.

**ТУЗ-ийн хараат бус гишүүн Ч.Хашчулуун**



Ч. Хашчулуун нь ОХУ-ын Москвагийн Улсын Их Сургуульд эдийн засгийн ухааны бакалавр, Япон Улсын Йокохама Хотын Их Сургуульд эдийн засгийн ухааны магистр, Япон Улсын Токио хотын Кейо Их Сургуульд эдийн засгийн ухааны докторын зэрэг тус тус хамгаалсан. Тэрээр эдийн засаг, банк, санхүүгийн салбарт 30 гаруй жил ажилласан бөгөөд Монгол Улсын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль, Концессын тухай хууль, Инновацын хууль болон Төсвийн тухай хууль боловсруулж, батлуулах ажилд оролцож байсан. Ч.Хашчулуун нь Монгол Улсын Хөгжлийн Банк, МУИС-ийн Эрдмийн Зөвлөл, "Энержи Ресурс" ХХК, "Нээлттэй нийгэм форум", "Практикал даатгал", "Монголын Ипотекийн Корпораци" болон "УБ Хотын Хөгжлийн Корпораци"-д эрх бүхий албан тушаал хашиж байсан. Тэрбээр макро эдийн засаг, хөгжил ба аж үйлдвэржилт, бүс нутгийн эдийн засгийн чиглэлээр мэргэшсэн, туршлагатай.

**ТУЗ-ийн нарийн бичгийн дарга О.Уянга**



О.Уянга нь Шихихутаг Хууль Зүйн Их Сургуулийг бизнесийн эрх зүйч мэргэжлээр бакалаврын зэрэгтэй төгссөн. Тэрээр "Чимид энд Ассошэйтс" ХХК-д хуульч, "Шунхлай групп" ХХК-д хуулийн зөвлөхөөр ажиллаж байсан туршлагатай. О.Уянга нь компанийн засаглал, компанийн эрх зүй, иргэний эрх зүй, бизнесийн эрх зүй болон хөдөлмөрийн эрх зүйгээр мэргэшсэн, туршлагатай.

**Санхүү хариуцсан захирал Р. Пүрэв**



Р.Пүрэв нь МУИС-ийн Эдийн Засгийн Сургуульд нягтлан бодогч, эдийн засгийн мэргэжлээр бакалаврын зэрэг, Япон Улсын Олон Улсын Их Сургуульд санхүүч мэргэжлээр магистрын зэрэг тус тус хамгаалсан. Тэрээр банк, санхүүгийн салбарт 17 жил ажилласан туршлагатай бөгөөд Голомт банканд дилер, Сангийн яаманд мэргэжилтэн, "Оюу Толгой" ХХК-д аудитораар ажиллаж байсан туршлагатай. Р.Пүрэв нь санхүү, нягтлан бодох бүртгэл, нөөцийн удирдлага, аудит болон бичил зээлийн чиглэлээр мэргэшсэн, туршлагатай.

TDB CAPITAL LLC

### 2.3.6 ХҮНИЙ НӨӨЦ

“Инвескор ББСБ” ХХК нь хүний нөөцийг бүрдүүлэх, сурган хөгжүүлэх, нийгмийн баталгааг хангах, хүний нөөцийн удирдлагыг цогцоор нь хэрэгжүүлэх замаар гүйцэтгэлд суурилсан бүтээлч, чадварлаг, тогтвор суурьшилтай хүний нөөцийг бий болгон компанийн өрсөлдөх чадварыг өндөр байлгаж, тогтвортой хөгжлийг хангахад чиглэгдсэн хүний нөөцийн бодлогын баримт бичигтэй.

**Зураг 3: Компанийн үнэт зүйлс**



| Хариуцлага | Хурд | Хамтын ажиллагаа | Хайгуул |
|---|---|---|---|
| Харилцагчид, ажиллагсад, хөрөнгө оруулагчид, хамтрагчдынхаа өмнө хариуцлагаа ухамсарлан, бизнесийн ёс зүйтэй, зарчимтай, шударгаар ажиллахыг зорьдог. | Хором тутамд өөрчлөгдөж буй бизнесийн орчин, технологийн хувьсал, санхүүгийн салбарын өрсөлдөөн дунд шийдвэр гаргах, хэрэгжүүлэх, өдөр тутмын үйл ажиллагааг өндөр хурдтай явуулахыг шаарддаг. | Хүн бүр давуу болон сул талуудтай. Тиймээс ч нэгэндээ итгэж, сэтгэл, санаа, гар нийлж хамтарч ажиллах, хамтаар амжилтанд хүрэхийг чухалчилдаг. | Одоо байгаа зүйлдээ сэтгэл ханалгүй, үргэлж шинэ орон зай, шинэ арга барил, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг эрэн хайх хүсэл, тэмүүлэл компанийг урагшлуулдаг. |

Үнэт цаас гаргагч нь салбартаа шилдэг мэргэжилтнүүдээ урт хугацаанд өндөр бүтээмжтэй ажиллахад нь зориулж тав тухтай ажиллах орчин бүрдүүлэх, мэргэжлийн болон хувь хүний хөгжлийн сургалт зохион байгуулах, спортоор хичээллэх боломж олгох, эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд тогтмол хамруулах чиглэлийг баримталдаг байна. Мөн компани нь ажилтнуудаа зориулсан тэнцвэржүүлсэн KPI үнэлгээ, карьер төлөвлөлтийн систем, хуримтлалын хөтөлбөртэй юм.

Хүснэгт 10: Хүний нөөцийн бодлого

| | | |
|---|---|---|
| **Тав тухтай ажиллах орчин** | ✓ | Төв оффис болон салбаруудаа стандартын дагуу ажиллах таатай орчныг бүрдүүлдэг. |
| **Мэргэжлийн сургалт** | ✓ | Салбарын мэргэжлийн байгууллагуудын мэргэшил дээшлүүлэх сургалтад ажилтнуудаа тогтмол хамруулдаг. |
| **Хувь хүний хөгжлийн сургалт** | ✓ | Хувь хүний хөгжлийн сургалтыг дотоодын хүний нөөцдөө тулгуурлан сар тутамд зохион байгуулдаг. |
| **Эрүүл мэндийн үзлэг, оношилгоо** | ✓ | Жил бүр ажилтнууддаа эрүүл мэндийн бүрэн үзлэг, оношилгоонд хамруулдаг. |
| **Спортоор хичээллэх боломж** | ✓ | "Эрүүл биед саруул ухаан" гэсэн философийн үндсэн дээр ажилтнууддаа иог, цанын спорт гэх мэт спортоор хичээллэхэд нь зориулж тодорхой хэмжээний зардлыг нь компани хариуцдаг. |
| **Хуримтлалын хөтөлбөр** | ✓ | Ирээдүйн санхүүд нь дэмжлэг үзүүлэх үүднээс хуримтлалын хөтөлбөр хэрэгжүүлдэг. |
| **Цалин, хангамж, урамшуулал** | ✓ | Шударга үнэлгээний системийн дагуу зах зээлд өрсөлдөхүйц цалин хангамж олгодог. |
| **Бусад хангамжууд** | ✓ | Өндөр бүтээмжтэй ажиллахад шаардлагатай бусад хангамжуудыг тогтмол олгодог. |

"Инвескор ББСБ" ХХК нь хүний нөөцөө бүрдүүлэхдээ Монгол Улсын тэргүүлэх банк, санхүүгийн байгууллагад ажиллаж байсан, арвин туршлага, мэргэжлийн ур чадвар, зөв хандлагатай залуучуудыг эгнээндээ нэгтгэж чадсан ба эдгээр ажилтнууд компанийн өндөр өсөлт, амжилтын гол хөдөлгүүр болон ажиллаж байна.

Үнэт цаас гаргагч нь 2018 оны жилийн эцсийн байдлаар нийт 38 ажилтны орон тоотойгоос үндсэн 36 ажилтны бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулсан байна. Ажиллагсдын 99 хувь нь дээд боловсролтой, 43 хувь нь банк, санхүү, эдийн засгийн чиглэлээр ажилласан туршлагатай, эрх бүхий албан тушаалтнуудын 25 хувь нь Монгол Улсын томоохон банкуудад 3-12 жил удирдах албан тушаал хашиж байсан туршлагатай, чадварлаг боловсон хүчинтэй.

Зураг 4: Ажиллагсдын ажлын туршлага



СЗХ 2019.04.24 БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2019.03.26 БҮРТГЭВ-02

## 2.4 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БУСАДТАЙ БАЙГУУЛСАН ИХ ХЭМЖЭЭНИЙ БОЛОН СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ

### 2.4.1 ХУУЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ДҮГНЭЛТ

Үнэт цаас гаргагч нь нийтэд хувьцаагаа санал болгохтой холбоотойгоор Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.1 дахь заалтад заасан шалгуурыг хангасан хууль зүйн зөвлөгөө өгөх үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулах шаардлагатай бөгөөд Өмгөөллийн "Эм Ди Эс энд Хаан Лекс" ХХН нь Үнэт цаас гаргагчтай байгуулсан гэрээний дагуу Хорооны "Үнэт цаасны бүртгэлийн журам" болон Биржийн "Үнэт цаасны бүртгэлийн журам"-д тусгагдсан дараах асуудлаар хуульзүйн дүгнэлт гаргасан байна. Үүнд:

- Үнэт цаас гаргагч нь хуулийн дагуу үүсгэн байгуулагдаж, бүртгэгдсэн эсэх
- Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтан нь холбогдох хууль тогтоомж болон Хорооноос баталсан "Монголын компанийн засаглалын кодекс"-т заасан шаардлагыг хангаж байгаа эсэх, тэдгээрийн удирдах чадвар, дадлага туршлагын байдал;
- Үнэт цаас гаргагчийн дүрэм, дотоод журмууд нь холбогдох хууль тогтоомж, Хорооноос баталсан "Монголын компанийн засаглал кодекс"-т нийцсэн эсэх;
- Бусадтай байгуулсан худалдах болон худалдан авах, бэлтгэн нийлүүлэх, зээлийн гэрээ болон үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх бусад гэрээ, контракт нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх;
- Сүүлийн 3 жил дотор хийгдсэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл нь холбогдох хууль, тогтоомжийн дагуу хийгдсэн эсэх;
- Үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, лиценз, зохиогчийн эрх, патент, бараа, үйлчилгээний тэмдэг нь хүчин төгөлдөр эсэх, тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн зэргээр үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд нь бодитой нөлөөлж болохуйц нөхцөл бүй эсэх;
- Үнэт цаас, үл хөдлөх болон бусад эд хөрөнгө өмчлөх эрх нь хүчин төгөлдөр эсэх, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн эсэх;
- Үнэт цаасыг бүртгүүлэх өргөдөл, танилцуулгад тусгагдсан мэдээлэл нь хүчин төгөлдөр баримтаар нотлогдож байгаа эсэх;
- Компанийн толгой, охин, хараат, зэрэгцээ компанийн талаарх мэдээлэлд үндэслэн үнэт цаас гаргагч компанийн хяналтыг хэрэгжүүлэгч этгээдийг тодорхойлох;

Хууль зүйн дүгнэлтийн дэлгэрэнгүйг хавсралтаас үзнэ үү.

### 2.4.2 БУСАДТАЙ БАЙГУУЛСАН ИХ ХЭМЖЭЭНИЙ ХЭЛЦЭЛ

Компанийн тухай хуулийн 87 дугаар зүйлийн 87.1 дэх хэсэгт зааснаар "хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн хэлцэл (компанийн өдөр тутмын үндсэн үйл ажиллагаатай холбогдсон хэлцэл үүнд хамаарахгүй)", мөн "компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа авах эрхийн бичиг буюу энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргах, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн гаргалт"-ыг их хэмжээний хэлцэлд тооцно.

Их хэмжээний хэлцлийн эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг ТУЗ /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/ тогтоох бөгөөд ТУЗ нь их хэмжээний хэлцэл мөн эсэхийг тодорхойлохдоо аудиторын зөвлөмжийн дагуу эд хөрөнгийн балансын үнийг мөнгөний ханшны уналтын түвшинтэй зохицуулан шинэчилж дахин тогтоож болдог.

ТИ ДИ БИ КАПИТАЛ TDB CAPITAL TDB CAPITAL LLC
"ИНВЕСКОР ББСБ" ХХК InvesCore УЛААНБААТАР ХОТ

Их хэмжээний хэлцэл хийх тухай шийдвэрийг ТУЗ /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/ Компанийн тухай хуулийн 88 дугаар зүйлийн 88.1 дэх хэсэгт заасны дагуу санал нэгтэйгээр гаргах ёстой бөгөөд шийдвэрийг санал нэгтэй гаргаж чадаагүй тохиолдолд асуудлыг Хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулна. Хувьцаа эзэмшигчдийн хурал нь их хэмжээний хэлцэл хийх асуудлыг хуралд оролцож байгаа хувьцаа эзэмшигчдийн саналын олонхоор шийдвэрлэнэ.

Хуулийн байгууллагын дүгнэлтэд дурьдсанаар "Инвескор ББСБ" ХХК нь өөрийн толгой компани болох "Эс Ай Би Жэй Капитал" ХХК-тай 2017 оны 3 дугаар сарын 30-ны өдөр 18033001 тоот Зээлийн эрх нээх үндсэн гэрээ байгуулж, 25 тэрбум төгрөгийн зээлийн эрхийг нээсэн байна. Энэхүү гэрээ нь Компанийн тухай хуулийн 87 дугаар зүйлийн 87.1 дэх хэсэгт заасан их хэмжээний хэлцэлд хамаарч байна.

"Инвескор ББСБ" ХХК-ийн ТУЗ-ийн 2017 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн хурлын А/02-Т-01 дугаартай "Их хэмжээний хэлцэл хийх тухай" тогтоолоор уг зээлийн эрх нээх гэрээ байгуулахыг зөвшөөрч, гэрээнд гарын үсэг зурах эрхийг гүйцэтгэх захирал Д.Баясгаланд олгосон нь Компанийн тухай хуулийн 88.1 дэх хэсэгт заасан их хэмжээний хэлцэл хийх журамд нийцсэн. Тус гэрээ нь үнэт цаасны танилцуулга бэлтгэх өдрийн байдлаар хүчин төгөлдөр байна.

"Инвескор ББСБ" ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2019 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн Б-19/814 тоот Баталгаа бичигт дурьдсанаас үзвэл дүгнэлт гаргах өдрийн байдлаар сүүлийн 3 жилийн дотор Хуулийн дүгнэлтэд дурьдсанаас өөр их хэмжээний хэлцэл байгуулаагүй байна.

### 2.4.3 БУСАДТАЙ БАЙГУУЛСАН СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ

Компанийн тухай хуулийн 89 дүгээр зүйлийн 89.1-д зааснаар сонирхлын зөрчил бүхий этгээд гэдэг нь компанийн энгийн хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч, компанийн эрх бүхий албан тушаалтан, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд нь өөрийн ажиллаж байгаа болон хувьцааг нь эзэмшиж байгаа компанитай хуульд заасан харилцаанд орсон бол компанитай, эсвэл түүний харaат болон охин компанитай сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээд байна.

Сонирхлын зөрчилтэй хэлцэл гэдэгт сонирхлын зөрчил бүхий этгээдийн өөрийн ажиллаж байгаа болон хувьцааных нь хяналтын багцыг эзэмшиж байгаа компанитай хийж байгаа хэлцлийг хэлнэ. Хэлцлийг хийхийг зөвшөөрөх тухай шийдвэрийг уг хэлцлийг хийх талаар сонирхлын зөрчилгүй ТУЗ-ийн гишүүдийн олонхын саналаар гаргах бөгөөд ТУЗ нь сонирхлын зөрчилтэй хэлцлээр худалдах, худалдан авах, захиран зарцуулах эд хөрөнгө, эд хөрөнгийн болон мөнгөөр үнэлж болох бусад эрхийн зах зээлийн үнэ, үйлчилгээний хөлсний хэмжээг тогтооно.

Хуулийн байгууллагын дүгнэлтэд дурьдсанаар "Инвескор ББСБ" ХХК нь өөрийн толгой компани болох "Эс Ай Би Жэй Капитал" ХХК-тай 2017 оны 3 дугаар сарын 30-ны өдөр 18033001 тоот Зээлийн эрх нээх үндсэн гэрээ /цаашид "Гэрээ" гэх/ байгуулж, 25 тэрбум төгрөгийн зээлийн эрхийг нээсэн байна. Энэхүү гэрээ нь Компанийн тухай хуулийн 89 дугаар зүйлийн 89.1 дэх хэсэгт заасан сонирхлын зөрчилтэй хэлцэлд хамаарч байна.

"Инвескор ББСБ" ХХК-ийн гүйцэтгэх захиралын 2019 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн Б-19/814 тоот Баталгаа бичигт дурьдсанаас үзвэл дүгнэлт гаргах өдрийн байдлаар сүүлийн 3 жилийн дотор Хуулийн дүгнэлтэд дурьдсанаас өөр сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулаагүй байна.

СЗХ 2019.04.24 БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2019-03-26 БҮРТГЭВ-02

### 2.4.4 ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ТАВ БОЛОН ТҮҮНЭЭС ДЭЭШ ХУВЬТАЙ ТЭНЦЭХ ХЭМЖЭЭНИЙ ҮНИЙН ДҮН БҮХИЙ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН ГЭРЭЭ, ХЭЛЦЭЛ

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.5.7 дахь хэсэг, Биржийн Үнэт цаасны бүртгэлийн журмын 4.3.7 дахь хэсэгт заасны дагуу Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ, хэлцэл 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 4 байсан байна.

**Хүснэгт 11: Тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ, хэлцэл**

| № | Гэрээний нөгөө тал | Гэрээ, хэлцэл | Гэрээний огноо, дугаар | Гэрээгээр хүлээсэн үүрэг | Хэрэгжилт |
|---|---|---|---|---|---|
| 1 | "Эс Ай Би Жэй Капитал" ХХК | Зээлийн эрх нээх үндсэн гэрээ | 2017.03.30<br>18033001 | "Инвескор ББСБ" ХХК нь 25 тэрбум төгрөгийн зээлийн эрхийг жилийн 19 хувийн хүүтэй, 15 жилийн хугацаатай, бизнесийн эргэлтийн зээлийн зориулалтаар нээлгэсэн байна. Зээлдэгч нь зээлийн хүүг хуримтлуулж тооцох ба үндсэн төлбөртэй хамт зээлийн хугацааны эцэст төлнө. | Гэрээний хүрээнд 2018 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар зээлийн үлдэгдэл 9.97 тэрбум төгрөг бөгөөд зээл эргэн төлөгдөх хугацаа хүртэл 14 жил. |
| 2 | Худалдаа, хөгжлийн банк | Зээлийн эрх нээх нэмэлт гэрээ | 2018.07.09<br>ЗЭНГ/RCC 170911005 -1-2 | "Инвескор ББСБ" ХХК нь 1.5 тэрбум төгрөгийн зээлийн эрхийг жилийн 19.2 хувийн хүүтэй, 2 жилийн хугацаатай, эргэлтийн хөрөнгөө нэмэгдүүлэх зориулалтаар нээлгэсэн байна. Зээлдэгч нь зээлийн хүүг сар бүр төлөх ба үндсэн төлбөрийг зээлийн хугацааны эцэст буюу 2019 оны 9 сарын 15-ны өдөр төлнө. | 2018 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар 1,5 тэрбум төгрөгийг хүлээн авсан ба Монголбанкны Зээлийн мэдээллийн сангийн мэдээллээр зээлийн ангилал нь хэвийн байна. |
| 3 | Япон Улсын иргэн Кавада Макото | Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ (Итгэлцлийн үйлчилгээ) | 2018.06.13<br>T18061301 | Кавада Макото нь 793,363,023 төгрөгийг "Инвескор ББСБ" ХХК-д итгэмжлэн удирдуулахаар шилжүүлэх ба итгэмжлэгдэгч нь жилийн 19 хувийн хүү болон үндсэн төлбөрийг гэрээний хугацаа дуусахад төлөх үүрэг хүлээсэн. | Гэрээ хэрэгжсэн ба хүү болон үндсэн төлбөрийг 2019 оны 6 сарын 13-ны дотор төлнө. |
| 4 | "Бридж Жапан" ХХК | Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ (Итгэлцлийн үйлчилгээ) | 2018.11.01<br>T18110102 | "Бридж Жапан" ХХК нь 300,000 ам. долларыг "Инвескор ББСБ" ХХК-д итгэмжлэн удирдуулахаар шилжүүлэх ба итгэмжлэгдэгч нь жилийн 10 хувийн хүү болон үндсэн төлбөрийг гэрээний хугацаа дуусахад төлөх үүрэг хүлээсэн. | Гэрээ хэрэгжсэн ба хүү болон үндсэн төлбөрийг 2019 оны 10 сарын 31-ны дотор төлнө. |

ТИ ДИ БИ КАПИТАЛ ҮЦК ХХК TDB CAPITAL LLC



"ИНВЕСКОР ББСБ" ХХК InvesCore УЛААНБААТАР ХОТ

# Компанийн үйл ажиллагаа



СЗХ
2019 .04. 24
БҮРТГЭВ
№ 01



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2019 03 26
БҮРТГЭВ-02

## 3.1 ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

"Инвескор ББСБ" ХХК нь анх 2016 оны 3 дугаар сарын 29-ний өдөр үүсгэн байгуулагдаж, Хорооны 2016 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн 159 тоот тогтоолоор "Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх" тусгай зөвшөөрлөө авсан бөгөөд өнгөрсөн хугацаанд хурдацтай өсөж, салбартаа шинэлэг шуурхай үйлчилгээ болон дэвшилтэт технологийг нэвтрүүлж, харилцагчдынхаа санхүүгийн хариуцлагатай дэмжигч байх зорилго тавин ажилласаар салбартаа манлайлагчдын нэг болж чаджээ.

**Хүснэгт 12: "Инвескор ББСБ" ХХК-ийн эрхэм зорилго, алсын хараа, бизнесийн зарчим**

| | |
|---|---|
| **Эрхэм зорилго** | ✓ "Инвескор ББСБ" ХХК нь харилцагчдадаа санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, шуурхай үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд үзүүлж, хариуцлагатай санхүүгийн дэмжигч нь байна. |
| **Алсын хараа** | ✓ "Инвескор ББСБ" ХХК нь хөгжиж буй улс орнуудын бичил санхүүгийн зах зээлд шинэ бүтээгдэхүүн, шуурхай үйлчилгээг нэвтрүүлж, иргэд болон жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжсэн хариуцлагатай санхүүгийн бий болгоно. |
| **Удирдлагын багийн зарчим** | ✓ Оновчтой, шуурхай шийдвэр гаргалт;<br>✓ Зөв зохистой төлөвлөлт;<br>✓ Гүйцэтгэлийн хяналт. |
| **Бизнесийн зарчим** | "Инвескор ББСБ" ХХК нь санхүүгийн зөв үйлчилгээ үзүүлэгч, харилцагчдынхаа санхүүгийн хариуцлагатай дэмжигч байгууллага болохын хувьд зохистой засаглалын үндсэн зарчмын дагуу аливаа үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх, сайжруулах тогтолцоог үйл ажиллагаандаа төлөвшүүлж, байнга хөгжин дэвшихийн тулд дараах зургаан бизнесийн зарчмыг тодорхойлж, мөрдлөг болгон ажиллаж байна.<br><br>✓ **Зөв засаглал:** Компанийн засаглалын тогтолцоог нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн кодекс, нийтлэг зарчмуудад бүрэн нийцүүлсний үр дүнд олон улсын түвшинд бизнесийн үлгэр жишээ загвар болох;<br>✓ **Зөв хөрөнгө оруулалт:** Ирээдүйд чиглэсэн, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлэх замаар Компанийн ашгийг нэмэгдүүлэх;<br>✓ **Зөв бүтээгдэхүүн:** Санхүүгийн шилдэг үйлчилгээг цахимжуулалттай хослуулан харилцагчид хүрсэн брэнд бүтээгдэхүүнтэй болох;<br>✓ **Зөв санхүүжилт:** Харилцан ашигтай санхүүгийн шийдлийг санал болгох замаар үр ашгаа нэмэгдүүлэх;<br>✓ **Зөв ур чадвар:** Тогтвортой ажиллах өндөр ур чадвар бүхий олон улсын баг хамт олныг бүрдүүлэх;<br>✓ **Зөв үйлчилгээ:** Үйлчилгээний стандартаар салбартаа тэргүүлэх. |

Үнэт цаас гаргагч нь уламжлалт банк бус санхүүгийн зах зээл болон финтек буюу технологид суурилсан санхүүгийн зах зээлийг хослуулан үйл ажиллагаа явуулдаг онцлогтой бөгөөд одоогоор Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хүрээнд нийт 6 төрлийн үйлчилгээ үзүүлж, төв оффисоос гадна Улаанбаатар хотод байрлах нийт 5 салбар, мэргэжлийн өндөр ур чадвар бүхий 36 ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

"Инвескор ББСБ" ХХК нь финтек бүтээгдэхүүнийг ирээдүйн хөгжлийн нэг тулгуур бүтээгдэхүүн хэмээн онцгойлон үздэг ба урт хугацаанд өрсөлдөгчөөсөө давуу байдлыг олж

ТИ ДИ БИ КАПИТАЛ ҮЦК ХХК
TDB CAPITAL
5251494
TDB CAPITAL LLC



"ИНВЕСКОР ББСБ" ХХК
InvesCore
NON-BANK FINANCIAL INSTITUTION
УЛААНБААТАР ХОТ

СЗХ 2019.04.24 өдөр БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE



авч, зах зээл дээр байгаа бэлэн бүтээгдэхүүн, шийдэл худалдан авалгүй, өөрийн мэдээлэл технологийн багийг бүрдүүлэн, өөрийн бүтээгдэхүүнийг хөгжүүлэх зорилго тавин “Инвескор Эй Ай Лаб" ХХК-ийг үүсгэн байгуулсан. Үнэт цаас гаргагчийн охин компани болох “Инвескор Эй Ай Лаб" ХХК нь хиймэл оюун ухаанд суурилсан финтек бүтээгдэхүүнийг хөгжүүлдэг байна.

Үнэт цаас гаргагч нь салбартаа АНХДАГЧ болж, иргэд, аж ахуйн нэгжүүдэд шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэдэг, үргэлж шинийг санаачлагч байгууллага ба уг зорилгынхоо хүрээнд тус компани бизнес эрхлэгч аж ахуй нэгж, иргэдэд зориулж тэдний эрэлт, хэрэгцээг судлан үзсэний үндсэн дээр бага хүүтэй валютын зээл, зээлийн шугам, гүүрэн зээл, хамтын санхүүжилт, кредит карт зэрэг зээлийн үйлчилгээг үзүүлэхээс гадна финтек буюу технологид суурилсан түргэн шуурхай бүтээгдэхүүн, үйлчилгээг өөрийн үйл ажиллагаандаа амжилттай нэвтрүүлэн ажиллаж байна.

**Хүснэгт 13: “Инвескор ББСБ” ХХК-ийн үйл ажиллагаа**

| | | |
|---|---|---|
| **Үйл ажиллагааны чиглэл** | ✓ Зээлийн үйл ажиллагаа;<br>✓ Факторингийн үйлчилгээ;<br>✓ Итгэлцлийн үйлчилгээ;<br>✓ Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх;<br>✓ Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө өгөх, мэдээлэл өгөх;<br>✓ Төлбөрийн баталгаа гаргах. | |
| **Салбарууд** | ✓ Төмөр зам салбар;<br>✓ 100 айл салбар;<br>✓ Да хүрээ салбар;<br>✓ Авто цогцолбор салбар;<br>✓ Дүнжингарав салбар. | |
| **Ажилтнуудын тоо** | 36 ажилтан | |
| **Охин компани** | “Инвескор Эй Ай Лаб" ХХК<br>(Хиймэл оюун ухаанд суурилсан Финтек бүтээгдэхүүнийг хөгжүүлдэг мэдээлэл технологийн компани) | |
| **Бүтээгдэхүүн, үйлчилгээ** | 1. ААН, бизнес эрхлэгчдэд зориулсан зээл | ✓ SMB буюу жижиг, дунд бизнесийн зээл;<br>✓ Бизнесийн зээл;<br>✓ Бизнесийн зээлийн шугам;<br>✓ Дугааргүй авто машин барьцаалсан зээл;<br>✓ Том зээл; |
| | 2. Иргэдэд зориулсан зээл | ✓ Хэрэглээний зээл;<br>✓ Автомашин худалдан авах зээл;<br>✓ Цалингийн зээл;<br>✓ Дугаар барьцаалсан зээл;<br>✓ Итгэлцэл барьцаалсан зээл; |
| | 3. Кредит карт | ✓ Invescore Black card;<br>✓ Invescore White card |
| **Үйл ажиллагаандаа ашиглаж буй дэвшилтэт технологи** | ✓ Төрийн мэдээллийн ХУР систем;<br>✓ Зээлийн үйл ажиллагааны бүрэн автоматжуулсан Smart-LOS систем;<br>✓ Хиймэл оюун ухаанд суурилсан кредит онооны систем. | |

TDB CAPITAL LLC
InvesCore УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2019.04.24 сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2019 ... 26
БҮРТГЭВ-02

| | | |
|---|---|---|
| **Нэвтрүүлэхээр зорьж буй бүтээгдэхүүн, үйлчилгээ** | ✓ | Бичил зээл, төлбөр тооцооны аппликэйшн; |
| | ✓ | Жижиг дунд бизнес эрхлэгчдэд зориулсан SMB хөтөлбөр; |
| | ✓ | Цахим мөнгө, төлбөр тооцооны систем; |
| | ✓ | Төлбөрийн баталгаа гаргах үйлчилгээ; |
| | ✓ | Факторингийн үйлчилгээ; |
| | ✓ | Санхүүгийн зуучлал; |
| | ✓ | Бусад. |
| **Зорилтот зах зээл** | ✓ | Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй жижиг, дунд бизнес эрхлэгчид, иргэд; |
| | ✓ | 2019-2023 оны хугацаанд нийт 12 салбар нээхээр төлөвлөж байна; |
| | ✓ | Цаашид Япон Улс болон Төв Ази, Зүүн Өмнөд Азийн зах зээлд нэвтрэхээр төлөвлөн ажиллаж байна. |

## 3.2 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ЭЗЭМШИЖ БУЙ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

Үнэт цаас гаргагч нь банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх 1 тусгай зөвшөөрөл болон банк бус санхүүгийн байгууллагын 5 нэгжийн гэрчилгээтэй бөгөөд эдгээр нь бүгд хугацаагүй нөхцөлөөр олгогдсон буюу хуулийн хүчинтэй хугацаандаа байна.

### Үнэт цаас гаргагчийн эзэмшиж буй Тусгай зөвшөөрөл

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-т зааснаар аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл гэж тодорхой төрлийн аж ахуйн үйл ажиллагааг тогтоосон хугацаа, нөхцөл, шаардлагын дагуу эрхлэн явуулах эрхийг иргэн, ашгийн ба ашгийн бус хуулийн этгээдэд эрх бүхий байгууллагаас олгосон албан ёсны баримт бичгийг хэлнэ гэж тодорхойлсон.

Үнэт цаасны танилцуулга бэлтгэх өдрийн байдлаар Үнэт цаас гаргагч нь Хорооны 2016 оны 5 сарын 17-ны өдрийн 159 тоот тогтоолоор олгогдсон “Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх” тусгай зөвшөөрлийн хүрээнд дараах 6 төрлийн үйл ажиллагааг эрхлэх зөвшөөрөлтэй байна.

**Хүснэгт 14: Үнэт цаас гаргагчийн эзэмшиж буй тусгай зөвшөөрөл**

| № | Үйл ажиллагааны төрөл | Тусгай зөвшөөрөл олгосон огноо | Тусгай зөвшөөрөл олгосон шийдвэрийн дугаар |
|---|---|---|---|
| 1 | Зээл | 2016.05.17 | №159 |
| 2 | Факторинг | 2016.05.17 | №159 |
| 3 | Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх | 2016.05.17 | №159 |
| 4 | Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх | 2016.05.17 | №159 |
| 5 | Итгэлцэл | 2016.05.17 | №159 |
| 6 | Төлбөрийн баталгаа гаргах | 2018.01.10 | №17 |

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4-т "Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх этгээд нь өөрийн салбар, төлөөлөгчийн газар, нэгжийг Хорооны зөвшөөрөлтэйгээр нээнэ” гэж заасан байдаг.

TDB CAPITAL LLC



"ИНВЕСКОР ББСБ" ХХК
InvesCore
NON-BANK FINANCIAL INSTITUTION
УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2019 -03- 26
БҮРТГЭВ-02

Үнэт цаасны танилцуулга бэлтгэх өдрийн байдлаар "Инвескор ББСБ" ХХК нь өөрийн салбаруудын нэр дээр дараах банк бус санхүүгийн байгууллагын нэгжийн гэрчилгээнүүдийг эзэмшиж байна. Үүнд:

Хүснэгт 15: Үнэт цаас гаргагчийн эзэмшиж буй нэгжийн гэрчилгээ

| № | Нэр | Нэгжийн гэрчилгээний дугаар | Зөвшөөрөл олгосон огноо | Зөвшөөрөл олгосон шийдвэрийн дугаар | Хаяг |
|---|---|---|---|---|---|
| 1 | Төмөр зам салбар | 1/554-01 | 2017.04.18 | №245 | УБ, БГД, 4-р хороо, Байр хороолол, Нарны зам – 62, 2 давхар |
| 2 | 100 айл салбар | 1/554-02 | 2017.08.02 | №381 | УБ, СБД, 10-р хороо, Зуун айл, Цалам төв, 07 тоот |
| 3 | Да хүрээ салбар | 1/554-03 | 2017.08.02 | №381 | УБ, БЗД, 17-р хороо, Да хүрээ техникийн зах дотор |
| 4 | Авто цогцолбор | 1/554-04 | 2018.02.14 | №83 | УБ, СХД, 32-р хороо, Авто худалдааны цогцолбор |
| 5 | Дүнжингарав салбар | 1/554-05 | 2018.09.24 | №521 | УБ, БЗД, 26-р хороо, Дүнжингарав худалдааны төв, 86 тоот |

## 3.3 АМЖИЛТ ОЛОЛТ, НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

### АМЖИЛТ ОЛОЛТ

"Инвескор ББСБ" ХХК нь өнгөрсөн хугацаанд харилцагчдадаа зориулан үргэлж шинийг санаачилж, салбартаа шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэхийг зорьсоор ирсэн. Уг зорилгын хүрээнд компани харилцагчдадаа уламжлалт зээлийн үйлчилгээнээс гадна дараах бүтээгдэхүүн үйлчилгээг амжилттай нэвтрүүлжээ. Үүнд:

- ✓ **Орон сууцны зээл:** Үл хөдлөх хөрөнгийн барилгын төсөл хэрэгжүүлэгч барилгын компаниудтай хамтран гадаадад ажиллаж амьдардаг Монголчууддаа зориулан жилийн 8 хувийн хүүтэй, 20 жил хүртэлх хугацаатай орон сууцны зээл олгосон;
- ✓ **Кредит карт:** Худалдаа хөгжлийн банктай хамтран олон улсын эрхтэй кредит картыг салбартаа АНХ УДАА гаргасан;
- ✓ **ЖДҮ бизнесийн зээлийн шугам:** Жижиг дунд бизнес эрхлэгч нарт зориулсан бизнесийн зээлийн шугам нээж олгосон;
- ✓ **ХУР систем:** Харилцагчдын цаг завыг хэмнэх үүднээс төрийн мэдээллийн ХУР системийг салбартаа АНХ УДАА үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн;
- ✓ **Факторингийн үйлчилгээ:** Монголд төдийлөн түгээмэл бус факторингийн үйлчилгээг туршилтын журмаар үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн;
- ✓ **Зээлийн үйл ажиллагааны бүрэн автоматжуулсан систем**: Зээлийн үйл ажиллагааны бүрэн автоматжуулсан Smart-LOS системийг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн;
- ✓ **Кредит онооны систем:** Хиймэл оюун ухаанд суурилсан кредит онооны системийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэхээр ажиллаж байна.

ТИ ДИ БИ КАПИТАЛ ҮЦК ХХК
TDB CAPITAL LLC

"ИНВЕСКОР ББСБ" ХХК
InvesCore
NON-BANK FINANCIAL INSTITUTION
УЛААНБААТАР ХОТ

Зураг 5: Бизнесийн шинэлэг ололтууд




## ШАГНАЛ УРАМШУУЛАЛ

Үнэт цаас гаргагч нь үүсгэн байгуулагдсан цагаасаа эхлэн богино хугацаанд олон амжилт гаргажээ. Тухайлбал, Компани нь дүүргийн "Шилдэг татвар төлөгч байгууллага"-аар 2017 онд, Монголын Худалдаа Аж Үйлдвэрийн танхимаас шалгаруулдаг банк бус санхүүгийн салбарын "Оны Онцлох энтрепренер"-ээр 2017 болон 2018 онд, МББСБХ-ны "2017 оны Шилдэг хөрөнгө оруулагч ББСБ"-аар 2017 онд, МББСБХ-ны "Шилдгийн шилдэг ББСБ"-аар 2018 онд тус тус шалгарч байсан.

Хүснэгт 16: Үнэт цаас гаргагчийн шагнал урамшуулал

| | | |
|---|---|---|
| МТА | ✓ Дүүргийн "Шилдэг татвар төлөгч байгууллага" | 2017 он |
| | ✓ Монголын Худалдаа Аж Үйлдвэрийн танхимаас жил бүр шалгаруулдаг банк бус санхүүгийн салбарын "Оны онцлох энтрепренер" | 2017 он, 2018 он |
| МОНГОЛЫН ББСБ-УУДЫН ХОЛБОО | ✓ МББСБХ-ны "2017 оны Шилдэг хөрөнгө оруулагч ББСБ" | 2017 он |
| | ✓ МББСБХ-ны "2018 оны Шилдгийн шилдэг ББСБ" | 2018 он |

## НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

"Инвескор ББСБ" ХХК нь нийгмийн хариуцлагын хүрээнд хамтын үнэ цэнийг бүтээхээр зорин ажилладаг бөгөөд харилцагчдын санхүүгийн боловсролыг сайжруулах, байгаль орчинд

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2019 -03- 26
БҮРТГЭВ-02

2019 .04. 24

ээлтэй үйл ажиллагаа эрхлэх, мөн хүүхэд залуусын боловсрол, эрүүл мэндэд чиглэсэн үйл ажиллагааг тогтмол зохион байгуулдаг.

Хүснэгт 17: **"Инвескор ББСБ" ХХК-ийн нийгмийн хариуцлагын хүрээнд хийж гүйцэтгэсэн ажлууд**

| | |
|---|---|
| **Харилцагчдын санхүүгийн боловсролыг сайжруулах үйл ажиллагаа** | ✓ Харилцагчдад үнэ төлбөргүй санхүүгийн зөвлөгөө өгөх зорилгоор сургалтын материал, гарын авлагыг боловсруулж, өөрийн цахим хуудсанд тогтмол байршуулдаг.<br>✓ Компани харилцагчдын, тэр дундаа жижиг, дунд бизнес эрхлэгчдийн санхүүгийн боловсролыг дэмжих зорилгоор 2019 онд санхүүгийн академи байгуулан "SMB хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Ингэснээр нэг талаас зээлдэгчдийн бизнесийн үйл ажиллагаа сайжрах, нөгөө талаас санхүүгийн сахилга бат сайтай, хариуцлагатай зээлдэгчдийг бий болгох боломжтой юм. |
| **Байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа** | ✓ Байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулдаг хувь хүн, аж ахуйн нэгжүүдэд хөнгөлөлттэй зээл олгодог бөгөөд Компанийн зүгээс мод тарих, хог цэвэрлэх зэрэг нийгэмд тустай үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж, байгаль орчинд ээлтэй байгууллагын соёлыг бий болгон ажилладаг. |
| **Хүүхэд залуусын боловсрол, эрүүл мэндэд чиглэсэн арга хэмжээ** | ✓ МУИС-ийн нэрэмжит "Эдийн засгийн онолыг хэн сайн мэдэх вэ?" сэдэвт улсын 13-р олимпиадын үндсэн ивээн тэтгэгч;<br>✓ Олон улсын чөлөөт бөхийн өсвөрийн аварга шалгаруулах тэмцээний ивээн тэтгэгч;<br>✓ МББСБХ-ноос зохион байгуулсан "Мянган цүнх аян"-ны алтан ивээн тэтгэгч;<br>✓ "Лантуун Дохио" ТББ-аас санаачлан хэрэгжүүлсэн "Ид Шидийн Орон" хүүхэд хамгааллын төвд буцалтгүй тусламж;<br>✓ "Маруима" ХХК-тай хамтран, өнчин хүүхдийн "Өнөр бүл" төвийн "Бялзуухай" бүлэгт 24 хүүхдийн таван өрөөг иж бүрэн тохижуулсан. |

## 3.4 БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ

Үнэт цаасны танилцуулга бэлтгэх өдрийн байдлаар "Инвескор ББСБ" ХХК нь зээлийн болон итгэлцлийн үйлчилгээ үзүүлж, хиймэл оюун ухаан болон финтект суурилсан бүтээгдэхүүнийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллаж байна.

### 3.4.1 ЗЭЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

#### 3.4.1.1 Зээлийн бүтээгдэхүүн

Үнэт цаас гаргагч нь зах зээлд бага хүүтэй төгрөгийн болон валютын зээл (ам. доллар, иен), зээлийн шугам, гүүрэн зээл, хамтын санхүүжилт, кредит карт зэрэг зээлийн үйлчилгээг үзүүлж байна.

TDB CAPITAL LLC

"ИНВЕСКОР ББСБ" ХХК
InvesCore
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2019 .04. 24
БҮРТГЭВ



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2019 -03- 26
БҮРТГЭВ-02

Хүснэгт 18: Зээлийн бүтээгдэхүүний төрлүүд

| Зээлийн төрөл | Бизнесийн зээл | Хэрэглээний зээл |
|---|---|---|
| **Зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ** | ✓ Байгууллагын бизнесийн зээл;<br>✓ Бизнесийн зээлийн шугам;<br>✓ Жижиг, дунд бизнесийн зээл;<br>✓ Том зээл;<br>✓ Дугааргүй авто машин барьцаалсан зээл | ✓ Цалингийн зээл;<br>✓ Хэрэглээний зээл;<br>✓ Автомашин худалдан авах зээл;<br>✓ Дугаар барьцаалсан зээл;<br>✓ Итгэлцэл барьцаалсан зээл;<br>✓ Кредит карт |
| **Зээлийн хугацаа** | ✓ 1-24 сар | ✓ 1-48 сар |
| **Төгрөгийн зээлийн нөхцөл** | ✓ Сарын хүү: 2.3-3.4%<br>✓ Доод хэмжээ: ₮ 5,000,000<br>✓ Дээд хэмжээ: ₮ 2,500,000,000 | ✓ Сарын хүү: 2.0*-3.7%<br>✓ Доод хэмжээ: ₮ 500,000<br>✓ Дээд хэмжээ: ₮ 170,000,000 |
| **Валютын зээлийн нөхцөл** | ✓ Сарын хүү: 1.2%-2.0%<br>✓ Доод хэмжээ: $ 2,000<br>✓ Дээд хэмжээ: $ 1,000,000 | ✓ Сарын хүү: 1.1*%-2.3%<br>✓ Доод хэмжээ: $ 600<br>✓ Дээд хэмжээ: $ 20,000 |

***Итгэлцэл барьцаалсан хүү***

**Кредит карт**

“Инвескор ББСБ” ХХК нь 2018 онд Худалдаа, хөгжлийн банктай хамтран Монгол Улсын банк бус санхүүгийн байгууллагууд дундаас анх удаа олон улсад буюу дэлхийн 212 улсад ашиглах эрхтэй 2 төрлийн зээлийн карт гаргаж, зах зээлд амжилттай нэвтрүүлээд байна.

Хүснэгт 19: Кредит картуудын товч танилцуулга

| | Black Card  | White Card  |
|---|---|---|
| **Сүлжээ** | – Виза | – Виза |
| **Валют** | – MNT | – MNT |
| **Эрх** | – Олон улс (212 улс) | – Олон улс (212 улс) |
| **Жилийн хураамж** | – ₮ 50,000 | – ₮ 30,000 |
| **Зээлийн эрх** | – Доод: ₮ 1,000,000<br>– Дээд: ₮ 20,000,000 | – Доод: ₮ 500,000<br>– Дээд: ₮ 5,000,000 |
| **Зээлийн сарын хүү** | – 3.5% | – 3.5% |

Хэдий кредит картын зах зээлд хүчтэй өрсөлдөөн байгаа боловч арилжааны банкуудын зүгээс жижиг дунд бизнес эрхлэгчид, хувиараа бизнес эрхлэгчдэд 3 сая төгрөг хүртэл буюу бага дүнтэй зээлийн эрх бүхий картыг ихэвчлэн санал болгодог. Компанийн зүгээс бизнес эрхлэгчдийн гэнэтийн санхүүгийн хэрэгцээг шийдэх зорилгоор **20 сая хүртэлх** төгрөгийн эрхтэй, **барьцаат** кредит картын бүтээгдэхүүнийг нэвтрүүлсэн нь харилцагчдын талархлыг хүлээсэн бүтээгдэхүүн болоод байна. Харилцагч өөрийн үл хөдлөх хөрөнгө, автомашинаа барьцаалан 20 сая хүртэлх төгрөгийг хүссэн үедээ гар утасны аппликэйшн, интернэт банк, АТМ-ээс шилжүүлэх, бэлнээр авах, худалдан авалтын төлбөр тооцоо хийх болон картад орлого хийн дебит карт хэлбэрээр ашиглах боломжтой юм.

TDB CAPITAL LLC



InvesCore
NON BANK FINANCIAL INSTITUTION
УЛААНБААТАР ХОТ

### 3.4.1.2 Зээлийн үйл ажиллагаа

**Зураг 6: 2018 оны нийт зээлийн үлдэгдэл, зээлдэгчдийн тоо, тэрбум төгрөг**




**Зураг 7: 2019-2023 оны нийт зээлийн багцын төлөвлөгөө, тэрбум төгрөг**




2018 онд “Инвескор ББСБ” ХХК нь өөрийн төв оффис болон Улаанбаатар хотод байрлах 5 салбараараа дамжуулан давхардсан тоогоор 2,230 харилцагчдад зээлийн үйлчилгээ үзүүлжээ. Компанийн нийт зээлдэгчдийн тоо жилд дунджаар 3.4 дахин өссөн үзүүлэлттэй байна. 2016 онд Үнэт цаас гаргагчийн нийт зээлийн үлдэгдэл 4.2 тэрбум төгрөгтэй тэнцэж байсан бол жил бүр дунджаар 1.9 дахин өсөж, 34.9 тэрбум төгрөгт хүрсэн. 2016-2018 онд компанийн нийт зээлийн багц 8.3 дахин өссөн үзүүлэлттэй байна. Компани дотоодын зах зээлд 100% автомат бичил зээлийн аппликэйшн, цахим мөнгөний гүйлгээ, төлбөр тооцооны систем, хэрэглээний зээл олголтын бүрэн автоматжуулсан систем зэрэг хиймэл оюун ухаан, финтект суурилсан бүтээгдэхүүн болон санхүүгийн эх үүсвэрийн давуу талаа ашиглан компанийн зээл олголтын хэмжээг ирэх 5 жилийн хугацаанд жилд дунджаар 43 хувиар нэмэгдүүлж, 2023 он гэхэд 205.4 тэрбум төгрөгт хүргэхээр зорьж байна.

Компани нь Хорооны дарга болон Сангийн сайдын 2015 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 144/125 тоот хамтарсан тушаалаар батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын дагуу ББСБ-ын активыг хэвийн, хугацаа хэтэрсэн, хэвийн бус, эргэлзээтэй, муу гэсэн төрөлд ангилж, актив тус бүрийн үлдэгдэл дүнгээс 0%, 5%, 25%, 50%, 100%-аар эрсдэлийн сан байгуулдаг. Үнэт цаас гаргагчийн зээлийн эрсдэлийн сан 2018 онд 1.1 тэрбум төгрөгтэй тэнцэж байсан бол зээлийн багцын өсөлттэй уялдуулан 2023 онд 7.6 тэрбум төгрөгт хүрэхээр төлөвлөгдсөн байна.

**Зураг 8: Зээлийг багцын бүтэц, 2018 он**




**Зураг 9: Зээлийг багцын бүтэц, 2023 он**



“Инвескор ББСБ” ХХК-ийн хувьд барьцаагүй зээлийн хувь хэмжээг маш анхааралтайгаар тооцон үйл ажиллагаагаа явуулдаг ба одоогийн байдлаар нийт зээлийн бүтээгдэхүүний 97.0 хувь нь үл хөдлөх болон хөдлөх хөрөнгөөр баталгаажсан байна. Цаашид энэ үзүүлэлтийг тогтвортой түвшинд барин ажиллах төлөвлөгөөтэй байна. Компани нийт зээлийн багцынхаа 50 хувийг бизнесийн зээл, 50 хувийг хэрэглээний зээлээр бүрдүүлэхийг зорьж ажилладаг.

2018 оны жилийн эцсийн байдлаар Үнэт цаас гаргагчийн зээлийн багцын 40.4 хувийг автомашины зээл, 31.2 хувийг хувь хүнд олгосон бизнесийн зээл буюу жижиг, дунд бизнесийн зээл, 22.0 хувийг бусад бизнесийн зээл, 5.6 хувийг хэрэглээний зээл тус тус эзэлж байна. 2019-2023 онд Үнэт цаас гаргагч нь автомашин барьцаалсан зээлийн хэмжээг үе шаттайгаар бууруулж, 2023 он гэхэд 20.7 орчим хувьд хүргэх бол бичил зээлийг өөрийн аппликэйшнээр олгож эхэлснээр хэрэглээний зээлийн хэмжээ нэмэгдэж 27.9 хувьд хүргэхээр төлөвлөж байна. “Инвескор ББСБ” ХХК нь жижиг, дунд бизнесийн зээлийг нийт багцын 30.5 хувьд, том зээлийг 3.4 хувьд, бусад бизнесийн зээлийг 16.1 хувьд, кредит картын зээлийг 1.4 хувьд хүргэн ажиллахаар төлөвлөж байна.

---

**Зураг 10: Зээлийн багцын чанар, 2018 он**




**Зураг 11: Зээлийн багцын чанар, 2019-2023 он**




2018 оны байдлаар Үнэт цаас гаргагчийн зээлийн багцын чанарын 89.5 хувийг хэвийн зээл, 5.7 хувийг хугацаа хэтэрсэн зээл, 4.8 хувийг чанаргүй зээл эзэлж байна.

Компани зээлийн багцын чанарыг хангах, тогтмол хянах зорилгоор бие даан хөгжүүлсэн зээлийн үйл ажиллагааны бүрэн автоматжуулсан Smart-LOS системийг үйл ажиллагаандаа нэвтрүүлснээр ирэх 5 жилийн хугацаанд зээлийн чанарыг дээрх түвшинд барин ажиллахаар төлөвлөж байна.

---

Компанийн 2018 оны эцсийн байдлаарх зээлийн жинлэсэн дундаж хүүг 2017 оны зээлийн хүүтэй харьцуулахад 0.6 нэгж хувиар буурч 2.9 хувьд хүрсэн бөгөөд цаашид ч мөн зээлийн хүүг тогтмол бууруулах бодлого баримтлан ажиллахаар төлөвлөж байна.

**2023 оны төлөвлөсөн жинлэсэн дундаж хүү**

| | |
|---|---|
| ✓ Бизнес - Том | 2.09% |
| ✓ Бизнесийн зээл | 2.65% |
| ✓ Хэрэглээний зээлийн хүү, шимтгэл | 4.09% |
| ✓ Автомашины зээл | 2.43% |
| ✓ Кредит карт | 1.59% |

Компани нь 2023 он хүртэлх бизнес төлөвлөгөөндөө уламжлалт зээлийн бүтээгдэхүүнийхээ хүүг аажмаар бууруулахаар төлөвлөсөн хэдий ч 2019 оны 9 дүгээр сард зах зээлд нэвтрүүлэхээр төлөвлөж буй финтект суурилсан хэрэглээний бичил зээлийн бүтээгдэхүүний нийт багцад эзлэх хувийг цаашид нэмэгдүүлэх бодлого баримтлахтай

холбоотойгоор нийт зээлийн жинлэсэн дундаж хүү 2020 хүртэл өсөх хандлагатай байхаар байна. Гэсэн хэдий ч компанийн энэхүү хэрэглээний бичил зээлийн хүү, шимтгэлийн түвшин нь зах зээлд нэвтэрсэн бусад ижил төстэй бүтээгдэхүүний дунджаас доогуур байхаар төлөвлөгджээ.

Зураг 12: Жилийн эцсийн ЖДХүү, 2018 он




Зураг 13: Төлөвлөгөөт оны ЖДХүү, 2023 он




Компани нь 2023 он гэхэд хэрэглээний зээлийн багцын нийт зээлд эзлэх хувийг 50 хувьд хүргэхээр төлөвлөсөн.

Зураг 14: Зээлийн багцын төлөвлөлт




Хэдийгээр зах зээл дэх зээлийн хүүгийн түвшин буурах хандлагатай байгаа боловч эдийн засаг, хууль эрхзүйн орчноос хамаарч банк бус санхүүгийн байгууллагууд нь дотоодын зах зээлээс эх үүсвэр татах боломж хязгаарлагдмал, гадна зах зээлээс гадаад валютаар эх үүсвэр бүрдүүлдэг ББСБ-уудын хувьд төгрөгийн ханш голлох валютын эсрэг тасралтгүй суларч байгаа нь зээлийн хүүг богино хугацаанд бууруулах боломжид саад учруулж болохоор байна.

## 3.4.2 ИТГЭЛЦЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

"Инвескор ББСБ" ХХК нь хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний үндсэн дээр итгэмжлэгчээс мөнгөн хөрөнгийг гэрээнд заасан хугацаанд, тодорхой хүүтэйгээр авч ашигладаг бөгөөд энэхүү санхүүгийн эх үүсвэрийг өөрийн бизнесийн үйл ажиллагааг өргөжүүлэхэд буюу зээлийн эх үүсвэрийг нэмэгдүүлэхэд зарцуулдаг.

Компани нь итгэлцлийн үйлчилгээг гүйцэтгэх захирлын баталсан Итгэлцлийн үйлчилгээний журмын дагуу үзүүлдэг бөгөөд уг журмаар итгэлцлийн үйлчилгээний хэлбэрийг тодорхойлох, итгэлцлийн үйлчилгээнд оролцогчдын эрх ашгийг хамгаалах, тэдгээрийн хоорондын харилцааг зохицуулах, хяналт тавих, итгэлцлийн үйлчилгээг эрхлэхэд учирч болзошгүй санхүү, төлбөрийн чадварын эрсдэлээс сэргийлэх, итгэлцлийн үйлчилгээг боловсронгуй болгохтой холбоотой харилцааг зохицуулдаг байна.

Итгэлцлийн үйлчилгээний нөхцөлийг Компанийн зээлийн хорооны хурлаас баталдаг бөгөөд Компани итгэлцлийн үйлчилгээг 6 сараас доошгүй хугацаагаар үзүүлдэг.

Итгэлцлийн үйлчилгээнд талууд дараах үндсэн зарчмыг баримтлан ажиллана. Үүнд:

**Зураг 15: Итгэлцлийн үйлчилгээний 5 зарчим**




**Зураг 16: 2018 оны итгэлцлийн үйлчилгээний дүн, тэрбум төгрөгөөр, жинлэсэн дундаж хүү**




**Зураг 17: 2018-2023 оны итгэлцлийн үйлчилгээний өглөг, тэрбум төгрөг, жинлэсэн дундаж хүү**




2018 оны жилийн эцсийн байдлаар Үнэт цаас гаргагч нь нийт 1.2 тэрбум төгрөгтэй тэнцэх иенийн, 4.0 тэрбум төгрөгтэй тэнцэх ам.долларын болоод 4.7 тэрбум төгрөгийн итгэлцлийн үйлчилгээ үзүүлжээ. Нийт итгэлцлийн үйлчилгээний жинлэсэн дундаж хүү 13.7 хувь буюу төгрөгийнх 19.1%, ам.долларынх 8.8%, иенийнх 8.9% байв.

Үнэт цаас гаргагчийн санхүүгийн тайланд тусгагдсан итгэлцлийн үйлчилгээний өглөгийн үлдэгдэл нь итгэлцлийн үйлчилгээний мөнгөн хөрөнгийн дүн болон хуримтлуулж тооцсон хүүгийн өр төлбөрийг багтаасан байдаг. 2018 онд Үнэт цаас гаргагчийн итгэлцлийн үйлчилгээний үлдэгдэл 10.4 тэрбум төгрөгтэй тэнцэж байна.

2016-2018 онд "Инвескор ББСБ" ХХК-ийн итгэлцлийн үйлчилгээний үлдэгдэл жилд дунджаар 1.2 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Үнэт цаас гаргагч нь ирэх 5 жилийн хугацаанд итгэлцлийн үйлчилгээний үнийн дүнг жилд дунджаар 29.3 хувиар нэмэгдүүлж, 2023 он гэхэд 37.5 тэрбум төгрөгт хүргэхээр зорьж байна. Ингэхдээ эх үүсвэрийг гадаад зах зээлээс татан төвлөрүүлэх стратеги баримталж байгаа юм.

### 3.4.3 ТЕХНОЛОГИЙН ШИЙДЭЛ

**Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем**

Компани нь ББСБ-ын салбарт анхдагч болж **ХУР** системийг үйлчилгээндээ нэвтрүүлснээр харилцагчдад хүндрэл чирэгдэлгүй, түргэн шуурхай үйлчлэхээс гадна, хуурамч мэдээлэлтэй холбоотой эрсдэлийг багасгасан. 2019 оны эхний хагас жилд багтаан төслийн 2 дах шат болох **ДАН** системийг нэвтрүүлснээр зайнаас судалгаа хийх, цахим гарын үсэг ашиглан гэрээ хийх боломжтой болно.

**Зээлийн үйл ажиллагааны бүрэн автоматжуулсан Smart-LOS систем**

“Инвескор ББСБ” ХХК нь үйл ажиллагаагаа хялбаршуулах зорилгоор зээлийн судалгаа, шийдвэр гаргалт, олголт, явцын хяналт, хаалт гэсэн үндсэн 5 үйл явцыг бүрэн автоматжуулсан SMART-LOS зээлийн үйл ажиллагааны дотоод системийг өөрийн охин компани болох “Инвескор Эй Ай Лаб” ХХК-иар дамжуулан хөгжүүлж үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн бөгөөд дараагийн шатны нэмэлт хөгжүүлэлтүүдийг хийж байна.

Зураг 18: **SMART- LOS систем**



Энэхүү систем нь харилцагчийн тухай мэдээллийг 19-22 төрлийн эх сурвалж (database) уруу автоматаар хандан авч, анхан шатны боловсруулалт хийн, маягт, тайлан, зээлийн судалгааны тайлан хэлбэрээр бэлтгэж, зээлийн шийдвэр гаргахад бэлэн болгодог. Компанийн тооцоолсноор энэ нь зээлийн эдийн засагчийн хийдэг механик ажлыг **75 хувиар** багасгаж, ажлын бүтээмжийг эрс нэмэгдүүлж байгаа ба хүнээс шалтгаалсан алдаа гарах нөхцөлийг бүрэн хаах боломжийг бий болгосон.
Энэхүү системийг нэвтрүүлснээр өмнө нь бүртгэж чаддаггүй байсан олон төрлийн мэдээллийг эмх цэгцтэйгээр бүртгэх боломж бий болсноос гадна тухайн мэдээлэлд үндэслэн дата анализ хийж, үйл ажиллагааг сайжруулах, зээлийн үнэлгээний системийн оновчлолыг нэмэгдүүлэх, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг гаргах боломж бүрдсэн.

Мөн Компанийн үзэж байгаагаар тус системийн дараагийн түвшний хөгжүүлэлт хийгдсэнээр зээлдэгчийн явцын хяналтыг долоо хоног тутамд автоматаар хийж, бүх зээлдэгчдийг үр ашигтайгаар хянах боломжтой болно.

СЗХ 2019 .04 .24 өдөр БҮРТГЭВ № 01



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2019-02-26

Зураг 19: SMART-LOS систем хэрхэн ажилладаг вэ?

| Зээлийн судалгаа | Шийдвэр гаргалт | Олголт | Явцын хяналт | Хаалт |
|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 |
| Харилцагчийн тухай мэдээллийг 19-22 төрлийн эх сурвалж (database) руу автоматаар хандан авч, анхан шатны боловсруулалт хийн, маягт, тайлан, зээлийн судалгааны тайлан хэлбэрээр бэлдэж, шийдвэр гаргахад бэлэн болгодог. | 1-р шатанд бэлэн болсон мэдээллийг үндэслэн зээлийн хэмжээнээс хамаарч Салбарын захирал, Гүйцэтгэх захирал, Зээлийн хороо болоод ТУЗ зээл олгох эсэх шийдвэрийг системээр нэвтрэн гаргадаг байна. | Энэ шатанд харилцагчдаас баталгаажуулах шаардлагатай бичиг баримтуудыг хүлээн авч системд оруулах бөгөөд нэр шилжүүлэх албан тоот болон харилцагчтай байгуулах гэрээг системээс автоматаар гаргаж, зээлийн олголт хийгдэнэ. | 4-р шатанд энэхүү систем нь олгосон зээлийг тодорхой хугацааны давтамжтайгаар автоматаар хянаж, анхаарал хандуулах шаардлагатай зээлүүдэд анхааруулах дохио өгнө. | Зээлийн эргэн төлөлт бүрэн хийгдсэн үед харилцагчийн барьцаа хөрөнгийг чөлөөлөх, зээлийг хаах үйл ажиллагаа хийгдэнэ. |

## 3.5 ДУНД ХУГАЦААНЫ СТРАТЕГИ

### 3.5.1 ЗАХ ЗЭЭЛИЙН СТРАТЕГИ

"Инвескор ББСБ" ХХК нь дотоод болон гадаад зах зээлд дараах стратегийг баримтлан ажиллахаар төлөвлөж байна.

- ✓ **Гадаад стратеги: "Financial export"**

Монгол Улсын зах зээлд туршигдсан үйл ажиллагааны ноу-хау, финтек бүтээгдэхүүний шийдлүүдийг өндөр хөгжилтэй орнуудаас татах бага зардалтай эх үүсвэртэй хослуулан Япон болон Төв Ази, Зүүн Өмнөд Азийн улсуудын зах зээлд нэвтэрч, улмаар 3 улсад 5 салбар, компани байгуулахаар төлөвлөж байна.

- ✓ **Дотоод стратеги: "Smart Expansion"**

Үр дүнтэй хөрөнгө оруулалт, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх замаар дотоодын зах зээлд бага зардлаар, өндөр үр ашигтай ажиллах бүтцийг бий болгох ба энэ стратегийн хүрээнд ирэх 5 жилийн хугацаанд дотооддоо 7 салбарыг нээхээр зорилт тавин ажиллаж байна.

Хүснэгт 20: Шинээр нээх салбарын тоо

| | 2019 | 2020 | 2021 | 2022 | 2023 |
|---|---|---|---|---|---|
| **Шинээр нээх салбарын тоо** | 5 | 3 | 2 | 1 | 1 |

TDB CAPITAL LLC



"ИНВЕСКОР ББСБ" ХХК InvesCore NON BANK FINANCIAL INSTITUTION УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2019 03 26 БҮРТГЭВ-02

СЗХ 2019 .04. 24

Үнэт цаас гаргагчийн зорилтот зах зээлийн томоохон төлөөлөл нь санхүүжилт шаардлагатай жижиг, дунд бизнес эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагууд болон иргэд бөгөөд Компани зээлийн багцынхаа 50 хувийг бизнесийн зээл, 50 хувийг хэрэглээний зээлээр бүрдүүлэхээр зорьж байна.

Үнэт цаас гаргагч нь уламжлалт банк бус санхүүгийн зах зээлийн гол бүтээгдэхүүн болох бизнесийн зээл болон хэрэглээний зээлийн бүтээгдэхүүнийхээ давуу байдлыг бататгахын тулд зээлийн судалгаа, олголтын механик ажиллагааг автоматжуулснаар зээлийн мэргэжилтнүүдээ харилцагчийн үйлчилгээ болон бизнесийн зөвлөгөө өгөх чиглэлээр мэргэшүүлж ажиллуулахаар төлөвлөж байна. Ингэснээр хэрэглэгчийн үйлчилгээний стандарт улам бүр сайжрах бөгөөд сэтгэл ханамжийг дээшлүүлэх замаар хэрэглэгчийн бааз суурийг нэмэгдүүлнэ.

Үнэт цаас гаргагч нь харилцагчдадаа бизнесийн сургалт, боловсрол олгох, бизнесийн зөвлөх үйлчилгээ, бизнес эрхлэгчдийг хооронд нь танилцуулах, шууд холбогдох боломжоор хангах зорилгын хүрээнд 2019 онд Сургалтын академиа байгуулахаар төлөвлөж байна. Энэхүү академи нь харилцагчдын бааз суурийг нэмэгдүүлэхээс гадна, зээлийн эрсдэлийг бууруулах боломжтой.

### 3.5.2 ХИЙМЭЛ ОЮУН УХААН БОЛОН ФИНТЕКТ СУУРИЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН ХӨГЖҮҮЛЭЛТ

Үнэт цаас гаргагчийн охин компани болох "Инвескор Эй Ай Лаб" ХХК нь Япон Улсын "Toyota" корпорацийн хүнгүй машины төслийг хэрэгжүүлэгч "Liberra" компанитай хамтран Үнэт цаас гаргагчийн SMART-LOS зээлийн үйл ажиллагааны системд зээлийн судалгаа хэсгийн чухал үе шат болох зээлийн үнэлгээ (Credit Scoring) хэсгийн хөгжүүлэлтийг хийж байна. Мөн Компани энэхүү системийн хяналтын үйл явцыг сайжруулах, бичил зээлийн аппликэйшн хөгжүүлэх ажлуудыг гүйцэтгэж байна.

**Хүснэгт 21: Финтект суурилсан бүтээгдэхүүн хөгжүүлэлт**

| Хөгжүүлж буй программ, хангамж | Хөгжүүлэгч | Зорилго |
|---|---|---|
| SMART-LOS зээлийн судалгааны системийн Зээлийн үнэлгээ (Credit scoring) | ✓ "Инвескор Эй Ай Лаб" ХХК;<br>✓ Япон Улсын "Liberra" компани | ✓ Хиймэл оюун ухааны алгоритмыг ашиглан зээлийн үнэлгээний оновчлолыг нэмэгдүүлэх |
| SMART-LOS зээлийн судалгааны системийн Зээлийн явцын хяналт | ✓ "Инвескор Эй Ай Лаб" ХХК | ✓ Олгосон зээлийг долоо хоног тутамд автоматаар хянаж, харилцагчид зээл олгох шийдвэр гаргахад нөлөөлсөн үндсэн мэдээллүүдэд ач холбогдол бүхий өөрчлөлт орсон тохиолдолд дохио өгөх |
| Бичил зээлийн аппликэйшн | ✓ "Инвескор Эй Ай Лаб" ХХК | ✓ Гар утасны аппликэйшнээр дамжуулан бичил зээлийг түргэн шуурхай олгох |

ТИ ДИ БИ КАПИТАЛ ХХК TDB CAPITAL LLC

"ИНВЕСКОР ББСБ" ХХК InvesCore NON-BANK FINANCIAL INSTITUTION УЛААНБААТАР ХОТ

### 3.5.3 ШИНЭЭР ЗАХ ЗЭЭЛД НЭВТРҮҮЛЭХ БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ

Хүснэгт 22: Шинээр зах зээлд нэвтрүүлэх бүтээгдэхүүн, үйлчилгээ

| Бүтээгдэхүүн, үйлчилгээ | Харилцагчийн сегмент | Стратеги |
|---|---|---|
| **Жижиг, дунд бизнесийн зээл** | Жижиг, дунд бизнес эрхлэгчид | Жижиг, дунд бизнес эрхлэгч нарт зориулсан “SMB хөтөлбөр”, зөвлөгөө үйлчилгээ; |
| **Төлбөрийн баталгаа, факторинг, санхүүгийн зуучлал** | Жижиг, дунд бизнес эрхлэгчид | Финтек ашиглан Банк бус санхүүгийн салбарт нэвтрээгүй байсан шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгох; |
| **Бичил зээл** | Хувь хүн | Финтек ашиглан бүрэн автомат бичил зээлийн аппликэйшн нэвтрүүлэх; |
| **Төлбөр тооцоо, шилжүүлэг** | Жижиг дунд бизнес эрхлэгчид, хувь хүн | Финтек ашиглан цахим мөнгөний гүйлгээ, төлбөр тооцооны систем нэвтрүүлэх. |

### 3.5.4 МАРКЕТИНГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Өнгөрсөн хугацаанд “Инвескор ББСБ” ХХК нь сувгийн маркетинг буюу салбарууд дээрх маркетингад түлхүү анхаарч ажиллаж ирсэн байна. Компани 2019 оноос эхлэн маркетингийн стратеги төлөвлөгөөний дагуу олон нийтэд хандсан брэнд маркетинг, бүтээгдэхүүний маркетингдаа илүү анхаарал хандуулж ажиллахаар төлөвлөж байна.

Банк болон банк бус санхүүгийн байгууллагын хувьд зээлийн хүү хамгийн чухал үзүүлэлт байдаг бөгөөд харилцагчдын шийдвэрт шууд нөлөөлдөг. Иймд Үнэт цаас гаргагч нь салбартаа тэргүүлэгч банк бус санхүүгийн байгууллагуудын тоонд зүй ёсоор багтдагийн хувьд зах зээлд өрсөлдөх чадвартай хүүг харилцагчдадаа санал болгож ажиллахаар төлөвлөж байна.

Мөн түүнчлэн харилцагчдын ББСБ-ыг сонгох голлох шалтгааны нэг нь зээл судлах хугацаа байдаг. Үнэт цаас гаргагч нь зээлийн үйл ажиллагааны бүрэн автомат Smart-LOS системийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн, уламжлалт зээлийн бүтээгдэхүүн санал болгох үйл явцыг хурдасгасан нь маш том давуу талыг бий болгож байна. Мөн “Инвескор ББСБ” ХХК нь өөрийн бие даан хөгжүүлж буй бичил зээлийн аппликэйшнийг зах зээлд нэвтрүүлэхээр төлөвлөж байгаа нь энэхүү давуу талуудыг улам илүү тодотгож байна.

Хүснэгт 23: Маркетингийн төлөвлөгөө

| Зорилго | Маркетингийн төлөвлөгөө |
|---|---|
| **Найдвартай харилцагчидтай урт хугацааны харилцаа холбоог бэхжүүлэх** | Найдвартай харилцагчдын хүрээнд урамшуулал, бонусын системийг нэвтрүүлж, лоялти хөтөлбөрийг шинээр санаачлан хэрэгжүүлэх; |
| **Бүтээгдэхүүн үйлчилгээнийхээ нэр хүнд, чанарыг дээшлүүлэх** | Шинэ бүтээгдэхүүн үйлчилгээнээс гадна зах зээлд нэвтэрсэн, харилцагчдад танигдсан бүтээгдэхүүн үйлчилгээний нөхцөлийг сайжруулах; |
| **Байгууллагын имижийг хөгжүүлэх, төлөвшүүлэх, хэвшүүлэх** | Байгууллагын ЗӨВ имижийг бүрдүүлэх, хөгжүүлэх, төлөвшүүлэх, хэвшүүлэх; |

| | |
|---|---|
| **Нийгмийн хариуцлага** | Нийгэмд чиглэсэн, мөн хүүхэд залуучуудын боловсролд чиглэсэн төсөл хөтөлбөрүүдийн санхүүжилтийг бүрдүүлэх үйл ажиллагааг нийгмийн хариуцлагатай уялдуулан зохион байгуулах. |

Үнэт цаас гаргагч нь нийгмийн сүлжээгээр дамжуулан дараах төрлийн дижитал маркетинг хийхээр төлөвлөж байна.

**Зураг 20: Харилцагчдад зориулсан дижитал маркетингийн сувгууд**




| Харилцааны маркетинг буюу Conversional Marketing | Шууд бичлэг буюу Video Live | Дижитал түүх буюу Digital Storytelling | "SMB TOOLKIT" цахим хуудас болон аппликэйшн |
|---|---|---|---|
| Харилцагч нэг бүртэй шууд харилцаж хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад тохирсон бүтээгдэхүүн үйлчилгээг санал болгох. Үүнд, харилцагч бүрт тохирсон харилцааны хэрэгслийг ашиглах (Утсан харилцаа, Facebook messenger, Viber, WeChat, Twitter) | Олон харилцагчидтай нэгэн зэрэг санал солилцох хүндрэлтэй байдаг тул сүүлийн үед өргөн хэрэглэгдэх болсон мессенжер, чатбот зэргээр дамжуулан тусгай сургалт, мэдээллийг шууд бичлэг (video live) хийж нийтэд түгээх | Харилцагчийн амжилтын тухай нэвтрүүлэг, видео, кэйс, судалгаа, ярилцлага, нийтлэл мэдээ гэх мэт арга хэлбэрийг ашиглах | Жижиг дунд бизнес эрхлэгчдэд зориулсан анхан шатны зөвлөх үйлчилгээг цахим болон мобайл хэлбэрээр хүргэх боломжтой |

# Санхүүгийн үйл ажиллагаа




СЗХ
2019 .04. 24-ний
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
26

TDB CAPITAL LLC

"ИНВЕСКОР БББС" ХХК
InvesCore

## 4.1 АУДИТЫН ДҮГНЭЛТ

"БДО Аудит" ХХК нь "Инвескор ББСБ" ХХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр тасалбар болсон жилийн ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж, дүгнэлт гаргасан байна.

Аудитын дүгнэлтээр, санхүүгийн тайлангууд нь Компанийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал, санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаараа СТОУС-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн гэж дүгнэсэн байна.

"БДО Аудит" ХХК нь "Инвескор ББСБ" ХХК болон түүний охин компани болох "Инвескор Эй Ай Лаб" ХХК-ийг хамруулсан группийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр тасалбар болсон жилийн нэгтгэсэн ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгаас бүрдсэн нэгтгэсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж, дүгнэлт гаргасан байна.

Аудитын дүгнэлтээр, Группийн нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь Компанийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн нэгтгэсэн санхүүгийн байдал, нэгтгэсэн санхүүгийн гүйцэтгэл болон нэгтгэсэн мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаараа СТОУС-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн гэж дүгнэсэн байна.

## 4.2 ОРЛОГЫН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

### 4.2.1 ОРЛОГЫН ТАЙЛАНГИЙН ТҮҮХЭН ҮЗҮҮЛЭЛТ

**Хүснэгт 24: Орлогын тайлангийн үзүүлэлт**

| | Аудитлагдсан | | | Төлөвлөлт* |
|---|---|---|---|---|
| **Үзүүлэлт (тэрбум төгрөгөөр)** | **2016** | **2017** | **2018** | **2019** |
| Хүү болон түүнтэй адилтгах орлого | 0.7 | 4.5 | 10.8 | 19.0 |
| Хүү болон түүнтэй адилтгах зардал | (0.2) | (0.7) | (2.6) | (4.4) |
| **Хүүгийн цэвэр орлого** | **0.5** | **3.8** | **8.2** | **14.6** |
| Хүүгийн бус цэвэр орлого | 0.1 | 0.1 | 0.4 | 0.6 |
| **Үйл ажиллагааны орлого** | **0.62** | **3.95** | **8.62** | **15.2** |
| Ажиллагсадтай холбогдолтой зардал | (0.1) | (0.3) | (0.9) | (2.1) |
| Үйл ажиллагааны бусад зардал | (0.0) | (0.2) | (0.6) | (1.9) |
| **Зээлийн үнэ цэнийн бууралтын өмнөх ашиг, (алдагдал)** | **0.5** | **3.4** | **7.1** | **11.2** |
| Зээлийн үнэ цэнийн бууралтын зардал | (0.1) | (0.3) | (1.0) | (1.1) |
| **Татварын өмнөх ашиг** | **0.4** | **3.1** | **6.2** | **10.1** |
| Орлогын албан татвар | (0.0) | (0.3) | (1.1) | (2.2) |
| **Цэвэр ашиг (алдагдал)** | **0.4** | **2.7** | **5.1** | **7.9** |
| Ирээдүйд ашиг алдагдлаар ангилагдаж болзошгүй эрсдэлийн сангийн нөөц | - | (0.1) | - | - |
| **Нийт дэлгэрэнгүй орлого (алдагдал)** | **0.4** | **2.6** | **5.1** | **7.9** |

***Дэлгэрэнгүй төлөвлөлтийг 4.2.3 хэсгээс харна уу**

## 4.2.2 ОРЛОГЫН ТАЙЛАНГИЙН ШИНЖИЛГЭЭ

Зураг 21: Хүү болон түүнтэй адилтгах орлого




Хүү болон түүнтэй адилтгах орлого нь 2017 онд 3.8 тэрбум төгрөг буюу 572.7 хувиар, 2018 онд 6.3 тэрбум төгрөг буюу 141.1 хувиар тус тус өссөн байна.

2018 оны байдлаар орлогын 99.9 хувийг зээлийн хүүгийн орлого, 0.1 хувийг нь харилцах дансны хүүгийн орлого эзэлж байна.

Зураг 22: Хүү болон түүнтэй адилтгах зардал




Хүү болон түүнтэй адилтгах зардал нь 2017 онд 499.7 сая төгрөг, 2018 онд 1.9 тэрбум төгрөгөөр тус тус өсжээ.

2018 оны байдлаар зардлын 67.4 хувийг зээлийн хүүгийн зардал, 32.6 хувийг итгэлцлийн үйлчилгээний зардал эзэлж байна.

Зураг 23: Хүүгийн цэвэр орлого болон үйл ажиллагааны орлого




Хүүгийн цэвэр орлого нь 2017 онд 3.3 тэрбум төгрөг буюу 679.4 хувиар өссөн бол 2018 онд 4.4 тэрбум төгрөг буюу 116.4 хувиар өссөн байна. Хүүгийн цэвэр орлогын хүү болон түүнтэй адилтгах орлогод харьцуулсан хувь 2018 онд 76.2 хувьтай байна.

Үйл ажиллагааны орлого нь 2017 онд 3.3 тэрбум төгрөг буюу 534.8 хувиар, 2018 онд 4.7 тэрбум төгрөг буюу 118.4 хувиар өссөн байна. Үйл ажиллагааны орлогыг хүү болон түүнтэй адилтгах орлогод харьцуулсан хувь 2018 онд 79.9 хувьтай байна.

СЗХ 2019 04 2 БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2019-03-26 БҮРТГЭВ-02

**Зураг 24: Компанийн зардлын бүтэц**




Компанийн нийт зардал нь 2017 онд 401 сая төгрөгөөс, 1.9 тэрбум төгрөг болж 1.5 тэрбум төгрөгөөр өссөн бол 2018 онд 4.3 тэрбум төгрөгөөр нэмэгджээ.

Зардлын бүтцийн хувьд 2018 онд 2.6 тэрбум төгрөг буюу нийт зардлын 41.9 хувь нь хүү болон түүнтэй адилтгах зардал, 1.5 тэрбум төгрөг буюу 24.0 хувь нь үйл ажиллагааны зардал, 972 сая төгрөг буюу 15.8 хувь нь зээлийн үнэ цэнийн бууралтын зардал буюу зээлийн эрсдэлийн сан байгуулахтай холбоотой зардал, 1.1 тэрбум төгрөг нь орлогын албан татварын зардал тус тус байна.

Хүү болон түүнтэй адилтгах зардал нь компанийн итгэлцлийн үйлчилгээний өглөг болон банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл өссөнтэй холбоотойгоор нэмэгдсэн бол үйл ажиллагаа өргөжсөнтэй холбоотойгоор үйл ажиллагааны зардал, зээлийн багцын өсөлт болон багцад зээлж буй хэвийн бус зээлийн өөрчлөлттэй холбоотойгоор зээлийн үнэ цэнийн бууралтын зардлууд тус тус өссөн байна. Ашигт ажиллагаа нэмэгдсэнтэй холбоотойгоор орлогын албан татварын зардал нэмэгджээ.

**Зураг 25: Компанийн ашигт ажиллагаа**




Компанийн цэвэр ашиг 2017 онд 2.3 тэрбум төгрөг буюу 2016 онтой харьцуулахад 585.4 хувиар өссөн бол 2018 онд мөн 2.3 тэрбум төгрөгөөр 84.7 хувиар өссөн байна.

Хүү болон түүнтэй адилтгах орлогод харьцуулсан цэвэр ашгийн хувь нь 2018 оны байдлаар 46.8 хувьтай байна.

TDB CAPITAL LLC
"ИНВЕСКОР ББСБ" ХХК InvesCore NON BANK FINANCIAL INSTITUTION УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE

### 4.2.3 ОРЛОГЫН ТАЙЛАНГИЙН ТӨСӨӨЛӨЛ

Хүснэгт 25: Орлогын тайлангийн төсөөлөл

| | Аудит* | Төлөвлөлт | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| **Үзүүлэлт (тэрбум төгрөгөөр)** | **FY18** | **FY19** | **FY20** | **FY21** | **FY22** | **FY23** |
| Хүү болон түүнтэй адилтгах орлого | 10.8 | 19.0 | 35.6 | 51.6 | 60.4 | 68.1 |
| Хүү болон түүнтэй адилтгах зардал | (2.6) | (4.4) | (7.1) | (9.7) | (9.8) | (8.8) |
| **Хүүгийн цэвэр орлого** | **8.2** | **14.6** | **28.4** | **41.9** | **50.6** | **59.3** |
| Хүүгийн бус цэвэр орлого | 0.4 | 0.6 | 0.9 | 1.2 | 1.4 | 1.6 |
| **Үйл ажиллагааны орлого** | **8.6** | **15.2** | **29.4** | **43.1** | **52.0** | **61.0** |
| Ажиллагсадтай холбогдолтой зардал | (0.9) | (2.1) | (2.8) | (3.4) | (3.9) | (4.4) |
| Үйл ажиллагааны бусад зардал | (0.6) | (1.9) | (2.4) | (2.5) | (2.7) | (2.8) |
| **Зээлийн үнэ цэнийн бууралтын өмнөх ашиг, (алдагдал)** | **7.1** | **11.2** | **24.2** | **37.2** | **45.4** | **53.8** |
| Зээлийн үнэ цэнийн бууралтын зардал | (1.0) | (1.1) | (1.7) | (1.3) | (1.1) | (1.1) |
| **Татварын өмнөх ашиг** | **6.2** | **10.1** | **22.5** | **35.9** | **44.3** | **52.7** |
| Орлогын албан татвар | (1.1) | (2.2) | (5.3) | (8.7) | (10.8) | (12.9) |
| **Цэвэр ашиг (алдагдал)** | **5.1** | **7.9** | **17.2** | **27.3** | **33.5** | **39.8** |

***Аудитын тайлангийн мэдээллийг 4.2.1 хэсгээс харна уу**

### 4.2.4 ДУНД ХУГАЦААНЫ ОРЛОГЫН ТАЙЛАНГИЙН ТӨСӨӨЛЛИЙН ШИНЖИЛГЭЭ

Зураг 26: Хүү болон түүнтэй адилтгах орлого




Үнэт цаас гаргагчийн хүүгийн цэвэр орлого нь 2018-2023 онуудад дунджаар 44.5 хувиар өсөхөөр дунд хугацааны бизнес төлөвлөгөөнд тусгасан байна.

Компанийн харилцагчдад олгосон зээлийн багцын хэмжээ өсөхөөр нийт хүү болон түүнтэй адилтгах орлогын хэмжээ нэмэгдэхээр төлөвлөгдөж байна.

Зураг 27: Хүү болон түүнтэй адилтгах зардал




Хүү болон түүнтэй адилтгах зардал нь 2018-2023 онуудад дунджаар 27.8 хувиар өсөхөөр төлөвлөгөөнд тусгагдсан байна.

Хүү болон түүнтэй адилтгах зардал нь банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл болон итгэлцлийн үйлчилгээний өглөгийн өсөлттэй холбоотойгоор нэмэгдэхээр төлөвлөгдөж байна.

СЗХ
2019.04.24
ТИ ДИ БИ КАПИТАЛ ҮЦК ХХК
TDB CAPITAL LLC
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2019 03 26
БҮРТГЭВ-02



**Зураг 28: Хүүгийн орлого, зардал**




Хүү болон түүнтэй адилтгах орлогыг зээлийн дундаж багцтай харьцуулахад 2017 онд 41.1 хувь, 2018 онд 41.2 хувь байсан бөгөөд 2019-2023 онд буурсаар 35.7 хувь хүрэхээр төлөвлөсөн байна.

Хүү болон түүнтэй адилтгах зардал нь зээлийн хүүгийн болон итгэлцлийн үйл ажиллагааны зардлуудаас бүрдэх бөгөөд тухайн зардлуудын холбогдох өглөгийн дундажтай харьцуулсан хувийг графикаас харж болно.

Компанийн цэвэр хүүгийн маржин дараагийн 5 жилд дунджаар 28.0 хувь байхаар төсөөлөгдсөн байна.

**Зураг 29: Үйл ажиллагааны зардал, хүүгийн орлогын харьцаа**




2019 онд компани үйл ажиллагаагаа өргөжүүлэхтэй холбоотойгоор ажиллагсадтай холбоотой зардал буюу цалингийн зардал, мөн үйл ажиллагааны бусад зардлын дийлэнх хэсгийг эзэлж буй түрээсийн зардал болон маркетингийн үйл ажиллагааны зардлууд өсөхөөр төлөвлөсөн байна.

**Зураг 30: Цэвэр ашиг, цэвэр ашгийн хувь**




Цэвэр ашиг нь 2018-2023 онуудад дунджаар 51.1 хувиар өсөхөөр төлөвлөгөөнд тусгасан байна.

Цэвэр ашгийн хувийн өсөлтийн дийлэнх хэсэг нь хүү болон түүнтэй адилтгах зардлын орлогод эзлэх хувь буурсантай холбоотой байна. Компанийн хүү тооцогдох өр төлбөрийн нийт эх үүсвэрт эзлэх хувь буурах нь ашигт ажиллагааг сайжруулах төлөвтэй байна.

"ИНВЕСКОР ББСБ" ХХК
InvesCore
УЛААНБААТАР ХОТ

СЗХ 2019.04.24 өдөр БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2019.03.26 БҮРТГЭВ-02

## 4.3 САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

### 4.3.1 САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАНГИЙН ТҮҮХЭН ҮЗҮҮЛЭЛТ

**Хүснэгт 26: Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан**

| | Аудитлагдсан | | | Төлөвлөлт* |
|---|---|---|---|---|
| **Үзүүлэлт (тэрбум төгрөгөөр)** | **2016** | **2017** | **2018** | **2019** |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | 0.2 | 1.1 | 2.3 | 3.1 |
| Цэвэр зээл | 4.3 | 17.9 | 34.9 | 65.0 |
| Өмчлөх бусад хөрөнгө | - | 0.5 | 0.4 | 0.7 |
| Бусад хөрөнгө | 0.0 | 0.0 | 0.8 | 7.2 |
| Үндсэн болон биет бус хөрөнгө – цэвэр | 0.0 | 0.1 | 0.6 | 2.8 |
| **Нийт хөрөнгө** | **4.6** | **19.6** | **39.0** | **78.8** |
| Итгэлцлийн үйлчилгээний өглөг | 2.1 | 2.5 | 10.4 | 18.6 |
| Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл | - | 7.9 | 13.9 | 14.4 |
| Бусад өр төлбөр | 0.0 | 0.4 | 0.9 | 6.0 |
| **Өр төлбөрийн дүн** | **2.2** | **10.8** | **25.1** | **38.9** |
| Дүрмийн сан ба НТК | **2.0** | 6.1 | 6.1 | 32.0** |
| Хуримтлагдсан ашиг | **0.4** | 2.6 | 7.8 | 7.9 |
| Бусад эздийн өмч | - | 0.1 | 0.0 | - |
| **Эздийн өмч** | **2.4** | **8.8** | **13.9** | **39.9** |

***Дэлгэрэнгүй төлөвлөлтийг 4.3.3 хэсгээс харна уу.**

****СЗХ-ны 2019 оны 02 дугаар сарын 25-ны 118 дугаарт тогтоолоор дүрмийн санг 7.7 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж 13.8 тэрбум төгрөг болгож өсгөсөн дүн орсон болно.**

### 4.3.2 САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАНГИЙН ШИНЖИЛГЭЭ

**Зураг 31: Нийт хөрөнгө, Эх үүсвэрийн бүтэц**




Компанийн нийт хөрөнгө 2017 онд 15.1 тэрбум төгрөг буюу 331.6 хувиар, 2018 онд 19.4 тэрбум төгрөг буюу 98.7 хувиар тус тус өсжээ.

2018 оны байдлаар нийт хөрөнгийн 64.4 хувийг өр төлбөр, 35.6 хувийг эздийн өмч бүрдүүлж байна.

TDB CAPITAL LLC
"ИНВЕСКОР ББСБ" ХХК InvesCore NON BANK FINANCIAL INSTITUTION УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2019.04.24 өдөр
БҮРТГЭВ
№ 31



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2019-03-26
БҮРТГЭВ-02

**Зураг 32 Нийт хөрөнгийн бүтэц**




2018 оны байдлаар нийт хөрөнгийн 89.3 хувийг харилцагчдад олгосон зээл эзэлж байна. Зээлийн багц нь 2017 онд 13.6 тэрбум төгрөгөөр буюу 315.9 хувиар, 2018 онд 17.0 тэрбум төгрөгөөр буюу 95.2 хувиар өсжээ.

2018 онд Компани 2 салбар нээсэнтэй холбоотойгоор тавилга, эд хогшилд хийсэн хөрөнгө оруулалт, мөн зээл олголтын үйл ажиллагааны LOS системийн хөгжүүлэлттэй холбоотойгоор биет болон биет бус хөрөнгө 0.5 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

**Зураг 33: Зээлийн багцын бүтэц**




2018 онд компанийн зээлийн багцын 47.0 хувийг хэрэглээний зээл, 53.0 хувийг бизнесийн зээл бүрдүүлж байна. Бизнесийн зээлийн дийлэнх хэсгийг хувь хүнд олгосон бизнесийн зээл эзэлж байгаа ба 2018 онд 3.3 тэрбум төгрөгөөр өсөж, 10.9 тэрбум төгрөгт хүрсэн байна.

2018 онд Автомашины зээл 13.4 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь хэрэглээний зээлийн эзлэх хувийг нэмэгдүүлсэн байна.

**Зураг 34: Эздийн өмчийн бүтэц**




Компанийн эздийн өмч 2017 онд 6.4 тэрбум төгрөг буюу 268.3 хувиар, 2018 онд 5.1 тэрбум төгрөг буюу 57.2 хувиар өссөн байна. Компани 2017 онд дүрмийн сангаа 4.1 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлжээ.

2018 оны эцсийн байдлаар эздийн өмчийн 56.1 хувийг хуримтлагдсан ашиг 43.9 хувийг дүрмийн сан бүрдүүлж байна.

TDB CAPITAL LLC

"ИНВЕСКОР ББСБ" ХХК
InvesCore
УЛААНБААТАР ХОТ

**Зураг 35: Өр төлбөрийн бүтэц**




Компанийн өр төлбөр 2017 онд 8.7 тэрбум төгрөг буюу 402.1 хувиар, 2018 онд 14.3 тэрбум төгрөг буюу 132.6 хувиар өссөн байна.

Бүтцийн хувьд 2018 онд нийт өр төлбөрийн 55.2 хувь нь банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл (хөрөнгө оруулагчийн зээлийг оролцуулан), 41.3 хувь нь итгэлцлийн үйлчилгээний өглөг 3.5 хувь нь бусад өр төлбөр байна.

**Зураг 36: Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл**




Компани 2016 онд банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлгүй байсан бөгөөд 2017 онд 7.9 тэрбум төгрөг, 2018 онд 6.0 тэрбум төгрөгөөр зээлийн хэмжээ нэмэгджээ.

Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн дийлэнх хэсгийг хөрөнгө оруулагчийн зээл эзэлж байна. Тус зээл нь 2017 онд “Эс Ай Би Жэй Капитал” ХХК-тай байгуулсан 15 жилийн хугацаатай, 25.0 тэрбум төгрөгийн зээлийн эрхийн гэрээний хүрээнд авсан зээл байна.

Зураг 37: **Итгэлцлийн үйлчилгээний өглөг**




Итгэлцлийн үйлчилгээний өглөг нь 2017 онд 0.4 тэрбум төгрөг буюу 18.9 хувиар, 2018 онд 7.9 тэрбум төгрөг буюу 313.7 хувиар тус тус өсжээ.

2018 оны байдлаар өглөгийн дийлэнх хэсэг буюу 64.0 хувийг иргэдийн итгэлцлийн үйлчилгээний өглөг эзэлж байгаа бол 31.1 хувийг хуулийн этгээд, үлдсэн 4.9 хувийг хүүгийн өглөг эзэлж байна.

### 4.3.3 САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАНГИЙН ДУНД ХУГАЦААНЫ ТӨСӨӨЛӨЛ

**Хүснэгт 27: Санхүүгийн байдлын тайлангийн төсөөлөл**

| | Аудит* | Төлөвлөлт | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| **Үзүүлэлт (тэрбум төгрөгөөр)** | **FY18** | **FY19** | **FY20** | **FY21** | **FY22** | **FY23** |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | 2.3 | 3.1 | 5.8 | 6.6 | 6.6 | 6.2 |
| Цэвэр зээл | 34.9 | 65.0 | 112.3 | 147.4 | 178.8 | 210.8 |
| Өмчлөх бусад хөрөнгө | 0.4 | 0.7 | 1.2 | 1.5 | 1.6 | 1.6 |
| Бусад хөрөнгө | 0.8 | 7.2 | 7.2 | 7.2 | 7.2 | 7.2 |
| Үндсэн болон биет бус хөрөнгө – цэвэр | 0.6 | 2.8 | 3.0 | 2.6 | 2.3 | 1.9 |
| **Нийт хөрөнгө** | **39.0** | **78.8** | **129.4** | **165.3** | **196.4** | **227.8** |
| Итгэлцлийн үйлчилгээний өглөг | 10.4 | 18.6 | 43.8 | 49.8 | 45.9 | 37.5 |
| Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл | 13.9 | 14.4 | 19.4 | 19.4 | 19.4 | 19.4 |
| Бусад өр төлбөр | 0.9 | 6.0 | 9.2 | 13.2 | 17.2 | 21.1 |
| **Өр төлбөрийн дүн** | **25.1** | **38.9** | **72.4** | **82.4** | **82.5** | **78.0** |
| Дүрмийн сан ба НТК | 6.1 | 32.0 | 32.0 | 32.0 | 32.0 | 32.0 |
| Хуримтлагдсан ашиг | 7.8 | 7.9 | 25.1 | 51.0 | 82.0 | 117.8 |
| **Эздийн өмч** | **13.9** | **39.9** | **57.0** | **82.9** | **113.9** | **149.8** |

***Аудитын тайлангийн мэдээллийг 4.3.1 хэсгээс харна уу.**

### 4.3.4 САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАНГИЙН ДУНД ХУГАЦААНЫ ТӨСӨӨЛЛИЙН ШИНЖИЛГЭЭ

**Зураг 38: Нийт хөрөнгө, Эх үүсвэрийн бүтэц**




Компанийн нийт хөрөнгө нь 2018-2023 онуудад дунджаар 42.3 хувийн өсөлттэй байхаар төлөвлөгөөнд тусгагдсан ба өр төлбөр болон эздийн өмч нь дунд хугацаанд 25.4 хувь болон 60.9 хувиар тус тус өсөхөөр байна.

2023 онд нийт хөрөнгийн эх үүсвэрийн бүтцийн хувьд авч үзвэл 34.2 хувь нь өр төлбөр, 65.8 хувь нь эздийн өмчөөс бүрдэж байна.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ-02

**Зураг 39: Харилцагчдад олгосон зээл – цэвэр дүнгээр**




Харилцагчдад олгосон цэвэр зээл нь 2018 оны байдлаар нийт хөрөнгийн 89.3 хувийг эзэлж байгаа ба 2018-2023 онуудад дунджаар 43.3 хувиар өсөхөөр төлөвлөгөөнд тусгасан байна.

2023 оны төлөвлөгөөний дагуу цэвэр зээлийн дүн 210.8 тэрбум төгрөг байхаас 205.4 тэрбум төгрөг нь нийт олгосон зээл, 13.0 тэрбум төгрөг нь зээлийн хүүгийн авлага байх бол, зээлийн үнэ цэнийн бууралтын нөөц сан зээлийн багцын хэмжээтэй уялдан 7.6 тэрбум төгрөг байхаар төсөөлсөн байна.

**Зураг 40: Зээлийн багцын бүтэц**




Зээлийн багцыг бүтцээр нь харвал 2021 оноос бизнесийн болон хэрэглээний зээлүүдийн нийт олгосон зээлд эзлэх хувь 50 хувьтай тэнцүү байхаар тооцоолсон байна.

2023 оны зорилтот зээлийн багцын төсөөлөлд хувь хүнд олгосон бизнесийн зээл дийлэнх хувийг эзэлж 62.7 тэрбум төгрөгт хүрэх бол энгийн хэрэглээний зээл 57.3 тэрбум төгрөг, автомашины зээл 42.5 тэрбум төгрөг, байгууллагад олгох бизнесийн зээл 33.1 тэрбум төгрөг, том дүнтэй бизнесийн зээл 7.0 тэрбум төгрөг, кредит картын зээл 2.9 тэрбум төгрөг тус тус олгосон байхаар төлөвлөжээ.

ТИ ДИ БИ КАПИТАЛ ҮЦК ХХК
TDB CAPITAL LLC
"ИНВЕСКОР ББСБ" ХХК
InvesCore
УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2019 05 26
БҮРТГЭВ-02

**Зураг 41: Эздийн өмчийн бүтэц**




СЗХ-ны 2019 оны 02 сарын 25-ны 118 дугаарт тогтоолоор Компани дүрмийн сангаа хуримтлагдсан ашгаас 7.7 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж 13.8 тэрбум төгрөг болгож өсгөсөн ба үнэт цаасыг олон нийтэд санал болгон гаргаснаар дүрмийн сан болон нэмэгдэж төлөгдсөн капитал 32.0 тэрбум төгрөгт хүрэх төлөвлөгөөтэй байна. 2019 оноос хойш эздийн өмч хуримтлагдсан ашгийн дүнгээр нэмэгдэх бөгөөд 2023 онд эздийн өмчийн 78.7 хувь нь хуримтлагдсан ашиг, 21.3 хувь нь дүрмийн сан болон нэмж төлөгдсөн капитал байх төлөвтэй байна.

## 4.4 МӨНГӨН УРСГАЛЫН ТӨСӨӨЛӨЛ

**Хүснэгт 28: Мөнгөн урсгалын төсөөлөл**

| Үзүүлэлт | FY19 | FY20 | FY21 | FY22 | FY23 |
|---|---|---|---|---|---|
| **Үйл ажиллагааны мөнгөн урсгал** | **(15.4)** | **(1.9)** | **2.2** | **2.5** | **3.6** |
| Цэвэр ашиг | 7.9 | 17.2 | 27.3 | 33.5 | 39.8 |
| Элэгдэл | 0.2 | 0.3 | 0.4 | 0.4 | 0.4 |
| Ажлын капиталын өөрчлөлт | (23.5) | (19.3) | (25.4) | (31.4) | (36.6) |
| **Хөрөнгө оруулалтын мөнгөн урсгал** | **(2.4)** | **(0.5)** | **(0.0)** | **(0.0)** | **(0.0)** |
| Биет хөрөнгө | (0.97) | (0.05) | (0.03) | (0.02) | (0.01) |
| Биет бус хөрөнгө | (1.47) | (0.41) | (0.00) | (0.00) | (0.00) |
| **Санхүүгийн мөнгөн урсгал** | **18.6** | **5.0** | **(1.4)** | **(2.5)** | **(4.0)** |
| Санхүүжилт болон эргэн төлөлт | 0.5 | 5.0 | - | - | - |
| Хувь нийлүүлсэн хөрөнгө+НТК | 18.1 | - | - | - | - |
| Ногдол ашиг хуваарилалт | - | - | (1.4) | (2.5) | (4.0) |
| **Цэвэр мөнгөн урсгал** | **0.8** | **2.7** | **0.8** | **0.0** | **(0.4)** |
| Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 3.1 | 5.8 | 6.6 | 6.6 | 6.2 |

Компани 2019 онд нэмэлт хувьцаа гаргах замаар ойролцоогоор 18.1 тэрбум төгрөгийн санхүүжилт татан, зээлийн үйл ажиллагаандаа зарцуулахаар төлөвлөсөн бөгөөд 2021 оноос эхлэн ногдол ашиг хуваарилж эхлэхээр төлөвлөжээ. Мөн компанийн стратеги төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 2019 онд шинээр нээх салбарууд болон үндсэн хөрөнгөд 0.97 тэрбум төгрөгийн, финтек технологид суурилсан бүтээгдэхүүн хөгжүүлэлт, програм хангамжид зориулан 1.47 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэхээр төлөвлөгдсөн байна.

TDB CAPITAL LLC
InvesCore
УЛААНБААТАР ХОТ

## 4.5 ХАРЬЦАА ҮЗҮҮЛЭЛТИЙН ШИНЖИЛГЭЭ

### 4.5.1 ОРЛОГЫН ТАЙЛАНГИЙН БҮТЦИЙН ШИНЖИЛГЭЭ

Компанийн нийт орлогод эзлэх орлого, зардал болон ашгийн хэмжээ дараах байдалтай байна.

Хүснэгт 29: Орлогын тайлангийн бүтцийн шинжилгээ

| | Аудит | | | Төлөвлөлт | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Үзүүлэлт | FY16 | FY17 | FY18 | FY19 | FY20 | FY21 | FY22 | FY23 |
| **Хүү болон түүнтэй адилтгах орлого** | **100%** | **100%** | **100%** | **100%** | **100%** | **100%** | **100%** | **100%** |
| Хүү болон түүнтэй адилтгах зардал | 27% | 15% | 24% | 23% | 20% | 19% | 16% | 13% |
| **Хүүгийн цэвэр орлого** | **73%** | **85%** | **76%** | **77%** | **80%** | **81%** | **84%** | **87%** |
| Хүүгийн бус цэвэр орлого | 20% | 3% | 4% | 3% | 3% | 2% | 2% | 2% |
| **Үйл ажиллагааны орлого** | **93%** | **88%** | **80%** | **80%** | **83%** | **84%** | **86%** | **90%** |
| Үйл ажиллагааны зардал | 15% | 13% | 13% | 20% | 14% | 11% | 10% | 10% |
| **Зээлийн үнэ цэнэ бууралтын өмнөх ашиг** | **78%** | **75%** | **66%** | **59%** | **68%** | **72%** | **75%** | **79%** |
| Зээлийн эрсдэлийн сангийн зардал | 12% | 7% | 9% | 6% | 5% | 2% | 2% | 2% |
| **Татварын өмнөх ашиг** | **67%** | **68%** | **57%** | **53%** | **63%** | **70%** | **73%** | **77%** |
| Орлогын татварын зардал | 7% | 7% | 10% | 12% | 15% | 17% | 18% | 19% |
| **Цэвэр ашиг** | **60%** | **61%** | **47%** | **41%** | **48%** | **53%** | **56%** | **58%** |

### 4.5.2 САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАНГИЙН БҮТЦИЙН ШИНЖИЛГЭЭ

Компанийн нийт хөрөнгөд эзлэх хөрөнгө болон эх үүсвэрийн хэмжээ дараах байдалтай байна.

Хүснэгт 30: Санхүүгийн байдлын тайлангийн бүтцийн шинжилгээ

| | Аудит | | | Төлөвлөлт | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Үзүүлэлт | FY16 | FY17 | FY18 | FY19 | FY20 | FY21 | FY22 | FY23 |
| Мөнгөн хөрөнгө | 5% | 6% | 6% | 4% | 4% | 4% | 3% | 3% |
| Цэвэр зээл | 94% | 91% | 89% | 82% | 87% | 89% | 91% | 93% |
| **Эргэлтийн хөрөнгө** | **99%** | **99%** | **98%** | **96%** | **98%** | **98%** | **99%** | **99%** |
| **Эргэлтийн бус хөрөнгө** | **1%** | **1%** | **2%** | **4%** | **2%** | **2%** | **1%** | **1%** |
| **Нийт хөрөнгө** | **100%** | **100%** | **100%** | **100%** | **100%** | **100%** | **100%** | **100%** |
| Итгэлцлийн үйлчилгээний өглөг | 46% | 13% | 27% | 24% | 34% | 30% | 23% | 16% |
| Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл | 0% | 40% | 36% | 18% | 15% | 12% | 10% | 9% |
| Бусад өр төлбөр | 1% | 2% | 2% | 8% | 7% | 8% | 9% | 9% |
| **Нийт өр төлбөр** | **47%** | **55%** | **64%** | **49%** | **56%** | **50%** | **42%** | **34%** |
| Хувь нийлүүлсэн хөрөнгө+НТК | 44% | 31% | 16% | 41% | 25% | 19% | 16% | 14% |
| Хуримтлагдсан ашиг | 9% | 13% | 20% | 10% | 19% | 31% | 42% | 52% |
| **Өөрийн хөрөнгө** | **53%** | **45%** | **36%** | **51%** | **44%** | **50%** | **58%** | **66%** |

СЗХ 2019.04.24 өдөр № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2019 05 26 БҮРТГЭВ-02

### 4.5.3 КОМПАНИЙН ХАРЬЦАА ҮЗҮҮЛЭЛТҮҮД

**Хүснэгт 31: Компанийн харьцаа үзүүлэлтүүд**

| | Аудит | | Төлөвлөлт | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Үзүүлэлт** | **FY17** | **FY18** | **FY19** | **FY20** | **FY21** | **FY22** | **FY23** |
| **Ашигт ажиллагаа** | | | | | | | |
| Нийт ашгийн маржин | 85% | 76% | 77% | 80% | 81% | 84% | 87% |
| Үйл ажиллагааны маржин | 75% | 66% | 59% | 68% | 72% | 75% | 79% |
| Цэвэр ашгийн маржин | 61% | 47% | 41% | 48% | 53% | 56% | 58% |
| **Хөрвөх чадвар** | | | | | | | |
| Эргэлтийн харьцаа | 6.7 | 3.4 | 3.1 | 2.4 | 2.6 | 3.1 | 3.9 |
| Бэлэн мөнгөний харьцаа | 0.4 | 0.2 | 0.1 | 0.1 | 0.1 | 0.1 | 0.1 |
| **Төлбөрийн чадвар** | | | | | | | |
| Өглөг, эздийн өмчийн харьцаа | 1.2 | 1.8 | 1.0 | 1.3 | 1.0 | 0.7 | 0.5 |
| Өглөг, нийт хөрөнгийн харьцаа | 0.6 | 0.6 | 0.5 | 0.6 | 0.5 | 0.4 | 0.3 |
| Санхүүгийн хөшүүрэг | 2.2 | 2.6 | 2.2 | 2.1 | 2.1 | 1.8 | 1.6 |
| **Хорооны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт** | | | | | | | |
| I зэрэглэлийн өөрийн хөрөнгө / Эрсдэлээр жинлэсэн актив (>10%) | 47% | 37% | 52% | 46% | 52% | 60% | 67% |
| Өөрийн хөрөнгө / Эрсдэлээр жинлэсэн актив (>20%) | 47% | 37% | 52% | 46% | 52% | 60% | 67% |
| I зэрэглэлийн өөрийн хөрөнгө / Нийт актив (>10%) | 45% | 36% | 51% | 44% | 50% | 58% | 66% |
| Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар (>8%) | 10% | 9% | 8% | 8% | 8% | 8% | 8% |
| Итгэлцлийн үйлчилгээний өглөг / Өөрийн хөрөнгө % (<80%) | 28% | 75% | 47% | 77% | 60% | 40% | 25% |
| Цэвэр үндсэн хөрөнгийн харьцаа (<15%) | 0% | 1% | 4% | 2% | 2% | 1% | 1% |
| **Хөрөнгө оруулалтын өгөөж** | | | | | | | |
| **Өөрийн хөрөнгийн өгөөж (RoE)** | **49%** | **44%** | **29%** | **35%** | **39%** | **34%** | **30%** |
| **Нийт хөрөнгийн өгөөж (RoA)** | **23%** | **17%** | **13%** | **16%** | **18%** | **19%** | **19%** |
| **Нэгж хувьцааны дансны үнэ (₮)** | **145** | **227** | **556** | **795** | **1,156** | **1,589** | **2,088** |
| Нэгж хувьцааны дансны үнийн өсөлт | 21% | 57% | 144% | 43% | 45% | 37% | 31% |
| **Нэгж хувьцаанд ногдох ашиг (₮)** | **45** | **83** | **109** | **239** | **380** | **468** | **555** |
| Нэгж хувьцаанд ногдох ашгийн өсөлт | 125% | 85% | 32% | 118% | 59% | 23% | 19% |
| **Ногдол ашиг төлөлтийн хувь** | | | | | **5.0%** | **7.5%** | **10.0%** |

TDB CAPITAL LLC

"ИНВЕСКОР ББСБ" ХХК InvesCore NON-BANK FINANCIAL INSTITUTION УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2019.04.24
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2019-03-26
БҮРТГЭВ-02



### 4.5.4 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ӨГӨӨЖ

**Зураг 42: Ашигт ажиллагаа**




2019 онд Компанийн төлөвлөсөн үйл ажиллагааны өргөжилттэй холбогдуулан үйл ажиллагааны зардлын хэмжээ нэмэгдсэнээр ашигт ажиллагаа өмнөх онтой харьцуулахад буурах хэдий ч 2020 оноос сайжирч, 2023 он гэхэд цэвэр ашгийн хувь 58.5% болж өсөхөөр таамаглагдсан байна.

**Зураг 43: Дупонт шинжилгээ, Өөрийн хөрөнгийн өгөөж**




Дупонт шинжилгээнээс харахад компанийн хөрөнгийн эргэц тогтвортой, өөрийн хөрөнгийн өсөлттэй холбоотойгоор санхүүгийн хөшүүрэг буурч байгаа бол цэвэр ашгийн хувь хэмжээ өсөх хандлагатай байна.

Өөрийн хөрөнгийн өгөөж нь санхүүгийн хөшүүргийн хэмжээтэй уялдан дараагийн 5 жилийн хугацаанд 29-39 хувийн хооронд хэлбэлзэхээр байгаа бол нийт хөрөнгийн өгөөж тогтвортой өсөн 19 хувьд хүрэх төлөвтэй байна.

Компанийн нэгж хувьцааны дансны үнэ 2019-2023 онд 556 төгрөгөөс 2,088 төгрөгт хүрч жилд дунджаар 39.2 хувиар, нэгж хувьцаанд ногдох ашиг 109 төгрөгөөс 555 төгрөгт хүрч жилд дунджаар 50.2 хувиар өсөх төлөвтэй байна.

Компанийн ногдол ашгийн бодлоготой уялдан ногдол ашиг төлөлтийн харьцаа 2021 оноос эхлэн нэмэгдэхээр төсөөлөгдджээ.

TDB CAPITAL LLC
"ИНВЕСКОР ББСБ" ХХК
InvesCore
УЛААНБААТАР ХОТ



# Зах зээлийн орчин

САХ 2019.04.24 он сар өдөр Б...ТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2019-03-26 БҮРТГЭВ-02

## 5.1 МОНГОЛ УЛСЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ

**Хүснэгт 32: Монгол Улсын макро эдийн засгийн үзүүлэлтүүд**

| Үзүүлэлт | 2014 | 2015 | 2016 | 2017 | 2018 |
|---|---|---|---|---|---|
| **Дотоодын нийт бүтээгдэхүүн** | | | | | |
| ДНБ, оны үнээр, тэрбум төгрөг | 22,227 | 23,150 | 23,943 | 27,896 | 32,166 |
| ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр, тэрбум төгрөг | 15,482 | 15,851 | 16,036 | 16,886 | 18,060 |
| ДНБ-ний өсөлт, хувиар | 7.9 | 2.4 | 1.2 | 5.3 | 6.9 |
| 1 хүнд ногдох ДНБ, оны үнээр, мянган төгрөг | 7,653 | 7,810 | 7,910 | 9,005 | N/A |
| **Инфляци** | | | | | |
| Инфляцийн түвшин, хугацааны эцэст хувиар | 10.4 | 1.9 | 1.1 | 6.4 | 8.1 |
| Инфляцийн жилийн дундаж түвшин, хувиар | 12.8 | 6.6 | 1.1 | 4.3 | 6.8 |
| **Мөнгө, санхүү** | | | | | |
| Мөнгө М1, тэрбум төгрөг | 1,816 | 1,685 | 2,148 | 2,826 | 4,031 |
| Мөнгө М2, тэрбум төгрөг | 10,634 | 10,049 | 12,159 | 15,861 | 19,475 |
| Бодлогын хүү, хувиар | 12.0 | 13.0 | 14.0 | 11.0 | 11.0 |
| Гадаад валютын албан нөөц, сая ам.доллараар | 1,650 | 1,323 | 1,296 | 3,008 | 3,542 |
| Төгрөгийн ам.доллартай харьцах албан ханш, хугацааны эцэст, төгрөг | 1,888 | 1,996 | 2,490 | 2,427 | 2,644 |
| Хадгаламжийн үлдэгдэл, тэрбум төгрөгөөр | 7,379 | 7,382 | 8,580 | 11,154 | 13,176 |
| Хадгаламжийн хүү, төгрөгийн, хувиар | 12.5 | 13.3 | 13.1 | 12.9 | 12.0 |
| Хадгаламжийн хүү, валютын, хувиар | 5.8 | 6.6 | 6.0 | 5.4 | 5.3 |
| **Банкны салбар** | | | | | |
| Зээлийн өрийн үлдэгдэл, тэрбум төгрөгөөр | 12,441 | 11,634 | 12,338 | 13,506 | 17,082 |
| Чанаргүй зээлийн хувь, хувиар | 5.0 | 7.5 | 8.5 | 8.5 | 10.4 |
| Зээлийн хүү, төгрөгийн, хувиар | 17.5 | 18.2 | 18.5 | 18.1 | 17.1 |
| Зээлийн хүү, валютын, хувиар | 12.0 | 11.9 | 12.1 | 11.2 | 10.5 |
| **Улсын нэгдсэн төсөв** | | | | | |
| Төсвийн нийт тэнцвэржүүлсэн тэнцэл, тэрбум төгрөг | (868) | (1,157) | (3,660) | (1,742) | 12 |

***Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк***

ТИ ДИ БИ КАПИТАЛ ҮЦК ХХК TDB CAPITAL LLC 1115204194



"ИНВЕСКОР ББСБ" ХХК InvesCore 1116224289 6060854 УЛААНБААТАР ХОТ

### 5.1.1 МОНГОЛ УЛСЫН ЗЭЭЛЖИХ ЗЭРЭГЛЭЛ

Монгол Улсын зээлжих зэрэглэлийг олон улсын зэрэглэл тогтоогч байгууллагууд болох Moody's, Fitch болон Standard & Poors агентлагуудаас тогтоосон байдаг. Монгол улсын зээлжих зэрэглэл болон "төлөв" нь сүүлийн жилүүдэд буурч хөрөнгө оруулалтын хувьд өндөр эрсдэлтэй орны ангилалд багтаад байсан бол 2018 онд эдгээр агентлагууд Монгол Улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээг нэг шат ахиулаад байна.

- **Moody's** агентлаг Монгол Улсын зээлжих зэрэглэлийг 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр "Caa1"-ээс "B3" болгон дээшлүүлж, төлөвийг "тогтвортой" хэвээр үнэлсэн. Тус агентлаг улсын төсвийн үзүүлэлтүүд, тэдгээрийн төлөв харьцангуй сайжирсан, нийт өрийн хэмжээ буурах хандлагатай, түүхий эдийн үнийн савлагаанаас хамаарах хамаарал тодорхой хэмжээгээр буурах төлөвтэй байгаа бөгөөд Монгол Улсын эдийн засаг сэргэж байгаа нь зээлжих зэрэглэлийг дээшлүүлэх хүчин зүйл болсныг онцолжээ. Moody's агентлагийн үзэж байгаагаар түүхий эдийн үнэ буурсан хэдий ч макро эдийн засгийн тогтвортой байдлыг ханган, төсвийн мөчлөг дагасан эмзэг байдлыг бууруулж, төсвийн алдагдал болон өрийн дарамт эрчимтэйгээр багасаж, бүтцийн өөрчлөлтийн бодлогыг үр дүнтэй, тогтвортой хэрэгжүүлж байгаа нь зээлжих зэрэглэлийг сайжруулахад чухал нөлөөтэйг онцлов. Түүнчлэн тус агентлагийн үнэлгээгээр төлөв "тогтвортой" байгаа нь Монгол Улсын эрсдэлийн хүчин зүйлс тэнцвэртэй байгааг илтгэж байна.

- **Fitch** агентлаг нь 2018 оны 7 дугаар сарын 09-ний өдөр Монгол Улсын урт хугацааны зээлжих зэрэглэлийн үнэлгээг "B-" байсныг "B" болгон дээшлүүлж, төлөвийг "тогтвортой" гэж үнэлэв. Үүнд: төсвийн гүйцэтгэл, тоон үзүүлэлтүүд 2017 оны 11 дүгээр сараас хойш тогтмол сайжирсан, Засгийн газрын нийт өрийн хэмжээ буурах хандлагатай байгаа, уул уурхайн салбартай холбоотой хөрөнгө оруулалтууд нэмэгдсэнээр эдийн засгийн өсөлт сайжирсан, Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлснээр нийтдээ 5.5 тэрбум ам.долларын санхүүжилтийг ОУВС болон донор орнуудаас татах нөхцөл бүрдсэн зэрэг нь голлон нөлөөлснийг онцолжээ.

- **Standard & Poors** агентлаг нь 2018 оны 11 дүгээр сарын 09-ний өдөр Монгол Улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээг "B-" байсныг "B" болгон дээшлүүлж, хэтийн төлөвийг "тогтвортой" гэж үнэлсэн. Тус агентлагийн тайланд дурдсанаар Монгол Улсад тулгамдаад байсан хөрвөх чадварын дарамт буурсан, эдийн засгийн болон төсвийн суурийг сайжруулах зорилгоор өргөн хэмжээний реформ, шинэчлэлүүд хийгдэж буй нь зэрэглэлийг дээшлүүлэхэд голлон нөлөөлөв. Түүнчлэн зээлжих зэрэглэлийн төлөв "тогтвортой" байгаа нь эрсдэлийн хүчин зүйлс тэнцвэртэй байгааг онцлоод, цаашид Монгол Улс бодлогын шинэчлэл хийснээр дэлхийн зах зээл дээрх түүхийн эдийн үнийн мөчлөг дагасан хамаарал буурч, төсвийн чадамж, гадаад төлбөрийн чадвар сайжрах боломжтойг дурджээ. Зээлжих зэрэглэлийн агентлагуудын хувьд Монгол Улсын эдийн засгийг богино хугацааны эрсдэл, сорилтуудтай тулгарч буй боловч ирэх жилүүдэд ОУВС-гийн хөтөлбөр үргэлжилж, уул уурхайн томоохон төсөл хөтөлбөрүүд амжилттай хэрэгжсэнээр эдийн засаг сэргэх, улсын төсөв, гадаад төлбөрийн чадвар сайжрах хүлээлттэй буюу Монгол Улсын дунд болон урт хугацааны эдийн засгийн төлөвийг эерэгээр үнэлсэн хэвээр байна.

2019 .04. 24
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2019 -03- 26

## 5.1.2 МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ, ТӨЛӨВ БАЙДАЛ

**Зураг 44: Нэрлэсэн ДНБ, өсөлтийн хувь**




***Эх сурвалж: ҮСХ***

Монгол Улсын эдийн засгийн үзүүлэлтүүд 2017 онд харьцангуй сайжирсан бөгөөд энэхүү эерэг хандлага 2018 онд хэвээр хадгалагдсан байна. ДНБ-ний өсөлт 2016 онд 1.2 хувь болж буураад байсан бол 2017 онд 5.3 хувь, 2018 онд 6.9 хувиар тус тус нэмэгджээ.

Сүүлийн жилүүдийн эдийн засгийн сэргэлтийн гол хүчин зүйл нь түүхий эдийн гадаад зах зээлийн тааламжтай орчин, уул уурхайн томоохон төслүүд болон гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдсэнтэй холбоотой байна.

**Зураг 45 Мөнгөний бодлогын хүү, инфляцийн түвшин**




***Эх сурвалж: Монголбанк***

Монгол Улсын инфляцийн түвшин 2016 онд 1.1 хувь болж буурсан бол 2017 онд 6.4 хувь, 2018 онд 8.1 хувь болж өсчээ. 2018 онд инфляцийн түвшин зорилтот түвшин болох 8 хувьтай ойролцоо байсан хэдий ч цалин болон төсвийн зардал нэмэгдэж, улмаар дотоод эрэлт нэмэгдсэнээр 2019-2020 онд өсөх хандлагатай байна.

ТИ ДИ БИ КАПИТАЛ ҮЦК ХХК
TDB CAPITAL LLC
"ИНВЕСКОР ББСБ" ХХК
InvesCore
NON BANK FINANCIAL INSTITUTION
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2019 .04. 24
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
Зах зээлийн орчин
2019 -03- 26
БҮРТГЭВ-02

### 5.1.3 МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ЦААШДЫН ТӨЛӨВ БАЙДАЛ

Дэлхийн зах зээл болон гол худалдан авагч орны зах зээл дээр экспортын гол нэрийн бүтээгдэхүүний үнэ тогтвортой өсөж байгаагаас шалтгаалан улсын эдийн засгийн өсөлт 2019 онд хадгалагдах магадлал өндөр байгаа бөгөөд энэхүү өсөлт нь 2023 он хүртэл тогтмол хадгалагдахаар хүлээгдэж байна.

Энэхүү өсөлтөд нөлөөлөх гол хүчин зүйлс нь экспортын гол бүтээгдэхүүн болох зэс, алтны үнийн тогтвортой байдал, 2022 оноос ашиглалтад орох Оюу Толгой төслийн 2-р ээлжийн бүтээн байгуулалт, Цагаан суварга, Таван толгой зэрэг томоохон төслүүдийн хөрөнгө оруулалт зэрэг зэрэг хүчин зүйлүүд байна.

ОУВС Монгол Улсын 2018 оны ДНБ-ий өсөлтийг урьдчилсан гүйцэтгэлээр 6.2 хувь бөгөөд 2019 онд энэхүү өсөлт хадгалагдаж, 6.3 хувь байна гэж үзсэн бол Сангийн яамны 2019 оны улсын төсвийн төсөлд дурдсанаар Монгол Улсын эдийн засаг ирэх жил 8 хувь хүртэл өснө хэмээн таамаглажээ.

УИХ-ын чуулганаар батлагдсан 2019 оны улсын төсвийн тухай хуулиар гадаад худалдааны хэмжээг нэмэгдүүлэх, татварын тогтолцооны үр ашгийг дээшлүүлэх, гадаад болон дотоодын өрийн дарамтыг бууруулахаар тусгасан.

Мөнгөний бодлогын зах зээлийн зарчимд суурилсан хэрэгслийг ашиглан хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцийг 2019-2020 онд жилийн 8 хувь, дунд хугацаанд 6 хувь орчимд тогтворжуулахаар Монголбанк дунд хугацаанд зорьж байна. Гэсэн хэдий ч өрхийн хэрэглээ дунд хугацаанд үргэлжлэн өсөх төсөвтэй байгаа тул Төв банкнаас инфляцийн түвшинг хянахын тулд мөнгөний бодлогоо алгуур чангатгаж болзошгүй юм.

ТИ ДИ БИ КАПИТАЛ ҮЦК ХХК
TDB CAPITAL
TDB CAPITAL LLC
"ИНВЕСКОР ББСБ" ХХК
InvesCore
NON BANK FINANCIAL INSTITUTION
УЛААНБААТАР ХОТ

СЗХ 2019.04.24
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2019-03-26 БҮРТГЭВ-02

## 5.2 БАНК БУС САНХҮҮГИЙН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

### 5.2.1 САНХҮҮГИЙН САЛБАРЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

**Хүснэгт 33: Санхүүгийн салбарын үзүүлэлт**

| Үзүүлэлт | 2014 | 2015 | 2016 | 2017 | 2018-III |
|---|---|---|---|---|---|
| **Санхүүгийн салбарын нийт хөрөнгө, тэрбум төгрөгөөр** | | | | | |
| Банк | 22,582 | 21,521 | 25,338 | 28,773 | 31,033 |
| Үнэт цаас | 137 | 63 | 92 | 93 | N/A |
| Даатгал | 153 | 173 | 208 | 245 | 327 |
| ББСБ | 508 | 623 | 787 | 969 | 1,202 |
| ХЗХ | 81 | 98 | 113 | 153 | N/A |
| **Санхүүгийн салбарын хөрөнгийн хэмжээ нийт дүнд эзлэх хувиар** | | | | | |
| Банк | 96.3% | 95.7% | 95.5% | 95.2% | N/A |
| Үнэт цаас | 0.6% | 0.3% | 0.3% | 0.3% | N/A |
| Даатгал | 0.7% | 0.8% | 0.8% | 0.8% | N/A |
| ББСБ | 2.2% | 2.8% | 3.0% | 3.2% | N/A |
| ХЗХ | 0.3% | 0.4% | 0.4% | 0.5% | N/A |

**Хүснэгт 34: Банк бус санхүүгийн салбарын үзүүлэлт**

| Үзүүлэлт | 2014 | 2015 | 2016 | 2017 | 2018-III |
|---|---|---|---|---|---|
| **Салбарын үзүүлэлтүүд** | | | | | |
| ББСБ тоо | 378 | 450 | 518 | 534 | 540 |
| Харилцагчдын тоо | 533,016 | 636,341 | 592,461 | 1,387,894 | 1,510,982 |
| **Санхүүгийн үзүүлэлтүүд, тэрбум төгрөгөөр** | | | | | |
| Нийт хөрөнгө | 508.0 | 623.2 | 787.2 | 969.2 | 1,202.0 |
| Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө | 258.2 | 308.4 | 440.5 | 595.4 | 725.6 |
| Нийт хуримтлагдсан ашиг | 64.0 | 102.0 | 130.4 | 155.1 | 195.6 |
| **Зээлийн багцын ангилал, тэрбум төгрөгөөр** | | | | | |
| Нийт зээл | 303.1 | 391.2 | 478.2 | 638.0 | 811.6 |
| Хэвийн зээл | 263.1 | 330.7 | 392.0 | 527.0 | 690.4 |
| Хугацаа хэтэрсэн | 20.8 | 22.2 | 26.7 | 29.9 | 35.6 |
| Чанаргүй | 19.2 | 38.3 | 59.5 | 81.1 | 85.7 |
| Хэвийн бус | 4.6 | 10.9 | 12.8 | 17.6 | 17.9 |
| Эргэлзээтэй | 5.9 | 10.6 | 18.2 | 14.2 | 19.3 |
| Муу | 8.7 | 16.8 | 28.5 | 49.3 | 48.4 |
| Зээлийн эрсдэлийн сан | (15.2) | (26.6) | (42.1) | (56.0) | (63.4) |
| **Зээлийн багцын ангилал нийт зээлд эзлэх хувиар** | | | | | |
| Нийт зээл | 100.0% | 100.0% | 100.0% | 100.0% | 100.0% |
| Хэвийн зээл | 86.8% | 84.5% | 82.0% | 82.6% | 85.1% |
| Хугацаа хэтэрсэн | 6.9% | 5.7% | 5.6% | 4.7% | 4.4% |
| Чанаргүй | 6.3% | 9.8% | 12.4% | 12.7% | 10.6% |
| Хэвийн бус | 1.5% | 2.8% | 2.7% | 2.8% | 2.2% |
| Эргэлзээтэй | 2.0% | 2.7% | 3.8% | 2.2% | 2.4% |
| Муу | 2.9% | 4.3% | 6.0% | 7.7% | 6.0% |
| Зээлийн эрсдэлийн сан | 5.0% | 6.8% | 8.8% | 8.8% | 7.8% |

*Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанк*

"ИНВЕСКОР ББСБ" ХХК InvesCore NON-BANK FINANCIAL INSTITUTION 1116224259 6060854 УЛААНБААТАР ХОТ
TDB CAPITAL 1115204194

### 5.2.2 САНХҮҮГИЙН САЛБАРЫН ХӨРӨНГӨ

2017 оны жилийн эцсийн байдлаар улсын хэмжээнд санхүүгийн салбарын нийт хөрөнгө 30.2 их наяд төгрөг, үүнээс банкны салбарын хөрөнгө 28.8 их наяд төгрөг буюу 95.2 хувь, банк бус санхүүгийн салбарын хөрөнгө 969 тэрбум төгрөг буюу 3.2 хувь, даатгалын салбарын хөрөнгө 245 тэрбум төгрөг буюу 0.8 хувь, үлдсэн 246 тэрбум төгрөг буюу 0.8 хувийг үнэт цаас болон хадгаламж зээлийн хоршооны салбарын хөрөнгө бүрдүүлж байна.

**Зураг 46: Салбарын хөрөнгийн дундаж өсөлт (2014-2017)**




*Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо*

Банк бус санхүүгийн салбар нь 2014-2017 онуудад дунджаар 24.0 хувийн өсөлттэй ажилласан бол ХЗХ-ны салбар 23.9 хувь, даатгалын салбар 17.1 хувь, банкны салбар 8.4 хувийн дундаж өсөлттэй ажиллажээ.

### 5.2.3 БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ТОО

Үйл ажиллагаа явуулж буй: **540**

Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй: **464**

Гадаадын хөрөнгө оруулалттай: **28**

Зээлийн үйл ажиллагааны эрхтэй: **491**

Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх эрхтэй : **31**

Итгэлцлийн үйлчилгээний эрхтэй: **29**

Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээний эрхтэй: **23**

Төлбөрийн баталгаа гаргах эрхтэй: **18**

Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах эрхтэй: **3**

Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх эрхтэй: **9**

**Хүснэгт 35: ББСБ-ын тоо 2018 III, хөрөнгийн хэмжээгээр, тэрбум төгрөг**

| Нийт хөрөнгө /интервалаар/ | ББСБ-ын тоо | Хөрөнгийн хэмжээ | Зээлэх хувь | Дундаж хөрөнгө |
|---|---|---|---|---|
| 5 тэрбум ба түүнээс дээш | 38 | 524.9 | 43.7% | 13.8 |
| 1-4.9 тэрбум хүртэл | 367 | 631.3 | 52.5% | 1.7 |
| 1 тэрбумаас доош | 135 | 45.7 | 3.8% | 0.3 |
| **Нийт дүн** | **540** | **1,202.0** | **100.0%** | **2.2** |

*Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо*

5 тэрбум төгрөгөөс дээш хөрөнгөтэй нийт 38 ББСБ байгаа нь зах зээлийн 43.7 хувийг эзэлж байгаа ба эдгээр ББСБ-уудын хөрөнгийн дундаж хэмжээ 13.8 тэрбум төгрөг байна.

## 5.2.4 ББСБ-ЫН ХАРИЛЦАГЧ БОЛОН ЗЭЭЛДЭГЧ

**Зураг 47: Нийт харилцагчдын тоо (мянга)**




*Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо*

2018 оны 3-р улирлын байдлаар нийт 540 ББСБ-д бүртгэлтэй 1.5 сая харилцагч байгаагаас 217.6 мянга нь зээлдэгчид байна.

2017 оны жилийн эцсийн тоон үзүүлэлтээс харахад зээлдэгчийн тоо нь нийт харилцагчийн 7.7% байсан бол энэ үзүүлэлт нь 2018 оны 3-р улиралд өсөж 14.4%-д хүрчээ.

2014-2016 оны хооронд харилцагчдын тоо болон зээлдэгчдийн тоо харьцангуй тогтвортой байсан бол 2017 онд нэр бүхий 1 ББСБ-ын цахим мөнгөний үйлчилгээний харилцагчдын тоо 1,175,964 болсон нь нийт ББСБ-ын харилцагчдын тоог өмнөх оны үзүүлэлтээс 2.3 дахин өсөхөд хүргэсэн байна.

**Хүснэгт 36: ББСБ-ын харилцагчдын тоо 2018 III**

| | ББСБ тоо | Хувь | Харилцагчдын тоо | Хувь |
|---|---|---|---|---|
| 1,000,000-аас дээш | 1 | 0.2% | 1,184,098 | 78.4% |
| 10,000-1,000,000 | 7 | 1.3% | 169,368 | 11.2% |
| 1001-10,000 | 31 | 5.7% | 102,049 | 6.8% |
| 100-1000 | 152 | 28.1% | 43,166 | 2.9% |
| 100-аас доош | 349 | 64.6% | 12,301 | 0.8% |
| **НИЙТ** | **540** | **100.0%** | **1,510,982** | **100.0%** |

*Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо*

Хорооны ББСБ-уудын 2018 оны 3-р улирлын санхүүгийн нэгтгэсэн тайлангаас харахад хоёр ББСБ-ын харилцагчид нь нийт харилцагчийн 83.1%-ийг эзэлж байна. Харин дийлэнх ББСБ буюу 349 ББСБ нь 100-аас доош харилцагчтай байгаа нь нийт банк бус санхүүгийн салбарын харилцагчдын 0.8%-ийг бүрдүүлж, нэг ББСБ дунджаар 35 орчим харилцагчтай байна.

2019 .04. 24
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2019 -03- 2

### 5.2.5 ББСБ-ЫН САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Хүснэгт 37: Банк бус санхүүгийн салбарын нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан, тэрбум төгрөг

| Үзүүлэлтүүд | Тод. | 2016 | 2017 | 2017-III | 2018-III |
|---|---|---|---|---|---|
| Мөнгөн хөрөнгө | | 243.1 | 264.1 | 247.8 | 298.9 |
| Цэвэр зээл | b | 436.1 | 582.0 | 539.0 | 748.2 |
| Бусад эргэлтийн хөрөнгө | | 75.1 | 86.6 | 82.0 | 108.3 |
| **Эргэлтийн хөрөнгийн дүн** | | **754.3** | **932.7** | **868.8** | **1,155.4** |
| Эргэлтийн бус хөрөнгийн дүн | | 32.9 | 36.5 | 37.2 | 46.6 |
| **Нийт хөрөнгө** | **a** | **787.2** | **969.2** | **906.0** | **1,202.0** |
| Итгэлцлийн үйлчилгээний өглөг | d | 30.5 | 39.2 | 35.6 | 48.8 |
| Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг | | 121.4 | 112.8 | 104.9 | 135.6 |
| ББСБ-аас гаргасан өрийн бичиг | e | 4.1 | 6.9 | 4.5 | 21.1 |
| Бусад өр төлбөр | | 52.7 | 52.2 | 44.1 | 64.6 |
| **Өр төлбөрийн дүн** | **c** | **208.7** | **211.0** | **189.1** | **270.0** |
| Хувь нийлүүлсэн хөрөнгө | f | 440.5 | 595.4 | 575.8 | 725.6 |
| Хуримтлагдсан ашиг/алдагдал | | 130.4 | 155.1 | 133.3 | 195.6 |
| Өөрийн хөрөнгийн бусад хэсэг | | 7.6 | 7.7 | 7.7 | 10.8 |
| **Өөрийн хөрөнгийн дүн** | | **578.5** | **758.2** | **716.8** | **932.0** |

***Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо***

a. 2018 оны III улиралд ББСБ-уудын нийт хөрөнгө 1.2 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 32.7% буюу 295.9 тэрбум төгрөгөөр, оны эхнээс 24.0% буюу 232.8 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлт байна. Салбарын нийт активын 96.1 хувийг эргэлтийн хөрөнгө, 3.9 хувийг эргэлтийн бус хөрөнгө бүрдүүлж байна.

b. Нийт хөрөнгийн гол өөрчлөлтүүдийг харвал цэвэр зээлийн үлдэгдэл оны эхнээс 28.6% буюу 166.2 тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 38.8% буюу 209.2 тэрбум төгрөгөөр, мөнгөн хөрөнгө оны эхнээс 13.2% буюу 34.8 тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 20.6% буюу 51.1 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

c. Салбарын нийт хөрөнгийн 22.5% буюу 270.0 тэрбум төгрөгийг бусдаас татсан эх үүсвэр, 77.5% буюу 932.0 тэрбум төгрөгийг өөрийн хөрөнгө бүрдүүлж байна.

d. 2018 оны III улирлын байдлаар ББСБ-уудын нийт өр төлбөр, өөрийн хөрөнгийн бүрэлдэхүүнд дараах өөрчлөлтүүд орсон байна.

   **1.** Итгэлцлийн үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй 29 ББСБ-ын 23 нь 48.8 тэрбум төгрөгийн санхүүгийн эх үүсвэр татан төвлөрүүлсэн нь салбарын нийт эх үүсвэрийн 4.1 хувьтай тэнцэж байна.

   **2.** 13 ББСБ 1 тэрбум төгрөг хүртэлх дүнгээр 4.5 тэрбум төгрөгийн, 10 ББСБ 1 тэрбум төгрөгөөс дээш дүнгээр 44.2 тэрбум төгрөгийн итгэлцэл татан төвлөрүүлсэн байна.

   3. Итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлсэн 48.8 тэрбум төгрөгийн 81.4% буюу 39.7 тэрбум төгрөгийг 22 ББСБ төгрөгөөр, 18.6% буюу 9.1 тэрбум төгрөгийг давхардсан тоогоор 10 ББСБ валютаар татан төвлөрүүлсэн байна.

e. 2018 оны III улирлын байдлаар 18 ББСБ 21.1 тэрбум төгрөгийн өрийн бичиг гаргасан нь өмнөх оны мөн үеэс 4.7 дахин буюу 16.6 тэрбум төгрөгөөр, оны эхнээс 3.1 дахин буюу 14.2 тэрбум төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны мөн үеэс 4.7 дахин өссөн өсөлтөд 12 ББСБ 16.2 тэрбум төгрөгийн өрийн бичгээр хөрөнгө оруулалт татсан нь нөлөөлсөн байна.

f. Хорооны 2017 оны 1-р сарын 13-ны өдөр "Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг үе шаттай нэмэгдүүлэх тухай" тогтоолыг гаргасан.

   1. Тус тогтоолын дагуу ББСБ-уудын ХНХ-ийг 2018 оны 2 сарын 10-нд 1.0 тэрбум төгрөг, 2019 онд 1.4 тэрбум төгрөг, 2020 онд 1.9, 2021 онд 2.5 болгох юм.

   2. 2018 оны 3-р улирлын байдлаар Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй 464 ББСБ-аас 9 ББСБ нь ХНХ-ийн доод хэмжээг хангаж ажиллаагүй байна.

   3. Мөн түүнчлэн 3 ББСБ-ын үйл ажиллагааг 3 сарын хугацаатай түдгэлзүүлсэн зэрэг нь ирэх жилүүдэд энэхүү тогтоолтой холбоотойгоор хэт жижиг, үйл ажиллагаа зогсонги байдалд байгаа ББСБ-ууд хоорондоо нийлэх, бусад томоохон ББСБ-уудад нэгдэх, татан буугдах зэргээр өөрчлөн байгуулагдаж, зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагуудын чанар сайжрах төлөвтэй байна.

TDB CAPITAL LLC
5251494
"ИНВЕСКОР ББСБ" ХХК
InvesCore
УЛААНБААТАР ХОТ

### 5.2.6 ЗЭЭЛИЙН БАГЦ

2018 оны 3-р улирлын байдлаар 491 ББСБ 217,623 зээлдэгчдийн 811.6 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байсан ба энэ нь банк бус санхүүгийн салбарын нийт хөрөнгийн 67.5 хувийг бүрдүүлж байна. Тайлант хугацаанд өмнөх оны жилийн эцэстэй харьцуулахад нийт зээлийн дүн 27.2%-иар өссөн бөгөөд чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь 10.6% болж 2.1 пунктээр буураад байгаа юм.

**Зураг 48: Нийт зээлийн ангилал, зээлийн эрсдэлийн сан, тэрбум төгрөгөөр**




*Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо*




2018 оны III улирлын байдлаар 434 ББСБ нийт 852.3 тэрбум төгрөгийн зээл олгосон бол 451 ББСБ-ын 677.0 тэрбум төгрөгийн зээл эргэн төлөгдөж 2018 оны III улирлын байдлаар 491 ББСБ-ын 811.6 тэрбум төгрөгийн зээлийн эцсийн үлдэгдэлтэй гарчээ.

Олгосон зээлийн 84.8% буюу 722.4 тэрбум төгрөгийг иргэдэд олгосон бол 15.2% буюу 129.9 тэрбум төгрөгийг хуулийн этгээдэд олгосон байна.

**Зураг 49: Нийт олгосон зээл, зориулалтаар, тэрбум төгрөгөөр**




2017 онд нийт шинээр олгосон зээлийн дийлэнх буюу 42%-ийг хэрэглээний зээл эзэлж байсан бол 2018 оны 3-р улирлын байдлаар нийт олгосон зээлийн 53%-ийг хэрэглээний зээл дангаар эзэлсэн. Өөрөөр хэлбэл 2018 оны 3-р улирлын байдлаар олгосон хэрэглээний зээлийн хэмжээ 451 тэрбум төгрөгт хүрч, 2017 оны жилийн эцсийн үзүүлэлтээс 56.9 хувиар өссөн байна.

СЗХ 2019.04.24 өлөр

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2019-03-26 БҮРТГЭВ-02

## 5.3 БАНК БУС САНХҮҮГИЙН САЛБАРЫН ЦААШДЫН ЧИГ, ХАНДЛАГА

Монгол Улсын санхүүгийн зах зээл эдийн засгийн өсөлттэй уялдан тогтвортой өсөх төлөв харагдаж байна. Тэр тусмаа банк бус санхүүгийн салбарын өсөлт бусад салбаруудтай харьцуулахад өндөр байна.

Өмнөх жилүүдийн эдийн засгийн өсөлт, инфляци, санхүүгийн салбарын өсөлтөд дүн шинжилгээ хийж, 2023 он хүртэлх банк бус санхүүгийн салбарын өсөлтийг тооцоход 2023 он хүртэл банк бус санхүүгийн салбарын нийт хөрөнгө 3.0 дахин өсөж, 3.6 их наяд төгрөгт хүрч, улмаар банк бус санхүүгийн салбарын ДНБ-д эзлэх хувь 5.1 хувиас 6.3 хувь болж өсөх хандлагатай байна.

**Хүснэгт 38: ББСБ салбарын өсөлтийн таамаглал**

| | H17 | H18-III | FY19 | FY20 | FY21 | FY22 | FY23 |
|---|---|---|---|---|---|---|---|
| Нэрлэсэн ДНБ (их наяд төг.) | 27.9 | 23.7 | 36.4 | 40.7 | 45.5 | 51.0 | 57.3 |
| **Эдийн засгийн цэвэр өсөлт** | **5.3%** | **6.5%** | **6.3%** | **4.9%** | **5.0%** | **5.2%** | **5.7%** |
| Банк бус санхүүгийн салбарын нийт хөрөнгө (их наяд төг.) | 1.0 | 1.2 | 1.6 | 2.0 | 2.4 | 2.9 | 3.6 |
| **Салбарын өсөлт** | **23.1%** | **24.0%** | **26.3%** | **20.5%** | **20.9%** | **21.7%** | **23.8%** |
| Банк бус санхүүгийн салбарын ДНБ-д эзлэх хувь | 3.5% | 5.1% | 4.5% | 4.8% | 5.2% | 5.7% | 6.3% |

***Эх сурвалж: Компанийн судалгаа, ОУВС***

Дараах нөхцөл байдлууд нь банк бус санхүүгийн салбарын өсөлтөд нөлөө үзүүлэх гол хүчин зүйл болж болохоор байна. Үүнд:

- ✓ 2019 оноос эхлэх банкны салбар дахь хэрэглээний зээлийн хязгаарлалт;
- ✓ Хорооноос тавьж буй ББСБ-ын дүрмийн сангийн доод хэмжээний шаардлага;
- ✓ Финтек буюу технологид суурилсан санхүүгийн бүтээгдэхүүний нэвтрэлт.

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооноос 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж эхлэх иргэдийн хэрэглээний зээлийн өр орлогын харьцаанд дээд хязгаар тогтоох шийдвэртэй уялдуулан хэрэглээний зээлийн хугацааг хамгийн ихдээ 30 сар байхаар журамлажээ.

Хорооноос ББСБ-уудын дүрмийн санг 2020 он хүртэл үе шаттайгаар 2.5 тэрбум төгрөг хүртэл нэмэгдүүлэх шаардлага тавьсан бөгөөд үүнд зөвхөн валют арилжааны эрхтэй болон орон нутгийн ББСБ-ууд хамаарахгүй юм.

Дунд хугацаанд Банк бус санхүүгийн салбарт дараах өөрчлөлтүүд гарах хандлагатай байна:

- Гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдэж, ББСБ-уудын хэмжээ томорч, чадваржих тусам уг салбарын өрсөлдөөн нэмэгдэнэ.
- Мөнгө угаалтын эсрэг механизм, татварын системийн сайжралт, өрсөлдөөн зэргээс шалтгаалан салбарын тоглогчдын мэргэшсэн байдал нэмэгдэнэ.
- Финтек буюу технологид тулгуурласан бүтээгдэхүүн, үйлчилгээний нэвтрэлттэй холбоотойгоор банк бус санхүүгийн салбарын харилцагчийн тоо, борлуулалт, ашигт ажиллагаа нэмэгдэнэ.
- Томоохон ББСБ-ууд жижиг болон дунд хэмжээтэй ББСБ-уудыг өөртөө нэгтгэх байдлаар зах зээлд эзлэх хувиа нэмэгдүүлэх төлөвтэй байна.

ТИ ДИ БИ КАПИТАЛ ХХК TDB CAPITAL TDB CAPITAL LLC

"ИНВЕСКОР ББСБ" ХХК InvesCore УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2019-03-26
БҮРТГЭВ-02

### 5.3.1 ЗЭЭЛИЙН ЭРЭЛТ

**Хэрэглээний зээл**

2018 онд банкны салбарын олгосон нийт хэрэглээний зээлийн хэмжээ 8,922.6 тэрбум төгрөг, 2018 оны 3-р улирлын байдлаар ББСБ-ын олгосон хэрэглээний зээлийн хэмжээ 451.2 тэрбум төгрөг байна. ҮСХ-оос 2018 онд гаргасан "Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа 2017" түүвэр судалгаанаас харахад Монгол улсад нийт 885.6 мянган өрх байгаагаас давхардсан тоогоор ойролцоогоор 469.4 мянган өрх цалингийн, тэтгэврийн, лизингийн, автомашины, өрхийн хэрэглээний, малчны зээл болон бусад төрлийн хэрэглээний зээлтэй байна.

Монголбанкны Мөнгөний бодлогын зөвлөлөөс өрхийн зээл хурдацтай өсөх нь санхүүгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй хэмээн үзэж, макро эдийн засгийн зохистой бодлогын хүрээнд иргэдийн хэрэглээний зээлийн өр орлогын харьцаанд дээд хязгаар тогтоон, ипотекийн зээлээс бусад иргэдийн хэрэглээний зээлийн хугацааг 30 сараас хэтрүүлэхгүй байхаар шийдвэрлэжээ. Энэхүү шийдвэрийг 2019 оны 1 сарын 1-нээс эхлэн мөрдүүлэхээр тогтоосонтой холбогдуулан, банкуудын хэрэглээний зээл олголтын хэмжээ нь тус шийдвэр хэрэгжиж эхлэхээс өмнөх тайлант хугацаанд буюу 2018 оны 4-р улиралд 2,976.7 тэрбум төгрөгт хүрч, өмнөх улирлаас 36.0%-аар өсөхөд нөлөөлжээ.

ББСБ-ын хэрэглээний зээл олголтын хувьд, сүүлийн жилүүдэд финтект суурилсан санхүүгийн хялбар шийдлийг санал болгож буй ББСБ-ууд бий болсноор тус салбарын харилцагчдын тоо болон хэрэглээний зээл олголтын хэмжээг нэмэгдүүлж байна. Монголбанкны хэрэглээний зээлийн хугацааг хязгаарлах шийдвэр болон ББСБ-ын салбар дах финтект суурилсан бүтээгдэхүүний хурдацтай өсөлт нь ББСБ дах хэрэглээний зээлийн эрэлтэд цаашид эерэгээр нөлөөлөх хандлагатай байна.

**Зураг 50. Банк болон ББСБ-аас олгосон хэрэглээний зээл, тэрбум төгрөгөөр**




*Эх сурвалж: Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо*

**Бизнесийн зээл**

Бизнесийн зээл олголтын хэмжээнд улирлын нөлөөлөл харьцангуй өндөр бөгөөд 2018 онд банкны салбарын жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд олгосон зээлийн хэмжээ 4,230.8 тэрбум төгрөг, 2018 оны 3-р улирлын байдлаар ББСБ-ын олгосон бизнесийн зээлийн хэмжээ 401.1 тэрбум төгрөг байна.

**Зураг 51. Банкнаас олгосон ЖДҮ-ийн зээл болон ББСБ-ын бизнесийн зээл, тэрбум төгрөгөөр**




***Эх сурвалж: Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо***

Монголбанкнаас 2018 онд "Жижиг дунд үйлдвэрлэлийн хөгжил, санхүүжилтийн байдал" түүвэр судалгааг гаргажээ. Энэхүү түүвэр судалгаанд 2018 оны 2-р улиралд Монгол улсад идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй 83,086 аж ахуйн нэгж байгууллагуудаас аж ахуйн нэгжүүдийн байршил, ажиллагсдын тоо болон үйл ажиллагааны чиглэлийг харгалзан үзэж, эх олонлогийг төлөөлөхүйц, санамсаргүй түүврийн аргаар сонгогдсон 1,922 аж ахуйн нэгж хамрагджээ. Тус судалгааны үр дүнгээс харахад ЖДҮ эрхлэгчдийн 49% нь ирэх нэг жилийн хугацаанд үйл ажиллагаа явуулахад нь санхүүжилт зайлшгүй шаардлагатай талаар дурдсан бөгөөд санхүүжилт хэрэгцээтэй бизнес эрхлэгчдийн 20% нь 10 сая төгрөг хүртэлх, 56% нь 10-100 сая төгрөгийн, 18% нь 100-500 сая төгрөгийн, 6% нь 500 сая төгрөгөөс дээш дүнтэй санхүүжилтийн хэрэгцээ байгаа гэжээ. Энэхүү түүвэр судалгаанд үндэслэн тооцоход жижиг дунд бизнес эрхлэгчдэд шаардлагатай нэмэлт санхүүжилтийн хэмжээ 2019 онд хамгийн багадаа 2.6 их наяд төгрөг байхаар байна.

### 5.3.2 ФИНТЕК БҮТЭЭГДЭХҮҮН

**Зураг 52: Бичил зээлийн үйлчилгээ үзүүлэгч компаниуд, нэвтрүүлсэн үйлчилгээ**

MobiFinance

lendmn
асаа. асуудлаа шийд

ARD КРЕДИТ ББСБ

CENTRAL CAPITAL

Зах зээлд Мобифинанс ББСБ, Лэндмн ББСБ, Ард кредит ББСБ, Централ Капитал ББСБ зэрэг байгууллагууд гар утасны аппликэйшн ашиглан бичил хэрэглээний зээл авах бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлээд байна. Цаашид ч олон компаниуд финтек бүтээгдэхүүн хөгжүүлж, энэхүү зах зээлд нэвтрэх хандлагатай байгаа.

**Зураг 53: Финтек бүтээгдэхүүний онцлог**




Финтек бүтээгдэхүүний гол онцлог нь зээлдэгчийн богино хугацааны, бага дүнтэй эх үүсвэрийн дутагдлыг маш хялбар аргаар, цаг хугацаа бага зарцуулан зээл авах боломжийг олгох замаар шийдвэрлэхэд оршино.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2019 -03- 26

Финтек бүтээгдэхүүнүүд зах зээлд нэвтэрч эхэлснээр ББСБ-ын салбарын харилцагчдын тоог огцом өсөхөд нөлөөлсөн хэдий ч энэ нь нийт зээлийн дүнд одоогоор харьцангуй багаар нөлөөлж байна. Мөн финтек бүтээгдэхүүн нь зах зээлд оролцогч боломжит харилцагчдын тоог нэмэгдүүлснээр, цаашлаад уламжлалт банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааг дэмжиж боломжтой юм.

## 5.4 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ЗАХ ЗЭЭЛД ЭЗЛЭХ БАЙР СУУРЬ, SWOT ШИНЖИЛГЭЭ

### 5.4.1 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ЗАХ ЗЭЭЛД ЭЗЛЭХ БАЙР СУУРЬ

**Салбарын өсөлт**

Хүснэгт 39: Салбарын өсөлт 2018.II болон 2018.III харьцуулалт

| | Зээлийн өсөлт | Хөрөнгийн өсөлт |
|---|---|---|
| Салбар | 5.6% | 5.1% |
| Инвескор | 17.4% | 16.7% |
| | x3.1 | x3.3 |

Банк бус санхүүгийн зах зээлийн салбарын үзүүлэлтүүдийг үнэт цаас гаргагчийн үзүүлэлтүүдтэй харьцуулан харахад 2018 оны 3-р улиралд зээлийн өсөлт салбараас 3.1 дахин, хөрөнгийн өсөлт 3.3 дахин илүү байна.

**Салбарын хөрөнгө**

Зураг 54: Банк бус санхүүгийн салбарын хөрөнгө, таамаглал, тэрбум төгрөг




2018 оны 3-р улирлын байдлаар үнэт цаас гаргагчийн нийт хөрөнгийн хэмжээг салбарын хөрөнгөд харьцуулсан харьцаа буюу зах зээлд эзлэх хувь 2.9% байсан нь 2017 оны үзүүлэлтээс 9 пунктээр нэмэгдсэн үзүүлэлт байна. Банк бус санхүүгийн салбарын өсөлтийн таамагт үндэслэн тооцоход Үнэт цаас гаргагчийн төсөвлөсөн хөрөнгийн хэмжээ 2023 онд зах зээлийн 6.4 хувийг эзлэхээр байна.



TDB CAPITAL LLC
"ИНВЕСКОР ББСБ" ХХК
InvesCore
УЛААНБААТАР ХОТ

**Зураг 55: Нийт хөрөнгө 2018 он, тэрбум төгрөгөөр**




***Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо, Ард Кредит үнэт цаасны танилцуулга, ЛэндМн санхүүгийн тайлан***

Банк бус санхүүгийн байгууллагуудын нийт хөрөнгийн хэмжээ 2018 оны 3-р улиралд 1,202 тэрбум төгрөг, өөрийн хөрөнгийн хэмжээ 932 тэрбум төгрөг байсан байна. Үнэт цаас гаргагчийн 2018 оны нийт хөрөнгө болон өөрийн хөрөнгийн хэмжээг Монголын хөрөнгийн биржид бүртгэгдсэн "ЛендМн ББСБ" болон танилцуулга бэлтгэх үеийн байдлаар үнэт цаасаа нийтэд санал болгосон "Ард Кредит ББСБ"-ын хэмжээтэй харьцуулж үзэхэд нийт хөрөнгийн хэмжээ нь "ЛендМн ББСБ"-аас 60.5%, "Ард Кредит ББСБ"-аас 271.4%-аар өндөр байна.

### Салбарын зээл

**Зураг 56: Нийт зээлийн дүн, чанаргүй зээлийн хувь хэмжээ 2018 он, тэрбум төгрөгөөр**




***Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанк***

2018 оны байдлаар арилжааны банкуудын нийт зээл 17.1 их наяд төгрөг байсан бол банк бус санхүүгийн салбарын 2018 оны 3-р улирлын зээлийн дүн түүнээс 21 дахин бага буюу 811.6 тэрбум төгрөг байсан байна. Банк бус санхүүгийн байгууллагын 2018 оны 3-р улирлын чанаргүй зээлийн түвшин Банкны салбарын жилийн эцсийн түвшинтэй харьцуулахад 0.2 пунктээр өндөр байна. 2018 оны 3-р улирлын байдлаар үнэт цаас гаргагчийн нийт зээлийн үлдэгдэл банк бус санхүүгийн салбарын нийт зээлийн 3.7% байсан бол чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь банк болон банк бус санхүүгийн салбарын үзүүлэлтээс харгалзан 5.6 болон 5.8 пунктээр бага байна.

СЗХ 2019 .04 .24 он сар өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2019 -05- 2 6 БҮРТГЭВ-02

## Салбарын ашигт ажиллагаа

2018 оны 3-р улиралд ББСБ-ын салбарын цэвэр ашиг нийт 73.5 тэрбум төгрөг, өөрийн хөрөнгийн өгөөж 8.9%, нийт хөрөнгийн өгөөж 7.0% байсан бол Үнэт цаас гаргагчийн 2018 оны өөрийн хөрөнгийн өгөөж 44.5%, нийт хөрөнгийн өгөөж 17.2% байгаа нь салбарын болон харьцуулагдах боломжтой бусад компаниудтай харьцуулахад өндөр байна.

Зураг 57: Ашигт ажиллагааны үзүүлэлт 2018 он, хувиар




*Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо, Ард Кредит үнэт цаасны танилцуулга, ЛэндМн санхүүгийн тайлан*

## Зээлийн хүү

Инвескор ББСБ-ын зээлийн жинлэсэн дундаж хүү нь салбарын трендийг даган сүүлийн улирлуудад тогтмол буурч байсан. 2018 оны 3-р улирлын байдлаар салбарын үзүүлэлт 3.3% байсан бол үнэт цаас гаргагчийнх 3.1% болж, цаашлаад 2018 оны жилийн эцсийн байдлаар 2.9% хүрч буураад байна.

Зураг 58: Зээлийн жинлэсэн дундаж хүүгийн түвшин




*Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанк*

ТИ ДИ БИ КАПИТАЛ ҮЦК ХХК TDB CAPITAL LLC



"ИНВЕСКОР ББСБ" ХХК InvesCore УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE

### 5.4.2 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН SWOT ШИНЖИЛГЭЭ

**Дотоод орчны шинжилгээ**

**S - Давуу тал**

- Шилдэг хүний нөөц: Банк санхүү, эдийн засгийн салбарт ажиллаж байсан туршлагатай хүний нөөц нийт ажиллагсдын 43%, томоохон арилжааны банкуудад удирдах албан тушаал хашиж байсан туршлагатай хүний нөөц нийт удирдах албан тушаалтны 25%-ийг тус тус эзэлж байна;
- Тогтвортой, санхүүгийн эх үүсвэр: Гадаад болон дотоодын хөрөнгө оруулагчдаас өндөр хэмжээтэй, тогтмол санхүүгийн эх үүсвэр бүрдүүлж чадсан;
- Үйл ажиллагааны давуу тал: Банкны болон олон улсын банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа, дүрэм журамд судалгаа хийсний дүнд шинээр боловсруулсан үйл ажиллагааны процесс, ноу-хау, зээлийн үйл ажиллагааны автоматжуулсан системтэй;
- Тэргүүлэх арилжааны банкууд болон Даатгалын компаниудтай нягт хамтарч ажилладаг;
- Холбогдох хууль эрхзүйн шаардлага, татвар тайлагнал, эрх зүйн хэрэгжилтийг нягт мөрдөж ажилладаг;
- Финтек буюу технологид тулгуурласан бүтээгдэхүүн, хиймэл оюун ухааны чиглэлээр хөгжүүлэлт хийх өөрийн мэдээлэл технологийн багтай ба гаднаас хамаарах хамаарал багатай;
- Инвескор ҮЦК, Инвекор лизинг, Инвескор фанд зэрэг санхүүгийн үйл ажиллагаа явуулдаг групп компаниудтай хамтран шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ гаргах боломжтой.

**W - Сул тал**

- Компанийн нэр, брэнд олон нийтэд сайтар танигдаагүй. Компанийн брэнд маркетингийн талаар судалгаан дээр үндэслэн маркетингийн стратеги, төлөвлөгөө гарган 2019 оноос хэрэгжүүлэхээр ажиллаж байна.
- Финтек зах зээлд бага зэрэг хоцорч нэвтэрч байгаа.

**Гадаад орчны шинжилгээ**

**O – Боломж**

- Монгол Улсын ББСБ салбарын эрчимтэй өсөлт;
- Төв Ази, Зүүн өмнөд Азийн зах зээлд нэвтрэх: Япон зэрэг өндөр хөгжилтэй улс орнуудаас татах бага хүүтэй, их хэмжээний санхүүгийн эх үүсвэр болон Монгол Улсад хэрэгжүүлсэн бизнесийн туршлага, хүний нөөц, ноу хау, бүтээгдэхүүн хөгжүүлэлтэд суурилан бусад хөгжиж буй орнуудын зах зээлд нэвтрэх;
- Финтект суурилсан шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэн, бизнесээ тэлэх бүрэн боломжтой.
- Нээлттэй хувьцаат компани болох, цаашлаад олон улсын хөрөнгийн зах зээлд гарах боломж бий болсноор олон улсын байгууллагуудтай хамтран ажиллахад хялбар болох, гадаад дотоодын зах зээлээс татах эх үүсвэрийн өртгийг боломжтой.

**T – Аюул**

- Эдийн засаг, улс төр, бизнесийн орчны эрсдэл: Одоогоор бизнесийн үйл ажиллагаа зөвхөн Монгол Улс дахь үйл ажиллагаанаас 100% хамааралтай байгаа тул дунд хугацаанд гадаадын зах зээлд нэвтрэхээр төлөвлөж байна.
- Зээлийн эрсдэл: Эдийн засгийн нөхцөл байдалтай холбогдуулан муу зээлийн хэмжээ өсөх магадлалтай тул хиймэл оюун ухаанд суурилсан кредит скоринг, автомат зээлийн судалгааны систем, автомат зээлийн хяналтын системүүдийг тус тус хөгжүүлж үйл ажиллагаандаа нэвтрүүлж байна.
- Нэмэгдэж буй өрсөлдөгчийн тоо, салбарын өрсөлдөөн.

TDB CAPITAL LLC
"ИНВЕСКОР ББСБ" ХХК
InvesCore

СЗХ
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2019 -03- 26
БҮРТГЭВ-02



# Хууль, эрх зүйн орчин

TDB CAPITAL
TDB CAPITAL LLC

"ИНВЕСКОР ББСБ" ХХК
InvesCore
NON-BANK FINANCIAL INSTITUTION
УЛААНБААТАР ХОТ

## 6.1 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ДАГАЖ МӨРДӨХ ХУУЛЬ ТОГТООМЖ

**ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА НЬ ДАРААХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХОЛБОГДОХ ХЭСГЭЭР ЗОХИЦУУЛАГДАНА. ҮҮНД:**

**Иргэний хууль**

2002 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр батлагдсан Иргэний хуулиар эрх зүйн этгээдийн хооронд үүсэх эдийн болон эдийн бус баялагтай холбоотой харилцааг зохицуулна.

Үнэт цаас гаргагч нь үнэт цаас гаргах бүхий л үе шатанд аливаа баримт бичиг, гэрээ хэлцлийг боловсруулахдаа Иргэний хуулийн ерөнхий зарчим, нийтлэг үндэслэл, гэрээний эрх зүйн ерөнхий болон тухайлсан зохицуулалтуудыг баримтлах үүрэгтэй байна.

**Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль**

2001 оны 02 дугаар сарын 01-ний өдөр батлагдсан Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулиар нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй, тодорхой нөхцөл, нарийн мэргэжил шаардах аж ахуйн зарим үйл ажиллагааг эрхлэхэд тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбоотой харилцааг зохицуулна.

Үнэт цаас гаргагчийн дараах үндсэн үйл ажиллагаа нь тусгай зөвшөөрөлтэй эрхлэх үйл ажиллагаанд хамаарна. Үүнд:

- Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх.

Үнэт цаас гаргагч нь өөрийн нэр дээр байх тусгай зөвшөөрлүүдэд холбогдох бүхий л харилцаанд тус хууль болон түүнтэй холбогдох бусад хуулиар тогтоосон журмыг баримталж ажиллах үүрэгтэй байна.

**Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль**

2002 оны 12 дугаар сарын 12-ны өдөр батлагдсан Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулиар банк бус санхүүгийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоож, банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн удирдлага, зохион байгуулалт, хяналтын бүтцийг тогтоох, түүнд зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд заасны дагуу Үнэт цаас гаргагч нь дараах үйл ажиллагааг Хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлнэ. Үүнд:

- Зээл;
- Факторингийн үйлчилгээ;
- Итгэлцлийн үйлчилгээ;
- Төлбөрийн баталгаа гаргах;
- Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх;
- Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө өгөх, мэдээлэл өгөх.

Үнэт цаас гаргагч нь өөрийн үйл ажиллагаанд холбогдох бүхий л харилцаанд тус хууль болон түүнтэй холбогдох бусад хуулиар тогтоосон журмыг баримталж ажиллах үүрэгтэй байна.

СЗХ 2019 .04 24 өдөр № 11

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2019 -03- 26 БҮРТГЭВ-02

**Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль**

2002 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр батлагдсан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар иргэний эрхзүйн харилцаанд оролцогчдын хооронд үүссэн иргэний эрхзүйн маргааныг шүүх иргэний хэрэг үүсгэн хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна. Банк бус санхүүгийн байгууллагаас олгосон зээлийн үүрэг хангагдаагүй тохиолдолд энэхүү хуульд нийцүүлэн шүүхэд нэхэмжлэл гаргаж, маргааныг Шүүхээр шийдвэрлүүлнэ.

**Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль**

2017 оны 6 дугаар сарын 09-ний өдөр батлагдаж, 2017 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсөн. Банк бус санхүүгийн байгууллагын нэхэмжлэлийг Шүүх хангаж шийдвэрлэсэн ч зээлдэгч, барьцаалуулагч нар шүүхийн шийдвэрийг сайн дураар биелүүлээгүй тохиолдолд энэ хуульд заасны дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлнэ.

**ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БОЛОН ҮНЭТ ЦААС ГАРГАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА НЬ ТАТВАРЫН БАГЦ ХУУЛИУДЫН ХОЛБОГДОХ ХЭСГЭЭР ЗОХИЦУУЛАГДАНА. ҮҮНД:**

**Татварын ерөнхий хууль**

2008 оны 5 дугаар сарын 20-ны өдөр батлагдсан Татварын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгаар Монгол Улсад татвар бий болгох, тогтоох, ногдуулах, тайлагнах, төлөх, хянан шалгах, хураах эрх зүйн үндсийг тогтоож, татвар төлөгч болон татварын албаны эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлон тэдгээрийн хооронд үүсэх харилцааг зохицуулна.

Үнэт цаас гаргагч нь татвар төлөгч болохын хувьд тус хуулиар тогтоосон татварын төрөл, ангиллаар татвар төлөх, татварын эрх зүйн нийтлэг үндэслэл, татварын хөнгөлөлт, чөлөөлөлт болон татвар төлөгчийн үүрэг, хариуцлага болон холбогдох харилцаанд хуулиар тогтоосон журмыг баримтлах үүрэг хүлээнэ.

**Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль**

2006 оны 6 дугаар сарын 29-ний өдөр батлагдсан Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулиар аж ахуйн нэгжийн орлогод албан татвар ногдуулах, уг албан татварыг төсөвт төлөх, тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулна.

Үнэт цаас гаргагчаас нэмж хувьцаа гарган нээлттэй зах зээлд арилжаалахтай холбоотойгоор хөрөнгө оруулагч хуулийн этгээд нь компанийн тухай хуулийн дагуу компаниас ногдол ашиг хүртсэн тохиолдолд ногдол ашгийн албан татвар төлөх бөгөөд өөрийн эзэмшлийн хувьцааг бусдад худалдаж орлого олсон тохиолдолд хөрөнгө борлуулсны албан татварыг тус тус төлөх үүрэг хүлээнэ. Албан татвар төлөгч өөрийн эзэмшлийн хувьцаанаас бусдад худалдаж орлого олсон тохиолдолд нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурииар гаргасан улирал, жилийн татварын тайланг үндэслэн жилийн эхнээс өссөн дүнгээр орлого болон төлөх албан татвараа өөрөө үнэн зөв тодорхойлж төсөвт төлнө. Ногдол ашгийн орлогод ногдох албан татвар нь тус хуулийн 17.2.1-д заасанаар 10 хувь байх бөгөөд хуульд заасан албан татвар суутгах үүрэг бүхий этгээд дээрх хувь хэмжээгээр суутгаж, ажлын 7 хоногийн дотор төсөвт шилжүүлэх үүрэг хүлээнэ.

Мөн тус хуульд Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчийн Монгол Улсын нутаг дэвсгэрт болон Монгол Улсаас эх үүсвэртэй олсон орлогод 20 хувиар татвар ногдуулахаар заасан. Харин давхар татварын гэрээтэй улсуудын хувьд ихэнх тохиолдолд үнэт цаас гаргаж буй компанийн буюу Монгол Улсад ногдол ашгийн татвар төлөхөөр зохицуулсан байдаг

TDB CAPITAL LLC

InvesCore УЛААНБААТАР ХОТ

боловч гэрээнд заасан хувь хэмжээ нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасныаас бага байдгийг анхаарах нь зүйтэй.

Төсөл бэлтгэх өдрийн байдлаар Монгол Улс дараах 26 улстай байгуулсан "Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай хэлэлцээр" хүчин төгөлдөр үйлчилж байна.

**Хувь хүний орлогын албан татварын тухай хууль**

2006 оны 6 дугаар сарын 16-ны өдөр батлагдсан Хувь хүний орлогын албан татварын тухай хуулиар хувь хүний орлогод албан татвар ногдуулах, уг албан татварыг төсөвт төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

Үнэт цаас гаргагчаас нэмж хувьцаа гарган нээлттэй зах зээлд арилжаалахтай холбоотойгоор хөрөнгө оруулагч хувь хүн нь Компанийн тухай хуулийн дагуу компаниас ногдол ашиг хүртсэн тохиолдолд ногдол ашгийн албан татвар төлөх бөгөөд өөрийн эзэмшлийн хувьцааг бусдад худалдаж орлого олсон тохиолдолд хөрөнгө борлуулсны албан татварыг Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасны дагуу тус тус төлөх үүрэг хүлээнэ.

Үнэт цаасанд хөрөнгө оруулагч хувь хүн нь "Хувь хүний орлогын албан татварын тухай хууль"-ийн 13.1.3-т заасан орлого (ногдол ашгийн орлого)-ын нийт дүнгээс хуулийн 23.1-д заасан 10 хувийн татвар төлөх бөгөөд татварыг мөн хуулийн 26.1.1-д заасанаар, хуулийн 4.1.4-д заасан суутгагч суутгаж, улсын төсөвт шилжүүлнэ. Мөн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.3-т заасан орлого (хувьцаа, үнэт цаас борлуулсны орлого)-оос худалдаж авсан үнийг хассан зөрүүгээс тус хуулийн 23.1-т заасан 10 хувийн хэмжээгээр татвар төлөх бөгөөд хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.4-д заасанаар татвар төлөгч өөрөө орлогоо үнэн зөв тодорхойлж төсөвт төлөх үүрэгтэй байна.

Тус хуульд 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр оршин суугч бус албан татвар төлөгчийн Монгол Улсын нутаг дэвсгэрт олсон орлогод албан татвар ногдуулахтай холбоотой зүйл нэмж, улмаар оршин суугч бус албан татвар төлөгчийн олсон орлогод 20 хувиар татвар ногдуулахаар заасан. Мөн цалин хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах орлогод албан татвар ногдуулах орлогод ногдох жилийн албан татварт хөнгөлөлт үзүүлэх нөхцөлийг шинэчлэн тогтоосон байна.

## 6.2 ҮНЭТ ЦААС ГАРГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ДАГАЖ МӨРДӨХ ХУУЛЬ ТОГТООМЖ, ЖУРМУУД

**ҮНЭТ ЦААС ГАРГАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА НЬ ДАРААХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХОЛБОГДОХ ХЭСГЭЭР ЗОХИЦУУЛАГДАНА. ҮҮНД:**

**Компанийн тухай хууль**

2011 оны 10 дугаар сарын 06-ны өдөр батлагдсан Компанийн тухай хуулиар компани үүсгэн байгуулах, бүртгүүлэх, өөрчлөн байгуулах, компанийн удирдлага, зохион байгуулалт, хяналтын бүтэц, хувьцаа эзэмшигчийн эрх, үүргийг тогтоох, компани татан буулгахтай холбогдсон харилцааг зохицуулна.

Үнэт цаас нэмж гаргах үйл ажиллагаанд холбогдох хуулийн дараах зохицуулалтууд байна. Үүнд:

СЗХ 2019.04.24 БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2019-03-26 БҮРТГЭВ-02

- Хувьцаа эзэмшигчдийн хувьцаа нэмж гаргах, ТУЗ-ийн нэмж гаргах хувьцааны тоо тогтоох бүрэн эрх;
- Нээлттэй хувьцаат компанийн энгийн хувьцаа эзэмшигч нь нэмж гаргасан хувьцаа, түүнд хамаарах үнэт цаасыг тэргүүн ээлжинд худалдан авах эрх;
- Энгийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх мэдэгдэл хүргүүлэх болон хурал зарлах журам;
- Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх;
- Нэмж гаргах хувьцааны бүртгэлийн эрх зүйн үндэслэл болон төлбөр төлөх журам;

Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтнууд тус хуульд заасан компанийн удирдлага, хяналтын бүтэц, хувьцаа эзэмшигчдийн эрх, үүргийн хүрээнд шийдвэр гаргаж, хувьцаа нэмж гарган нээлттэй зах зээлд арилжаалах замаар Компанид хөрөнгө оруулалт татаж байгаа болно.

**Үнэт цаасны зах зээлийн тухай хууль**

2013 оны 5 дугаар сарын 24-ний өдөр батлагдсан Үнэт цаасны зах зээлийн тухай хуулиар үнэт цаасны зах зээлд оролцогчдын үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулна.

Үнэт цаас гаргах үйл ажиллагаанд холбогдох хуулийн дараах зохицуулалтууд байна. Үүнд:

- Нийтэд санал болгон үнэт цаас гаргах ажиллагааны журам, заавар, дарааллыг Хороо, Бирж батлах эрх зүйн үндэслэл;
- Үнэт цаасыг нийтэд санал болгон гаргах, анхдагч зах зээлд худалдах, бүрдүүлэх бичиг баримт, үнэлгээ тайлан, тайлагнах үүрэг;
- Үнэт цаасны танилцуулгын талаарх нарийвчилсан зохицуулалт;
- Нийтэд санал болгох үнэт цаас гаргах ажиллагаан дахь андеррайтерийн оролцоо;
- Үнэт цаас гаргагчийн удирдлагад тавигдах нөхцөл, шаардлагыг Хороо, Бирж тогтоох эрх зүйн үндэслэл;

Үнэт цаас гаргагч нь тус хуульд заасан нийтэд санал болгон үнэт цаас гаргах ажиллагааны бэлтгэл ажлыг хангах эрх зүйн зохицуулалтын хүрээнд Хорооны тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлдэг андеррайттер, хууль, аудит, үнэлгээний байгууллагуудтай гэрээ байгуулан ажилласан байна.

Хуульд зааснаар Компанийн нийтэд санал болгон гаргах үнэт цаасыг Хороо үнэт цаасны анхдагч зах зээлд санал болгох зөвшөөрлийг олгож, Бирж нь үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжааг зохион байгуулна. Үнэт цаас гаргагч нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.9 дэх хэсэгт зааснаар үнэт цаасны арилжаанаас төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг тухайн Үнэт цаасны танилцуулгад заасанаас өөр зориулалтаар зарцуулахыг хориглоно.

**Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль**

2018 оны 6 дугаар сарын 21-ний өдөр батлагдсан Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулиар хуулийн этгээдийг шинээр үүсгэн байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгасныг болон түүний мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгэх, иргэн, хуулийн этгээд болон эрх бүхий байгууллага, албан тушаалтанд лавлагаа олгох, хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

Үнэт цаас гаргах үйл ажиллагаанд холбогдох хуулийн дараах зохицуулалтууд байна. Үүнд:

- Хуулийн этгээдийн лавлагааг бичгээр, эсхүл цахим хэлбэрээр, шаардлагатай баримт бичгийн хуулбараар гаргуулан авах;

ТИ ДИ БИ КАПИТАЛ ХХК TDB CAPITAL LLC



InvesCore ББСБ ХХК УЛААНБААТАР ХОТ

- Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлт болон үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан өөрчлөлтийг бүртгүүлэх.

Үнэт цаас гаргагч нь тус хуульд заасан компанийн хувьцаа эзэмшигчийн бүтэц, тэдгээрийн хувь эзэмшил болон хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд орсон өөрчлөлтийг тусгасан дүрмийн шинэчилсэн найруулгыг улсын бүртгэлд бүртгүүлэх, компанийн хувийн хэргээс лавлагаа гаргуулах зэргээр улсын бүртгэлийн үйлчилгээ авахад холбогдох эрх зүйн зохицуулалтыг мөрдөж ажилласан байна.

Үнэт цаас гаргагч нь олон нийтэд үнэт цаас санал болгон гаргах ажиллагаа амжилттай болсон тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн бүтцэд орж ирэх хувьцаа эзэмшигчид, хувьцаа эзэмшигчдийн эзэмшлийн хувь хэмжээ, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээний өөрчлөлт, хувьцааны тоонд орсон өөрчлөлтийг тусгасан дүрмийн шинэчилсэн найруулгыг бүртгүүлэх үүргийг хүлээнэ.

**Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль**

2009 оны 7 дугаар 09-ний өдөр батлагдсан Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулиар Монгол Улсын нутаг дэвсгэрт бараа, ажил, үйлчилгээний үнийг үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлж, төлбөр тооцоог гүйцэтгэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

Үнэт цаас гаргагч нь нэмж гаргаж буй хувьцааг худалдах Биржийн арилжаа нь Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох төгрөгөөр хийгдэнэ.

**ҮНЭТ ЦААС ГАРГАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА НЬ ХОРООНЫ ДАРААХ ЖУРМУУДЫН ХОЛБОГДОХ ХЭСГЭЭР ЗОХИЦУУЛАГДАНА. ҮҮНД:**

**Үнэт цаасны бүртгэлийн журам**

Хорооны 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 408 тоот тогтоолоор батлагдсан Үнэт цаасны бүртгэлийн журмаар Хорооноос компанийн шинээр болон нэмж гаргасан хувьцаа, өрийн хэрэгслийг нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгэхэд Үнэт цаас гаргагч, арилжаа эрхлэх байгууллага, Хорооны эрх, үүргийг тодорхойлох, хувьцаа, өрийн хэрэгслийг бүртгүүлэх хүсэлт гаргах, хүсэлтийг хянах, бүртгэхээс татгалзах, бүртгэсэн үнэт цаасыг нийтэд танилцуулах, анхдагч зах зээлд арилжих, тайлагнах, Хорооны бүртгэлд өөрчлөлт оруулах, бүртгэлээс хасахтай холбогдсон харилцааг зохицуулна.

Үнэт цаас гаргах үйл ажиллагаанд холбогдох журмын дараах зохицуулалтууд байна. Үүнд:

- Үнэт цаас гаргагч, Арилжаа эрхлэх байгууллага болон Хорооны эдлэх эрх, үүрэг;
- Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах
  /Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах, Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах хүсэлт гаргах, хүсэлтийг хянах, Хорооны бүртгэлд өөрчлөлт оруулах/;

Үнэт цаас гаргагчтай гэрээ байгуулан ажилласан байгууллагууд нь Үнэт цаас гаргагчид үйлчилгээ үзүүлэх байгууллагаар Хороонд бүртгэгдсэн андеррайтер, хууль, аудит, үнэлгээний байгууллагууд байна.

**Компанийн засаглалын кодекс**

Хорооны 2014 оны 5 дугаар сарын 07-ны өдрийн 162 тоот тогтоолоор батлагдсан Компанийн засаглалын кодексоор компанийн засаглалын суурь үндэс, хувьцаа эзэмшигчдийн эрх, мэргэжлийн хөрөнгө оруулагчдын эрх, үүрэг, хувьцаа эзэмшигчдийн хурлын эрх хэмжээ,

хурлын бэлтгэл ажлыг хангах, хурал хуралдуулах болон хурлын шийдвэр, тэмдэглэлд тавих шаардлага, ТУЗ, түүний хороод, гишүүдийн эрх хэмжээ, гүйцэтгэх удирдлагын эрх, санхүүгийн тайлагнал, хөндлөнгийн аудит, мэдээллийн ил тод байдал, дотоод хяналтын тогтолцоо ба аудитын үйл ажиллагаа, эрсдэлийн удирдлагын зохистой үндэслэлийг нарийвчлан зохицуулна.

Үнэт цаас гаргах үйл ажиллагаанд холбогдох журмын дараах зохицуулалтууд байна. Үүнд

- Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, ногдол ашиг авах, санал өгөх, сонгох сонгогдох, мэдээлэл авах, хувьцааг эргүүлэн авахыг шаардах, нэмж гаргаж буй хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах, компанийн үйл ажиллагаанд шалгалт хийлгэхийг шаардах болон компанийн татан буугдахад үлдсэн хөрөнгөөс хувь хүртэх эрх;
- Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах журам, Ногдол ашгийн бодлого батлах;
- Хувьцаа эзэмшигчдийн хурлын эрх хэмжээ, хуралд бэлтгэх, хурал зохион байгуулахтай холбоотой ТУЗ-ийн авч хэрэгжүүлэх арга хэмжээ, хурал хуралдуулах журам болон хурлаас гарах шийдвэр, тэмдэглэлийн хүчин төгөлдөр байдлыг хангах хэлбэр агуулгын шаардлагууд;
- Мэргэжлийн хөрөнгө оруулагчид тэдний томоохон хөрөнгө оруулалтын үйл ажиллагаатай холбогдон гарч болзошгүй ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах журам батлах;
- ТУЗ-ийн бүтэц, хороодын чиг үүрэг, ТУЗ, түүний гишүүд, нарийн бичгийн даргын эрх, үүрэг, гишүүдийн сонгох, чөлөөлөх болон ТУЗ-ийн гишүүдийн сонирхлын зөрчил ба нэгдмэл сонирхолтой этгээд хоорондын хэлцлүүд;
- ТУЗ-ийн үйл ажиллагааны журам болон ТУЗ-ийн дэргэдэх хороодын журмыг батлах;
- Гүйцэтгэх удирдлагын эрх хэмжээг ТУЗ-тэй байгуулсан гэрээгээр тодорхойлох, гэрээнд тусгах гол нөхцөлүүд;
- Санхүүгийн тайлагнал, тайлагналын системд мөрдөх шаардлагууд, хөндлөнгийн аудитын үйл ажиллагааг зохицуулах дотоод журам батлах, мэдээллийн ил тод нээлттэй байдлыг хангах, тус үйл ажиллагааг зохицуулах журам батлах;
- Дотоод хяналтын тогтолцооны хүрээнд явуулах үйл ажиллагаа, дотоод аудитын газартай байх, тус газрын үйл ажиллагааны зарчим;
- ТУЗ-ийн хариуцах гадаад, дотоод орчны эрсдэлийг хянах, бууруулах ерөнхий чиг үүрэг болон эрсдэлийн удирдлагын журам батлах.

Үнэт цаас гаргагч нь тус журамд заасан анх удаа нийтэд санал болгон нэмж хувьцаа гаргаж байгаа компанийн батлан мөрдөх шаардлагатай холбогдох журмын төслүүдийг ТУЗ-ийн хурлаар дэмжин баталгаажуулсан бөгөөд нэмж хувьцаа гаргах ажиллагаа амжилттай болсон тохиолдолд шинэ хувьцаа эзэмшигчдийн төлөөллийн саналыг тусгаж, ТУЗ-ийн анхны хурлаар эцэслэн батлахаар ажилласан байна.

**Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журам**

Хорооны 2015 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 443 тоот тогтоолоор батлагдсан Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журмаар Үнэт цаас гаргагчийн хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдэд компанийн үйл ажиллагааны талаарх болон хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг тогтмол хүргэх, уг мэдээллийн төрөл, хэлбэр, давтамж, мэдээллийн ил тод байдлыг хангах, нийтэд хүргэх, нэгдсэн нэг мэдээллийн урсгалтай байх, түүнийг хэрэгжүүлэх, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулна.

Үнэт цаас гаргах үйл ажиллагаанд холбогдох журмын дараах зохицуулалтууд байна. Үүнд:

- Хагас жилийн болон жилийн үйл ажиллагааны хугацаат тайланг нийтэд мэдээлэх хэлбэр, хугацаа;

СЗХ 2019.04.24
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2019-03-26
TDB CAPITAL TDS CAPITAL LLC
"ИНВЕСКОР ББСБ" ХХК InvesCore УЛААНБААТАР ХОТ

- Компанийн ТУЗ болон гүйцэтгэх удирдлага нь хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдад компанийн бизнесийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, түүний эдийн засгийн үзүүлэлт, өмч хөрөнгийн болон удирдлага зохион байгуулалтын бүтэцтэй холбоотой мэдээллийг тухай бүр нийтэд мэдээлэх;
- Нийтэд мэдээлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх, мэдээллийг нийтэд хүргэхэд тавигдах хязгаарлалт, хариуцлагын тухай.

Үнэт цаас гаргагч нь олон нийтэд үнэт цаас санал болгон гаргах ажиллагаа амжилттай болсон тохиолдолд компанийн талаарх шаардлагатай мэдээллийг тус журмын дагуу нийтэд тогтмол хүргэх үүрэг хүлээнэ.

**Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам**

Хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 тоот тогтоолоор батлагдсан Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журмаар хувьцаат компанийн хувьцаа эзэшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлын зарыг хувьцаа эзэмшигчдэд хүргэх, хурлын мэдэгдлийг Хороо болон арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлэх, түүнд хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулна.

Үнэт цаас гаргагч нь нээлттэй хувьцаат компани болсон тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурал зохион байгуулах, хувьцаа эзэмшигчдэд хурлын зар хүргэх ажиллагаанд тус журмыг мөрдөж ажиллана.

**Хувьцаат компанийн ногдол ашиг хуваарилалтад хяналт тавих тухай журам**

Хорооны 2003 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн 65 тоот тогтоолоор батлагдсан Хувьцаат компанийн ногдол ашиг хуваарилалтад хяналт тавих тухай журмаар хувьцаат компанийн эрх бүхий байгууллагаас ногдол ашиг хуваарилах тухай шийдвэр гаргах, энэ талаар хувь нийлүүлэгчдэд мэдээлэх, ногдол ашгийг тараах, тайлагнах асуудалд хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулна.

Үнэт цаас гаргагч нь олон нийтэд үнэт цаас санал болгон гаргах ажиллагаа амжилттай болсон тохиолдолд Компанийн ТУЗ нь өөрийн баталсан ногдол ашгийн бодлого, ногдол ашиг хуваарилах журамд заасан нөхцөл бүрдсэнээр хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах шийдвэр гаргах, хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх, ногдол ашиг хуваарилахтай холбоотой ажиллагаанд тус журмыг мөрдлөг болгоно.

**Үнэт цаасны дотоод мэдээлэл, түүнийг эзэмшигчээс үнэт цаасны зах зээл дээр явуулах үйл ажиллагааны тухай журам**

Хорооны 2014 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 05 тоот тогтоолоор батлагдсан Үнэт цаасны дотоод мэдээлэл, түүнийг эзэмшигчээс үнэт цаасны зах зээл дээр явуулах үйл ажиллагааны тухай журмаар үнэт цаасны зах зээл дэх дотоод мэдээлэлд тооцогдох мэдээллийн агуулга, жагсаалтыг тодорхойлох, түүний эзэмшигчийг тогтоох, дотоод мэдээлэл эзэмшигчийн үнэт цаасны зах зээлд явуулах үйл ажиллагааг зохицуулна.

Үнэт цаас гаргах үйл ажиллагаанд холбогдох журмын дараах зохицуулалтууд байна. Үүнд:

- Дотоод мэдээлэлд хамаарах мэдээлэл, дотоод мэдээллийг эзэмшигчид хамаарах этгээдүүдийг тодорхойлох;
- Дотоод мэдээллийг нийтийн хүртээл болгохоос өмнө дотоод мэдээлэл эзэмшигчид хориглох үйл ажиллагаа;

- Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхэлж буй этгээдийн чиг үүргээ хэрэгжүүлсэнтэй холбоотой дотоод мэдээлэл ашиглан арилжаанд оролцсонд тооцохгүй байх тохиолдлууд;
- Дотоод мэдээллийг нийтэд мэдээлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд дагаж мөрдөх журам, дотоод мэдээллийг нийтэд мэдээлэх этгээдийн эрх, үүрэг, хүлээх хариуцлага.

Үнэт цаас гаргагчийн нэмж гаргаж байгаа үнэт цаасыг олон нийтэд санал болгох хүртэлх буюу эрх бүхий этгээдийн шийдвэр гарах хүртэл Үнэт цаас гаргагчийн дотоод мэдээлэл эзэмшигчд нь журамд заасан үүрэг хүлээх бөгөөд үнэт цаас нэмж гаргах ажиллагаа амжилттай болсон тохиолдолд тус журамд заасан дотоод мэдээллийг нийтэд мэдээлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд дагаж мөрдөх журмыг батлан, мөрдөж ажиллах үүрэг хүлээнэ.

**ҮНЭТ ЦААС ГАРГАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА НЬ БИРЖИЙН ДАРААХ ЖУРМУУДЫН ХОЛБОГДОХ ХЭСГЭЭР ЗОХИЦУУЛАГДАНА. ҮҮНД:**

**Үнэт цаасны бүртгэлийн журам**

Биржийн 2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 2018/01 тоот тогтоолоор батлагдсан Үнэт цаасны бүртгэлийн журмаар Үнэт цаас гаргагчийн хувьцаа, өрийн хэрэгслийг Биржийн үнэт цаасны бүртгэлд бүртгэх, бүртгэлийн ангилал, шалгуурыг тогтоох, үнэт цаасыг нийтэд танилцуулах, үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах, бүртгэлээс хасахтай холбогдсон харилцааг зохицуулна.

Үнэт цаас гаргах үйл ажиллагаанд холбогдох журмын дараах зохицуулалтууд байна. Үүнд:

- Үнэт цаасны бүртгэлд бүртгэх, бүртгэхээс татгалзах
  /Үнэт цаасны бүртгэлд бүртгэх, бүртгэхээс татгалзах, үнэт цаас бүртгүүлэх хэлбэр/;
- Үнэт цаасны бүртгэлийн ангилал, шалгуур
  /Хувьцааны бүртгэлийн I ангиллын шалгуур, хувьцааны бүртгэлийн II ангиллын шалгуур, хувьцааны бүртгэлийн III ангиллын шалгуур, өрийн хэрэгслийн шалгуур, бүртгэлийн шалгуураас чөлөөлөх буюу хөнгөлөх/;
- Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах
  /Хаалттай хүрээнд нэмж үнэт цаас гаргах, нийтэд санал болгон нэмж үнэт цаас гаргах, үнэт цаас гаргагчийг өөрчлөн байгуулах, үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах, үнэт цаасыг хуваах, нэгтгэх, бүртгэлийн ангилал тогтоох/;
- Үнэт цаас гаргагчийн тогтмол биелүүлэх үүрэг;
- Бүртгэлтэй компанид төлөх үйлчилгээний хөлс.

Энэхүү журмыг Биржийн үнэт цаасны бүртгэлд бүртгэгдсэн, бүртгүүлэхээр хүсэлт гаргасан үнэт цаас гаргагч, тэдгээрийн ТУЗ-ийн гишүүн, эрх бүхий албан тушаалтан, нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид болон андеррайтер, аудитор, хуульч, хөрөнгийн үнэлгээчин, үнэт цаас гаргахтай холбоотой хөндлөнгийн шинжээч зэрэг мэргэжлийн зөвлөхүүд дагаж мөрдөнө.

**Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам**

Биржийн 2018 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 15 тоот тогтоолоор батлагдсан Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журмаар Биржид бүртгэлтэй компанийн шинээр болон нэмж гаргасан хувьцаа, өрийн хэрэгслийг анхдагч зах зээлд байршуулах, хуваарилалт хийх, арилжих үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шударга, ил тод, шуурхай явуулахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

СЗХ 2019.04.24 он сар өдөр БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2019-03-26

**Арилжааны журам**

Биржийн 2017 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 2017/08 тоот тогтоолоор өөрчлөн батлагдсан Арилжааны журмаар Биржийн үнэт цаасны арилжааны төрөл, хэлцэл хийгдэх нөхцөл, арилжааг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

Арилжааны журамд Биржид бүртгэлтэй компаниудын арилжаа хийгдэхтэй холбоотой захиалгын төрөл, нөхцөл, арилжаа явагдах шатлал, арилжааны өмнөх үе, нээлтийн дуудлага арилжаанд захиалга оруулах, энгийн арилжаа, багцын арилжаа, бүгдийг нь биелүүлэх эсхүл үл биелүүлэх дуудлага арилжааны захиалгын сан, захиалгыг өөрчлөх, цуцлах, арилжааны хаалтын үе, зах зээлийн мэдээллийг нийтлэх, түгээх, хаалтын дараах үе, арилжааг түр зогсоох, хадгаламжийн программын мэдээллийг шинэчлэх зэрэг харилцааг нарийвчлан тусгасан байна.

**Бүртгэлтэй компаниудаас цахим хэлбэрээр мэдээлэл ирүүлэх заавар**

Биржийн 2017 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр батлагдсан Бүртгэлтэй компаниудаас цахим хэлбэрээр мэдээлэл ирүүлэх заавраар Биржид бүртгэлтэй компаниуд нь Биржтэй байгуулсан хамтран ажиллах гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу үнэт цаасны үнэ ханшид нөлөөлөх мэдээллийг ил тод болгох, компаниудаас ирүүлэх мэдээллийн төрөл, жагсаалтыг тогтоох, түүнийг компаниудаас цахим хэлбэрээр илгээх, хүлээн авах, хянах, боловсруулах, хадгалах, олон нийтэд мэдээллийг хүргэхтэй холбоотой харилцааг зохицуулна.

ТИ ДИ БИ КАПИТАЛ ҮЦК ХХК TDB CAPITAL LLC
"ИНВЕСКОР ББСБ" ХХК InvesCore УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2019.04.24 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2019-03-26
БҮРТГЭВ-02

# Эрсдэлийн удирдлага



TDB CAPITAL LLC

InvesCore
УЛААНБААТАР ХОТ

СЗХ 2019.04.24 он сар өдөр БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2019-03-26 БҮРТГЭВ-02

## 7.1 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТАД ХАРГАЛЗАХ НӨХЦӨЛ БА ЭРСДЭЛИЙН ХҮЧИН ЗҮЙЛ

**Хууль, эрхзүйн орчин, хяналт зохицуулалттай холбоотой эрсдэл**

Үнэт цаас гаргагч нь Монгол Улсын Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Компанийн тухай хууль, Иргэний хууль болон холбогдох бусад хууль, тогтоомжоос гадна Хорооны “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам, заавар”, “ББСБ-ын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”, “ББСБ-ын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам” болон холбогдох бусад журам, зааврыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгож ажилладаг. Эдгээр хууль, тогтоомж, дүрэм, журамд эрх бүхий байгууллагууд банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх томоохон өөрчлөлт оруулах нь хууль, эрхзүйн эрсдэлийг авчирна. Тухайлбал, арилжааны банкуудын иргэдийн хэрэглээний зээлийн өр, орлогын харьцааг 70 хувиас давуулахгүй байх хязгаарлалтыг банкуудад бий болгосон нь тухайн салбарын хэрэглээний зээлийн багцад шууд нөлөөлөл авчирсан. Мөн, банкуудын зээлийн хүүгийн дээд хязгаарыг тогтоох тухай яриа, хэлэлцүүлэг, хуулийн төсөл сүүлийн жилүүдэд идэвхтэй өрнөж байгаа нь банк бус санхүүгийн салбарт нөлөөлөх эрсдэлтэй байна. Түүнчлэн, Банк бус санхүүгийн байгууллагын үндсэн үйл ажиллагаа болох зээл олгох үйл ажиллагааны хүрээнд хөрөнгө барьцаалж зээл олгодог бөгөөд зээлдэгч зээлийн гэрээний үүргээ гүйцэтгээгүй тохиолдолд зээлийн үүргийг барьцаагаар хангуулахаар Шүүхэд нэхэмжлэл гаргах ажиллагаа явагддаг, мөн Шүүхийн шийдвэр нэхэмжлэгчийн талд гарсан ч зээлдэгч, барьцаалуулагч шийдвэрийг сайн дураар биелүүлээгүй тохиолдолд шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх ажиллагааг хийлгүүлэх шаардлагатай болдог бөгөөд энэ бүх үйл ажиллагаанд цаг хугацаа их шаардагдана. Энэхүү үйл ажиллагааны явцад барьцааны зүйл үнэ цэнээ алдах эрсдэл бий болж болно.

**Макро эдийн засгийн эрсдэл**

ОУВС-гийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд манай улсад олон улсын байгууллага, хандивлагч орнуудаас нийтдээ 5.5 тэрбум орчим ам.долларын санхүүжилтийг олгохоор төлөвлөсөн бөгөөд уг эх үүсвэрийг төсвийн нөхцөл байдлыг сайжруулахаас гадна төлбөрийн тэнцлийн алдагдлыг бууруулахад зарцуулахаар төлөвлөсөн. Тус хөтөлбөрийн хүрээнд макро эдийн засгийн орчин тогтворжин, дунд хугацаанд төлбөрийн тэнцлийн эрсдэл бага байх хүлээлттэй байна. Түүнчлэн уул уурхайн болон дэд бүтцийн томоохон төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилттэй холбоотойгоор импортын хэмжээ өсөхөөс гадна дунд хугацаанд зээлийн үйлчилгээний төлбөр нэмэгдэхээр хүлээгдэж байна.

Олон улсын зах зээл, ялангуяа түүхий эдийн зах зээл болон экспортын нөлөөлөл нь гадаад хүчин зүйлийн эрсдэл болох бол дотоодын эдийн засагт хөтөлбөрийн хэрэгжилт зогсох, ам.долларын санхүүжилтүүд хойшлох, гадаадын шууд хөрөнгө оруулалт буурах, төсвийн төлөвлөөгүй зардал, гадаад өрийн дарамт, төлбөрийн тэнцлийн алдагдал нэмэгдэх зэрэг нь урт хугацааны эдийн засгийн бүтцийн эмзэг байдалд нөлөөлөх, цаашлаад макро эдийн засгийн суурь нөхцөлийг бууруулах эрсдэлтэй. Эдийн засгийн нөхцөл байдал муудах нь ханшийн тогтворгүй байдлыг бий болгох, иргэдийн худалдан авах чадварыг бууруулах, инфляцийн түвшин өсөхөд нөлөөлөхөөс гадна аж ахуйн нэгжүүдийн бизнесийн үйл ажиллагаа, мөнгөн урсгал, санхүүгийн нөхцөлд нөлөөлж энэ нь банк бус санхүүгийн байгууллагуудын зээлийн багцын өсөлт, чанарт сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй.

**Салбарын эрсдэл**

Монгол Улсын банк бус санхүүгийн салбарт 540 гаруй аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаа явуулж байгаа нь хамгийн их өрсөлдөөнтэй зах зээлийн нэгд тооцогддог. Тус салбарт

TDB CAPITAL LLC
"ИНВЕСКОР ББСБ" ХХК InvesCore УЛААНБААТАР ХОТ

сүүлийн үед уламжлалт бүтээгдэхүүн, үйлчилгээнээс гадна финтект суурилсан болон хосолмол бүтээгдэхүүн үйлчилгээг банк бус санхүүгийн байгууллагууд нэвтрүүлж эхэлснээр үйлчилгээг харилцагчдад улам хүртээмжтэй болоход хүргэж байна. Түүнчлэн, банкны салбараас финтект суурилсан үйлчилгээг харилцагчид үзүүлэхээр ажиллаж эхэлж буй нь тус салбарын зах зээлд томоохон өрсөлдөөнийг бий болгох, энэ нь зээлийн багц, хүү, ашигт ажиллагаанд нөлөөлөх эрсдэлтэй.

**Зээлийн эрсдэл**

Банк бус санхүүгийн байгууллагуудын хувьд бизнесийн үндсэн эрсдэл нь зээлийн эрсдэл байдаг. Зээлдэгч зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ бүхэлд нь эсвэл хэсэгчилэн биелүүлэхгүй байх, зээлийн үндсэн төлбөр, хүү, алданга болон холбогдох бусад зардлыг тогтоосон хугацаанд төлөхгүй байх тохиодолд зээлийн эрсдэл үүсдэг. Энэхүү эрсдэлтэй нөхцөл байдал үүсэхэд банк бус санхүүгийн байгууллагуудын чанаргүй зээлийн хэмжээ нэмэгдэж улмаар эрх бүхий зохицуулах байгууллага болох Хорооноос тавигддаг шаардлага болох үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллах боломжгүйд хүрдэг. Үүнээс гадна зээлийн эрсдэл нэмэгдэх нь чанаргүй зээлийн багцыг нэмэгдүүлэх, банк бус санхүүгийн байгууллагын санхүүгийн үзүүлэлтүүдэд сөрөг нөлөөлөл үзүүлэх, ашигт ажиллагааг бууруулах эрсдэлтэй.

**Валютын ханшийн эрсдэл**

Үнэт цаас гаргагч нь үйл ажиллагааны үндсэн чиглэл болох зээлийн үйлчилгээг нэмэгдүүлэх зорилгоор итгэлцлийн үйлчилгээний хүрээнд харилцагчидтай Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ байгуулж мөнгөн хөрөнгийг гадаад болон дотоодын зах зээл дээрээс татан төвлөрүүлдэг бөгөөд мөнгөн хөрөнгийг төгрөгөөр болон гадаад валют болох ам.доллар болон иенээр хүлээн авдаг тул төгрөг, ам.долллар, иенийн ханшийн эрсдэл нь Үнэт цаас гаргагчид учирч болох эрсдэл болно.

**Хүүгийн эрсдэл**

Үнэт цаас гаргагч нь голчлон зээл болон итгэлцлийн үйлчилгээний өглөгөөр санхүүжилтийн эх үүсвэрээ бүрдүүлдэг бөгөөд зээлийн хүү болон итгэлцлийн үйлчилгээний өртөг нэмэгдэх нь Компанийн хувьд хүүгийн эрсдэлийг бий болгоно. Ийнхүү эрсдэлтэй нөхцөл байдал үүсэхэд зээлийн бүтээгдэхүүнээ зах зээлд өрсөлдөхүйц түвшинд байлгах Компанийн боломж хязгаарлагддаг. Үүнээс гадна компанийн зээлийн жинлэсэн дундаж хүүг бууулгах замаар багцын чанар, эргэлтийг сайжруулахгүй байх нь хүүгийн эрсдэлийг нэмэгдүүлэх боломжтой.

**Хөрвөх чадварын эрсдэл**

Харилцагч өндөр дүнтэй зээл авах хүсэлт гаргасан тохиолдолд олголт хийх бэлэн мөнгөний нөөцгүй байх нь банк бус санхүүгийн байгууллагын боломжит эрсдэл юм. Үүнээс гадна зээлийн эргэн төлөлт, актив, пассивын хугацааны зөрүүгээс хамаарч хөрвөх чадварын эрсдэл гарч болзошгүй.

**Эх үүсвэрийн эрсдэл**

Одоогийн эдийн засгийн орчин, нөхцөл байдлаас хамаарч банк бус санхүүгийн байгууллагууд нь өөрийн хөрөнгө, итгэлцлийн үйлчилгээ болон банк, санхүүгийн байгууллагаас татсан зээлээр эх үүсвэрээ бүрдүүлж байгаа бөгөөд эх үүсвэр татах боломж хязгаарлагдмал байна. Энэ тохиолдолд эх үүсвэрийн зардал нэмэгдэх, өндөр хүүтэй богино хугацаатай эх үүсвэр татах боломж нь компанийг бизнест эрсдэл бий болгож болно.

**Үйл ажиллагааны эрсдэл**

Байгууллагын дотоод бүтэц, зохион байгуулалт, зээлийн бодлого, зээлийн үйл ажиллагааны журам, зээл олгох аргачилэл, зээл олголтын үйл явц, зээлийн эдийн засагчийн мэдлэг



СЗХ 2019.04.24 сар өдөр БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2019-03-26
ТИ ДИ БИ КАПИТАЛ ҮЦК ХХК TDB CAPITAL LLC
"ИНВЕСКОР ББСБ" ХХК InvesCore УЛААНБААТАР ХОТ

чадвар, туршлагаас хамаарч чанаргүй зээл гарах, алдаатай гүйлгээ хийгдэх нь үйл ажиллагааны эрсдэл бий болгох боломжтой.

**Мэдээллийн технологи, аюулгүй байдлын эрсдэл**

Цахим халдлага болон дайралт нь ББСБ-уудын мэдээллийн бааз, сүлжээнд тохиолдож болзошгүй томоохон эрсдэлүүдийн нэг юм. Үүний үр дүнд ББСБ-уудын болон харилцагчийн мэдээлэл алдагдах, устах, солигдох, сүлжээ болон программ хангамжид алдаа гарах, цахилгаан тасрах зэрэг эрсдэлүүд бий болдог.

**Нэр хүндийн эрсдэл**

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааг зохицуулах хууль, дүрэм, журам, заавар болон тухайлсан бодлого байхгүй байх, эсвэл уг хууль эрхзүйн баримт бичгүүд нь шаардлага хангахгүй байх, эсвэл холбогдох эрхзүйн баримт бичгүүдийг Компанийн эрх бүхий албан тушаалтан болон ажилтнууд үйл ажиллагаандаа дагаж мөрдөхгүй байх; мэдээлэл, технологийн систем доголдох, ажиллагаагүй болох, харилцагчийн мэдээллийн нууцлал алдагдах, хувь хүний санамсаргүй алдаа, санаатай гэмт хэргийн шинжтэй үйл ажиллагаа болон гадаад хүчин зүйлс нь Компанийн нэр хүндийн эрсдэлд нөлөөлнө.

## 7.2 ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Үнэт цаас гаргагч нь өөрийн удирдлагын тогтолцоо, ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо, эрсдэлийн удирдлагын хороо, дотоод хяналтын алба болон зээлийн хороогоороо дамжуулан компанийн үйл ажиллагаанд учирч болох гадаад, дотоод эрсдэлийг тодорхойлох, сэргийлэх, эрсдэлийг бууруулах, хариу арга хэмжээ авах талаар эрсдэлийн удирдлагын бодлого, дотоод хяналтын журам, аудитын хорооны журам, эрсдэлийн удирдлагын хорооны журам болон зээлийн хорооны журмын хүрээнд тодорхойлогдсон үйл ажиллагааг хэрэгжүүлж, хяналт тавин ажилладаг.

Зураг 59. Эрсдэлийн удирдлагын бүтэц




**Төлөөлөн удирдах зөвлөл**

Компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын дагуу ажиллаж, компанийн бодлого, зорилтыг тодорхойлох, тогтвортой, ашигтай үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлэхтэй холбогдуулан ТУЗ-өөс тогтоол шийдвэр гаргах, тэдгээрийн биелэлтэд хяналт тавих, хэрэгжилтийг хангуулан ажилладаг.

СЭЗ
2019 .04. 24
БҮРТГЭВ
№ 01



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2019-03-26
БҮРТГЭВ-02

**Дотоод хяналтын алба**

Үнэт цаас гаргагчийн дотоод хяналтын алба нь дотоод хяналтын журмын дагуу ажиллаж, Компанийн үйл ажиллагаа, үзүүлж байгаа үйлчилгээ нь холбогдох хууль журамд нийцэж байгаа эсэхэд хяналт тавих, зөрчил, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хяналтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, байгууллагын үйл ажиллагааг сайжруулах талаар зөвлөмж гаргах, хэрэгжилтийг хангуулах, зөрчил дахин давтагдахаас сэргийлэх болон гэм буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэн ажилладаг.

**Аудитын хороо**

Компанийн Аудитын хороо нь Хувьцаа эзэмшигчид болон ТУЗ-д компанийн дотоод аудит, хөндлөнгийн аудит, дотоод хяналтын систем, эрсдэлийн удирдлага, санхүүгийн тайлан, ёс зүйн дүрэм, хууль журмын хэрэгжилтийн байдалд үнэлгээ өгөх, дүгнэлт гаргах, аудитын үйл ажиллагааны үр дүнг Хувьцаа эзэмшигчид болон ТУЗ-д мэдээлэх, компанийн удирдлага, зохион байгуулалтын бүх түвшинд байгууллагын сайн засаглалын тогтолцоог бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлдэг.

**Эрсдэлийн удирдлагын хороо**

Компанийн Эрсдэлийн удирдлагын хороо нь Компанийн үйл ажиллагаа, санхүү, хууль эрхзүйн гол эрсдэлүүдийг тодорхойлох болон хянах ба Компанийн удирдлагын зүгээс эрсдэлийг тодорхойлох, үнэлгээ хийх, эрсдэлийг бууруулах, тодорхой хугацаанд хянах явцад баримтлах удирдамж, бодлогыг боловсруулан ажилладаг. Дотоод хяналт, санхүүгийн тайлан, эрсдэлийн удирдлагын системийн үр дүнгийн талаарх удирдлагын болон дотоод аудиторын тайланд үнэлэлт, дүгнэлт өгдөг.

**Гүйцэтгэх захирал**

Гүйцэтгэх захирал нь Компанийн тухай хууль, холбогдох хууль, дүрмийн хүрээнд компанийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, аж ахуйн менежментийг боловсронгуй болгох, техник технологийг шинэчлэх, тухайн жилийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг биелүүлж, бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний чанарыг өндөр түвшинд хүргэж, ажиллагсдын нийгмийн асуудлыг оновчтой шийдвэрлэж ажилладаг.

**Зээлийн хороо**

Компани нь зээлийн үйл ажиллагааны бодлого, журамд зааснаар зээлийн бүтээгдэхүүний нөхцөл, зээлийн асуудал шийдвэрлэх үндсэн нэгж болох зээлийн хороотой байна. Зээлийн хороо нь эрх үүргийнхээ хүрээнд эрсдэлийн сангаас хаах зээлийн саналыг хэлэлцэн шийдвэрлэх, нэг зээлдэгчид олгох зээлийн нөхцөлийг тогтоох, сар бүрийн зээлийн олголтын хэмжээг батлах, зээлийн багцын чанар, байршуулалт, эрсдэлийн түвшинг хэлэлцэх зэрэг асуудлуудыг шийдвэрлэж ажилладаг.

## Эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө

**Хууль, эрхзүйн орчин, хяналт зохицуулалттай холбоотой эрсдэлийн удирдлага**

Үнэт цаас гаргагч нь Хороноос ББСБ-ын үйл ажиллагаа явуулахад тавьдаг шаардлагыг бүрэн хангаж, Хорооны 2016 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн 159 тоот тогтоолоор олгогдсон "Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх" тусгай зөвшөөрөлтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

"Инвескор ББСБ" ХХК нь Хорооны 2016 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн 147 тоот тогтоолоор батлагдсан "ББСБ-ын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам"-ын дагуу зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж ажилладаг ба холбогдох тайланг Хороонд тогтмол хүргүүлдэг.

TDB CAPITAL LLC



InvesCore
УЛААНБААТАР ХОТ

Үнэт цаас гаргагч нь Хорооны дарга болон Сангийн сайдын 2015 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн "ББСБ-ын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж , зарцуулах журам"-д заасны дагуу зээлийн багцыг ангилж, тогтоосон хувиар эрсдэлийн сан байгуулж ажилладаг.

2017 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн ХЭХ-ийн А/11 тоот шийдвэрээр Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 4.1 тэрбум төгрөгөөр, 2019 оны 01 дүгээр сарын 31-ны өдрийн ХЭХ-ын А/01 тоот шийдвэрээр Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг хуримтлагдсан ашгаас 7.7 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, нийт 13.8 тэрбум төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй болсон.

**Макро эдийн засгийн байдлаас хамаарсан эрсдэлийн удирдлага**

Үнэт цаас гаргагч нь Компанийн макро эдийн засгийн байдлаас хамаарсан эрсдэлд өртөмтгий байдлыг бууруулахын тулд зээлдэгчийн бааз суурийг нэмэгдүүлэх, хүүгийн түвшинг бууруулах, шинэ бүтээгдэхүүн хөгжүүлж, зах зээлд нэвтрүүлэх замаар тогтвортой орлогын суурийг бий болгон ажиллахыг зорьдог.

**Зээлийн эрсдэлийн удирдлага**

Компанийн зүгээс бизнесийн үндсэн эрсдэл болох зээлийн эрсдэлийг бууруулахын тулд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна. Үүнд:

- Зээлийн үйл ажиллагаанд бүрэн автоматжуулсан Smart-LOS системийг ашигладаг болсон;
- Зээлийн явцын хяналтыг ухаалаг системийн тусламжтайгаар тогтмол хугацаанд автоматаар хийдэг болсон;
- Бизнес эрхлэгчдэд зориулсан зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээг нэвтрүүлсэн;
- Чанаргүй зээлийн ангилалд шилжсэн зээл тус бүр дээр дэлгэрэнгүй судалгаа, шинжилгээ хийж, шалтгааныг тодруулан, засаж сайжруулах арга хэмжээ авдаг.

**Валютын ханшийн эрсдэлийн удирдлага**

Үнэт цаас гаргагч нь валютын ханшийн эрсдэлээс сэргийлэхийн тулд санхүүжилтийн гол эх үүсвэрүүдээ төгрөгт шилжүүлэхдээ хэджинг хийдэг. Валютаар илэрхийлэгдсэн эх үүсвэрийн позицоо судалж, валютын бага хүүтэй зээл гаргах замаар ханшийн эрсдэлийг тэнцвэржүүлж ажилладаг.

**Хүүгийн эрсдэлийн удирдлага**

Компани нь өөрийн хуримтлуулсан туршлага, хөрөнгө оруулагчидтай тогтоосон бат бөх сайн харилцаандаа тулгуурлан Япон Улсаас итгэлцлийн үйлчилгээний гэрээний хүрээнд урт хугацаатай, хямд өртөгтэй санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэх бүрэн боломжтой юм.

**Хөрвөх чадварын эрсдэлийн удирдлага**

Үнэт цаас гаргагч нь Компанийн мөнгөн урсгалыг тогтмол төлөвлөж, хяналт тавин ажилладаг бөгөөд Зээлдэгчдээс зээлийн олголт хийгдэх хуваарийг урьдчилан гаргуулж авдаг. Хорооноос мөрдлөг болгодог ББСБ-ын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг үйл ажиллагаандаа хэвшүүлэн хангаж ажиллаж байна. Мөн, арилжааны банкнуудад зээлийн эрх нээлгэх замаар хөрвөх чадварын эрсдэлээс сэргийлж ажилладаг.

**Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлага**

Компани нь үйл ажиллагааны эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор доор дурьдсан арга замуудыг авч хэрэгжүүлж байна. Үүнд:

- Зээл олголт болон зээлийн шийдвэр гаргахад хүний хүчин зүйлээс шалтгаалан гардаг механик алдааг бууруулахын тулд зээлийн судалгааны бүрэн автомат систем нэвтрүүлсэн;
- Мөн зээлийн судалгаа, шийдвэр гаргах явцад байнгын үнэлгээ өгч, шаардлагатай шинэчлэлийг түргэн шуурхай хийж ажиллаж байна;
- Төрийн мэдээллийн ХУР системийг ашигладаг болсноор харилцагчийн зүгээс хуурамч бичиг баримт бүрдүүлэх эрсдэлийг бууруулсан;
- Компанийн дотоод хяналтын алба нь сар бүр зээлийн олголт, явцын хяналтад дүн шинжилгээ хийдэг бөгөөд тухайн асуудал бүр дээр үндсэн шалтгааныг олж тогтоон, дүрэм журамд заасны дагуу арга хэмжээ авч ажилладаг.

**Мэдээллийн технологийн аюулгүй байдалтай холбоотой эрсдэлийн удирдлага**

Үнэт цаас гаргагч нь өөрийн сүлжээ, мэдээллийн баазын аюулгүй байдлыг хангах, хадгалах, дээшлүүлэх зорилтын хүрээнд олон улсын стандартыг нэвтрүүлэхээр ажиллаж байна. Тухайлбал үүлэн технологийн шийдэл болох Office 365-ыг нэвтрүүлж, дотоод зохион байгуулалтыг Active Director-ын удирдлагаар бүрэн хангаж, хэрэглэгчийн төхөөрөмж бүр дээр Device lock системийг суулган мэдээллийн аюулгүй байдалд анхаарал тавьж ажиллана. Гадны халдлагаас бүрэн хамгаалагдсан Firewall, Antivirus хамгаалалтын системийг нэвтрүүлэхээс гадна серверийг үүлэн технологид суурилж, хэд хэдэн газар давхар хадгалах замаар мэдээллийн аюулгүй байдалд анхаарч ажиллана. Мөн мэдээллийн аюулгүй байдлын журмын хүрээнд ажилтнуудад мэдээллийн аюулгүй байдлын тухай сургалтыг тогтмол хийж хэвшүүлээд байна.

**Нэр хүндийн эрсдэлийн удирдлага**

Компанийн үйл ажиллагаатай холбоотой дүрэм, журам, зааврuудыг холбогдох хууль тогтоомжийн шаардлагад нийцүүлэн тухай бүр нь боловсруулж, эрх бүхий этгээдээр баталгаажуулан, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилладаг. Компанийн зүгээс мэдээллийн технологийн аюулгүй байдалтай холбоотой асуудлыг чухалчилж авч үздэг.



# Үнэт цаасны танилцуулга

TDB CAPITAL LLC
"ИНВЕСКОР БЕСІІ" ХХК
InvesCore
УЛААНБААТАР ХОТ

## 8.1 ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

| | |
|---|---|
| Үнэт цаас гаргагч | "Инвескор ББСБ" ХХК |
| Бүртгэл | Монголын хөрөнгийн бирж |
| Самбар | III ангилал |
| Үнэт цаасны төрөл | Энгийн хувьцаа |
| Нэрлэсэн үнэ | 227 төгрөг |
| Зарласан хувьцааны тоо | 82,000,000 ширхэг |
| Гаргасан хувьцааны тоо | 60,968,730 ширхэг |
| Нийтэд санал болгож буй хувь | 15% |
| Нэмж гаргах хувьцааны тоо | 10,759,188 ширхэг |
| Нийтэд санал болгосны дараах хувьцааны тоо | 71,727,918 ширхэг |
| Үнэт цаасны арилжаа явуулах арга | Захиалгын бүртгэлийн арга |
| Стратегийн хөрөнгө оруулагчид санал болгох нөхцөл | |
| Санал болгох хэмжээ | ▪ Нэмж гаргах хувьцааны 85% буюу 9,145,310 ш |
| Санал болгох үнэ | ▪ Дээд үнэ 1,750 төгрөг<br>Доод үнэ 1,650 төгрөг |
| Нэмэлт нөхцөл | ▪ Стратегийн хөрөнгө оруулагч нь хоёрдогч зах зээлийн арилжаа нээгдсэнээс хойш 6 сарын хугацаанд хувьцаагаа арилжаалахгүй байх үүрэг хүлээх нөхцөлийг хүлээн зөвшөөрсөн, стратегийн хөрөнгө оруулагчид санал болгох үнийн түвшинд 100,000,000 (нэг зуун сая) төгрөгөөс дээш үнийн дүн бүхий хувьцаа захиалах |
| Олон нийтэд санал болгох нөхцөл<br>Санал болгох хэмжээ<br>Санал болгох үнэ | ▪ Нэмж гаргах хувьцааны 15% буюу 1,613,878 ш<br>▪ Дээд үнэ 1,650 төгрөг<br>Доод үнэ 1,550 төгрөг |
| Татан төвлөрүүлэх хөрөнгийн<br>Доод хэмжээ<br>Дээд хэмжээ | 17.6 тэрбум төгрөг<br>18.7 тэрбум төгрөг |
| Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт | Зээлийн хөрөнгийг нэмэгдүүлэх |
| Үндсэн андеррайтер | "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК |
| Туслах андеррайтер | "Инвескор Капитал ҮЦК" ХХК |
| Андеррайтерийн үүрэг | Хөрөнгө оруулагчид тухайн үнэт цаасыг танилцуулах замаар түүнийг худалдахад шаардлагатай бүх хүчин чармайлт гаргах |

## 8.2 ҮНЭТ ЦААС ГАРГАХ ТУХАЙ ШИЙДВЭР

### Хувьцаа эзэмшигчийн шийдвэр

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2.2 дах заалт, 62 дугаар зүйлийн 62.1.3, 62.1.8 заалтууд, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, Компанийн Дүрмийн 7 дугаар зүйлийн 7.2.13 дах заалт болон “Эс Ай Би Жэй Капитал” ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн, Үнэт цаас гаргагчийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2019 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн А/03 тоот шийдвэрээр Компани хувьцаа нэмж гарган, Монголын хөрөнгийн биржээр дамжуулан нийтэд санал болгох замаар компанийн хэлбэрийг хувьцаат компани болгохоор шийдвэрлэсэн байна.

Тус тогтоолоор Компанийн одоогийн гаргасан 60,968,730 ширхэг энгийн хувьцаан дээр нэмж, зарласан энгийн хувьцаанаас нэг бүр нь 227 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 10,759,188 ширхэг энгийн хувьцааг буюу нийт гаргасан хувьцааны 15 хувийг анх удаа нийтэд нээлттэй арилжаалахаар нэмж гаргахаар шийдвэрлэжээ. Компанийн одоогийн хувьцаа эзэмшигч болох “Эс Ай Би Жэй Капитал” ХХК нь нэмж гаргах хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах давуу эрхээ хэрэгжүүлэхээс татгалзахаар шийдвэрлэсэн.

### Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол

Компанийн тухай хуулийн 43 дугаар зүйл, 55 дугаар зүйлийн 55.1, 55.2, 55.6 дахь хэсэг, Компанийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4.3 дахь заалт, Компанийн хувьцаа эзэмшигчийн хурлын шийдвэр болон хараат бус үнэлгээний байгууллагын дүгнэлтийг үндэслэн, Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 3 дугаар сарын 01-ний өдрийн А/12-Т тоот шийдвэрээр Компанийн нэмж гаргах хувьцааны үнийг дараах байдлаар тогтоосон байна.

Компанийн нэмж гаргах хувьцаанаас стратегийн хөрөнгө оруулагчид 9,145,310 ширхэг хувьцааг захиалгын бүртгэлийн аргаар доод үнийг 1,650 төгрөг, дээд үнийг 1,750 төгрөгөөр санал болгох, олон нийтэд 1,613,878 ширхэг хувьцааг захиалгын бүртгэлийн аргаар доод үнийг 1,550 төгрөг, дээд үнийг 1,650 төгрөгөөр санал болгохоор тус тус тогтоожээ.

Мөн анхдагч зах зээлийн арилжаагаар нийтээс татан төвлөрүүлэх хөрөнгийн доод хэмжээг 17,591,272,400 төгрөг байхаар тогтоож, хөрөнгө оруулагчдаас хүлээн авсан захиалгын дүн энэ хэмжээнд хүрсэн нөхцөлд үнэт цаасыг анхдагч зах зээлд нээлттэй худалдах ажиллагааг амжилттай болсонд тооцохоор дурьджээ.

## 8.3 ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ӨӨРЧЛӨЛТ

Үнэт цаас гаргагч нь нэмж үнэт цаас гаргахаас өмнөх үеийн байдлаар 82,000,000 ширхэг зарласан хувьцаатай, нэг бүр нь 227 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 60,968,730 ширхэг гаргасан энгийн хувьцаатай, 13.8 тэрбум төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй байна. Компани нийт хувьцааны 15 хувь буюу 10,759,188 ширхэг энгийн хувьцааг нэмж гарган, нийтэд санал болгосноор нийт 71,727,918 ширхэг гаргасан энгийн хувьцаатай болно.

СЗХ БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ 2019-04-26 БҮРТГЭВ-02
TDB CAPITAL LLC
"ИНВЕСКОР ББСБ" ХХК InvesCore УЛААНБААТАР ХОТ

Зураг 60: Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц




Компани нэмж гаргаж буй 10,759,188 ширхэг хувьцааны 85 хувийг стратегийн хөрөнгө оруулагчид, 15 хувийг олон нийтэд санал болгон арилжаалахаар төлөвлөсөн бөгөөд хувьцааны анхдагч зах зээлийн арилжаагаар татан төвлөрүүлэхээр төлөвлөсөн хөрөнгийн доод хэмжээ 17.6 тэрбум төгрөг, дээд хэмжээ 18.7 тэрбум төгрөг буюу дунджаар 18.1 тэрбум төгрөг байхаар байна.

Хүснэгт 40: Нэмж хувьцаа гарган татан төвлөрүүлэх хөрөнгө

| Хөрөнгө оруулагчид | Нэмж гаргах хувьцаанаас санал болгох хувь | Санал болгох хувьцааны тоо | Санал болгох үнэ /төгрөг/ Доод үнэ | Санал болгох үнэ /төгрөг/ Дээд үнэ | Татан төвлөрүүлэх хөрөнгө /төгрөг/ Доод хэмжээ | Татан төвлөрүүлэх хөрөнгө /төгрөг/ Дээд хэмжээ |
|---|---|---|---|---|---|---|
| Стратегийн хөрөнгө оруулагч | 85% | 9,145,310 | 1,650 | 1,750 | 15,089,761,500 | 16,004,292,500 |
| Олон нийт | 15% | 1,613,878 | 1,550 | 1,650 | 2,501,510,900 | 2,662,898,700 |
| **Нийт** | | **10,759,188** | | | **17,591,272,400** | **18,667,191,200** |

Үнэт цаас гаргагч нь нэмж хувьцаа гаргаснаар Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 16.3 тэрбум төгрөг, дүрмийн сан болон НТК-ын хэмжээ 31.4 тэрбум төгрөгөөс 32.5 тэрбум төгрөг болох боломжтой байна.

Хүснэгт 41: Хувь нийлүүлсэн хөрөнгөд гарах өөрчлөлт

| Хувьцаа эзэмшигч | Эзэмших хувь | Нэрлэсэн үнэ | Хувьцааны тоо ширхэг | Хувь нийлүүлсэн хөрөнгө (төг) |
|---|---|---|---|---|
| **Нэмэлт хувьцаа гаргахаас өмнөх хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц** | | | | |
| "Эс Ай Би Жэй Капитал" ХХК | 100% | 227 | 60,968,730 | 13,839,901,710 |
| **Нийт ХНХ** | **100%** | | **60,968,730** | **13,839,901,710** |
| **Нэмэлт хувьцаа гаргасны дараах хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц** | | | | |
| "Эс Ай Би Жэй Капитал" ХХК | 85% | 227 | 60,968,730 | 13,839,901,710 |
| Шинэ хөрөнгө оруулагчид | 15% | 227 | 10,759,188 | 2,442,335,676 |
| **Нийт ХНХ** | **100%** | | **71,727,918** | **16,282,237,386** |
| Нэмж төлөгдсөн капитал | | | Доод хэмжээ | 15,148,936,724 |
| | | | Дээд хэмжээ | 16,224,855,524 |
| **Дүрмийн сан ба НТК-ын хэмжээ** | | | **Доод хэмжээ** | **31,431,174,110** |
| | | | **Дээд хэмжээ** | **32,507,092,910** |

Үнэт цаасны танилцуулга

## 8.4 ҮНЭТ ЦААСААР ГЭРЧЛЭГДЭХ ЭРХ, ҮҮРЭГ

### 8.4.1 ҮНЭТ ЦААС ЭЗЭМШИГЧИЙН ЭРХ

Үнэт цаас эзэмшигч нь Компанийн тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасан хувьцаа эзэмшигчийн дараах эрх эдлэхээс гадна өөрийн эзэмшиж буй үнэт цаасыг хоёрдогч зах зээл дээр чөлөөтэй арилжих, захиран зарцуулах, компанийн дүрэмд заасан бусад эрхийг эдэлнэ. Үүнд:

- Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, хурлаар хэлэлцэж байгаа бүх асуудлаар өөрийн эзэмшлийн хувьцааны тоотой хувь тэнцүүлэн санал өгөх;
- Давуу эрхийн хувьцааны ногдол ашиг төлсний дараагаар Компанийн ТУЗ-өөс тогтоосон хэмжээгээр ногдол ашиг авах;
- Компани татан буугдахад хүрвэл Компанийн тухай хуульд заасан журмын дагуу компанийн өр төлбөрийг барагдуулсны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хувь хүртэх;
- Хувьцаат компанийн энгийн хувьцаа эзэмшигч нь Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйл болон компанийн дүрэмд заасны дагуу компаниас нэмж гаргах хувьцаа, түүнд хамаарах үнэт цаасыг тэргүүн ээлжинд худалдан авах.

Компанийн тухай хуулийн 53 дугаар зүйлд заасанаар хувьцаа эзэмшигчдийн хурлаар доорх асуудлаар шийдвэр гаргахад эсрэг саналтай байсан, эсвэл санал хураалтад оролцоогүй хувьцаа эзэмшигч бүр компанийн дүрэмд заасан үндэслэл, журмаар өөрийн эзэмшиж буй хувьцааг компаниас эргүүлэн худалдан авахыг шаардах эрхтэй. Үүнд:

- Нийлүүлэх, нэгтгэх, хуваах болон хувьцаат компанийг хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон өөрчлөх замаар компанийг өөрчлөн байгуулах;
- Компанийн дүрэмд хувьцаа эзэмшигчдийн эрхийг хязгаарласан нэмэлт, өөрчлөлтийг оруулсан, эсхүл ийм агуулгатай компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг баталсан;
- Компани нь хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлах шаардлагатай их хэмжээний хэлцэл байгуулсан;
- Хувьцаа эзэмшигч дангаараа, эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн энгийн хувьцааны 75 буюу түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа, түүнчлэн төрийн өмчийн эзэмшилд байсан хувьцааны хяналтын багцыг хувьчлан авсан тохиолдолд бусад энгийн хувьцаа эзэмшигч хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах;
- Компанийн дүрэмд заасан бусад тохиолдол.

### 8.4.2 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮҮРЭГ

Үнэт цаас гаргагч нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасны дагуу дараах нийтлэг үүрэгтэй байна. Үүнд:

- Үнэт цаас гаргах тухай шийдвэрийг эрх бүхий байгууллагын хурлаар хэлэлцэн гаргах;
- Үнэт цаасны арилжаатай холбоотой мэдээ, тайланг холбогдох аргачлал, маягтын дагуу үнэн зөв гаргаж, тогтоосон хугацаанд Хороонд хүргэх, нийтэд мэдээлэх;
- Компанийн тухай хуульд зааснаас доошгүй тооны хараат бус гишүүнтэй байх;
- Тохиромжтой этгээдийг эрх бүхий албан тушаалтнаар томилох буюу сонгох;
- Үнэт цаасны танилцуулгад заасан төслийн хэрэгжилт өөрчлөгдсөн тохиолдолд тухай бүр нийтэд болон хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх;
- Хагас жилийн болон Хороонд бүртгэлтэй аудитын байгууллагаар баталгаажуулсан жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан хугацаанд Хороо болон Биржид хүргүүлэх;

- Компанийн үйл ажиллагаа, санхүүгийн байдлын талаарх мэдээллийг Хорооноос тогтоосон журмын дагуу нийтэд мэдээлэх;
- Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийг нийтэд нэн даруй мэдээлж, холбогдох баримт бичиг, мэдээллийг хурал хуралдсанаас хойш ажлын гурван өдрийн дотор Хороо, Биржид хүргүүлэх;
- Үнэт цаасны ханш, арилжааны хэмжээнд мэдэгдэхүйц нөлөөлж болох нөхцөл байдал үүсмэгц энэ тухай нийтэд нэн даруй мэдээлэх;
- Хорооноос баталсан компанийн засаглалын зарчмыг үйл ажиллагаандаа дагаж мөрдөх;
- Хууль, тогтоомжид заасан бусад үүрэг.

Түүнчлэн Хорооны холбогдох заавар журмуудыг мөрдөж ажиллана.

- Үнэт цаас гаргагч нь Хорооноос баталсан “Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журам”-ын дагуу холбогдох мэдээллийг цаг тухайд нь үнэн зөв, агуулгын хувьд хоёрдмол утгагүй, бүрэн гүйцэд нийтэд мэдээлэх;
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулахдаа Хорооноос баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ыг дагаж мөрдөх.

### 8.4.3 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХАРИУЦЛАГА

Компанийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасны дагуу Компани болон хувьцаа эзэмшигч нь дараах хариуцлагыг хүлээнэ. Үүнд:

- Компанийн эд хөрөнгө нь эзэмшиж байгаа эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхээс бүрдэх бөгөөд компани нь эдгээр бүх хөрөнгөөрөө хариуцлага хүлээнэ.
- Компани нь хувьцаа эзэмшигчийн хүлээх үүргийг хариуцахгүй.
- Хувьцаа эзэмшигч нь компанийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд гагцхүү өөрийн эзэмшлийн хувьцааныхаа хэмжээгээр хариуцлага хүлээнэ.
- Дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн хувьцааны 10-аас дээш хувийг эзэмшигч болон компанийн үйл ажиллагааг бусад хэлбэрээр тодорхойлох эрх бүхий этгээдийн буруутай үйл ажиллагааны улмаас компанид учирсан эд хөрөнгийн хохирлыг тухайн этгээд өөрийн хөрөнгөөр компанийн өмнө хариуцна.
- Хувьцаа эзэмшигчийн компанид оруулсан эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх нь хувийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхээс тодорхой зааглагдаагүй бол уг хувьцаа эзэмшигч өөрийн бүх эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхээр компанийн өр төлбөрийг давхар хариуцна.

Компанийн эрх бүхий албан тушаалтан нь Компанийн тухай хуулийн 84.4, 84.5-д заасан үүргээ биелүүлээгүй, удаа дараа зөрчсөнөөс компанид хохирол учруулсан бол учруулсан хохирлыг өөрийн хөрөнгөөр нөхөн төлнө.

СЗХ 2019.04.24 БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2019-03-26 БҮРТГЭВ 02



ТИ ДИ БИ КАПИТАЛ ҮЦК ХХК TDB CAPITAL LLC
"ИНВЕСКОР ББСБ" ХХК InvesCore УЛААНБААТАР ХОТ

## 8.5 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО

### 8.5.1 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАЛТ

Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн зүгээс компанийн үйл ажиллагааны онцлог болон бизнес хөгжлийнхөө эхний үе шатанд байгаа зэргийг харгалзан үзэж, үйл ажиллагаа явуулсан 3 жилийн хугацаандаа ногдол ашиг хуваарилаагүй бөгөөд Компанийн 2019 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/01 тоот Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр Компани хуримтлагдсан ашгаас 7.7 тэрбум төгрөгөөр хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээгээ нэмэгдүүлжээ.

Энэ нь үйл ажиллагаанаас бий болсон ашгийг ногдол ашиг хэлбэрээр хувьцаа эзэмшигчдэд хуваарилахаас илүүтэйгээр компанидаа эргэн хөрөнгө оруулах нь бизнесийн өндөр өсөлтийн мөчлөгт яваа байгууллагын хувьд хувьцаа эзэмшигчиддээ ирээдүйд илүү их өгөөж, үнэ цэнийг бий болгоно гэсэн компанийн хувьцаа эзэмшигчдийн бодлоготой холбоотой юм. Энэхүү зарчим нь санхүүгийн хөшүүрэг өндөртэй санхүүгийн байгууллагын хувьд өөрийн хөрөнгийн хэмжээ их байхын хэрээр санхүүгийн бусад эх үүсвэрийг бий болгох чадамжийг нэмэгдүүлэх, нийт хөрөнгийн хэмжээ, улмаар зээлийн багцын хэмжээг нэмэгдүүлэх замаар ашигт ажиллагааны гүйцэтгэлийг өндөр түвшинд байлгахад эерэгээр нөлөөлж байгаа юм.

Компани энэхүү бодлогынхоо хүрээнд бизнесийн өндөр өсөлтийн үе буюу үйл ажиллагаа явуулж эхэлсэн эхний 5 жилийн хугацаа болох 2016-2020 онуудад ногдол ашиг хуваарилахгүй байх зарчмыг баримталж байгаа бөгөөд 2021 оноос эхлэн ногдол ашиг хуваарилалтын хэмжээг цэвэр ашгийн 5 хувиас эхлүүлэн жил бүр нэмэгдүүлэхээр төлөвлөсөн байна.

### 8.5.2 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО

Компанийн ногдол ашгийн бодлогын баримт бичиг нь Компанийн тухай хууль болон Компанийн засаглалын кодекст нийцүүлэн боловсруулагдсан бөгөөд уг бодлогын төслийг Компанийн ТУЗ-ийн 2019 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн № А/05-Т тоот тогтоолоор баталсан байна. Компани нь нэмж гаргаж буй хувьцааг Хороо болон Биржээс нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгэхийг зөвшөөрч, нээлттэй хувьцаат компани болсны дараа Хувьцаа эзэмшигчдийн анхдугаар хурлаар ногдол ашгийн бодлогоо батлуулахаар төлөвлөж байна.

Компанийн ногдол ашгийн бодлого нь ногдол ашиг хуваарилах нөхцөлийг тодорхойлох, ногдол ашиг хуваарилах тухай шийдвэр гаргах, ногдол ашиг хуваарилах, тайлагнахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

**Ногдол ашиг хуваарилах нөхцөл**

Компани дор дурдсан нөхцөл бүрэн хангагдаж байгаа тохиолдолд ногдол ашиг хуваарилж болно. Үүнд:

- Ногдол ашиг төлсний дараа Компани төлбөрийн чадвартай байх, Хорооноос тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хангаж байх;
- Ногдол ашиг төлсний дараа Компанийн өөрийн хөрөнгө нь давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, татан буулгах үед төлөх дүн, Компанийн дүрэмд заасан хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээний нийлбэрээс илүү байх;
- Компани хувьцаа эзэмшигчдийн шаардлагаар хувьцаагаа эргүүлэн авах нөхцөл байдал үүссэн, өрийн бичгээ эргүүлэн худалдан авах хугацаа болсон бол эдгээр үнэт цаасыг бүрэн эргүүлэн авсан, эсхүл бүрэн худалдан авахад шаардагдах хөрөнгөтэй байх;

- Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэр гаргах өдрийн байдлаарх зээлийн багцын чанар байдал нь Компанийн тогтвортой үйл ажиллагааг хангахуйц байх.

**Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэр гаргах**

Ногдол ашиг хуваарилах шийдвэрийг тухайн жилийн санхүүгийн тайланг хөндлөнгийн аудитын байгууллагаар баталгаажуулан, санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор ТУЗ гаргана. Хэрэв, Компани ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн бол энэ тухайгаа хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд заавал тайлагнах бөгөөд ногдол ашиг хуваарилах боломжгүй байдалд хүрсэн шалтгаан, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай тайлбар өгнө.

**Ногдох ашиг хуваарилах**

Компанийн хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг үндэслэн ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг ТУЗ-өөс гаргах ба ногдол ашиг төлөх хэлбэр, олгох хугацаа, журам нь хувьцаа эзэмшигчдэд аль болох тохиромжтой байна.

Компанийн ТУЗ-ийн ногдол ашиг хуваарилах шийдвэрт дараах зүйлийг тусгана. Үүнд:

- Нэгж хувьцаанд ногдох ногдол ашгийн хэмжээ;
- Ногдол ашиг олгох хэлбэр;
- Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр;
- Ногдол ашиг төлөх өдөр;
- Бусад холбогдох асуудал.

**Тайлагнах**

Компани ногдол ашиг хуваарилсан талаар Нягтлан бодох бүртгэлийн холбогдох журмын дагуу санхүүгийн тайланд үнэн зөвөөр тусгана.

Компани ногдол ашиг хуваарилалтын тайланг Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.14-т заасны дагуу ногдол ашиг хуваарилж дууссан өдрөөс хойш ажлын 15 өдрийн дотор гаргаж, тогтсон хугацаанд Хороо болон Биржид хүргүүлэх бөгөөд хувьцаа эзэмшигчдийн жилийн ээлжит хуралд өмнөх жилийн ногдол ашиг хуваарилалтын тайланг танилцуулна.

## 8.6 ҮНЭТ ЦААСНЫ ҮНЭ ТОГТООСОН ҮНДЭСЛЭЛ

Үнэт цаасны зах зээлд оролцогчид үйлчилгээ үзүүлэх эрх бүхий хөндлөнгийн үнэлгээний байгууллага болох “Гэрэгэ Эстимэйт” ХХК нь Үнэт цаас гаргагчийн бизнесийн үнэлгээг гүйцэтгэж, үр дүнг 2019 оны 02 дугаар сарын 5-ны өдрийн “Хараат бус бизнесийн үнэлгээний тайлан”-аар хүргүүлсэн байна.

Үнэлгээний байгууллага нь Үнэт цаас гаргагчийн хувьцаагаа нийтэд анх удаа санал болгох үйл ажиллагаанд зориулж, тус компанийн 100 хувийн өмчлөлийн үнэ цэнийг үнэлгээний өдрийн байдлаар тодорхойлжээ. Үнэлгээнд ҮОУС-д заасны дагуу үнэлгээний ажлын зорилгод нийцүүлэн зах зээлийн үнэ цэнийн суурийг сонгож, хөрөнгөд суурилсан шинжилгээ болон үнэлгээний зах зээлийн, орлогын арга хандлагуудаар бизнесийн үнэлгээг хийсэн байна.

**Хөрөнгөд суурилсан шинжилгээ**

Хөрөнгөд суурилсан хандлагыг үнэлгээнд хэрэглэхэд тухайн бизнесийн нийт хөрөнгөөс өр төлбөрүүдийг хасах замаар бизнесийн үнэ цэнийг тодорхойлдог. Энэ аргаар үнэлгээ хийхийн

СЗХ
2019 он 04 сар 24 өдөр
БҮРТГЭВ
№ 01



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2019 -03- 26
БҮРТГЭВ 02

тулд үнэлгээний байгууллага нь Үнэт цаас гаргагчийн биет болон биет бус бүх хөрөнгүүд, мөн өр төлбөрийн үзүүлэлтүүдийн зах зээлийн үнэ цэнийг тогтоох замаар цэвэр хөрөнгийн хэмжээг тодорхойлоход цэвэр хөрөнгийн хэмжээ нь 12.6 тэрбум төгрөг байна.

Энэхүү тооцоололд тус компанийн гүүдвил, барааны тэмдэгт, менежментийн ур чадвар зэрэг биет бус хөрөнгүүд ороогүй болно. Харьцуулан судлах ижил төстэй бизнесийн зах зээлийн мэдээлэл хомс үед компанийн ирээдүйн ашигт ажиллагаанд чухал үүрэг гүйцэтгэх эдгээр биет бус хөрөнгийн үнэ цэнийг тооцоолоход бизнесийн нийт үнэ цэнээс бусад хөрөнгийн үнэ цэнийг хасах зарчим дээр тулгуурлан тооцоолол хийх нь оновчтой байдаг. Харин энэ аргачлал нь үнэлгээний ажлыг зорилгын дагуу өгөгдсөн бизнесийн үнэ цэнийг тооцоолох ажилтай давхцаж байгаа тул хөрөнгөд суурилсан аргыг бизнес өмчлөлийн үнэ цэнийг тооцоолоход тохиромжгүй гэж үзжээ.

**Зах зээлийн харьцуулалтын аргаар хийсэн үнэлгээний үр дүн**

Үнэлгээнд хамрагдсан компанитай ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг гадаадын санхүүгийн байгууллагын мэдээлэл нээлттэй, олдоц сайтай бөгөөд Үнэлгээний байгууллага нь жишээ болгон бичил санхүүгийн зах зээл харьцангуй сайн хөгжсөн Балба улсын хөрөнгийн бирж дээр хувьцаа нь арилжаалагдаж буй Үнэт цаас гаргагчтай ойролцоо хэмжээтэй буюу дунджаар 95.1 тэрбум төгрөгийн зах зээлийн үнэлгээтэй санхүүгийн байгууллагуудыг сонгон үзэхэд Үнэ ашгийн үржүүлэгч (P/E) 25.64, Үнэ / дансны үнийн үржүүлэгч (P/B) 2.92 байсан байна. Олон улсын болон Монгол улсын бичил санхүүгийн зах зээлийн хэмжээ, хэрэглэгчийн тоо, хууль эрх зүйн орчин, хэрэглэгчдийн зан төлөв зэрэг нь ялгаатай бөгөөд хэрэв үнэлгээнд олон улсын бичил санхүүгийн компанийн үржүүлэгчийг ашиглах тохиолдолд эдгээр ялгааг судалж, харгалзах тохируулгын коэффициентыг тодорхойлох шаардлагатай. Тохируулгын коэффициент тооцоолох ажил нь субьектив дүгнэлт ихтэй тул бизнесийн үнэлгээг олон улсын бичил санхүүгийн байгууллагуудтай харьцуулан хийх нь учир дутагдалтай гэж үзжээ.

Монгол улсад 2018 оны байдлаар нийт 540 орчим банк бус санхүүгийн байгууллага үйл ажиллагаа явуулж байгаагаас зөвхөн нэг компани буюу "ЛэндМН ББСБ" нь хувьцаагаа Монголын хөрөнгийн бирж дээр гаргасан хувьцаат компанийн хэлбэрээр, бусад нь хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэрээр ажиллаж байна. Түүнчлэн, үнэлгээний тайлангийн өдрийн байдлаар "Ард Кредит ББСБ" нь хувьцаагаа нийтэд анх удаа санал болгох ажиллагаа явуулж байна. Үнэт цаас гаргагчийг "ЛэндМН ББСБ" болон "Ард Кредит ББСБ"-тай харьцуулан тооцсон үнэлгээний үр дүн нь 125,115.9-128,689.6 сая төгрөг байна.

**Хүснэгт 42: Зах зээлийн харьцуулалтын аргаар хийсэн үнэлгээний үр дүн**

| Үнэлгээний арга (сая төгрөг) | Жиших бизнес 1 ЛэндМН | Жиших бизнес 2 Ард Кредит | Инвескор |
|---|---|---|---|
| **Санхүүгийн үзүүлэлт** | | | |
| Нийт орлого | 7,143.3 | 2,960.0 | 11,195.9 |
| Цэвэр ашиг | 2,518.1 | 716.0 | 5,053.5 |
| Эздийн өмч | 13,350.8 | 9,353.0 | 13,893.8 |
| Өр төлбөр | 11,036.2 | 10,813.0 | 25,132 |
| Үнэлгээ | 56,800.0 | 24,554.9 | |
| **Харьцаа үзүүлэлт** | | | |
| Өр төлбөр/Эздийн өмч | 82.7% | 115.6% | 180.9% |
| Нийт хөрөнгийн өгөөж | 10.3% | 3.6% | 12.9% |
| Өөрийн хөрөнгийн өгөөж* | 18.9% | 7.7% | 36.4% |

TDB CAPITAL
TDB CAPITAL LLC
InvesCore

| | | |
|---|---|---|
| Үнэ ашгийн үржүүлэгч (P/E) | 22.6 | 34.3 |
| Үнэ/Дансны үнийн үржүүлэгч (P/B) | 4.3 | 2.6 |
| **Үнэт цаас гаргагчийн үнэлгээ** | | |
| Үнэ ашгийн үржүүлэгчээр (P/E) | 113,992.4 | 173,307.6 |
| Үнэ/Дансны үнийн үржүүлэгчээр (P/B) | 136,239.4 | 84,071.5 |
| **Тооцсон дундаж үнэлгээ** | **125,115.9** | **128,689.6** |

*Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж, "ЛэндМН ББСБ" санхүүгийн тайлан, "Ард Кредит ББСБ"-ийн үнэт цаасны танилцуулга*

**Тухайн тайлант жилийн цэвэр ашгийг өөрийн хөрөнгөд харьцуулсан хэмжээ*

### Орлогын хандлагын аргаар хийсэн үнэлгээний үр дүн

Үнэлгээний байгууллага нь Үнэт цаас гаргагчийн бизнесийн болон санхүүгийн загварт дүн шинжилгээ хийсний үндсэн дээр орлогын хандлагаар хийсэн үнэлгээг Компанийн ирэх 5 жилийн бизнес төлөвлөгөөнд үндэслэн хийж гүйцэтгэжээ. Үнэлгээний зорилго, үнэлгээнд хамрагдсан бизнесийн онцлогийг харгалзан энэхүү үнэлгээний ажилд Ногдол ашиг хорогдуулах (Dividend Discount Model) загварыг ашигласан байна.

Үнэлгээчин нь үнэлгээний төсөөлөлд урт хугацааны бизнесийн бодит өсөлтийг 5.0%, урт хугацааны инфляцийн түвшин 6.0%, хорогдуулах хувийг "Бондын өгөөж+Эрсдэлийн урамшуулал" буюу "Bond yield plus premium approach" аргаар тооцсон 20.5% зэрэг үзүүлэлтийг ашиглан, Компанийн бизнесийн үнэ цэнийг 120,031.4 сая төгрөг байхаар тооцжээ.

### Үнэлгээний үр дүн

Үнэлгээний байгууллага нь дээр дурдсан арга хандлагууд дундаас орлогын хандлагын аргын Ногдол ашиг хорогдуулах загвараар тооцсон үр дүн нь бизнесийн зах зээлийн үнэ цэнийг илүү сайн төлөөлж чадна гэж үзжээ. Үнэт цаас гаргагч нь нэмж хувьцаа гарган, өөрийн хөрөнгөө дунджаар 18.1 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсний дараах байдлаар тооцсон бизнесийн 100% өмчлөлийн үнэ цэнэ нь 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 120,031,357,479 төгрөг, хөрөнгө оруулалтын өгөөжийн дотоод хувийг 60.5% байхаар тооцоолсон байна.

Хүснэгт 43: Үнэлгээний үр дүн

| Үнэлгээний арга | Бизнесийн үнэ цэнэ /сая төгрөг/ |
|---|---|
| Ногдол ашгийг хорогдуулах арга | 120,031.4 |
| Зах зээлийн харьцуулалтын арга | 125,115.9-128,689.6 |
| **Үнэлгээчний сонгосон үнэ цэнэ** | **120,031.4** |

Үнэлгээний байгууллагын тооцоолсон бизнесийн үнэлгээний үр дүнгээр нэгж хувьцааны зах зээлийн үнэ цэнэ 1,673.4 төгрөг байх боломжтой байна. Үнэт цаас гаргагч нь хөндлөнгийн үнэлгээний байгууллагын хараат бус бизнесийн үнэлгээний тайланд үндэслэн нэмж гаргах хувьцаанаас стратегийн хөрөнгө оруулагчид захиалгын бүртгэлийн аргаар санал болгох доод үнийг 1,650.0 төгрөг, дээд үнийг 1,750.0 төгрөгөөр, олон нийтэд санал болгох доод үнийг 1,550.0 төгрөг, дээд үнийг 1,650.0 төгрөг байхаар тус тус тогтоосон байна.

СЗХ
2019 .04. 24
№ 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2019 -03- 26

## 8.7 ҮНЭТ ЦААС ГАРГАН ТАТАН ТӨВЛӨРҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ

Компани нь нийт хувьцааны 15 хувийг буюу 10,759,188 ширхэг энгийн хувьцааг нийтэд санал болгон арилжих замаар дунджаар 18.1 тэрбум төгрөгийн санхүүжилт татахаар төлөвлөсөн. Үнэт цаас гаргагч нь Компанийн дунд хугацааны бизнес төлөвлөгөөний зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд компанийн үйл ажиллагааг өргөжүүлэх, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх зорилгоор нээлттэй хүрээнд нэмж хувьцаа гаргах замаар татан төвлөрүүлэх хөрөнгийг Компанийн үндсэн бүтээгдэхүүн болох зээл олголт, зээлийн үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зарцуулахаар төлөвлөсөн.

**Хүснэгт 44: Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт**

| Зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ | Зарцуулах дүн, сая төгрөг | Эзлэх хувь, % |
|---|---|---|
| Бизнесийн том зээл - ААН | 1,812.9 | 10% |
| Бизнесийн зээл – ЖДҮ эрхлэгч ААН | 2,719.4 | 15% |
| Бизнесийн зээл – ЖДҮ эрхлэгч иргэд | 1,812.9 | 10% |
| Хэрэглээний зээл | 7,251.7 | 40% |
| Автомашины лизингийн зээл | 3,625.8 | 20% |
| Кредит карт | 906.5 | 5% |
| **Нийт** | **18,129.2** | **100%** |

Компани нь нэмэлт хувьцаа гарган хуримтлуулсан хөрөнгийг зээл олголтыг нэмэгдүүлэхэд зарцуулснаар бий болох эдийн засгийн үр ашиг, ач холбогдлын талаарх мэдээлэл нь Үнэт цаасны танилцуулгын 4.2.3 дугаар бүлэг буюу “Орлогын тайлангийн төсөөлөл” хэсэгт тусгагдсан бөгөөд үйл ажиллагааг өргөжүүлэх, стратегийн хэсгийг Үнэт цаасны танилцуулгын 3.5 дугаар буюу “Дунд хугацааны стратеги” хэсэгт дэлгэрэнгүй тусгагдсан болно.

TDB CAPITAL LLC
"ИНВЕСКОР ББСБ" ХХК
InvesCore
NON-BANK FINANCIAL INSTITUTION
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2019 .04р 24 өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2019 -04- 26
БҮРТГЭВ-02

# 8.8 ХУВЬЦААГ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛД САНАЛ БОЛГОХ

## 8.8.1 ХУВЬЦААГ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛД АРИЛЖААЛАХ АРГА ХЭЛБЭР

Үнэт цаас гаргагчийн хувьцаа нь Биржийн хувьцааны бүртгэлийн III ангиллын шалгуурыг хангаж байгаа тул Биржийн "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын дагуу Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.19 дэх хэсэгт тодорхойлсон мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэгчдийн хүрээнд санал болгон арилжаална. Биржийн III ангиллын хувьцааг мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэгч биш этгээд худалдан авч болох бөгөөд энэ тохиолдолд тухайн үнэт цаасыг мэргэжлийн хөрөнгө оруулагчдад санал болгосон болохыг ойлгож шийдвэрээ гаргасан тухай үйлчлүүлж буй брокерийн үйл ажиллагаа эрхлэгч үнэт цаасны компанид бичгээр мэдэгдсэн байна.

Үнэт цаас гаргагч нь хувьцааны анхдагч зах зээлийн арилжааг Биржийн ТУЗ-ийн 2018 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 15 тоот тогтоолоор баталсан "Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам"-ын 2 дугаар бүлэгт заасан "ЗАХИАЛГЫН БҮРТГЭЛИЙН АРГА"-ыг ашиглан нийтэд нээлттэй арилжаална.

Захиалгын бүртгэлийн аргаар хийх арилжаа нь заасан хугацаанд хөрөнгө оруулагчдаас ирүүлсэн захиалгын саналд үндэслэн, үнэт цаас гаргагчаас тогтоосон үнээр арилжих үйл ажиллагааг хэлэх бөгөөд Үнэт цаас гаргагч нь хувьцааг анхдагч зах зээлд санал болгох үнийг дараах байдлаар тогтоосон байна.

Хүснэгт 45: Хувьцааг анхдагч зах зээлд санал болгох үнэ

| Хөрөнгө оруулагчид | Нэмж гаргах хувьцаанаас санал болгох хувь | Санал болгох хувьцааны тоо | Санал болгох үнэ /төгрөг/ | | Татан төвлөрүүлэх хөрөнгө /тэрбум төгрөг/ | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Доод үнэ | Дээд үнэ | Доод хэмжээ | Дээд хэмжээ |
| Стратегийн хөрөнгө оруулагч | 85% | 9,145,310 | 1,650 | 1,750 | 15.1 | 16.0 |
| Олон нийт | 15% | 1,613,878 | 1,550 | 1,650 | 2.5 | 2.7 |
| **Нийт** | | **10,759,188** | | | **17.6** | **18.7** |

## 8.8.2 СТРАТЕГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ

Стратегийн хөрөнгө оруулагч гэдэгт Биржийн "Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам"-ын 3.4 дэх хэсэгт тодорхойлсон үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд давуу талыг бий болгох, үнэт цаасаа 6-аас доошгүй сарын хугацаанд тусгаарлуулах үүрэгтэй хөрөнгө оруулагчийг ойлгох бөгөөд Үнэт цаас гаргагчийн хувьд дараах нэмэлт шаардлагыг хангасан хөрөнгө оруулагчийг ойлгоно. Үүнд:

- Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа нээгдсэнээс хойш 6 сарын хугацаанд хувьцаагаа арилжаалахгүй байх нөхцөлийг зөвшөөрсөн, стратегийн хөрөнгө оруулагчид санал болгох үнийн түвшинд 100,000,000 (нэг зуун сая) төгрөгөөс дээш үнийн дүн бүхий хувьцаа захиалах хөрөнгө оруулагч;

Стратегийн хөрөнгө оруулагчид захиалгын бүртгэлийн аргаар санал болгох хувьцааны үнэ нь 1,650.0-1,750.0 төгрөг байна.

TDB CAPITAL LLC

"ИНВЕСКОР ББСБ" ХХК
InvesCore
УЛААНБААТАР ХОТ

СЗХ 2019.04.24



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2019-03-26
БҮРТГЭВ-02

### 8.8.3 ХУВЬЦААГ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛД БАЙРШУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Үнэт цаас гаргагч нь дараах хуваарийн дагуу үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааг зохион байгуулна.

**Зураг 61: Үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулах хуваарь**




### 8.8.4 ЗОХИЦУУЛАГЧ БАЙГУУЛЛАГЫН ШИЙДВЭР

Үнэт цаас гаргагч нь үнэт цаасаа нийтэд санал болгох үнэт цаасны бүртгэлд бүртгүүлэх хүсэлтийг Бирж болон Хороонд нэгэн зэрэг гаргах бөгөөд уг арилжаа эрхлэх болон зохицуулагч байгууллагууд үнэт цаасыг бүртгэхийг зөвшөөрснөөр үнэт цаасыг олон нийтэд санал болгон арилжаалах боломжтой болно.

Үнэт цаас гаргагч болон андеррайтер нь анхдагч зах зээлийн захиалга авч эхлэхээс ажлын гурваас доошгүй хоногийн өмнө анхдагч зах зээлийн арилжааг эхлүүлэх хүсэлтийг Хороонд гаргах бөгөөд тус зөвшөөрөл олгогдсоноор анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг хүлээн авахад бэлэн болно.

Андеррайтер нь анхдагч зах зээлийн арилжаа явагдаж дууссанаас хойш ажлын гурван өдөрт багтаан арилжааны тайланг Хороонд хүргүүлнэ. Хороо нь уг тайланг хүлээн авч анхдагч зах зээлийн арилжаа амжилттай явагдсан, аливаа зөрчил гараагүй гэж үзвэл үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад өмчлөх эрхийн бүртгэл хийх болон арилжаа эрхлэх байгууллагад үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх зөвшөөрлийг тус тус олгох тухай албан бичгийг ажлын гурван өдөрт багтаан хүргүүлнэ.

### 8.8.5 ОЛОН НИЙТЭД ТАНИЛЦУУЛАХ

Үнэт цаасыг анхдагч зах зээлд санал болгох, арилжаалахыг зөвшөөрсөн Бирж болон Хорооны зөвшөөрөл гарсны дараа үнэт цаасыг нийтэд санал болгох тухай нийтэд мэдээлэх, танилцуулах аяныг зохион байгуулах ажлыг эхлүүлнэ.

- ✓ Үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн оролцогчдод зориулан үнэт цаас гаргагчийн танилцуулга уулзалт зохион байгуулах;

TDB CAPITAL LLC
"ИНВЕСКОР ББСБ" ХХК
InvesCore
УЛААНБААТАР ХОТ

- ✓ Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээллийг хүргэж, олон нийтэд зориулсан танилцуулга уулзалт зохион байгуулах,
- ✓ Хувьцааг олон нийтэд танилцуулахаас өмнө стратегийн хөрөнгө оруулагчдад танилцуулга хийж болно.

### 8.8.6 АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН ЗАХИАЛГЫН БҮРТГЭЛ

Захиалгын бүртгэлийн эхлэх болон дуусах хугацааг Үнэт цаас гаргагч болон андеррайтерууд нь Хорооноос шийдвэр гаргасны дараа Биржтэй хамтран тогтооно.

Үнэт цаасны захиалгын бүртгэлийн ажиллагааг Биржийн анхдагч зах зээлийн арилжааны программаар зохион байгуулах бөгөөд Бирж нь захиалгын бүртгэлийн хугацаанд арилжааны програмд оруулсан үнийн санал арилжаанд оролцогчдод харагдахгүй байх нөхцөлийг бүрдүүлнэ.

Хөрөнгө оруулагч захиалгын бүртгэлийн хугацаанд заасан нөхцөлийг баримтлан, үнэт цаас гаргагчийн санал болгосон доод болон дээд үнийн хязгаарын хүрээнд эсхүл үнэ, тоо заалгүй худалдан авах нийт үнийн дүнг заасан захиалга өгч болно.

Захиалга бүртгэлийн хугацаанд стратегийн хөрөнгө оруулагчдын захиалга хүлээн авах захиалгын сан болон олон нийтээс захиалга хүлээн авах захиалгын сан нь тусдаа байх бөгөөд дараах байдлаар захиалгыг хүлээж авна.

**Стратегийн хөрөнгө оруулагчдаас анхдагч зах зээлийн захиалга авах**

- ✓ Хувьцаа худалдан авах захиалгыг Үнэт цаас гаргагчийн андеррайтерууд хүлээн авна.
- ✓ Стратегийн хөрөнгө оруулагч нь хоёрдогч зах зээлийн арилжаа нээгдсэнээс хойш 6 сарын хугацаанд хувьцаагаа арилжаалахгүй байх үүрэг хүлээх нөхцөлийг хүлээн зөвшөөрсөн, стратегийн хөрөнгө оруулагчид санал болгох үнийн түвшинд 100,000,000 (нэг зуун сая) төгрөгөөс дээш үнийн дүн бүхий хувьцаа захиалах хөрөнгө оруулагч байна.

**Олон нийтээс анхдагч зах зээлийн захиалга авах**

- ✓ Хувьцаа худалдан авах захиалгыг Биржийн гишүүн бүх үнэт цаасны компаниар дамжуулан авна.

### 8.8.7 ҮНЭ ТОГТООХ

Биржийн анхдагч зах зээлийн арилжааны захиалга хаагдсанаас хойш ажлын 3 өдрийн дотор үнэт цаасыг анхдагч зах зээлд арилжих үнийг андеррайтер, үнэт цаас гаргагч нар тухайн үнэт цаасны зах зээлийн үнийн өөрчлөлтөөс үүсч болзошгүй эрсдэл, үнэт цаасны эрэлттэй холбоотой хүчин зүйлсийг бүрэн хэмжээгээр авч үзсэний үндсэн дээр хамтран тогтооно. Уг үнийг тогтоохдоо тухайн үнэт цаасыг худалдан авахаар ирүүлсэн нийт захиалгын жинлэсэн дундаж үнэ, үнэт цаасны борлуулалтаас олохоор төлөвлөсөн хөрөнгийг бүрэн бүрдүүлэх боломжит үнэ, аль болох олон харилцагчдын захиалгыг биелүүлэх боломжит үнэ зэргийг харгалзана.

Хувьцааны үнэ нь стратегийн хөрөнгө оруулагчдын захиалга хүлээн авах захиалгын сан болон олон нийтээс захиалга хүлээн авах захиалгын сан тус бүрт ялгаатай тогтоогдож болно.

### 8.8.8 ХУВААРИЛАЛТ

Хувьцааны хуваарилалт хийх үйл ажиллагааг андеррайтер нь Үнэт цаас гаргагчтай зөвшилцөж, Биржийн "Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам"-ыг баримтална. Хувьцааны хуваарилалт нь Стратегийн хөрөнгө оруулагчдын захиалга хүлээн авах

СЭХ 2019-04-24 БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2019-04-26 БҮРТГЭВ-02
TDB CAPITAL LLC
"ИНВЕСКОР ББСБ" ХХК InvesCore 1116224289 6060354 УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2019 -03- 26
БҮРТГЭВ-02

захиалгын сан болон Олон нийтээс захиалга хүлээн авах захиалгын сан тус бүрээр дараах байдлаар хийнэ.

**Стратегийн хөрөнгө оруулагчдаас авсан захиалгын хуваарилалт**

- ✓ Стратегийн хөрөнгө оруулагчаас хүлээн авсан хувьцааны нийт захиалгын тоо нь стратегийн хөрөнгө оруулагчид санал болгон гаргасан хувьцааны тооноос илүү байх тохиолдолд үнийн ахлах дараалльг баримтлан, хувьцааг арилжих нэг үнийн түвшинг тогтооно.
- ✓ Стратегийн хөрөнгө оруулагчийн хувьцааны хуваарилалтыг андеррайтер болон Үнэт цаас гаргагч хамтран хийнэ.

**Олон нийтээс авсан захиалгын хуваарилалт**

- ✓ Олон нийтээс хүлээн авсан үнэт цаасны нийт захиалгын тоо нь нийтэд санал болгон гаргасан хувьцааны тооноос илүү байх тохиолдолд үнийн ахлах дараалльг баримтлан, үнэт цаасыг арилжих нэг үнийн түвшинг тогтооно.
- ✓ Үнийг тогтоосны дараа тогтоосон үнэ болон түүнээс дээгүүр үнээр өгсөн захиалгуудыг цаг хугацааны дараалаас үл хамаарч захиалсан хувьцааны тоонд хувь тэнцүүлэн хуваарилна.
- ✓ Үнэ, тоо заалгүй худалдан авах нийт үнийн дүнг заасан захиалгыг тухайн үнэт цаасыг арилжих үнийн түвшинд биелүүлж, хуваарилалтыг хийнэ.

### 8.8.9 ХУВЬЦАА ХУДАЛДАН АВАХ ЗАХИАЛГА ӨГӨХ ЗААВАР

Хөрөнгө оруулагч нь Биржид бүртгэлтэй үнэт цаасны компанид үнэт цаасны данс нээлгэж, өөрийн үнэт цаасны дансанд дараах зааврын дагуу хувьцаа худалдан авах мөнгөн хөрөнгө байршуулах ба өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компанид үнэт цаас худалдан авах захиалгаа өгнө.

Зураг 62: Хувьцаа худалдан авах захиалга өгөх заавар




**Мөнгөн хөрөнгө байршуулах**

Үнэт цаас гаргагчийн хувьцааг худалдан авах хүсэлтэй хөрөнгө оруулагч нь өөрийн хүссэн банкаар дамжуулан Арилжааны төлбөр тооцоо дахь өөрийн нэрийн дансандаа мөнгөө байршуулна.

TDB CAPITAL LLC
InvesCore

СЭХ 2019 .04. 24
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2019 -03- 26 БҮРТГЭВ-02

**Хүснэгт 46: Хувьцааны мөнгө байршуулах заавар**

| | |
|---|---|
| Хүлээн авагчийн банк | Арилжааны төлбөр тооцоо |
| Хүлээн авагчийн нэр | Овог, нэр |
| Дансны дугаар | ************ 12 орон бүхий үнэт цаасны дансны дугаар (үйлчлүүлдэг ҮЦК-аас лавлах) |
| Үнийн дүн | Хувьцааны үнэ + шимтгэл |
| Гүйлгээний утга | Хувьцааны мөнгө, [Овог нэр, регистрийн дугаар] |

**Арилжааны шимтгэл**

Үнэт цаас худалдан авагч нь гүйлгээний үнийн дүнгийн тодорхой хувиар тооцсон үйлчилгээний хөлс буюу шимтгэлийг өөрийн сонгосон болон захиалга өгсөн ҮЦК-д төлөх ба уг шимтгэлд эрх бүхий байгууллагууд болон арилжаа эрхлэх байгууллагын шимтгэл багтсан байна. Биржийн гишүүн ҮЦК-уудын шимтгэл нь харилцан адилгүй болохыг анхаарна уу.

**Албан татвар**

Үнэт цаасанд хөрөнгө оруулагч хувь хүн нь “Хувь хүний орлогын албан татварын тухай хууль”-ийн 13.1.3-т заасан орлого (ногдол ашгийн орлого)-ын нийт дүнгээс, 14.1.3-т заасан орлого (хувьцаа, үнэт цаас борлуулсны орлого)-оос худалдаж авсан үнийг хассан зөрүүгээс тус хуулийн 23.1-т заасан хувь хэмжээгээр татвар төлнө.

Үнэт цаасанд хөрөнгө оруулагч хуулийн этгээд буюу аж ахуйн нэгж нь “Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль”-ийн 16.3.1-т заасан “ногдол ашгийн орлого”-ын нийт дүнгээс, 16.8-д заасан “хувьцаа, үнэт цаас борлуулсны орлого”-оос худалдаж авсан үнийг хассан зөрүүгээс энэ хуулийн 17.1, 17.2.1-т заасан хэмжээгээр албан татвар төлнө.

**Валютын ханш**

Үнэт цаасны арилжаа нь Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр хийгдэнэ.

### 8.8.10 ҮНЭТ ЦААСНЫ ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА

Андеррайтер нь анхдагч зах зээлийн захиалгын бүртгэл явагдаж дууссанаас хойш ажлын 3 өдөрт багтаан арилжааны тайланг Хороонд хүргүүлнэ. Хороо нь уг тайланг хүлээн авч анхдагч зах зээлийн захиалгын бүртгэл амжилттай явагдсан, аливаа зөрчил гараагүй гэж үзвэл үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад өмчлөх эрхийн бүртгэл хийх болон арилжаа эрхлэх байгууллагад үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх зөвшөөрлийг тус тус олгох тухай албан бичгийг ажлын гурван өдөрт багтаан хүргүүлнэ. ҮЦТХТ болон Бирж нь уг зөвшөөрлийг хүлээн авснаар үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлнэ.

TDB CAPITAL LLC
"ИНВЕСКОР ББСБ" ХХК InvesCore NON BANK FINANCIAL INSTITUTION УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2019.04.24
БҮРТГЭВ
№01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2019-03-26
БҮРТГЭВ-02

# Үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд



СЭХ 2019 .04. 24

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2019 -03- 26

## 9.1 АНДЕРРАЙТЕР

### 9.1.1 АНДЕРРАЙТЕРИЙН ТАНИЛЦУУЛГА

**ҮНДСЭН АНДЕРРАЙТЕР**

| | |
|---|---|
| TDB CAPITAL | **"Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК** |
| **Регистрийн дугаар:** | 5251494 |
| **Хаяг:** | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Энхтайваны өргөн чөлөө, Худалдаа, хөгжлийн банкны байр |
| **Утас:** | 70100261, 11 311914 |
| **И-мэйл:** | info@tdbcapital.mn |

"Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК нь 2011 оноос эхлэн Монгол улсын хөрөнгийн зах зээлд үйл ажиллагаа явуулж буй, зах зээлд тэргүүлэгч үнэт цаасны компаниудын нэг бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооноос андеррайтер болон харилцагчийн нэрийн өмнөөс түүний даалгавраар гүйцэтгэх бусад ажил үйлчилгээ явуулах тусгай зөвшөөрөл авсан, Биржийн гишүүн үнэт цаасны компани юм. Тус компани нь харилцагчдын хүсэл зорилгыг эрхэмлэсэн, дэвшилтэт технологид суурилсан цогц бүтээгдэхүүн үйлчилгээ, санхүүгийн шийдлийг мэргэжлийн дээд түвшинд хүргэсэн, үндэсний баялаг бүтээгчдийг дэмжигч, харилцагчдын найдвартай зөвлөх байхыг зорин ажиллаж байна.

Тус компани нь хөрөнгө оруулалтын банкны болон үнэт цаасны зуучлалын үйлчилгээг харилцагчдадаа хүргэн, үнэт цаас, түүнд суурилсан санхүүгийн хэрэгслүүд, хувьцаа, бонд, өрийн хэрэгслийг нээлттэй болон хаалттай зах зээлд гарган санхүүжилт татах, компанийг өөрчлөн байгуулах, тухайн байгууллагын онцлогт тохирсон санхүүжилтийн хамгийн үр ашигтай хувилбарыг санал болгох зэргээр харилцагчдынхаа санхүүгийн хэрэгцээг бүрэн хангах, мэргэжлийн зөвлөгөө, туслалцааг үзүүлдэг. "Ти Ди Би Капитал ҮЦК" нь байгуулагдсан цагаасаа эхлэн олон улсын хөрөнгө оруулалтын банкуудтай хамтран болон бие даан харилцагчдадаа нийт 3.6 тэрбум ам.долларын санхүүжилтийг амжилттай татан төвлөрүүлж, зөвлөх үйлчилгээ үзүүлсэн бөгөөд 2018 онд Монголын хөрөнгийн бирж дээр нийт 71.6 тэрбум төгрөгийн үнэт цаасны арилжааг хийж гүйцэтгэжээ.

Мөн өдрөөс өдөрт хөгжин өөрчлөгдөж буй дэлхийн санхүүгийн зах зээлийн орчинд харилцагчдынхаа хүсэл сонирхолд тулгуурласан өндөр чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэхийг зорин ажиллаж, Биржтэй шууд холболт хийгдсэн "Ти Ди Би Брокер" онлайн арилжааны системээ 2018 онд бүрэн шинэчилснээс гадна хөрөнгийн зах зээлд оролцогчдын санхүүгийн боловсролыг дэмжих зорилгоор хөрөнгийн зах зээлийн тухай үндсэн ойлголт өгөх, арилжаанд оролцох болон үнэт цаас гаргахтай холбоотой интерактив хөтчүүдийг бэлтгэн олны хүртээл болгосон. Мөн хөрөнгийн зах зээлийн нэгдсэн статистик мэдээлэл болон хувьцаат компаниудын тоон шинжилгээг нийтлэх зэрэг нэмэлт үйлчилгээг үзүүлж байна.

ТИ ДИ БИ КАПИТАЛ ҮЦК ХХК 5251494 TDB CAPITAL LLC



"ИНВЕСКОР ББСБ" ХХК InvesCore УЛААНБААТАР ХОТ

СЭХ 2019.04.24
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2019-03-26

**ТУСЛАХ АНДЕРРАЙТЕР**

| InvesCore CAPITAL | **"Инвескор Капитал ҮЦК" ХХК** |
|---|---|
| **Регистрийн дугаар:** | 6317839 |
| **Хаяг:** | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 2-р хороо, Сөүлийн гудамж 10/1, Твин тауэр-1, 13 давхар |
| **Утас:** | 77090077 |
| **И-мэйл:** | info@icapital.mn |

"Инвескор Капитал ҮЦК" ХХК нь Монгол Улсын хөрөнгийн зах зээлд шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгох, гадаадын хөрөнгө оруулалтыг татах замаар хөрөнгийн зах зээлийн эргэлтийг нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулах, дотоодын хөрөнгө оруулагчдад олон улсын хөрөнгийн зах зээлээс өгөөж хүртэх боломжийг нэмэгдүүлэх зорилгоор 2018 онд үүсгэн байгуулагдсан үнэт цаасны компани юм. Тус компани нь Санхүүгийн зохицуулах хорооноос үнэт цаасны брокерийн үйл ажиллагаа, үнэт цаасны дилерийн үйл ажиллагаа, үнэт цаасны андеррайтерийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл авсан бөгөөд банк, санхүүгийн салбар, хөрөнгийн зах зээл, хууль эрх зүй, өмгөөллийн салбарт ажиллаж байсан чадварлаг хамт олонтой бөгөөд хөрөнгийн болон үнэт цаасны зах зээл, үнэт цаас, санхүүжилт татах, M&A, хөрөнгө оруулалт болон бизнесийн зөвлөгөө өгөх чиглэлээр мэргэшсэн багтай.

### 9.1.2 АНДЕРРАЙТЕРТАЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭ

Үнэт цаас гаргагч нь "Инвескор Капитал ҮЦК" ХХК-тай 2019 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр АҮГ-2019/01 тоот "Андеррайтерийн үйлчилгээний гэрээ", "Ти Ди Би Капитал ҮЦК"-тай 2019 оны 01 дүгээр сарын 3-ны өдөр TDBC 105/2019 190123/02 тоот "Хамтран ажиллах тухай санамж бичиг" болон "Инвескор Капитал ҮЦК" ХХК, "Ти Ди Би Капитал ҮЦК"-тай 2019 оны 3 дугаар сарын 01-ний өдөр TDBC 107/2019 190301/01 тоот "Андеррайтерийн болон зөвлөх үйлчилгээний гэрээ"-г тус тус байгуулан, Үнэт цаас гаргагчийн хувьцааг нийтэд санал болгох ажлыг зохион байгуулах андеррайтерийн үйлчилгээг Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хороо болон Биржийн Бүртгэлийн журам, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн үзүүлэхээр харилцан тохиролцжээ.

Гэрээний хүрээнд андеррайтерууд нь үнэт цаас гаргах ажлын төлөвлөгөө боловсруулах, хөрөнгө оруулалтын эдийн засгийн үр ашгийн тооцоо хийх, үнэт цаасны танилцуулга бэлтгэх, эрх бүхий этгээдэд үнэт цаасыг бүртгүүлэх хүсэлт гаргах, танилцуулах аяныг зохион байгуулах, анхдагч зах зээлийн арилжааг зохион байгуулах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэх бөгөөд үйлчилгээгээ мэргэжлийн өндөр түвшинд зохион байгуулах, мэдээллийн нууцлалыг хадгалах, задруулахгүй байх, задруулсан тохиолдолд хариуцлага хүлээхээр тусгасан.

Гэрээнд тусгагдсан гол нөхцөлүүд:

- Андеррайтерийн үйлчилгээг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.4.3-д заасны дагуу хөрөнгө оруулагчид тухайн үнэт цаасыг танилцуулах замаар түүнийг худалдахад шаардлагатай бүх хүчин чармайлт гаргах хэлбэрээр үзүүлэх;

TDB CAPITAL LLC
"ИНВЕСКОР ББСБ" ХХК InvesCore УЛААНБААТАР ХОТ

- Үнэт цаас гаргагчийн нэмж гаргаж буй хувьцааг 2 хэсэгт хуваан стратегийн хөрөнгө оруулагч болон олон нийтэд санал болгох бөгөөд үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааг зохион байгуулахдаа захиалгын бүртгэлийн аргыг ашиглах;
- Үнэт цаас гаргагчийн нэмж гаргах үнэт цаасны 85 хувиас багагүй хувийг стратегийн хөрөнгө оруулагчид санал болгох бөгөөд хувьцааг худалдан авах баталгааг стратегийн хөрөнгө оруулагчаас гаргуулах;

Түүнчлэн гэрээгээр дотоод мэдээлэл эзэмшигчийн асуудлыг зохицуулсан байх бөгөөд дотоод мэдээллийг аливаа гуравдагч этгээдэд дамжуулах, худалдах, шилжүүлэх, үнэт цаас гаргагчийн хувьцааг биржээр болон гуравдагч этгээдээр дамжуулан худалдан авах, борлуулах, ашиг олох, мөн санхүүжилт татах, эрх бүхий этгээдүүд болон андеррайтерийн зөвшөөрөлгүйгээр олон нийтэд мэдээлэхийг дотоод мэдээлэл эзэмшигчид хориглосон байна.

СЗХ 2019.04.24

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2019-03-26 БҮРТГЭЛ-02

## 9.2 АУДИТЫН КОМПАНИ

### 9.2.1 АУДИТЫН КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

| BDO | **“БДО Аудит” ХХК** |
|---|---|
| **Регистрийн дугаар:** | 2546442 |
| **Хаяг:** | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Нарны зам 62, Юнэскогийн гудамж, Юнион Бюлдинг, В блок, 1502 тоот |
| **Утас:** | 77404040, 77404041 |
| **И-мэйл:** | info@bdo.mn |

“БДО Аудит” ХХК нь аудит, нягтлан бодох бүртгэл, зөвлөх үйлчилгээний дэлхийн тав дахь том сүлжээ юм. БДО-ийн дэлхий даяарх 60,000 гаруй ажилчид дэлхийн 152 орон дахь 1328 салбар оффисоороо дамжуулан зөвлөх үйлчилгээ үзүүлдэг бөгөөд Монгол Улс дахь оффис нь аудит, нягтлан бодох бүртгэл, зөвлөх үйлчилгээний салбарт 15 жилийн туршлагатай “Итгэлт Аудит” ХХК-ийн суурин дээр 2012 оны 12 дугаар сард Улаанбаатар хотод үүсгэн байгуулагдсан. Тус компани нь 2012 оны 8 дугаар сарын 08-ны өдөр Хорооны 259 тоот тогтоолын дагуу үнэт цаас гаргагчид аудитын үйлчилгээ үзүүлэх эрх авсан юм. “БДО Аудит” ХХК нь 2 партнер, 40 орчим мэргэжилтнүүдтэй бөгөөд аудит ба баталгаажуулалт, үнэлгээ ба шинжилгээ, бизнесийн зөвлөх үйлчилгээ, дотоод гадаад аутсорсинг, татвар ба хууль зүйн зөвлөгөө үзүүлэх үйл ажиллагаа явуулж байна. Тус компани нь Голомт Банк, Чингис Хаан Банк, Энэржи Ресурс, Эм Си Эс, Юнител, Витафит, Би Ди Сек, Багануур, Эрдэнэс Таван Толгой, Дархан Нэхий зэрэг дотоодын шилдэг аж ахуйн нэгжүүдэд үйлчилгээ үзүүлсэн туршлагатай.

### 9.2.2 АУДИТЫН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭНИЙ ТУХАЙ

“БДО Аудит” ХХК нь үнэт цаас гаргагчтай 2018 оны 12 дугаар сарын 05-ны өдөр Аудитын үйлчилгээ үзүүлэх гэрээг байгуулсан бөгөөд “Инвескор ББСБ” ХХК, “Инвескор Эй Ай Лаб” ХХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан, тайлант жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлийн тайлан болон мөнгөн гүйлгээний тайлангуудыг багтаасан санхүүгийн тайлангууд, эдгээр санхүүгийн тайлангуудтай холбоотой нэмэлт тайлбар тодруулга болон нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (“СТОУС”)-ын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд аудит хийлгэхээр тохиролцсон. Аудитын компанийн ажил гүйцэтгэх хугацаа нь 2019 оны 01- дүгээр сарын 21-ний өдрийг хүртэл байна.

Гэрээний дагуу “БДО Аудит” ХХК нь аудитын үйлчилгээ үзүүлэх үедээ орхигдуулсан, хянамгай бус байсан тохиолдолд хариуцлага хүлээх ба гэрээнд заасан үйлчилгээг алдаатай үзүүлсэн тохиолдолд Үнэт цаас гаргагчид учирсан санхүүгийн шууд хохирлыг нөхөн төлөх үүрэг хүлээх бөгөөд уг нөхөн төлөх хохирлын хэмжээ нь гэрээт ажлын үйлчилгээний хөлсний дүнгээс хэтрэхгүй байна. Аудитын компани нь мөн үнэт цаас гаргагчийн нууц мэдээллийг ашиглахгүй, задруулахгүй байх, сонирхлын зөрчил үүсч болзошгүй тохиолдолд үйлчлүүлэгчийн эрх ашгийг хамгаалах арга хэмжээ авах үүргийг тус тус хүлээсэн байх ба гэрээт ажлыг эхлэхээс өмнө болон дараа гүйцэтгэсэн бүхий л ажилд холбогдох оюуны өмчийн эрхийг эзэмшихээр тохиролцсон байна.

ТИ ДИ БИ КАПИТАЛ ҮЦК ХХК TDB CAPITAL LLC
"ИНВЕСКОР ББСБ" ХХК InvesCore УЛААНБААТАР ХОТ

Үйлчлүүлэгч буюу Үнэт цаас гаргагч нь СТОУС-ын дагуу санхүүгийн тайлангуудыг үнэн бөгөөд шударгаар бэлтгүүлэх зорилгоор аудиторуудыг бүрэн гүйцэд, үнэн бодит, цаг үеэ олсон мэдээллээр хангах үүрэгтэй бөгөөд энэхүү үүргээ биелүүлж чадаагүйгээс үүдэх үр дагаврыг аудитын компани хариуцахгүй.

## 9.3 ҮНЭЛГЭЭНИЙ КОМПАНИ

### 9.3.1 ҮНЭЛГЭЭНИЙ КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

| ГЭРЭГЭ эстимэйт | **"Гэрэгэ Эстимэйт" ХХК** |
|---|---|
| **Регистрийн дугаар:** | 5342961 |
| **Хаяг:** | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 6-р хороо, Бага тойруу гудамж, 37Б байр |
| **Утас:** | 70005000 |
| **И-мэйл:** | gantulga@geregepartners.mn |

"Гэрэгэ Эстимэйт" ХХК нь үнэт цаас гаргагчид үйлчилгээ үзүүлэх эрх бүхий, хөрөнгийн болон бизнесийн үнэлгээний чиглэлээр ажилладаг үнэлгээний мэргэжлийн байгууллага юм. Тус компанийн үнэлгээний баг нь Монгол Улс болон олон улсын их дээд сургууль төгсөж, олон улсын нэр хүндтэй байгууллагуудад ажиллаж байсан академик болон мэргэжлийн туршлага хуримтлуулсан үнэлгээчин, актуарч, нягтлан бодогч, эдийн засагч болон санхүүгийн бусад мэргэжилтнүүдээс бүрддэг бөгөөд Монгол Улсын Сангийн Яамнаас олгодог Мэргэшсэн үнэлгээчний сертификаттай үнэлгээчид ажилладаг. Бизнесийн үнэлгээний болон хөрөнгийн үнэлгээний өргөн цар хүрээтэй ажлууд дээр "Гэрэгэ Эстимэйт" ХХК нь эдийн засаг, санхүү, бизнес, актуарын мэргэжлийн зөвлөх үйлчилгээний компани болох "Гэрэгэ Партнерс" ХХК-ийн мэргэжилтнүүдтэй хамтарч баг болон ажилладаг.

Тус компанийн үнэлгээчид нийт 15 гаруй бизнесийн үнэлгээний ажил хийж гүйцэтгэсэн ба компанийн харилцагчдад "М Си Эс Холдинг" ХХК, "Туушин Зочид Буудал" ХХК зэрэг Монгол Улсын томоохон компаниуд болон Биржид бүртгэлтэй "Тахько" ХК, Торонто Венчур Биржид бүртгэлтэй "Монголиа Гровт Групп" зэрэг компаниуд багтдаг. Мөн 2017 онд "ЛэндМн ББСБ" ХХК-ийн хувьцааг хөрөнгийн биржид хувьцаагаа анх удаа олон нийтэд санал болгоход зориулан бизнесийн үнэлгээг хийж гүйцэтгэсэн.

### 9.3.2 КОМПАНИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭГЭЭР ТАЛУУДЫН ХҮЛЭЭСЭН ҮҮРЭГ

"Гэрэгэ Эстимэйт" ХХК нь Үнэт цаас гаргагчтай 2018 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр A18112701 дугаар бүхий "Бизнесийн үнэлгээний ажил гүйцэтгэх гэрээ"-г байгуулсан байна. Гэрээний хүрээнд "Гэрэгэ Эстимэйт" ХХК нь үнэт цаас гаргагчийн бизнесийн үнэлгээг Монгол Улсын Хөрөнгийн үнэлгээний тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, шаардлагын хүрээнд Үнэлгээний Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэхээр тусгасан. Гэрээний хүчинтэй хугацаа нь 2018 оны 12 дугаар сарын 24-ний өдөр хүртэл байсныг талууд харилцан тохиролцож, 2018 оны 12 дугаар сарын 18-ны өдөр "A18112701 тоот Гэрээний нэмэлт өөрчлөлт" нэмэлт гэрээгээр 2019 оны 5 дугаар сарын 26-ны өдрийг хүртэл сунгажээ.

Гэрээнд үнэлгээний компани нь үнэлгээний тайланд үнэлгээ хийсэн аргачлал, үнэлгээнд нөлөөлсөн хүчин зүйлсийн үндэслэлийг нарийн тусгаж, үйлчлүүлэгчийн хүсэлтээр гуравдагч этгээдэд үнэ төлбөргүйгээр өөрийн хэрэглэсэн аргачлал, үндэслэлийг батлан харуулах, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх явцдаа олж мэдсэн мэдээллийг гэрээний хугацаа дуусгавар болсноос хойш 3 жилийн хугацаанд задруулахгүй байх, задруулсан тохиолдолд үйлчлүүлэгчид учирсан хохирлыг үл маргах журмаар нөхөн төлөх, ажил гүйцэтгүүлэхээр шилжүүлсэн баримт бичиг, эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, бүрэн бүтэн байдлыг

хариуцах, аливаа доголдолгүйгээр эргүүлэн өгөх, өөрийн гаргасан тайлангийн үнэн зөвийг Үнэт цаас гаргагчийн өмнө бүрэн хариуцах үүрэг хүлээсэн байна.

Үнэт цаас гаргагч нь ажил гүйцэтгэгчид бичиг, баримт мэдээллийг шаардлагатай хэмжээгээр хүлээлгэн өгөх, үнэлгдэж буй хөрөнгийг баланс болон тоо бүртгэлд тусгасан байх, гэрээнд заасан журмаар үйлчилгээний төлбөр тооцоог хугацаанд нь төлж барагдуулахаар заасан. Ажил гүйцэтгэгч нь үнэлгээчний хариуцлагын даатгалд даатгуулсан байх үүрэг хүлээх ба гэрээт ажлыг тогтоосон хугацаанд хийж гүйцэтгээгүй, тайланг үйлчлүүлэгчид хүлээлгэн өгөөгүй, мөн гүйцэтгэсэн ажлын үр дүн нь доголдолтой бол Иргэний хуулийн 352 дугаар зүйлд заасны дагуу доголдлыг арилгах болох тийнхүү арилгахтай холбогдон гарсан зардлыг нөхөн төлөх, ажлыг хөлсийг бууруулахаар заажээ. Мөн ажил гүйцэтгэгч дүгнэлт гаргахдаа мэргэжлийн алдаа гаргасныг Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд заасан Мэргэжлийн зөвлөл тогтоосон тохиолдолд Үнэт цаас гаргагчийн төлсөн бүхий л төлбөр, учирсан хохирол болон Мэргэжлийн зөвлөлийн зардлыг нөхөн төлөх үүрэгтэй гэж заасан байна.

## 9.4 ХУУЛИЙН ФИРМ

### 9.4.1 ХУУЛИЙН ФИРМИЙН ТАНИЛЦУУЛГА

MDSKhanLex **"Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН**

| | |
|---|---|
| **Регистрийн дугаар:** | **5495997** |
| **Хаяг:** | Улаанбаатар хот 14200, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай гудамж, Сентрал Тауэр, 13 давхар, 1301 тоот |
| **Утас:** | 11330048 |
| **И-мэйл:** | info@mdsa.mn |

"Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН нь "ЭмДиЭс энд Ассошэйтс" ЗБН болон "Хаанлекс Адвокэйтс" ЗБН-ийг нэгдлийн үр дүнд байгуулагдсан хуулийн фирм бөгөөд Монгол Улс дахь хамгийн олон гишүүнтэй хуулийн нөхөрлөл юм. Тус фирмийн хуульчид нь олон улсын эрх зүйг үндэсний хууль тогтоомж, туршлагатай уялдуулан үндэсний болон олон улсын хөрөнгө оруулагчдад төрөл бүрийн салбарт эрх зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг.

"Эм Ди Эс энд ХаанЛекс" ХХН нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 33.2.1-д заасан үнэт цаасны зах зээлд хууль зүйн зөвлөгөө өгөх үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдээр бүртгэгдсэн, үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээд бөгөөд тус зах зээлээс санхүүжилт татаж буй компаниудтай хамтран ажиллаж байсан арвин туршлагатай. Үүнд, тухайлбал "Эрдэнэс Таван Толгой" ХК-ийн үнэт цаасыг олон улсын түвшинд санал болгох, Монгол, Хонг Конг, Лондонгийн хөрөнгийн биржүүд дээр хувьцааг нийтэд анх удаа санал болгох Wolf Төслийн Монголын хууль тогтоомжтой холбоотой зөвлөгөөг өгөх, Монгол Улсын Хөрөнгийн Бирж дээр гаргасан анхны 100% даатгагдсан Эрчим бонд гаргах ажилд хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх, хууль зүйн магадлан шалгалт хийх, хууль зүйн дүгнэлт гаргах, "ЛэндМН ББСБ" ХХК-ийн анх удаа хувьцаагаа нийтэд санал болгох ажилд хуулийн зүйн дүгнэлт гаргах, "Түмэн шувуут" ХХК-ийн IPO төсөл дээр хууль зүйн судалгаа шинжилгээ хийж, хууль зүйн дүгнэлт гаргах ажлуудыг тус тус хийж гүйцэтгэсэн туршлагатай.

### 9.4.2 ХУУЛЬ ЗҮЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭНИЙ ТУХАЙ

"Эм Ди Эс энд Хаан Лекс" ХХН нь Үнэт цаас гаргагчтай 2018 оны 10 дугаар сарын 05-ны өдөр Д-18/380 дугаар бүхий "Хууль зүйн үйлчилгээ үзүүлэх гэрээ"-г байгуулсан байх бөгөөд гэрээ

нь талууд гэрээнд заасан үүргээ бүрэн гүйцэтгэж дуусах хүртэл хугацаатай байгуулагдсан байна. Гэрээгээр тодорхойлсон хууль зүйн үйлчилгээний агуулга нь Үнэт цаас гаргагчаас хувьцаагаа анх удаа нийтэд санал болгох ажилд Хороо болон Биржийн холбогдох журамд заасны дагуу хууль зүйн дүгнэлт гаргах байна.

Гэрээний дагуу хуулийн компанийн хүлээх үүрэгт ажлаа тохиролцсон хугацаанд чанарын өндөр түвшинд гүйцэтгэх, ажлыг гүйцэтгэх явцад сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал бий болсон даруйд үйлчлүүлэгчид мэдэгдэх, үйлчлүүлэгчийн нэр хүнд, ажилтан, албан хаагч, харилцагчдын ажил хэргийн нэр хүндэд нь харш үйлдэл хийхгүй байх, хувь хүний нууцыг задруулахгүй байх, хууль зүйн үйлчилгээ үзүүлэх явцдаа олж мэдсэн үйлчлүүлэгчийн нууцыг хугацаагүй хадгалах үүргүүд тус тус багтсан байна.

Нөгөө талаас Үнэт цаас гаргагч нь Хуулийн фирмд гэрээгээр тохиролцсон хууль зүйн үйлчилгээний хөлсийг хугацаанд нь бүрэн төлөх, үнэн зөв бодит мэдээлэл, шаардлагатай баримт, материалыг гаргаж өгөх зэргээр хууль зүйн үйлчилгээ үзүүлэхэд нь шаардагдах бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлэх үүрэг хүлээсэн бөгөөд хуулийн компани, түүний хуульчдын нэр төр, ажил хэргийн нэр хүндэд нь харш үйлдэл хийх, ашиг сонирхлын зөрчил, хараат байдалд оруулахуйц харилцаа холбоо үүсгэх болон хууль бус шаардлагыг биелүүлэх талаар хүсэлт, шаардлага гаргах эрхгүй байхаар тохиролцсон байна.

СЗХ
2019.04.24
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2019-03-26
БҮРТГЭВ



# Хавсралт

TDB CAPITAL LLC

InvesCore
УЛААНБААТАР ХОТ

2019 .04. 24

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
Хууль зүйн сайдын 2019 -03- 26
А/204 дүгээр тушаалаар батлав.
БҮРТГЭВ-02

МОНГОЛ УЛС

# ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

000177961

2016.03.30
/ Бүртгэсэн он,сар,өдөр /

9015003118
/ Хувийн хэргийн дугаар /

6060854
/ Регистрийн дугаар /

Инвескор ББСБ Хязгаарлагдмал хариуцлагатай компани
/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм
/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

| Шийдвэр | 01 | 2016.03.29 |
|---|---|---|
| / шийдвэрийн нэр / | / дугаар / | / он, сар, өдөр / |

6611 — Зээлийн үйл ажиллагаа
/ код / — / Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

| / код / | / Туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл / |
|---|---|
| 6430 | Факторингийн үйлчилгээ |
| 6622 | Итгэлцлийн үйлчилгээ |
| 6630 | Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх |
| 8299 | Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө өгөх, мэдээлэл өгөх |
| 6619 | Төлбөрийн баталгаа гаргах |

05

| Хугацаагүй | 1 | 13,839,901.7 |
|---|---|---|
| / хугацаа / | / гишүүдийн тоо / | / өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр / |

Улаанбаатар, Сүхбаатар, 2-р хороо, сөүл, 10/1, Твин Тауэр 1 байрны зүүн жигүүр 13 давхар, Утас1. 99099593, Утас2: , Факс:
/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг /

МОНГОЛ УЛС

Улсын бүртгэлийн ерөнхий газар
Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар
/ бүртгэсэн байгууллагын нэр /

Гэрчилгээ дахин олгосон 2019 он 2 сар 26 өдөр

ИНВЕСКОР ББСБ ХХК
InvesCore
11162... 6060854
УЛААНБААТАР ХОТ

TDB CAPITAL LLC

СЗХ
2019.04.24 өдөр
БҮРТГЭВ

## Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

| Д/д | Нэмэлт өөрчлөлтийн агуулга | Бүртгэсэн | |
|---|---|---|---|
| | | Огноо | Ажилтан тэмдэг |
| 1 | *Далайжамц овогтой Баясгалан-г Гүйцэтгэх захирал-р томилсныг бүртгэв.* | *2016.03.30* | *Б.Амартүвшин* |
| 2 | *Дахин гэрчилгээ олгов.* | *2019.02.26* | *Э.Эрдэнэбилэг* |

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE

2019 он 02 сар 28 өдөр Бүртгэлийн № 267
Нийслэлийн Сүхбаатар дүүргийн тойргийн нотариатч Б.Энхээ би энэ хуулбарын үнэн зөвийг гэрчлэв.
Үйлчилгээний хөлсөнд 1500 төгрөг хураав
Нотариатч

"ИНЗЕСКОР ББСБ" ХХК
InvesCore
NON BANK FINANCIAL INSTITUTION
УЛААНБААТАР

TDB CAPITAL LLC

МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

# ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

Дугаар 1/554

2016 оны 05 сарын 17 өдөр

Монгол улсын "Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль", "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль", бусад хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 05 сарын 17 өдрийн 159 дугаар тогтоолоор "Инвескор ББСБ" -ХХК/ХК/д банк бус санхүүгийн

үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрч, энэхүү гэрчилгээг олгов.

ДАРГА Э.БАТБОЛД

"тэмдэг"

Энэхүү гэрчилгээ нь хавсралтын хамт хүчинтэй

136

2019.04.24
2019.03.25
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2019 он 02 сар 25 өдөр Бүртгэлийн № 240
"ИНВЕСКОР"
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
2019 .04 . 24 өдөр
БҮРТГЭЛ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2019 -03- 28
БҮРТГЭЛ

МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

# ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

Дугаар 1/554

2016 оны 05 сарын 17 өдөр

Монгол улсын "Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль", "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль", бусад хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 05 сарын 17 өдрийн 159 дугаар тогтоолоор "Инвескор ББСБ" -ХХК/ХК/д банк бус санхүүгийн

үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрч, энэхүү гэрчилгээг олгов.

ДАРГА Э.БАТБОЛД

"тэмдэг"

Энэхүү гэрчилгээ нь хавсралтын хамт хүчинтэй

"Инвескор ББСБ" ХХК
5251494
УЛААНБААТАР

СЗХ
2019.04.24 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2019-03-26
БҮРТГЭВ-02

МОНГОЛ УЛСЫН
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

# 1/554 ТООТ

# ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ХАВСРАЛТ

"Тэмдэг"

Банк бус санхүүгийн байгууллагад зориулсан тэмдэглэлүүд

05

(Энэхүү хавсралт нь тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хамт хүчинтэй)

137

ТИ ДИ БИ КАПИТАЛ ҮЦК ХХК
TDB CAPITAL LLC

"ИНВЕСКОР ББСБ" ХХК
InvesCore
NON-BANK FINANCIAL INSTITUTION
1110224289 6060854
УЛААНБААТАР ХОТ

СЗХ 2019.04.24 БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2019-03-26

НЭГ. Хуулийн этгээдийн оноосон нэр: "Инвескор ББСБ" ХХК

ХОЁР. Хуулийн этгээдийн хаяг, хаягийн өөрчлөлтийн тэмдэглэл:

| Д/д | Хаяг | Утас, факс, и-мэйл хаяг | Тэмдэглэл хийсэн огноо, тэмдэг |
|---|---|---|---|
| 1. | УБ хот, ЧД, 2р хороо, 40.50 мянгат, Жамъянгуны гудамж 8р байр, 43 тоот. | 99099593 | 2016 05 27 |
| 2. | УБ хот, СБД, 2р хороо, Сөүлийн гудамж 10/1 [illegible] Тауэр ХХК барилгын зүүн жигүүр, 402 тоот | 2016.06.06 № 11/1016 албан тоот | 2016 06 07 |
| | | | |

ГУРАВ. Тусгай зөвшөөрлийн тэмдэглэл:

| Д/д | Үйл ажиллагааны төрөл | Тусгай зөвшөөрөл олгосон огноо | Тусгай зөвшөөрөл олгосон шийдвэрийн дугаар | Зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон огноо, шийдвэрийн дугаар |
|---|---|---|---|---|
| 1. | Зээл | 2016.05.17 | №159 | |
| 2. | Факторинг | 2016.05.17 | №159 | |
| 3. | Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх | 2016.05.17 | №159 | |
| 4. | Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх | 2016.05.17 | №159 | |
| 5. | Итгэлцэл | 2016.05.17 | №159 | |
| 6. | Төлбөрийн баталгаа гаргах | 2018.01.10 | №17 | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |

TDB CAPITAL LLC

"ИНВЕСКОР ББСБ" ХХК
InvesCore
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2019.04.24 өдөр
БҮРТГЭВ
№01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2019-03-26
БҮРТГЭВ-02

ДӨРӨВ. Хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газрын тэмдэглэл:

| Д/д | Нэр, дугаар | Хаяг, хаягийн өөрчлөлт | Зөвшөөрөл олгосон огноо | Зөвшөөрөл олгосон шийдвэрийн дугаар | Зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон огноо, шийдвэрийн дугаар |
|---|---|---|---|---|---|
| 1. | Баянгол салбар салбар 1/554/01 | ЧБ, БГД, 4-р хороо, БГД 2-р хороо | 2017.04.18 | №245 | |
| 2 | 100 айл салбар 1/554-02 | СБД 10-р хороо | 2017.08.02 | №381 | |
| 3 | Ца хүргэ салбар 1/554-03 | БЗД 17-р хороо | 2017.08.02 | №381 | |
| 4. | СХД салбар 1/554-04 | ЧБ, СХД, 32-р хороо | 2018.02.14 | №83 | |
| 5. | БЗД салбар 1/554-05 | ЧБ, БЗД 06-р хороо | 2018.9.24 | №321 | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |

ТАВ. Хувьцаа эзэмшигчийн талаар:

| Д/д | Овог нэр /Хуулийн этгээдийн нэр/ | Регистрийн дугаар | Хувь нийлүүлсэн хөрөнгийн дүн | Хувь | Зөвшөөрөл олгосон огноо | Зөвшөөрөл олгосон шийдвэрийн дугаар, тэмдэг |
|---|---|---|---|---|---|---|
| 1. | Н.Нэрмандах | ЧР79091817 | 2.000.000.000 | 100% | 2016.05.17 | №109 |
| | | | | | | |
| 1. | "Эс Ай Би Жэй Капитал" ХХК | 6057209 | 3701.590.000 | 60.7% | 2017.04.10 | №222 |
| 2. | Н.Нармандах | ЧР79091817 | 2.395.283.000 | 39.3% | 2017.04.10 | №222 |
| | | | | | | |
| 1. | "Эс Ай Би Жэй Капитал" ХХК | 6057209 | 6.096.873.000 | 100% | 2017.11.13 | №485 |
| | | | | | | |
| 1. | "Эс Ай Би Жэй Капитал" ХХК | 6057209 | 18.889.901.710 | 100% | 2019.08.25 | №118 |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |

TDB CAPITAL LLC

"ИНВЕСКОР ББСБ" ХХК
InvesCore
NON BANK FINANCIAL INSTITUTION
УЛААНБААТАР ХОТ

2019.04.24

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН...
MONGOLIAN STOCK ...
2019-03-26
БҮРТГЭЛ

ЗУРГАА. Хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлтийн тэмдэглэл:

| Д/д | Хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлсэн, хорогдуулсан хэмжээ | Зөвшөөрөл олгосон огноо | Зөвшөөрөл олгосон шийдвэрийн дугаар | Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ | Өөрчлөлтийн талаар мэдээлэл, шалтгаан |
|---|---|---|---|---|---|
| 1. | | 2016.05.17 | №:159 | 2.000.000.000 | |
| 2. | 4.096.873.000 | 2017.04.10 | №222 | 6.096.873.000 | |
| 3. | 7.743.028.710 | 2019.02.26 | №:118 | 13.839.901.710 | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |

05

2019 он 02 сар 15 өдөр Бүртгэлийн № 240
Нийслэлийн Сүхбаатар дүүргийн
тойргийн нотариатч Б.Энхээ би
энэ хуулбарын үнэн зөвийг гэрчлэв.
Үйлчилгээний хөлсөнд 1000 төгрөг хураав
Нотариатч

TDB CAPITAL LLC

InvesCore
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2019.04.24
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2019-03-26
БҮРТГЭВ-02

Хувьцаа эзэмшигчийн 2019 оны 01 дүгээр сарын 31-ний
өдрийн 01 тоот Шийдвэрийн Хавсралт

# ИНВЕСКОР БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН ДҮРЭМ

## 1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. “Инвескор ББСБ” (Банк бус санхүүгийн байгууллага) ХХК (цаашид “Компани” гэх) нь Монгол Улсын Компанийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн актад заасны дагуу ашгийн төлөө аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх зорилгоор хаалттай буюу хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэрээр зохион байгуулагдсан хуулийн этгээд юм.

1.2. Энэхүү Дүрмийн зорилт нь Компанийг үүсгэн байгуулах, өөрчлөн байгуулах, дотоод үйл ажиллагаатай холбоотойгоор өөрчлөн зохион байгуулах, Компанийн удирдлага, зохион байгуулалт тэдгээрийн чиг үүрэг, үйл ажиллагааны үндсэн зарчим, хяналтын бүтэц, хувьцаа эзэмшигчийн бүрэн эрх, үүргийг тогтоох болон Компанийг татан буулгахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

## 2. КОМПАНИЙН ОНООСОН НЭР, ОРШИН БАЙГАА ГАЗАР

2.1. Компанийн оноосон нэрийг **"ИНВЕСКОР ББСБ" ХХК** /*Банк бус санхүүгийн байгууллага*, англиар **INVESCORE NBFI LLC /Non Banking Financial Institution/** гэнэ. Компани нь хязгаарлагдмал хариуцлагатай компани буюу “ХХК” хэлбэртэй байна.

2.2. Компани нь оноосон нэрээ Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “СЗХ” гэх)-ноос зөвшөөрөл авсны үндсэн дээр өөрчлөх ба СЗХ-ны зөвшөөрлийг бичгээр авсан өдрөөс хойш хуанлийн 7 хоногийн дотор холбогдох төрийн эрх бүхий байгууллагуудад мэдэгдэж өөрчлөлтийг бүртгүүлнэ.

## 3. КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ, БАЙГУУЛАХ ХУГАЦАА

3.1. Компани нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль болон Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн актад заасны дагуу Санхүүгийн зохицуулах хорооноос зохих тусгай зөвшөөрлийг авсны үндсэн дээр дараах үндсэн үйл ажиллагаануудыг эрхэлнэ. Үүнд:

3.1.1. Зээлийн үйл ажиллагаа;

3.1.2. Факторингийн үйлчилгээ үзүүлэх;

3.1.3. Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт оруулах;

3.1.4. Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх;

3.1.5. Итгэлцэлийн үйлчилгээ;

3.1.6. Төлбөрийн баталгаа гаргах.

3.2. Компани нь Компанийн тухай хууль, Иргэний хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн акт, Дүрэмд заасны дагуу үйл ажиллагаагаа явуулна.

TDB CAPITAL LLC

"ИНВЕСКОР ББСБ" ХХК
InvesCore
ULAANBAATAR ХОТ

139

СЗХ
2019.04.24 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2019-03-26
БҮРТ...

3.3. Компани нь Хувьцаа Эзэмшигчийн шийдвэр болон холбогдох хууль тогтоомжийн актад заасан бусад үндэслэлээр Компанийн үйл ажиллагааг дуусгавар болгох хүртэлх хугацаанд үйл ажиллагаагаа хугацаагүй эрхлэн явуулна. Тусгай зөвшөөрөлтэйгөөр явуулах үйл ажиллагааны хугацаа нь хуулийн дагуу тусгай зөвшөөрлийн хүчин төгөлдөр хугацаагаар тодорхойлогдоно.

## 4. КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ

4.1. Дараах этгээд нь Компанийн хувьцаа эзэмшигч (цаашид "**Хувьцаа Эзэмшигч**" гэх) байна. Үүнд:

| № | Нэр | Регистрийн дугаар | Эзэмшиж буй хувьцааны тоо, хувь хэмжээ | Хаяг |
|---|---|---|---|---|
| 1. | "Эс Ай Би Жэй Капитал" ХХК | 6057209 | 60,968,730 ширхэг (100%) | УБ хот, Сүхбаатар дүүрэг, 11 хороо, Ногоон нуур, 25 ProOne оффис 1102 тоот |

4.2. Хувьцаа Эзэмшигч нь Компанид оруулсан хувь нийлүүлсэн хөрөнгийнхөө хэмжээгээр санхүүгийн хариуцлага хүлээх бөгөөд Компанийн хүлээх эрх, үүрэг, өр, төлбөр шаардах эрхийг хариуцахгүй.

## 5. КОМПАНИЙН ЭРХ ХЭМЖЭЭ

5.1. Компанийг улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэн Улсын бүртгэлийн гэрчилгээ авсан өдрийг Компани үүсгэн байгуулагдсан өдөр гэж үзнэ.

5.2. Компани үүсгэн байгуулагдсан өдрөөс эхлэн Хувьцаа Эзэмшигчээс тусгайлан өмчилсөн өөрийн эд хөрөнгөтэй, өөрийн үйл ажиллагаагаар эрх олж, үүрэг хүлээх, үйл ажиллагаанаасаа үүсэн гарах үүргийг өөрийн эд хөрөнгийн хэмжээгээр хариуцах, шүүх, арбитрт өөрийн нэрийн өмнөөс оролцох эрхийн чадвартай, банкинд өөрийн нэр бүхий данстай, бие даасан тайлан тэнцэлтэй, Дүрэмд заасан үйл ажиллагаа явуулах чадвартай байна.

5.3. Компани нь хүлээсэн үүргээ өөрийн өмчлөлд байгаа бүх эд хөрөнгөөрөө хариуцах ба Хувьцаа Эзэмшигчийн өр болон хүлээх үүргийг хариуцахгүй.

5.4. Компани нь өөрийн хараат болон охин компани, салбар, төлөөлөгчийн газрыг Компанийн тухай хуульд заасны дагуу байгуулж болно. Хараат болон охин компани нь бие даасан хуулийн этгээдийн эрхийг эдлэх бөгөөд тэдгээр нь эрх бүхий байгууллагаас баталсан дүрмийн дагуу бие дааж үйл ажиллагаагаа явуулна. Салбар болон төлөөлөгчийн газар нь бие даасан хуулийн этгээдийн эрхийг эдлэхгүй бөгөөд Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан дүрмийн дагуу үйл ажиллагаагаа явуулна.

5.5. Компани нь өөрийн тамга, цорын ганц тэмдэг (лого), бичгийн хэвлэмэл хуудастай байна. Гүйцэтгэх Захирал нь Компанийн тамга ашиглах аюулгүй ажиллагааг хангаж ажиллана. Аливаа албан бичгэн дээр дарагдах Компанийн тамга нь эрх бүхий этгээд, Гүйцэтгэх Захирал эсхүл тэдгээрийн эрх олгосон этгээдийн гарын үсгээр баталгаажигдаж гэрчлэгдэнэ.

5.6. Компани нь Санхүүгийн Зохицуулах Хорооноос авсан зөвшөөрлийг үндэслэн, салбар, нэгж байгуулж болно. Салбар, нэгжүүд нь тусдаа гэрчилгээ, тамга, тэмдэг, журамтай байна.

TDB CAPITAL LLC

"ИНВЕСКОР ББСБ" ХХК
InvesCore
УЛААНБААТАР ХОТ

СЗХ 2019.04.24 өдөр БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2019-03-26 БҮРТГЭВ-02

## 6. КОМПАНИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ, ХУВЬЦАА

6.1. Компанийн нийт хувь нийлүүлсэн хөрөнгө нь 13,839,901,710₮ (арван гурван тэрбум найман зуун гучин есөн сая есөн зуун нэг мянга долоон зуун арван) төгрөг (цаашид "**Хувь Нийлүүлсэн Хөрөнгө**" гэх) байх ба нэг бүр нь 227₮ (хоёр зуун хорин долоон) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 60,968,730 *(жаран сая есөн зуун жаран найман мянга долоон зуун гучин)* ширхэг энгийн гаргасан хувьцаанд хуваагдана.

6.2. Компани нь өөрийн хуримтлагдсан ашгийн хэмжээгээр Хувь Нийлүүлсэн Хөрөнгөө нэмэгдүүлж болно. Шаардлагатай тохиолдолд Хувь Нийлүүлсэн Хөрөнгөнд шинээр хөрөнгө оруулалт оруулж болно.

6.3. Компанийн Хувь Нийлүүлсэн Хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах тухай бүр СЗХ болон холбогдох бусад төрийн эрх бүхий байгууллагад мэдэгдэж өөрчлөлтийг албан ёсоор бүртгүүлнэ.

## 7. КОМПАНИЙН УДИРДЛАГА, ЭРХ ХЭМЖЭЭ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ

7.1. Компанийн эрх бүхий дээд байгууллага нь Хувьцаа Эзэмшигч байна.

7.2. Хувьцаа Эзэмшигч нь дараах бүрэн эрхүүдтэй байна. Үүнд:

7.2.1. Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, түүний шинэчилсэн найруулгыг батлах;

7.2.2. Нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах, буюу өөрчлөх замаар Компанийг өөрчлөн байгуулах;

7.2.3. Компанийн өрийг хувьцаагаар солих, хувьцаа нэмж гаргах, түүний тоог тогтоох;

7.2.4. Компанийн хэлбэрийг өөрчлөх, төлөөлөн удирдах зөвлөлийн өөрчлөн зохион байгуулах төслийг батлах, шийдвэр гаргах;

7.2.5. Компанийг татан буулгах, татан буулгах комиссыг томилох;

7.2.6. Компанийн хувьцааг хуваах буюу нэгтгэх;

7.2.7. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох, эрх хэмжээг тогтоох;

7.2.8. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох;

7.2.9. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөх;

7.2.10. Компаниас хууль ёсоор зарлан мэдэгдсэний дагуу ногдол ашиг авах;

7.2.11. Компанийг татан буулгаж эд хөрөнгийг нь хуваарилах тохиолдолд түүний үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос эзэмшиж буй хувьцааныхаа тоотой хувь тэнцүүлэн хувь хүртэх;

7.2.12. Компаниас нэмж гаргасан хувьцаа, хувьцаанд хөрвөх үнэт цаасыг тэргүүн ээлжинд худалдан авах;

7.2.13. Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх захирлын шийдвэрлүүлэхээр оруулсан бусад асуудлууд;

7.2.14. Хууль тогтоомжийн актад заасан бусад эрх, үүрэг.

7.3. Хувьцаагаа захиран зарцуулах, нэмж хувьцаа гаргах журам нь Компанийн тухай хууль болон бусад холбогдох хууль, эрх зүйн актын дагуу явагдана.

TDB CAPITAL LLC

140

InvesCore



УЛААНБААТАР ХОТ

7.4. Хувьцаа Эзэмшигч нь өөрийн бүрэн эрхийн хүрээнд Хувьцаа эзэмшигчийн шийдвэр гаргах бөгөөд шийдвэрт Хувьцаа эзэмшигч эсхүл түүний эрх олгосон этгээд гарын үсэг зурж баталгаажуулна.

## 8. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ, ТҮҮНИЙ ЭРХ ХЭМЖЭЭ

8.1. Хувьцаа эзэмшигчийн чөлөөт цагт Компанийн эрх барих байгууллага нь Төлөөлөн удирдах зөвлөл байна.

8.2. Төлөөлөн удирдах зөвлөл нь нийт 5 гишүүнтэй байна.

8.3. Төлөөлөн удирдах зөвлөл нь Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргатай байх бөгөөд түүнийг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга томилно.

8.4. Төлөөлөн удирдах зөвлөл нь Хувьцаа Эзэмшигчийн бүрэн эрхэд хамааруулснаас бусад дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

8.4.1. Компанийн эрхлэх үйл ажиллагааны чиглэлийг тогтоох, өөрчлөх;

8.4.2. Хувьцаа эзэмшигчийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах;

8.4.3. Компанийн зарласан хувьцааны төрөл болон тоонд багтаан хувьцаа гаргах;

8.4.4. Үнэт цаас гаргах;

8.4.5. Компанийн стратеги болон дунд хугацаа, жилийн бизнес төлөвлөгөө, төсөв, үйл ажиллагааны бодлогыг батлах;

8.4.6. Компанийн бүтэц, зохион байгуулалт, орон тоог батлах;

8.4.7. Компанийн бүх төрлийн бодлогын баримт бичгийг батлах;

8.4.8. Компанийн Гүйцэтгэх Захирлыг Сонгох, түүний бүрэн эрхийг тогтоох, бүрэн эрхийг хугацаанаас өмнө дуусгавар болгох, тусгайлсан асуудлаар түүнд итгэмжлэл олгох;

8.4.9. Гүйцэтгэх Захиралтай байгуулах гэрээний нөхцлийг батлах, өөрчлөлт оруулах, түүнд олгох, шагнал, урамшуулал, цалингийн хэмжээг тогтоох;

8.4.10. Компанийн жилийн бизнес төлөвлөгөөний гүйцэтгэл, үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаар Гүйцэтгэх Захирлаас гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;

8.4.11. Компанийн аудитын байгууллагыг сонгож, гэрээ байгуулах;

8.4.12. Компанийн тухай хуулийн 11 дүгээр бүлэгт заасан их хэмжээний хэлцлийг батлах;

8.4.13. Компанийн тухай хуулийн 12 дугаар бүлэгт заасан сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах;

8.4.14. Ногдол ашиг хуваарилах эсэх талаар шийдвэр гаргаж, ногдол ашгийн хэмжээ, хуваарилах журам, бодлого тодорхойлох;

8.4.15. Компанийн эрхэлж буй үндсэн болон туслах үйл ажиллагаатай холбоотойгоос бусад 1,000,000,001₮ (нэг тэрбум нэг) төгрөгөөс дээш зах зээлийн үнэтэй үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, барьцаалах, барьцаалуулах болон бусад хэлбэрээр захиран зарцуулах шийдвэр гаргах, түүнтэй холбогдсон гэрээ, хэлцэл эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн гэрээ, хэлцлийг батлах, гэрээ, хэлцэл хийх зөвшөөрөл олгох;

СЭХ
2019 04 24 сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ

8.4.16. Хараат болон охин компани, салбар, төлөөлөгчийн газар байгуулах, тэдгээрийн эрх хэмжээ, үйл ажиллагааны чиглэлийг тогтоох;

8.4.17. Компанийн Дүрмээр болон хууль тогтоомжийн актад заасан бусад эрх;

8.4.18. Гүйцэтгэх захирлын шийдвэрлүүлэхээр оруулсан бусад асуудал.

8.5. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, даргын бүрэн эрхийн хугацаа нь хувьцаа эзэмшигч тэдгээрийн бүрэн эрхийн хугацааг дуусгавар болгох өдөр хүртэл хүчинтэй байна.

8.6. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал нь хамгийн багадаа хагас жилд нэг удаа хуралдана.

8.7. Төлөөлөн удирдах зөвлөл нь шаардлагатай гэж үзвэл тодорхой асуудал эрхэлсэн байнгын болон түр хороог байгуулж болох ба тухайн хорооны эрх зүйн байдлыг Компанийн тухай хуульд заасны дагуу тодорхойлж, зохицуулна.

8.8. Төлөөлөн удирдах зөвлөлөөс тогтоол гаргах бөгөөд түүнд төлөөлөн удирдах зөвлөлийн дарга гагцхүү гарын үсэг зурж баталгаажуулна.

8.9. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга нь Компанийн хараат болон охин компанийн хувьцаа эзэмшигчийн эрхийг дангаар төлөөлж хэрэгжүүлэх ба хувьцаа эзэмшигчийн шийдвэр, тогтоолд Компанийг төлөөлж гарын үсэг зурах эрхтэй байна.

8.10. Төлөөлөн удирдах зөвлөл түүний хурлын бүрэн эрх, хуралтай холбоотой асуудлыг Компанийн тухай хуульд заасны дагуу зохицуулна.

## 9. ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА, ТҮҮНИЙ ЭРХ ХЭМЖЭЭ

9.1. Компанийн гүйцэтгэх удирдлагыг Төлөөлөн удирдах зөвлөлийн сонгосон Гүйцэтгэх Захирал (цаашид "**Гүйцэтгэх Захирал**" гэх) хэрэгжүүлэх ба Гүйцэтгэх захирал нь Дүрэм болон Төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах бөгөөд Компанийн эрх бүхий төлөөлөгч байна.

9.2. Гүйцэтгэх Захирал нь Компанийг төлөөлж, энэхүү Дүрэмд заасан үйл ажиллагаа тусгайлсан итгэмжлэлгүйгээр хэрэгжүүлж, шаардлагатай бичиг баримтад гарын үсэг зурах эрхтэй байна.

9.3. Гүйцэтгэх Захирал нь өөрт олгогдсон бүрэн эрхээ зохистой үйл ажиллагаанд хэрэгжүүлэх ба энэхүү Дүрэмд харшлах хэлбэрээр ажиллахыг хориглоно. Гүйцэтгэх Захирал нь өөрийн эрх, үүргийг хэрэгжүүлэхдээ үнэнч шударга байж Компанийн эрх, ашгийг тэргүүнд тавьж ажиллана.

9.4. Гүйцэтгэх Захирал нь дор дурьдсан эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

9.4.1. Компанийн стратегийн бодлого, дунд хугацааны болон жилийн бизнес төлөвлөгөө, төсвийг Компанийн зорилго, зорилтод нийцүүлэн боловсруулж Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулах;

9.4.2. Компанийн бүтэц, орон тоо, цалингийн систем зэргийг батлагдсан хүрээнд удирдан, зохион байгуулах;

9.4.3. Компанийн үйл ажиллагааг тухайн жилийн батлагдсан бизнес төлөвлөгөө, төсвийн хүрээнд эрхлэн явуулах, захиран зарцуулах;

9.4.4. Хувьцаа Эзэмшигчийн болон Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр, тогтоол, Компанийн бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах;

"ИНВЕСКОР ББСБ" ХХК
InvesCore
NON BANK FINANCIAL INSTITUTION
5
УЛААНБААТАР ХОТ

9.4.5. Компанийн эрхэлж буй үндсэн болон туслах үйл ажиллагаатай холбоотойгоос бусад 0-1,000,000,000 (нэг тэрбум) төгрөг хүртэлх зах зээлийн үнэтэй үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, барьцаалах, барьцаалуулах болон бусад хэлбэрээр захиран зарцуулах шийдвэр гаргах, түүнтэй холбогдсон гэрээ, хэлцэл эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн гэрээ, хэлцэлийг байгуулах гэрээ, хэлцэл хийх зөвшөөрөл олгох;

9.4.6. Зээлийн хорооны гишүүдийг томилох, чөлөөлөх;

9.4.7. Өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой заавар, дүрэм, журам батлан мөрдүүлэх;

9.4.8. Төлөөлөн удирдах зөвлөлөөс олгосон эрх хэмжээний хүрээнд итгэмжлэлгүйгээр Компанийн нэрийн өмнөөс аж ахуйн шинжтэй, үндсэн үйл ажиллагаатай холбогдсон бүх төрлийн гэрээ, хэлцэл байгуулах, хэлэлцээр хийх, гарын үсэг зурах, төлөөлөх, бусад этгээдэд эрх олгох;

9.4.9. Компанийн эрхэлж буй үйл ажиллагаа болон эд хөрөнгөтэй холбогдсон бүх татвар, хураамж, түүнтэй адилтгах төлбөрийг төлөх, төрийн эрх бүхий байгууллагатай тохиролцсоны дагуу компани хооронд дамжуулан тооцуулах шийдвэр гаргах, бусад зайлшгүй гарах зардлыг зохих журмын дагуу шийдвэрлэж, төлж барагдуулах;

9.4.10. Монгол Улсын хууль, Компанийн бизнес төлөвлөгөө, төсөв, Дүрэм болон гадаад харилцааны ёс зүйд Компанийн үйл ажиллагааг нийцүүлэн явуулах, аливаа зөрчил гарсан тохиолдолд зөрчлийг арилгах, хуульд нийцүүлэх арга хэмжээ авах, энэ тухай Дүрэмд заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөл эсхүл Хувьцаа Эзэмшигчид мэдэгдэж шийдвэрлүүлэх;

9.4.11. Хувьцаа эзэмшигч болон Төлөөлөн удирдах зөвлөлөөс шаардсан тайлан, мэдээлэл, баримт бичгийг тухай бүр бэлтгэн гаргаж өгөх;

9.4.12. Компанийн үйл ажиллагаатай холбогдон үүссэн шүүхийн маргаан, өр барагдуулах үйл ажиллагаа, хэрэг хянан шийдвэрлэх болон захиргааны журмаар шийдвэрлүүлэх аливаа ажиллагаанд Компанийг төлөөлөн оролцож, асуудлыг шийдвэрлэх, энэ талаар өмгөөлөгч болон бусад тусгайлан эрх авсан холбогдох этгээдүүдтэй гэрээ байгуулах, Компанийг төлөөлөх этгээдэд итгэмжлэл олгох, эрх ашгийг хамгаалах холбогдох арга хэмжээг авах;

9.4.13. Компанийн ажиллагсадыг ажилд авах, чөлөөлөх, хөдөлмөрийн гэрээ байгуулах, цуцлах, дуусгавар болгох, тэдгээрийн ажлын гүйцэтгэлд хяналт тавих, урамшуулах, Хөдөлмөрийн тухай хууль болон Компанийн Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу ажилтанд хөдөлмөрийн сахилгын арга хэмжээ авах;

9.4.14. Хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхэд хамаарахаас бусад Компанийн удирдах албан тушаалтнууд, салбар, нэгжийн гүйцэтгэх удирдлагыг бие даан томилох, чөлөөлөх, бүрэн эрхийг тогтоох, шаардлагатай тохиолдолд хугацаанаас нь өмнө чөлөөлөх, тэдгээрийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх.

9.5. Гүйцэтгэх Захирал нь дор дурьдсан үүргийг хүлээнэ. Үүнд:

9.5.1. Компанийн дүрэм, Хувьцаа Эзэмшигч, Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан дотоод бодлого, журамд заасан үүргийг биелүүлж, Компанийн ашиг сонирхлын төлөө үнэнч шударгаар ажиллах;

9.5.2. Компанийн үйл ажиллагаар Монгол Улсын хууль, тэдгээрт нийцүүлэн гаргасан эрх зүйн акт, Банк бус санхүүгийн байгууллагад холбогдох хууль, тогтоомж, журам болон Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанкны шаардлагад бүрэн нийцүүлж ажиллах;

9.5.3. Санхүүгийн тайлан бүртгэлийг холбогдох хууль, тогтоомж, заавар, журмын дагуу үнэн зөв гаргуулах;

9.5.4. Хөлсөөр ажиллах гэрээгээр тогтоосон үүргийг биелүүлэх.

9.6. Гүйцэтгэх Захирал нь Төлөөлөн удирдах зөвлөлийн зөвшөөрөлгүйгээр өөр байгууллагын удирдлага эсвэл удирдлагын гишүүнээр сонгогдох буюу аж ахуйн бусад үйл ажиллагаар биечлэн эрхлэхийг хориглоно.

9.7. Компанийн эрх бүхий албан тушаалтан нь өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас, Компанид учруулсан эд хөрөнгийн хохиролыг өөрийн хөрөнгөөр Компанийн өмнө хариуцна.

9.8. Гүйцэтгэх захирал нь бүрэн эрх хэмжээнийхээ хүрээнд тушаал гаргана.

## 10. КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ХЯНАЛТ

10.1. Компанийн Гүйцэтгэх Захирлын үйл ажиллагаанд тавих хяналтыг Төлөөлөн удирдах зөвлөл хэрэгжүүлнэ.

10.2. Компанийн Төлөөлөн удирах зөвлөлөөс хэрэгжүүлэх хяналтад дараах үйл ажиллагаа хамаарна. Үүнд:

10.2.1. Гүйцэтгэх Захиралтай байгуулсан гэрээний хэрэгжилт;

10.2.2. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн баталсан Компанийн стратеги, дунд болон жилийн бизнес төлөвлөгөө, төсвийн биелэлт;

10.2.3. Компанийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны төлөвлөгөөний биелэлт, бүрдүүлэлт;

10.2.4. Компанийн өмч хөрөнгийг захиран зарцуулах талаар тогтоосон Гүйцэтгэх Захирлын эрх хэмжээний хэрэгжилт;

10.2.5. Компанийн Хувьцаа Эзэмшигчийн болон Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан шийдвэр, тогтоолын хэрэгжилт.

10.3. Төлөөлөн удирдах зөвлөл болон Гүйцэтгэх Захирал нь Компанийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавих үүргийг гүйцэтгэнэ

10.4. Дотоод хяналтын үйл ажиллагааны журмыг Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас батална.

10.5. Салбар, нэгжийн үйл ажиллагаар Салбарын үйл ажиллагааны журам, Дотоод хяналтын үйл ажиллагааны журам, дотоод болон бусад холбогдох хууль тогтоомжийн актад заасны дагуу Компанийн дотоод хяналт хариуцсан ажилтан хяналт тавьж ажиллана.

## 11. КОМПАНИЙН САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮРТГЭЛ ТАЙЛАН, НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАЛТ

11.1. Компанийн санхүүгийн жил нь 1 дүгээр сарын 1-ний өдрөөс (эхний жилийн хувьд байгуулагдсан өдрөөс) эхэлж, 12 дугаар сарын 31-ний өдөр (сүүлийн жилийн хувьд Компанийн үйл ажиллагаар зогсоосон өдөр) дуусна.

11.2. Компани нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу орлогын албан татвар болон бусад албан татвар, гаалийн хураамж, газрын төлбөр болон бусад төлбөр хураамжийг төлнө.

11.3. Компани нь Монгол Улсад мөрдөгдөж байгаа хууль тогтоомж болон нягтлан бодох бүртгэлийн дүрэм журмын дагуу жилийн болон улирлын тайлан, татварын буцаалтыг бэлтгэж хүргүүлнэ.

11.4. Компани нь өөрийн хэлцлүүдийг танилцуулж тайлбарлах баримтуудыг хадгалж байх бөгөөд тэдгээр нь Компанийн санхүүгийн байдлыг хэзээд тодорхойлохуйц байна.

11.5. Аливаа ажилтны Компанид учруулсан хохирол болон эрх хэмжээгээ урвуулан ашигласан талаар зөрчил илэрсэн тохиолдолд нэн даруй Төлөөлөн удирдах зөвлөлд мэдэгдэх эрхтэй байна.

11.6. Бүхий л чек, төлбөр төлөх бичиг болон бусад санхүүгийн хэрэгсэл нь Төлөөлөн Удирдах зөвлөлөөс тогтоосон журмын дагуу гарын үсэг зурагдаж, хүлээн зөвшөөрөгдөж, бичигдэж, баталгаажсан эсхүл тусгайлан заасан журмын дагуу үйлдэгдсэн байна.

11.7. Санхүүгийн тайланд дараах бүрдэл хэсгүүдийг заавал оруулна. Үүнд:

11.7.1. Баланс;

11.7.2. Орлого үр дүнгийн тайлан;

11.7.3. Мөнгөн гүйлгээний тайлан;

11.7.4. Хуримтлагдсан ашгийн тайлан;

11.7.5. Тайлангийн тайлбар, тодруулага, илтгэх хуудас.

11.8. Санхүүгийн тайлангийн үнэн зөвийг Гүйцэтгэх Захирал хариуцна. Компанийн орон тоонд хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа Ерөнхий нягтлан бодогч энэхүү хариуцлагаас чөлөөлөгдөхгүй.

11.9. Санхүү аж ахуйн үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэл тайлан тэнцэл, татварын тооцооллын үнэн магадлал, хөндлөнгийн байгууллагаар шалгалт хийлгэж, ажил сайжруулах туслалцаа авч байна.

11.10. Компанийн жилийн санхүүгийн тайлан гарсны дараа дор дурьдсан нөхцөлд цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилна.

11.10.1. Ногдол ашиг хуваарилсны дараа Компани төлбөрийн чадвартай байх;

11.10.2. Ногдол ашиг хуваарилсны дараа Компанийн Хувь Нийлүүлсэн Хөрөнгө нь давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, татан буулгалтын үнэ, хуульд заасан өөрийн хөрөнгийн доод хэмжээний нийлбэрээс илүү байх;

11.10.3. Ногдол ашиг хуваарилсны дараа Компанийн Хувь Нийлүүлсэн Хөрөнгө нь хуваарилсны өмнөх хэмжээнээс 25-аас илүү хувиар багассан тохиолдолд ногдол ашгаа шилжүүлснээс хойш ажлын 15 хоногийн дотор зээлдүүлэгчиддээ Хувь Нийлүүлсэн Хөрөнгийн үлдэгдлийн хэмжээг бичгээр мэдэгдэнэ. Энэ үүргийг Гүйцэтгэх Захирал хэрэгжүүлнэ.

11.10.4. Ногдол ашиг хуваарилсны дараа үлдэх ашгаас ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх болон нийгэмд хандсан арга хэмжээ зохион байгуулах, сан байгуулж болно. Санг байгуулах асуудлыг Хувьцаа Эзэмшигч шийдвэрлэнэ. Уг санг байгуулах, түүний хөрөнгийг зарцуулах журмын төслийг Гүйцэтгэх Захирал боловсруулан Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулж, батлуулж мөрдөнө.

СЗХ
2019 .04. 24 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2019 -03- 26
БҮРТГЭВ

## 12. КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН

12.1. Компанийн албан ёсны шийдвэрийг гаргахад болон гэрээ, хэлцэл хийхэд шууд болон шууд бусаар оролцдог этгээдийг Компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно.Үүнд:

12.1.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн;

12.1.2. Гүйцэтгэх захирал;

12.1.3. Дэд захирал;

12.1.4. Газрын захирал;

12.1.5. Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга.

12.2. Компанийн эрх бүхий албан тушаалтан нь Компанийн тухай хууль, ажилтантай байгуулсан гэрээ, холбогдох бусад журамд заасан эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ.

## 13. БИЧИГ БАРИМТ ХАДГАЛАЛТ

13.1. Компани нь Компанийн тухай хуулийн 97 дугаар зүйлд заасны дагуу Компанийн бичиг баримтыг хадгална.

13.2. Хяналт шалгалт, лавлагаа, түүх архивын зорилгоор дараах бичиг баримтуудыг хуульд заасан хугацаагаар хадгална.

13.2.1. Компанийн дүрэм түүнд орсон нэмэлт өөрчлөлтүүд;

13.2.2. Компанийн Улсын бүртгэлийн гэрчилгээ;

13.2.3. Компанийн дотоод бичиг баримт материалууд;

13.2.4. Компанийн салбар болон төлөөлөгчийн газрын дүрэм гэрээнүүд;

13.2.5. Нягтлан бодох бүртгэлд тусгагдсан эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийг нотлох баримт бичгүүд;

13.2.6. Компанийн Хувьцаа Эзэмшигчийн шийдвэр, Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тогтоол, болон Гүйцэтгэх Захирлын тушаал, хурал зөвлөгөөний тэмдэглэл;

13.2.7. Санхүү аж ахуйн үйл ажиллагааны анхан шатны болон дэлгэрэнгүй бүртгэл, нягтлан бодох бүртгэлийн баримт бичиг материалууд;

13.2.8. Санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан тэнцэл түүнтэй холбогдох баримт материалууд.

## 14. КОМПАНИЙГ ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ, ТАТАН БУУЛГАХ, ӨР ТӨЛБӨРИЙГ БАРАГДУУЛАХ

14.1. Компанийн тухай хуульд зааснаар Компанийг хуваах, тусгаарлах, болон өөр хуулийн этгээдэд нэгтгэх, нийлүүлэх замаар өөрчлөн байгуулж болно.

14.2. Компанийг Хувьцаа Эзэмшигчийн шийдвэрээр татан буулгаж болно.

14.3. Татан буулгах комиссыг Хувьцаа Эзэмшигч томилно.

14.4. Татан буулгах комисс томилсноор тухайн Компанийн бүрэн эрх дуусгавар болж татан буулгах комисст шилжинэ.

14.5. Татан буулгах комисс нь татан буулгах ажлыг бүрэн гүйцэтгэсний дараа тайлан гаргана.

TDB CAPITAL LLC





"ИНВЕСКОР ББСБ" ХХК
InvesCore
УЛААНБААТАР ХОТ

14.6. Татан буулгах комиссоос зээлдүүлэгчийн өр төлбөрийг барагдуулсны дараа үлдсэн эд хөрөнгө нь Хувьцаа Эзэмшигчдэд олгогдоно.

14.7. Татан буулгах комисс нь Компанийн тухай хуульд заасны дагуу ажиллан, Компанийг улсын бүртгэлийн байгууллагын улсын бүртгэлээс хасалт хийлгэснээр татан буугдах ажиллагаа дуусгавар болгоно.

14.8. Татан буулгах комис үүргээ гүйцэтгэх үедээ өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас Компанид ямар нэг хохирол учруулсан бол уг хохиролыг хуульд заасан журмын дагуу хариуцан арилгана.

## 15. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

15.1. Энэхүү Дүрэм, Компанийн үйл ажиллагаатай холбогдон үүссэн Хувьцаа Эзэмшигчийн шийдвэрлэгдээгүй, эсхүл тухайн шийдвэрийг эс зөвшөөрсөнтэй холбоотой аливаа маргааныг гагцхүү шүүхээр шийдвэрлүүлнэ.

## 16. БУСАД ЗҮЙЛ

16.1. Компани нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад хууль, тогтоомж, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан холбогдох заавар журмыг мөрдөн ажиллана.

16.2. Энэхүү Дүрмийг монгол хэл дээр 3 хувь үйлдэж, нэг хувийг Санхүүгийн зохицуулах хороо, нэг хувийг улсын бүртгэлийн байгууллагад, нэг хувийг Компани өөртөө хадгална.

16.3. Энэхүү Дүрэм нь бүртгэх байгууллагад бүртгэгдсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ "ЭС АЙ БИ ЖЭЙ КАПИТАЛ" ХХК-ИЙГ ТӨЛӨӨЛЖ ИТГЭМЖЛЭГДСЭН ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭД**

**Б. АНХБОЛД**

СЗХ
2019.04.24
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2019-03-26
БҮРТГЭВ-02

InvesCore

## "ИНВЕСКОР ББСБ" ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ШИЙДВЭР

2019 оны 02 -р сарын 25-ны өдөр № А/03 Улаанбаатар хот

*Хувьцаа нэмж гаргах, хувьцаагаа*
*анх удаа олон нийтэд санал болгох тухай*

"Инвескор ББСБ" ХХК (цаашид "**Компани**" гэх)-ийн хувьцаа эзэмшигч "Эс Ай Би Жэй капитал" ХХК нь Компанийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2.2 дах заалт, 62 дугаар зүйлийн 62.1.3, 62.1.8 заалтууд, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, Компанийн Дүрмийн 7.2.13 дах заалт болон "Эс Ай Би Жэй капитал" ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2019 оны 2 сарын 24-ний өдрийн А/02 дугаар шийдвэрийг тус тус удирдлага болгон хувьцаагаа анх удаа нийтэд санал болгож Монголын Хөрөнгийн Биржээр арилжаалахтай холбогдуулан гүйцэтгүүлсэн хараат бус мэргэжлийн байгууллагуудын тайлан, дүгнэлтүүд болон Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн А/09-Т тоот тогтоолтой танилцсаны үндсэн дээр **ШИЙДВЭРЛЭХ НЬ:**

1. Компанийн **зарласан** энгийн хувьцааны тоог нийт 82,000,000 (наян хоёр сая) ширхэг болгон нэмэгдүүлсүгэй;

2. Компанийн одоогийн гаргасан 60,968,730 (жаран сая есөн зуун жаран найман мянга долоон зуун гучин) ширхэг энгийн хувьцаан дээр нэмж, зарласан энгийн хувьцаанаас нэг бүр нь 227 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 10,759,188 (арван сая долоон зуун тавин есөн мянга нэг зуун наян найман) ширхэг энгийн хувьцааг анх удаа олон нийтэд нээлттэй арилжаалахаар нэмж гаргасугай;

3. Энэхүү шийдвэрийн дагуу нэмж гаргаж буй 10,759,188 (арван сая долоон зуун тавин есөн мянга нэг зуун наян найман) ширхэг энгийн хувьцаа нь Компанийн нийт гаргасан 71,727,918 ширхэг энгийн хувьцааны 15 хувьтай тэнцэх бөгөөд Нэмж гаргах хувьцааны олон нийтэд санал болгох зах зээлийн үнийг хараат бус бизнесийн үнэлгээний тайланг үндэслэн тогтоохыг Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай;

4. Компанийн одоогийн хувьцаа эзэмшигч нь нэмж гаргах хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах давуу эрхээ хэрэгжүүлэхээс бүрэн татгалзахаар шийдвэрлэсүгэй;

5. Компанийн одоогийн хувьцаа эзэмшигч болон стратегийн хөрөнгө оруулагч нь хувьцааны хоёрдогч зах зээл нээгдсэнээс хойш 12 (арван хоёр) сарын хугацаанд

TDB CAPITAL LLC



"ИНВЕСКОР ББСБ" ХХК
InvesCore
УЛААНБААТАР ХОТ

хувьцаагаа арилжаанд оруулахгүй байх үүрэг хүлээх нөхцөлтэй болохыг дурьдсугай;

6. Нэмж гаргасан хувьцааг олон нийтэд санал болгохыг зөвшөөрч хувьцааг зах зээлд нээлттэй арилжахыг Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржээс зөвшөөрч Компанийн хэлбэрийг өөрчлөн хувьцаат компани болсны дараа зохион байгуулах Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх хувьцаат компанийн "Дүрмийн төсөл"-ийг Хавсралтад заасны дагуу баталсугай;

7. Энэхүү шийдвэрийн биелэлтийг хангаж ажиллах, Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид хувьцаагаа бүртгүүлэхэд шаардлагатай бүх талын арга хэмжээг авч ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл /Б.Анхболд/ - д даалгасугай;

8. Энэхүү шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хороо /Намики Хирохито/-нд даалгасугай.

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ "ЭС АЙ БИ ЖЭЙ КАПИТАЛ" ХХК-ИЙГ ТӨЛӨӨЛЖ ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭД:**

SIBJ CAPITAL LLC
6067209 1117238225
УЛААНБААТАР ХОТ

**Б. АНХБОЛД**

СЗХ 2019.04.24 өдөр БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2019-03-26
БҮРТГЭВ

TDB CAPITAL LLC

"ИНВЕСКОР ББСБ" ХХК
InvesCore
NON BANK FINANCIAL INSTITUTION
1116224289
УЛААНБААТАР ХОТ

2019.04.24
СЗХ
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2019 -03- 26
БҮРТГЭВ-02

*Хувьцаа эзэмшигчийн 2019 оны 02 дугаар сарын 25-ны
өдрийн А 03 дугаар Шийдвэрийн Хавсралт*

## "ИНВЕСКОР БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА ХУВЬЦААТ КОМПАНИЙН ДҮРЭМ"-ИЙН ТӨСӨЛ

### 1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. "Инвескор ББСБ" (Банк бус санхүүгийн байгууллага) ХК (цаашид "**Компани**" гэх) нь Монгол Улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн актад заасны дагуу ашгийн төлөө аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх зорилгоор нээлттэй буюу хувьцаат компанийн хэлбэрээр зохион байгуулагдсан хуулийн этгээд юм.

1.2. Энэхүү Дүрмийн зорилт нь Компанийг үүсгэн байгуулах, өөрчлөн байгуулах, дотоод үйл ажиллагаатай холбоотойгоор өөрчлөн зохион байгуулах, Компанийн удирдлага, зохион байгуулалт тэдгээрийн чиг үүрэг, үйл ажиллагааны үндсэн зарчим, хяналтын бүтэц, хувьцаа эзэмшигчийн бүрэн эрх, үүрэг, хариуцлагийг тогтоох, Дүрмийн 9.1 дэх хэсэгт заасан төлөөлөн удирдах зөвлөл (цаашид "**ТУЗ**" гэх)-ийн хурлын бүрэн эрх, үүрэг, хариуцлагийг тогтоох болон Компанийг татан буулгахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.3. Компанийн Дүрэм нь Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн акттай харшлах, зөрчилдөх тохиолдолд Компани нь холбогдох хууль тогтоомжийн актад нийцүүлэн энэхүү Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах үүрэгтэй байна. Энэ тохиолдолд Компани дээрх нэмэлт, өөрчлөлтийн талаарх мэдэгдлийг бүх хувьцаа эзэмшигчдэд хуанлийн 14 хоногийн дотор бичгээр хүргүүлнэ.

### 2. КОМПАНИЙН ОНООСОН НЭР, ОРШИН БАЙГАА ГАЗАР

2.1. Компанийн оноосон нэрийг "**ИНВЕСКОР ББСБ" ХК,** англиар **INVESCORE NBFI /Non Banking Financial Institution/ Joint Stock Company** гэнэ. Компани нь хувьцаат компани буюу "ХК" хэлбэртэй байна.

2.2. Компани хуулийн этгээдийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх, үйл ажиллагаа явуулах, гэрээ хэлцэл хийх зэрэг бүх тохиолдолд "ХК" гэсэн тэмдэглэгээг хэрэглэнэ.

2.3. Компанийн ерөнхий захиргаа, удирдлага оршин байрлаж байгаа хаяг нь Компанийн оршин байгаа хаяг байна.

### 3. КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

3.1. Компани нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль болон Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн актад заасны дагуу Санхүүгийн зохицуулах хорооноос зохих тусгай зөвшөөрлийг авсны үндсэн дээр дараах үндсэн аж ахуйн үйл ажиллагаануудыг эрхлэн явуулна. Үүнд:

3.1.1. Зээлийн үйл ажиллагаа;

3.1.2. Факторингийн үйлчилгээ үзүүлэх;

3.1.3. Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт оруулах;

3.1.4. Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх;

3.1.5. Итгэлцэлийн үйлчилгээ;

3.1.6. Төлбөрийн баталгаа гаргах.

TDB CAPITAL LLC



"ИНВЕСКОР ББСБ" ХХК
InvesCore
NON BANKING FINANCIAL INSTITUTION
УЛААНБААТАР ХОТ

145

СЗХ
2019.04.24
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2019-03-26
БҮРТГЭВ

3.2. Компани нь Компанийн тухай хууль, Иргэний хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тухай хууль, болон бусад холбогдох хууль тогтоомжийн акт, Дүрэмд заасны дагуу үйл ажиллагаагаа явуулна.

3.3. Компани нь ТУЗ болон холбогдох хууль тогтоомжийн актад заасан бусад үндэслэлээр Компанийн үйл ажиллагааг дуусгавар болгох хүртэлх хугацаанд үйл ажиллагаагаа хугацаагүй эрхлэн явуулна. Тусгай зөвшөөрөлтэйгөөр явуулах үйл ажиллагааны хугацаа нь хуулийн дагуу тусгай зөвшөөрлийн хүчин төгөлдөр хугацаагаар тодорхойлогдоно.

3.4. Дүрмийн 3.1 дэх хэсэгт заагаагүй бусад аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх асуудлыг ТУЗ шийдвэрлэх бөгөөд холбогдох төрийн байгууллагуудаас зөвшөөрөл авч бүртгүүлснээр үйл ажиллагааг эрхлэн явуулна.

## 4. КОМПАНИЙН ЭРХ ХЭМЖЭЭ

4.1. Компанийг улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэн Улсын бүртгэлийн гэрчилгээ авсан өдрийг Компани үүсгэн байгуулагдсан өдөр гэж тооцно.

4.2. Компани үүсгэн байгуулагдсан өдрөөс эхлэн Хувьцаа Эзэмшигчээс тусгайлан өмчилсөн өөрийн эд хөрөнгөтэй, өөрийн үйл ажиллагаагаар эрх олж, үүрэг хүлээх, үйл ажиллагаанаасаа үүсэн гарах үүргийг өөрийн эд хөрөнгийн хэмжээгээр хариуцах, шүүх, арбитрт өөрийн нэрийн өмнөөс оролцох эрхийн чадвартай, банкинд өөрийн нэр бүхий данстай, бие даасан тайлан балансгай, Дүрэмд заасан үйл ажиллагаа явуулах эрх зүйн чадвартай байна.

4.3. Компанийн эд хөрөнгө нь эзэмшиж байгаа эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхээс бүрдэх бөгөөд Компани нь хүлээсэн үүргээ өөрийн өмчлөлд байгаа бүх эд хөрөнгөөрөө хариуцах ба Хувьцаа Эзэмшигчдийн өр болон хүлээх үүргийг хариуцахгүй.

4.4. Хувьцаа Эзэмшигч нь Компанид оруулсан хувь нийлүүлсэн хөрөнгийнхөө хэмжээгээр санхүүгийн хариуцлага хүлээх бөгөөд Компанийн хүлээх эрх, үүрэг, өр, төлбөр шаардах эрхийг хариуцахгүй.

4.5. Компани нь Монгол Улсад болон гадаад улсад өөрийн хараат болон охин компани, салбар, төлөөлөгчийн газрыг Компанийн тухай хуулийн дагуу байгуулах эрхтэй байна. Хараат болон охин компани нь бие даасан хуулийн этгээдийн эрхийг эдлэх бөгөөд тэдгээр нь эрх бүхий байгууллагаас баталсан дүрмийн дагуу бие дааж үйл ажиллагаагаа явуулна. Салбар болон төлөөлөгчийн газар нь бие даасан хуулийн этгээдийн эрхийг эдлэхгүй бөгөөд Компанийн баталсан журмын дагуу үйл ажиллагаагаа эрхлэн явуулна.

4.6. Компани нь өөрийн тамга, цорын ганц тэмдэг (лого), бичгийн хэвлэмэл хуудастай байна. Гүйцэтгэх Захирал нь Компанийн тамга ашиглах аюулгүй ажиллагааг хангаж ажиллана. Аливаа албан бичгэн дээр дарагдах Компанийн тамга нь эрх бүхий этгээд, Гүйцэтгэх Захирал эсхүл тэдгээрийн эрх олгосон этгээдийн гарын үсгээр баталгаажигдаж гэрчлэгдэнэ.

4.7. Компани нь Санхүүгийн Зохицуулах Хорооноос авсан зөвшөөрлийг үндэслэн, салбар, төлөөлөгчийн газар байгуулж болно. Салбар, нэгжүүд нь тусдаа улсын гэрчилгээ, тамга, тэмдэг, үйл ажиллагааны журамтай байна.

## 5. КОМПАНИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ, ХУВЬЦАА

TDB CAPITAL LLC

"ИНВЕСКОР ЗЕСБ" ХХК
InvesCore
1116224289 6040854
УЛААНБААТАР ХОТ

5.1. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь Компанийн нийт гаргасан бөгөөд эргэлтэд байгаа хувьцаанаас бүрдэх бөгөөд хувь нийлүүлсэн хөрөнгөнд зарласан болон эргүүлэн худалдаж авсан халаасны хувьцаа хамаарахгүй.

5.2. Компанийн зарласан энгийн хувьцааны тоо нэг бүр нь 227 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 82,000,000 (наян хоёр сая) ширхэг байна.

5.3. Компани нь нэг бүр нь 227 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 71,727,918 (далан нэгэн сая долоон зуун хорин долоон мянга есөн зуун арван найман) ширхэг хувьцааг гаргасан бөгөөд хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь 16,282,237,386 (арван зургаан тэрбум хоёр зуун наян хоёр сая хоёр зуун гучин долоон мянга гурван зуун наян зургаан) төгрөг байна.

5.1. Компани Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ, үйл ажиллагааы зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хангаж ажиллана.

5.2. Компани нь давуу эрхийн хувьцаа гаргаж болно. Давуу эрхийн хувьцааны тоо, нэрлэсэн үнэ, зориулалт, тухайн төрлийн хувьцаа эзэмшигчдэд олгох давуу эрх зэргийг тухай бүр Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.

5.3. Гаргасан хувьцааны төлбөрийг мөнгөн бус хэлбэрээр хийж болох бөгөөд энэ тохиолдолд хувьцааны төлбөрт хүлээн авч байгаа эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх, оюуны өмчийн үнэлгээг эрх бүхий үнэлгээний байгууллагын дүгнэлтийг үндэслэн ТУЗ тогтооно.

5.4. Компани нь өөрийн хуримтлагдсан ашгийн хэмжээгээр хувь нийлүүлсэн хөрөнгөө нэмэгдүүлж болно. Шаардлагатай тохиолдолд хувь нийлүүлсэн хөрөнгөнд шинээр хөрөнгө оруулалт оруулж болно.

5.5. Компани тодорхой нөхцөлөөр хаалттай захилгын үндсэн дээр хувьцаа болон бусад үнэт цаас гаргаж болно.

## 6. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ, ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

6.1. Компанийн энгийн хувьцааг худалдан авч эзэмшсэн этгээд Компанийн хувьцаа эзэмшигч байна.

6.2. Компаниас хууль тогтоомжийн дагуу ногдол ашиг хуваарилахаар зарлан мэдэгдсэний дагуу ногдол ашиг авах эрхтэй байна.

6.3. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал зарлах үед ТУЗ-өөс тогтоосон “бүртгэлийн өдөр” компанийн хувьцааг эзэмшиж байсан этгээд хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож хэлэлцэж буй бүх асуудлаар өөрийн эзэмшлийн саналын эрхтэй хувьцааны тоотой хувь тэнцүүлэн санал өгөх эрхтэй байна.

6.4. Дүрмийн 5.7 дах хэсэгт зааасан асуудал болон хувьцаа эзэмшигчдэд хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байх асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа хувьцаа эзэмшигчдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ.

6.5. Хувьцаа эзэмшигч нь Компаниас нэмж гаргасан хувьцаа, хувьцаанд хөрвөх үнэт цаасыг тодорхой нөхцөлөөр тэргүүн ээлжид худалдан авах эрхтэй байна. Энэ давуу эрхийг Компанийн тухай хуулийн 38-р зүйлд заасан журмын дагуу хэрэгжүүлэх үүргийг ТУЗ хүлээнэ.

6.6. Саналын эрх бүхий энгийн хувьцааны тав буюу түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч нь хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах

асуудлаар болон ТУЗ, тооллогын комиссын гишүүнд нэр дэвшүүлэх хүний талаарх саналаа хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулахаар өмнөх санхүүгийн жил дууссанаас хойш хуанлийн 60 хоногийн дотор ТУЗ эсхүл Гүйцэтгэх захиралд гаргаж болно. Санал хүргүүлсэн хувьцаа эзэмшигч нь Компанийн тухай хуулийн 66.3 дах хэсэгт заасан нөхцөлийг хангасан саналыг хүргүүлнэ.

6.7. Саналын эрх бүхий энгийн хувьцааны арван хувиас дээш хувийг эзэмшигч нь Компанийн санхүүгийн үйл ажиллагаанд аудитын шалтгалтыг жилд нэг удаа тодорхой үндэслэл бүхий шаардлага гарган хийлгэх эрхтэй. Ийнхүү шаардлага гаргасан хувьцаа эзэмшигч шаардлагын дагуу шалгалт хийсэн аудиторын зардлыг хариуцна.

6.8. Компанийн энгийн хувьцааны гуравны нэг буюу түүнээс дээш хувийг дангаараа эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран худалдан авсан этгээд нь уг хяналтын багцыг худалдан авсан өдрөөс хойш ажлын 60 өдрийн дотор бусад хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж байгаа хувьцааг уг хувьцааны сүүлийн 6 сарын зах зээлийн үнийн жигнэсэн дунджаас доошгүй үнээр худалдан авахаар санал болгох үүрэгтэй байна.

6.9. Саналын эрх бүхий энгийн хувьцааны арав буюу түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшигч Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулахаар ТУЗ-д санал шаардлага гаргах эрхтэй. Ийнхүү санал, шаардлага гаргаж буй хувьцаа эзэмшигч нь санал, шаардлагаа бичгээр гаргах буюу Компанийн тухай хуулийн 61.3 дах хэсэгт заасан шаардлагыг хангасан байна.

6.10. Хувьцаа эзэмшигч нь Компанийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд гагцхүү эзэмшиж байгаа хувьцаанд оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээгээр хариуцлага хүлээнэ.

6.11. Компанийг татан буулгах үед Компанийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан журмын дагуу үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хувь хүртэх эрхтэй байна.

6.12. Компанийн ТУЗ-ийн гишүүн эсхүл эрх бүхий албан тушаалтан болсон хувьцаа эзэмшигч, дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран Компанийн хувьцааны арваас дээш хувийг эзэмшдэг бөгөөд түүний буруутай үйл ажиллагааны улмаас Компанид учруулсан эд хөрөнгийн хохирлыг тухайн этгээд өөрийн хувийн эд хөрөнгөөр Компанийн өмнө хариуцна.

6.13. Энэхүү Дүрэмд тусгагдаагүй хувьцаа эзэмшигчдийн эрх, үүрэг, хариуцлагатай холбоотой бусад харилцааг Монгол Улсын холбогдох хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн актад заасны дагуу зохицуулна.

## 7. КОМПАНИ ҮНЭТ ЦААС ГАРГАХ, ХУДАЛДАХ, ЭРГҮҮЛЭН АВАХ

7.1. Компани нь гаргасан энгийн хувьцаанаас гадна давуу эрхийн хувьцаа, өрийн бичиг, хувьцаанд хамаарах үнэт цаас /*опцион, хувьцаанд хөрвөх үнэт цаас*/ гаргаж болно.

7.2. Компани зарласан хувьцаанаас гүйлгээнд нэмж гаргах шийдвэрийг Төлөөлөн удирдах зөвлөл гаргана.

7.3. Үнэт цаасыг нийтэд санал болгон худалдахаар шийдвэрлэсэн бол Үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэнэ.

СЗХ
2019 04. 24 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2019 -03- 26
БҮРТГЭВ-02

7.4. Компанийн тодорхой тооны энгийн болон давуу эрхийн хувьцааг тогтоосон үнээр, тогтоосон хугацаанд худалдах, худалдан авах эрхийг баталгаажуулсан опцион гаргаж болно.

7.5. Компаниас гаргасан хувьцаанд хөрвөх үнэт цаасаар хөрвөх хувьцааны тоо, нийт гаргасан опционоор худалдах хувьцааны тоо, гүйлгээнд гаргасан хувьцааны тоо зэргийн нийлбэр нь нийт зарласан хувьцааны тооноос илүү байж болохгүй.

7.6. Хувьцаа болон бусад үнэт цаасны үнийг Компанийн тухай хуулийн 55-р зүйлд заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөл тогтооно.

7.7. Компаниас шинээр болон нэмж гаргаж байгаа хувьцааны төлбөр нь мөнгө, үнэт цаас, эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн хэлбэрээр байж болно.

7.8. Компани өөрийн гаргасан үнэт цаасыг эзэмшигчтэй нь тохиролцсоны үндсэн дээр худалдан авч болно. Компани энгийн хувьцаанаас бусад үнэт цаасыг бүхэлд нь эсхүл зарим хэсгийг худалдан авч болно. Харин энгийн хувьцааны хувьд тухайн жилд гүйлгээнд байсан нийт хувьцааны хорин таван хувиас хэтрэхгүй байна.

7.9. Компани өөрийн гаргасан үнэт цаасыг худалдан авах шийдвэрийг Компанийн тухай хуулийн 53.2 дах хэсэгт заасанаас бусад тохиолдолд ТУЗ гаргах бөгөөд уг шийдвэрт худалдаж авах үнэт цаасны төрөл тоо, үнэ, төлбөр хийх хугацаа, ашиглах журам зэргийг заана.

## 8. КОМПАНИЙН УДИРДЛАГА

8.1. Компанийн эрх бүхий дээд байгууллага нь Хувьцаа Эзэмшигчдийн хурал байна.

8.2. Хувьцаа эзэмшигчдийн хурал нь ээлжит болон ээлжит бус байна.

8.3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Төлөөлөн удирдах зөвлөлөөс санхүүгийн жил дууссанаас хойш 4 сарын дотор зарлан хуралдуулна.

8.4. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг даргалах этгээдийг тухайн хурлыг хуралдуулах санал гаргасан этгээд байх бөгөөд түүнийг тухайн хурал хуралуудах шийдвэрт тусгана.

8.5. Хувьцаа Эзэмшигчдийн хурал нь дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх эрхтэй байна. Үүнд:

8.5.1. Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, түүний шинэчилсэн найруулгыг батлах;

8.5.2. Нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах, буюу өөрчлөх замаар Компанийг өөрчлөн байгуулах;

8.5.3. Компанийн өрийг хувьцаагаар солих, хувьцаа нэмж гаргах, түүний тоог тогтоох;

8.5.4. Компанийн хэлбэрийг өөрчлөх, ТУЗ-ийн өөрчлөн зохион байгуулах төслийг батлах, шийдвэр гаргах;

8.5.5. Компанийг татан буулгах, татан буулгах комиссыг томилох;

8.5.6. Компанийн хувьцааг хуваах, нэгтгэх;

8.5.7. ТУЗ-ийн гишүүнийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох, эрх хэмжээг тогтоох;

8.5.8. Хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаасыг тэргүүн ээлжид худалдан авах давуу эрхийг хувьцаа эзэмшигчдэд эдлүүлэх эсэх шийдвэр гаргах;

TDB CAPITAL LLC



"ИНВЕСКОР ББСБ" ХХК
5
InvesCore
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2019.04.24 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2019-03-26
БҮРТГЭВ

8.5.9. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөх;

8.5.10. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;

8.5.11. ТУЗ-өөс хэлэлцүүлэхээр оруулсан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах;

8.5.12. Компанийн гаргасан хувьцааг буцаан худалдан авахыг зөвшөөрөх;

8.5.13. ТУЗ-ийн шийдвэрээр хувьцаа эзэмшигчдийн оруулсан бусад асуудлууд;

8.5.14. Хууль тогтоомжийн актад заасан бусад.

8.6. Нэг энгийн хувьцаа нэг саналын эрхтэй байна. ТУЗ-ийн гишүүдийг сонгоход саналын эрхийн тоог тухайн хувьцаа эзэмшигчийн эзэмшиж буй хувьцааны тоог ТУЗ-д сонгогдох гишүүний тоогоор үржүүлж тодорхойлно.

8.7. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах Дүрмийн 8.5.1-8.5.6 дах заалтуудад заасан асуудлыг саналын эрхтэй хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн дийлэнх олонхийн саналаар, Дүрэм болон холбогдох хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол бусад асуудлыг саналын эрхтэй хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.

8.8. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдах тухай нийтэд зарлах, хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийг тодруулах санал авах ажиллагааг Компанийн тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан "Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар, мэдээ хүргэх журам"-ын дагуу зохицуулна.

8.9. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай шийдвэр гаргаж, хурлаар хэлэлцэх асуудлын товыг тогтоосноос хойш ТУЗ, Гүйцэтгэх захирал, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэрээр Хувьцаа эзэмшигчдийн хурлаар нэн даруй хэлэлцэж шийдвэрлэх асуудал гарсан тохиолдолд хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн дийлэнх олонхийн саналаар уг асуудлыг хэлэлцэхээр шийдвэр гаргаж болно.

8.10. Компанийн саналын эрхтэй хувьцааны дийлэнх олонхийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хуралд оролцсоноор хурал хүчин төгөлдөр болно. Хэрэв Хувьцаа эзэмшигчдийн хурал хүчин төгөлдөр болох хувь хүрээгүй бол хурлыг хүчин төгөлдөр бус гэж үзэж хурлыг хойшлуулж дахин хуралдах өдрийг товлож энэ тухай тэмдэглэл үйлдэн ТУЗ-ийн Дарга гарын үсэг зурна. Тухайн хойшлогдсон Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлыг өөрчилж болохгүй.

8.11. Саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн олонхи оролцсоноор Дүрмийн 8.10 дах хэсэгт заасан хойшлогдсон хурал хүчин төгөлдөр болно.

8.12. Дүрмийн 8.10 дах хэсэгт заасан хойшлогдсон хурлын бүртгэлийн өдрийг өөрчлөхгүй ба ажлын 20 өдрийн дотор дахин зарлан хуралдуулна. Хойшлогдсон хурал хуралдахаас хамгийн багадаа ажлын 5 өдрийн өмнө хойшлогдсон хурал болох газар, өдөр, цагийг дахин мэдээллэнэ.

8.13. Дүрмийн 8.10 дах хэсэгт заасан хойшлогдсон хурал ажлын 20 өдрийн дотор хуралдаж чадаагүй тохиолдолд шинээр хурал товлон зарлаж хурал хүчин төгөлдөр болох ирцийг Дүрмийн 8.10 дах хэсэгт заасанаар тогтооно.

8.14. Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлыг хурал хуралдуулахгүйгээр хувьцаа эзэмшигчдээс эчнээ санал хураалт явуулах замаар шийдвэрлэж болно. Эчнээ санал хураалтыг Компанийн тухай хуульд заасны дагуу явуулна.

TDB CAPITAL LLC

"ИНВЕСКОР ПАСИ" ХХК
InvesCore
УЛААНБААТАР ХОТ

СЗХ 2019.04.24 БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2019-03-26 БҮРТГЭВ-02

8.15. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал болон дараах асуудлыг шийдвэрлэх хурлыг эчнээ санал хураалтаар явуулахыг хориглоно.

8.15.1. Компанийн Дүрмийн нэмэлт, өөрчлөлт, шинэчилсэн найруулгыг батлах;

8.15.2. Компанийг өөрчлөн байгуулах, зохион байгуулалтын хэлбэрийг өөрчлөх.

8.16. Компанийн нийт гаргасан хувьцааны арваас дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигч нь өөрөө хүсвэл эчнээ санал хураалтын дүнг нэгтгэн гаргах тооллогын комиссын үйл ажиллагаанд ажиллагчаар оролцох эрхтэй байна.

8.17. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэлийг Компанийн тухай хуульд заасан журмын дагуу хөтөлж, баталгаажуулан хадгална.

## 9. ТУЗ, ТҮҮНИЙ ЭРХ ХЭМЖЭЭ

9.1. Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт Компанийн эрх барих байгууллага нь ТУЗ байна. ТУЗ нь эрх хэмжээнийхээ дагуу хамгийн цөөндөө улирал бүр хуралдаж тогтоол гаргана.

9.2. ТУЗ нь нийт 9 гишүүнтэй байх бөгөөд тэдгээрийн 3 гишүүн нь хараат бус гишүүн байна.

9.3. ТУЗ-ийн гишүүдийн дийлэнх олонхийн саналаар ТУЗ-ийн дарга (цаашид "**ТУЗ-ийн Дарга**" гэх)-ыг ТУЗ-ийн гишүүдийн дотроос сонгоно.

9.4. ТУЗ-ийн гишүүн болон ТУЗ-ийн Даргыг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар гурван жилийн хугацаатай сонгоно. ТУЗ-ийн гишүүдийг сонгохдоо санал хураах кумулятив аргыг хэрэглэнэ.

9.5. ТУЗ-өөс тогтоол гаргах бөгөөд түүнд ТУЗ-ийн дарга гагцхүү гарын үсэг зурж баталгаажуулна.

9.6. ТУЗ нь Хувьцаа Эзэмшигчийн бүрэн эрхэд хамааруулснаас бусад дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

9.6.1. Компанийн эрхлэх үйл ажиллагааны чиглэлийг тогтоох, өөрчлөх;

9.6.2. Хувьцаа эзэмшигчийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах, хурлаар хэлэлцэх асуудал, хурлын бүртгэлийн өдөр, хурлын товыг тогтоох, саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах, хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулахтай холбоотой бусад асуудлыг шийдвэрлэх;

9.6.3. Компанийн зарласан хувьцааны төрөл болон тоонд багтаан хувьцаа нэмж гаргах;

9.6.4. Нэмж гаргах хувьцаа нь их хэмжээний хэлцэлд хамаарах бол хувьцаа нэмж гаргах асуудлыг ТУЗ-ийн гишүүд санал нэгтэй шийдвэрлэх бөгөөд санал нэгдээгүй тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлэх;

9.6.5. Хувьцаанд хамаарах болон бусад үнэт цаас гаргах;

9.6.6. Өөрийн гаргасан нийт энгийн хувьцааны тав хүртэлх хувийг болон бусад үнэт цаасыг худалдах, эргүүлэн авах шийдвэр гаргах;

9.6.7. Компанийн стратеги болон дунд хугацаа, жилийн бизнес төлөвлөгөө, төсөв, үйл ажиллагааны бодлогыг батлах;

9.6.8. Компанийн бүтэц, зохион байгуулалт, орон тоог батлах;

TDB CAPITAL LLC





"ИНВЕСКОР ББСБ" ХХК InvesCore НЕБАНКНЫ САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА УЛААНБААТАР ХОТ

СЭХ
2019 .04 сар 24 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2019 -03- 26
БҮРТГЭВ

9.6.9. Компанийн бүх төрлийн бодлогын болон засаглалын баримт бичгийг батлах;

9.6.10. ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох, үйл ажиллагааны журмыг батлах;

9.6.11. Компанийн Гүйцэтгэх Захирлыг Сонгох, түүний бүрэн эрхийг тогтоох, бүрэн эрхийг хугацаанаас өмнө дуусгавар болгох, тусгайлсан асуудлаар түүнд эрх олгох;

9.6.12. Гүйцэтгэх Захиралтай байгуулах гэрээний нөхцөлийг батлах, өөрчлөлт оруулах, түүнд олгох, шагнал, урамшуулал, цалингийн хэмжээг тогтоох;

9.6.13. Компанийн тухайн жилийн бизнес төлөвлөгөөний гүйцэтгэл, үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргах;

9.6.14. Компанийн аудитын байгууллагыг сонгож, түүнтэй байгуулах гэрээний нөхцөлийг тогтоох;

9.6.15. Компанийн тухай хуулийн 11 дүгээр бүлэгт заасан их хэмжээний хэлцлийг батлах;

9.6.16. Компанийн тухай хуулийн 12 дугаар бүлэгт заасан сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах;

9.6.17. Компанийн өдөр тутмын үйл ажиллагаатайгаас бусад бизнес төлөвлөгөө болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлахад тодорхойлох боломжгүй байсан 1,000,000,001₮ (нэг тэрбум нэг) төгрөгөөс дээш зах зээлийн үнэтэй үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, барьцаалах, барьцаалуулах болон бусад хэлбэрээр захиран зарцуулах шийдвэр гаргах, түүнтэй холбогдсон гэрээ, хэлцэл эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн гэрээ, хэлцэлийг батлах, гэрээ, хэлцэл хийх зөвшөөрөл олгох;

9.6.18. Ногдол ашиг хуваарилах эсэх талаар шийдвэр гаргаж, ногдол ашгийн хэмжээ, хуваарилах журам, бодлого тодорхойлох;

9.6.19. Хараат болон охин компани, салбар, төлөөлөгчийн газар байгуулах, тэдгээрийн эрх хэмжээ, үйл ажиллагааны чиглэлийг тогтоох;

9.6.20. Компанийг өөрчлөн байгуулах төсөл боловсруулж Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэх, шийдвэрийн төслийг бэлтгэх, гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;

9.6.21. ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо, нэр дэвшүүлэх хороо, цалин урамшууллын хороо болон эрсдэлийн удирдлагын хорооны гишүүдийг томилох тэдгээрийн эрх, үүргийг тодорхойлсон үйл ажиллагааны журмыг батлах;

9.6.22. Компанийн Дүрмээр болон хууль тогтоомжийн актад заасан бусад эрх;

9.6.23. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас эрх олгосон бусад асуудал.

9.7. ТУЗ-ийн Дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг зохион байгуулж, түүний хурлыг хуралдуулах, хурал даргалах, хурлын тэмдэглэлийг хөтлүүлэх, хяналт тавих зэрэг Компанийн тухай хуульд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

9.8. ТУЗ нь ТУЗ-ийн нарийн бичгийн даргатай байх бөгөөд түүнийг ТУЗ-ийн Дарга томилно.

TDB CAPITAL LLC

"ИНВЕСКОР ЗЕЭЛ" ХХК
Invescore
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
2019.04.24 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2019-03-26

9.9. ТУЗ-ийн гишүүдийн дийлэнх олонхи оролцсоноор хурал хүчин төгөлдөр болох бөгөөд хуралд оролцож байгаа гишүүдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэр хүчин төгөлдөр болно.

9.10. ТУЗ-ийн гишүүд нь ТУЗ-ийн хуралд биечлэн оролцох боломжгүй тохиолдолд цахим болон утсан холбооны харилцааг ашиглан хуралд оролцож хэлэлцэх асуудлаар санал өгөх болон эчнээ санал хураалтаар санал өгч шийдвэр гаргаж болно.

9.11. Компанийн тухай хуулийн 96.4 дэх хэсэгт заасан тайланг бэлтгэж, хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлагнана.

9.12. ТУЗ болон түүний дэргэдэх дэд хороод нь батлагдсан үйл ажиллагааныхаа журмын дагуу үйл ажиллагаа эрхлэн явуулна.

9.13. ТУЗ-ийн хараат бус гишүүд нь Компанийн тухай хуулийн 75.8, 79.1 дэх хэсэгт заасан шалгуур болон "ТУЗ-ийн үйл ажиллагааны журам"-д заасан шаардлагыг хангасан байна.

9.14. ТУЗ-ийн аль нэг гишүүн удаан хугацаагаар үүргээ хэрэгжүүлж чадахгүй болсон эсхүл нас барсан тохиолдолд түүнийг орлох этгээдийг нөхөн сонгууль явуулах хүртэл ТУЗ-өөс түр томилно.

9.15. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Дүрэмд заасан хугацаанд зарлан хуралдуулаагүй тохиолдолд ТУЗ-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурал зарлан хуралдуулахаас бусад бүрэн эрх тухайн жилийн 05 дугаар сарын 01-ний өдрөөр дуусгавар болно.

9.16. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын шийдвэрээр ТУЗ-ийн бүрэн эрх, бүрэн бүрэлдэхүүнийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгож болно.

9.17. ТУЗ түүний хурлын бүрэн эрх, хуралтай холбоотой асуудлыг Компанийн тухай хууль болон "ТУЗ-ийн үйл ажиллагааны журам"-д заасны дагуу зохицуулна.

## 10. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ХОРОО

10.1. ТУЗ нь байнгын үйл ажиллагаатай Аудитын хороо, Нэр дэвшүүлэх хороо, Цалин, урамшууллын хороо, Эрсдэлийн удирдлагын хороодтой байна.

10.2. ТУЗ нь шаардлагатай гэж үзвэл тодорхой асуудал эрхэлсэн байнгын болон түр хороог Компанийн тухай хуулийн 81-р зүйлд заасны дагуу байгуулж болно.

10.3. ТУЗ нь хороодын бүтэц, бүрэлдэхүүнийг Компанийн тухай хуулийн 81.2 дах хэсэгт заасны дагуу томилно.

10.4. ТУЗ-ийн дэргэдэх хороод нь тодорхой чиг үүрэгтэй байх бөгөөд тухайн асуудлаар дүгнэлт гаргаж ТУЗ-д танилцуулах, Компанийн тухай хууль болон энэхүү Дүрэмд заасан асуудлаар шийдвэр гаргах бүрэн эрхтэй байна.

10.5. ТУЗ-ийн дэргэдэх хороодын чиг үүрэг, бүрэн эрх хэмжээ болон үйл ажиллагааны журмыг ТУЗ батална.

## 11. ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ, ТҮҮНИЙ ЭРХ ХЭМЖЭЭ

11.1. Компанийн гүйцэтгэх удирдлагыг ТУЗ-ийн сонгосон Гүйцэтгэх Захирал (цаашид **"Гүйцэтгэх Захирал"** гэх) хэрэгжүүлэх ба Гүйцэтгэх захирал нь Дүрэм болон ТУЗ-тэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.

11.2. Гүйцэтгэх Захирал нь Компанийг төлөөлж энэхүү Дүрэмд заасан өдөр тутмын үйл ажиллагааг тусгайлсан итгэмжлэлгүйгээр хэрэгжүүлнэ.

"ИНВЕСКОР ББСБ" ХХК
Invescore
УЛААНБААТАР ХОТ
TDB CAPITAL LLC

11.3. Гүйцэтгэх Захирал нь ТУЗ-ийн гишүүн байж болно.

11.4. Гүйцэтгэх Захирал нь өөрт олгогдсон бүрэн эрхээ зохистой үйл ажиллагаанд хэрэгжүүлэх ба энэхүү Дүрэм болон ТУЗ-тэй байгуулсан гэрээтэй зөрчилдөх хэлбэрээр ажиллахыг хориглоно. Гүйцэтгэх Захирал нь өөрийн эрх, үүргийг хэрэгжүүлэхдээ үнэнч шударга байж Компанийн эрх, ашиг сонирхлыг тэргүүнд тавьж ажиллана.

11.5. Гүйцэтгэх Захирал нь дор дурьдсан эрх хэмжээтэй байна. Үүнд:

11.5.1. Компанийн стратегийн бодлого, дунд хугацааны болон жилийн бизнес төлөвлөгөө, төсвийг Компанийн зорилго, зорилтод нийцүүлэн боловсруулж ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн батлуулах;

11.5.2. Компанийн бүтэц, зохион байгуулалт, орон тоо, цалингийн систем зэргийг батлагдсан хүрээнд удирдан, зохион байгуулах, тэдгээртэй холбоотой шийдвэр гаргах;

11.5.3. Компанийн үйл ажиллагааг тухайн жилийн батлагдсан бизнес төлөвлөгөө, төсвийн хүрээнд эрхлэн явуулах, захиран зарцуулах;

11.5.4. Компанийн хараат болон охин компанийн хувьцаа эзэмшигчийн эрхийг итгэмжлэлгүйгээр төлөөлж, хувьцаа эзэмшигчийн бүх шийдвэрт Компанийн нэрийн өмнөөс төлөөлөн гарын үсэг зурах;

11.5.5. Компанийн эрхэлж буй үндсэн болон туслах үйл ажиллагаатай холбоотойгоос бусад 100,000,000 (нэг зуун сая) төгрөг хүртэлх зах зээлийн үнэтэй үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгийн эрх холбоотой мөн тухайн жилийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой ТУЗ-өөс олгосон эрх хэмжээний хүрээнд нэг нэг буюу хоорондоо шууд хамааралтай хэд хэдэн гэрээ, хэлцлийг байгуулах гэрээ, гарын үсэг зурах, уг эрхээ өөр этгээдэд итгэмжлэлээр олгох;

11.5.6. Зээлийн хорооны гишүүдийг томилох, чөлөөлөх;

11.5.7. Өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой заавар, журам, дүрэм батлан мөрдүүлэх;

11.5.8. Компанийн нэрийн өмнөөс аж ахуйн болон хөрөнгө оруулалтын үндсэн үйл ажиллагаатай холбогдсон нэг буюу хоорондоо шууд хамааралтай хэд хэдэн гэрээ, хэлцлийн нийлбэр дүн 100,000,000 (нэг зуун сая) төгрөгөөс дээш үнийн дүнтэй гэрээ, хэлцэл байгуулах зөвшөөрлийг ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн зөвшөөрөл авсны үндсэн дээр тухайн гэрээ, хэлцлийг байгуулах

11.5.9. Хувьцаа эзэмшигч болон ТУЗ-өөс шаардсан тайлан, мэдээлэл, баримт бичгийг тухай бүр бэлтгэн гаргаж өгөх;

11.5.10. Компанийн үйл ажиллагаатай холбогдон үүссэн шүүхийн маргаан, өр барагдуулах үйл ажиллагаа, хэрэг хянан шийдвэрлэх болон захиргааны журмаар шийдвэрлүүлэх аливаа ажиллагаанд Компанийг төлөөлөн оролцож, асуудлыг шийдвэрлэх, энэ талаар өмгөөлөгч болон бусад тусгайлан эрх авсан холбогдох этгээдүүдтэй гэрээ байгуулах, Компанийг төлөөлөх этгээдэд итгэмжлэл олгох, эрх ашгийг хамгаалах холбогдох арга хэмжээг авах;

11.5.11. Компанийн үндсэн болон гэрээт ажиллагсадыг ажилд авах, чөлөөлөх, хөдөлмөрийн гэрээ болон бусад төрлийн гэрээ байгуулах, цуцлах, дуусгавар болгох, тэдгээрийн ажлын байрны тодорхойлолтыг батлах, ажлын гүйцэтгэлд хяналт тавих, урамшуулах, Хөдөлмөрийн тухай хууль болон Компанийн Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу ажилтанд хөдөлмөрийн сахилгын арга хэмжээ авах, холбогдох гэрээний дагуу хариуцлага тооцох;

11.5.12. Хувьцаа эзэмшигч, ТУЗ-ийн бүрэн эрхэд хамаарахаас бусад Компанийн эрх бүхий албан тушаалтан, салбар, төлөөлөгчийн газрын гүйцэтгэх удирдлагыг бие даан томилох, чөлөөлөх, бүрэн эрх хэмжээг тогтоох, ажлын байрны тодорхойлолтыг батлах, шаардлагатай тохиолдолд хугацаанаас нь өмнө чөлөөлөх, тэдгээрийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх.

11.6. Гүйцэтгэх Захирал нь дор дурьдсан үүргийг хүлээнэ. Үүнд:

11.6.1. Компанийн дүрэм, Хувьцаа Эзэмшигчийн хурал, ТУЗ-өөс баталсан дотоод журамд заасан үүргийг биелүүлж, Компанийн ашиг сонирхлын төлөө үнэнч шударгаар ажиллах;

11.6.2. Компанийн үйл ажиллагааг Монгол Улсын хууль, тэдгээрт нийцүүлэн гаргасан эрх зүйн акт, Банк бус санхүүгийн байгууллагад холбогдох хууль, тогтоомж, журам болон Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанкны шаардлагад бүрэн нийцүүлж ажиллах;

11.6.3. Хувьцаа Эзэмшигчийн болон ТУЗ-ийн шийдвэр, тогтоол, Компанийн бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах;

11.6.4. Санхүүгийн тайлан бүртгэлийг холбогдох хууль, тогтоомж, заавар, журмын дагуу үнэн зөв гаргуулах;

11.6.5. Хөлсөөр ажиллах гэрээгээр тогтоосон үүргийг биелүүлэх.

11.7. Гүйцэтгэх Захирал нь ТУЗ-ийн зөвшөөрөлгүйгээр Компанийн нэгдлийн оролцогчид хамаарахгүй этгээдийн гүйцэтгэх удирдлагаар ажиллахыг хориглоно.

11.8. Компанийн эрх бүхий албан тушаалтан нь өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас, Компанид учруулсан эд хөрөнгийн хохиролыг өөрийн хөрөнгөөр Компанийн өмнө хариуцна.

11.9. Гүйцэтгэх захирал нь бүрэн эрх хэмжээнийхээ хүрээнд тушаал гаргана.

## 12. КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ХЯНАЛТ

12.1. ТУЗ нь Гүйцэтгэх Захирлын үйл ажиллагаанд тавих хяналтыг хэрэгжүүлнэ.

12.2. Компанийн Төлөөлөн удирах зөвлөлөөс хэрэгжүүлэх хяналтад дараах үйл ажиллагаа хамаарна. Үүнд:

12.2.1. Гүйцэтгэх Захиралтай байгуулсан гэрээний хэрэгжилт;

12.2.2. Компанийн ТУЗ-ийн баталсан Компанийн стратеги, дунд болон жилийн бизнес төлөвлөгөө, төсвийн биелэлт;

12.2.3. Компанийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны төлөвлөгөөний биелэлт, бүрдүүлэлт;

12.2.4. Компанийн өмч хөрөнгийг захиран зарцуулах талаар тогтоосон Гүйцэтгэх Захирлын эрх хэмжээний хэрэгжилт;



150

СЗХ 2019.04.24 өдөр БҮРТГЭВ №01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2019-03-26

12.2.5. Компанийн Хувьцаа Эзэмшигчийн болон ТУЗ-ийн гаргасан шийдвэр, тогтоолын хэрэгжилт.

12.3. Дотоод хяналтын үйл ажиллагааны журмыг ТУЗ-ийн хурлаас батална.

12.4. Санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийх аудиторын шалгалт нь ээлжит бус байна. Компанийн жилийн санхүүгийн тайланд дүгнэлт өгөхийн тулд ээлжит шалгалт хийнэ.

12.5. Ээлжит бус шалгалтыг ТУЗ-ийн шийдвэр, Компанийн энгийн хувьцааны арван хувиас дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигч, Гүйцэтгэх захирлын шийдвэрээр хэдий ч хийж болно. Аль нэг хувьцаа эзэмшигчийн захиалгаар хийгдсэнээс бусад шалгалтын хөлсийг Компани хариуцан төлнө. Хувьцаа эзэмшигчийн захиалгаар хийгдсэн шалгалтын хөлсийг тухайн хувьцаа эзэмшигч хариуцаж төлөх бөгөөд шалгалтын явцад эрх бүхий албан тушаалтан эсхүл хувьцаа эзэмшигч хуулийн этгээд, хувьцаа эзэмшигчид болон зээлдүүлэгчдэд хохирол учруулсан нь тогтоогдвол шалгалтын хөлсийг буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.

12.6. Салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг холбогдох дотоод журам болон холбогдох хууль тогтоомжийн актад заасны дагуу Компанийн дотоод хяналт хариуцсан ажилтан хяналт тавьж ажиллана.

## 13. КОМПАНИЙН САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮРТГЭЛ ТАЙЛАН, НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАЛТ

13.1. Компанийн санхүүгийн жил нь 1 дүгээр сарын 1-ний өдрөөс (эхний жилийн хувьд байгуулагдсан өдрөөс) эхлэж, 12 дугаар сарын 31-ний өдөр (сүүлийн жилийн хувьд Компанийн үйл ажиллагааг зогсоосон өдөр) дууснa.

13.2. Компани нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу орлогын албан татвар болон бусад албан татвар, гаалийн хураамж, газрын төлбөр болон бусад төлбөр хураамжийг төлнө.

13.3. Компани нь Монгол Улсад мөрдөгдөж байгаа хууль тогтоомж болон нягтлан бодох бүртгэлийн дүрэм, журмын дагуу санхүү, нягтлан бодох бүртгэлээ хөтөлж холбогдох тайлан, балансыг татвар, санхүүгийн байгууллага, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид хууль тогтоомжид заасан хугацаанд хүргүүлнэ.

13.4. Санхүүгийн тайлангийн үнэн зөвийг Гүйцэтгэх Захирал хариуцна. Компанийн орон тоонд хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа Ерөнхий нягтлан бодогч энэхүү хариуцлагаас чөлөөлөгдөхгүй.

13.5. Компани нь Санхүү аж ахуйн үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэл тайлан тэнцэл, татварын тооцооллын үнэн зөв магадлал, хөндлөнгийн байгууллагаар шалгалт хийлгэж, ажил сайжруулах туслалцаа авч байна.

13.6. Компанийн жилийн санхүүгийн тайлан гарсны дараа дор дурьдсан нөхцөлд цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилна.

13.6.1. Ногдол ашиг хуваарилсны дараа Компани төлбөрийн чадвартай байх;

13.6.2. Ногдол ашиг хуваарилсны дараа Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, татан буулгалтын үнэ, хуульд заасан өөрийн хөрөнгийн доод хэмжээний нийлбэрээс илүү байх;

13.6.3. Ногдол ашиг хуваарилсны дараа Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь хуваарилсны өмнөх хэмжээнээс 25-аас илүү хувиар багассан тохиолдолд ногдол ашгаа шилжүүлснээс хойш ажлын 15 хоногийн дотор



"ИНВЕСКОР ББСБ" ХХК InvesCore 1116221289 УЛААНБААТАР ХОТ

CAPITAL LLC

СЭХ
2019.04.24 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
2019-03-2

зээлдүүлэгчиддээ Хувь нийлүүлсэн хөрөнгийн үлдэгдлийн хэмжээг бичгээр мэдэгдэнэ. Энэ үүргийг Гүйцэтгэх Захирал хэрэгжүүлнэ.

13.6.4. Ногдол ашиг хуваарилсны дараа үлдэх ашгаас ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх болон нийгэмд хандсан арга хэмжээ зохион байгуулах, сан байгуулж болно. Сан байгуулах асуудлыг Хувьцаа Эзэмшигч шийдвэрлэнэ. Уг сан байгуулах, түүний хөрөнгийг зарцуулах журмын төслийг Гүйцэтгэх Захирал боловсруулан ТУЗ-д танилцуулж, батлуулж мөрдөнө.

13.7. Ногдол ашиг хуваарилаагүй бол ТУЗ нь энэ тухай шалтгааныг Хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлагнана.

13.8. ТУЗ нь Ногдол ашиг хуваарилах болон түүнтэй холбоотой бусад харилцааг Компанийн Ногдол ашгийн бодлогод заасны дагуу зохицуулна.

## 14. КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН

14.1. Компанийн ТУЗ-ийн гишүүд, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, Гүйцэтгэх Захирал, Газрын захирлууд нь Компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцогдоно.

14.2. Компанийн эрх бүхий албан тушаалтан нь Компанийн тухай хууль, ажилтантай байгуулсан гэрээ, холбогдох бусад журамд заасан эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ.

14.3. Компанийн эрх бүхий албан тушаалтнууд нь томилогдсоноос хойш ажлын 10 өдрийн дотор өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалтыг гаргаж ТУЗ-ийн Нарийн бичгийн даргад өгөх ба уг жагсаалтанд өөрчлөлт орсон тухай бүр уг мэдээллийг Компанид мэдэгдэнэ. Нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалт гаргах зааврыг ТУЗ батална.

## 15. КОМПАНИЙГ ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ, ТАТАН БУУЛГАХ, ӨР ТӨЛБӨРИЙГ БАРАГДУУЛАХ

15.1. Компанийн тухай хуульд зааснаар Компанийг хуваах, тусгаарлах, болон өөр хуулийн этгээдэд нэгтгэх, нийлүүлэх замаар өөрчлөн байгуулж болно.

15.2. Компанийг Хувьцаа Эзэмшигчдийн хурлын шийдвэрээр татан буулгаж болно.

15.3. Хувьцаа Эзэмшигчдийн хурал нь татан буулгах комиссыг томилно.

15.4. Татан буулгах комисс томилсноор тухайн Компанийн бүрэн эрх дуусгавар болж татан буулгах комисст шилжинэ.

15.5. Татан буулгах комисс нь татан буулгах ажлыг бүрэн гүйцэтгэсний дараа тайлан гаргана.

15.6. Татан буулгах комиссоос зээлдүүлэгчийн өр төлбөрийг барагдуулсны дараа үлдсэн эд хөрөнгө нь Компанийн тухай хуульд заасны дагуу хувьцаа эзэмшигчдэд олгогдоно.

15.7. Татан буулгах комисс нь Компанийн тухай хуульд заасны дагуу ажиллан, Компанийг улсын бүртгэлийн байгууллагын улсын бүртгэлээс хасалт хийлгэснээр татан буугдах ажиллагаа дуусгавар болгоно.

15.8. Татан буулгах комис үүргээ гүйцэтгэх үедээ өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас Компанид ямар нэг хохирол учруулсан бол уг хохиролыг хуульд заасан журмын дагуу хариуцан арилгана.

TDB CAPITAL LLC

"ИНВЕСКОР ББСБ" ХХК
InvesCore
1115224289 № 6060854
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2019 .04. 24
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ...
MONGOLIAN STO...
2019 -03- 26
БҮР...

## 16. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

16.1. Энэхүү Дүрэм, Компанийн үйл ажиллагаатай холбогдон үүссэн Хувьцаа эзэмшигчдийн хурал шийдвэрлэж чадаагүй, эсхүл тухайн шийдвэрийг эс зөвшөөрсөнтэй холбоотой аливаа маргааныг гагцхүү шүүхээр шийдвэрлүүлнэ.

## 17. БУСАД ЗҮЙЛ

17.1. Компани нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад хууль, тогтоомж, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржээс баталсан холбогдох заавар, журмыг мөрдөн ажиллана.

17.2. Энэхүү Дүрэм нь бүртгэх байгууллагад бүртгүүлснээр хүчин төгөлдөр болно.

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ**

TDB CAPITAL LLC

"ИНВЭСКОР ББСБ" ХХК
InvesCore
1116224289 5060854
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2019 .04. 24 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2019 -03- 26

InvesCore

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 03-р сарын 01-ны өдөр № А/12 -Т Улаанбаатар хот

*Нийтэд санал болгох хувьцааны үнийг*
*тогтоох, үнэт цаасны танилцуулга батлах тухай*

Компанийн тухай хуулийн 43 дугаар зүйл, 55 дугаар зүйлийн 55.1, 55.2, 55.6 дах заалтууд, "Инвескор ББСБ" ХХК ("Компани" гэх)-ийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4.3 дах заалт, Компанийн Хувьцаа эзэмшигчийн 2019 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн А/03 дугаар шийдвэр болон "Гэрэгэ эстимэйт" ХХК-ийн 2019 оны 2 сарын 5-ны өдрийн хараат бус бизнесийн үнэлгээний тайланд үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Нийтэд нээлттэй санал болгохоор Компанийн нэмж гаргах 10,759,188 (арван сая долоон зуун тавин есөн мянга нэг зуун наян найм) ширхэг хувьцааны олон нийтэд санал болгох зах зээлийн үнийг дараах зарчмаар тогтоосугай. Үүнд:
   1.1. Стратегийн хөрөнгө оруулагчид санал болгох 9,145,310 ширхэг хувьцааг захиалгын бүртгэлийн аргаар доод үнийг 1,650.0 (нэг мянга зургаан зуун тавин) төгрөг, дээд үнийг 1,750.0 (нэг мянга долоон зуун тавин) төгрөгөөр;
   1.2. Олон нийтэд санал болгох 1,613,878 ширхэг хувьцааг захиалгын бүртгэлийн аргаар доод үнийг 1,550.0 0 (нэг мянга таван зуун тавин) төгрөг, дээд үнийг 1,650 (нэг мянга зургаан зуун тавин) төгрөгөөр.
2. Анхдагч зах зээлийн арилжаагаар нийтээс татан төвлөрүүлэх хөрөнгийн доод хэмжээг 17,591,272,400 (арван долоон тэрбум таван зуун ерэн нэгэн сая хоёр зуун далан хоёр мянга дөрвөн зуун) төгрөг байхаар тогтоож, уг хөрөнгийг Үнэт цаасны танилцуулгад тусгасан зориулалтаар зарцуулахаар шийдвэрлэсүгэй;
3. Харилцагчдаас хүлээн авсан үнэт цаасны нийт захиалгын дүн энэхүү тогтоолын 2 дах хэсэгт заасан татан төвлөрүүлэх хөрөнгийн доод хэмжээнд хүрсэн нөхцөлд үнэт цаасыг анхдагч зах зээлд нээлттэй худалдах ажиллагааг амжилттай болсонд тооцохоор шийдвэрлэсүгэй;
4. Компанийн нэмж гаргасан хувьцааг нийтэд санал болгон арилжих үйл ажиллагаатай холбоотой "Үнэт цаасны танилцуулга"-ыг энэхүү тогтоолын Хавсралтаар баталсугай;
5. Энэхүү тогтоолын биелэлтийг хангаж, Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид хувьцаагаа бүртгүүлэн, арилжаалах үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах, шаардлагатай бүх талын арга хэмжээг мэргэжлийн байгууллагуудтай хамтран шуурхай зохион байгуулж, хувьцаа эзэмшигч болон төлөөлөн удирдах зөвлөлийг мэдээллээр хангаж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Д.Баясгалан/-д даалгасугай.

"ИНВЕСКОР ББСБ" ХХК

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Б. АНХБОЛД

1116224289 6060854
УЛААНБААТАР ХОТ

TDB CAPITAL LLC

152

"ИНВЕСКОР ББСБ" ХХК
InvesCore
1116224289 6060854
УЛААНБААТАР ХОТ

BDO

Tel: +976 77404040
Fax: +976 77404041
www.bdo.mn
Zip code: 14230-0059

Room 1502, Level 15
Union Building - B, Unesco Street
Narnii Zam - 62, Khoroo 1
Sukhbaatar District, Ulaanbaatar
Mongolia

Утас: +976 77404040
Факс: +976 77404041
www.bdo.mn
ШНК: 14230-0059

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
1-р хороо, Нарны зам - 62, ЮНЕСКО-гийн
гудамж, ЮНИОН БЮЛДИНГ Б блок
15 - р давхар, 1502 тоот

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2019-03-26
БҮРТГЭВ-02

2019 оны 02-р сарын 27 № 42/19 Улаанбаатар хот

**МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК-Д**

*Тулган баталгаажуулах тухай*

“БДО Аудит” ХХК нь “Инвескор ББСБ” ХХК болон түүний охин компани болох “Инвескор Эй Ай Лаб” ХХК-ийг хамруулсан групп (цаашид “Групп” гэх)-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр тасалбар болсон жилийн нэгтгэсэн ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн нэгтгэсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж дүгнэлтээ гаргасан.

Бидний 2019 оны 01 дүгээр сарын 31-ний өдрөөр огноолсон аудитын тайланд тусгасанчлан Группийн нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь компанийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн нэгтгэсэн санхүүгийн байдал, нэгтгэсэн санхүүгийн гүйцэтгэл болон нэгтгэсэн мөнгөн гүйлгээг бүх матерриаллаг талаараа СТОУС-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн болно.

“Инвескор ББСБ” ХХК нь анх удаа нийтэд, нээлттэй арилжаалахаар үнэт цаас гаргаж байгаатай холбогдуулан компанийн бэлтгэсэн Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан санхүүгийн мэдээлэл нь Группийн 2018 оны аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайланд тусгагдсан мэдээлэлтэй тохирч байна.

Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан санхүүгийн мэдээлэл болон энэхүү албан бичиг нь группийн нэгтгэсэн санхүүгийн тайланд гаргасан аудиторын дүгнэлтийг орлохгүй бөгөөд СТОУС болон Монгол улсын хууль, дүрэм, журмаар шаардсан бүх нэмэлт тодруулгыг агуулаагүй болно.

БДО АУДИТ ХХК-ийн
Гүйцэтгэх Захирал

БДО АУДИТ ХХК
УЛААНБААТАР ХОТ

Д.АЛТАНСҮХ

"ИНВЕСКОР ББСБ" ХХК
УЛААНБААТАР ХОТ

153

BDO AUDIT LLC, a Mongolian Limited Liability Company, is a member of BDO International Limited, a UK company limited by guarantee, and forms part of the international BDO network of independent member firms.
Монгол Улсын хязгаарлагдмал хариуцлагатай компани болох БДО АУДИТ ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн гишүүн, олон улсын БДО сүлжээний бие даасан гишүүн байгууллагуудын нэг юм.

2019.04.24

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2019-03-26

2018 оны 12 сарын 31-ний өдрөөр
тасалбар болсон жилийн

# НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

/СТОУС-ийн дагуу илэрхийлэгдсэн/

## "ИНВЕСКОР ББСБ"

Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани

DB CAPITAL LLC

"ИНВЕСКОР ББСБ" ХХК
InvesCore
1116224289 6060854
УЛААНБААТАР ХОТ

BDO

СЗХ
2019.04.24
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2019-03-26
БҮРТГЭВ-02

# "ИНВЕСКОР ББСБ" ХХК

## Байгууллагын талаарх мэдээлэл

| | |
|---|---|
| **Үүсгэн байгуулах шийдвэр** | "Инвескор ББСБ" ХХК нь анх 2016 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр Монгол улсын хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдсан. |
| **Тусгай зөвшөөрөл** | Монгол Улсын Санхүүгийн Зохицуулах Хорооны 2016 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 159 дугаар тогтоолоор Банк Бус Санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн 1/554 тоот гэрчилгээ авсан. |
| **Гэрчилгээ** | "Инвескор ББСБ" ХХК нь 2016 оны 03 дугаар сарын 29-ний өдөр Зээлийн үйл ажиллагаа, Факторингийн үйл ажиллагаа, Итгэлцлийн үйлчилгээ, Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх, Хөрөнгө оруулалт санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх үйл ажиллагаа эрхлэхээр Улсын Бүртгэлийн Албанд бүртгүүлж 6060854 регистрийн дугаар бүхий 9015003118 тоот Улсын Бүртгэлийн Гэрчилгээ авсан.<br><br>2017оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн №245 тоот шийдвэрийн дагуу Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 4-р хороо 62-р байр 2 давхарт Баянгол салбар нэгж нээв.<br><br>2017 оны 08 дугаар сарын 02-ны өдрийн №381 тоот шийдвэрийн дагуу Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг, 10-р хороонд 100 айл салбар нэгж нээв.<br>2017 оны 08 дугаар сарын 02-ны өдрийн №381 тоот шийдвэрийн дагуу Улаанбаатар хот Баянзүрх дүүрэг,17-р хороонд Да хүрээ салбар нэгж нээв.<br>2018 оны 02 дугаар сарын 14-ны өдрийн №83 тоот тушаалыг үндэслэн Улаанбаатар хот Сонгинохайрхан дүүрэг, 32-р хороонд Авто худалдааны цогцолбор салбар нэгж нээв.<br>2018 оны 09 дугаар сарын 24-ны өдрийн №521 тоот тушаалыг үндэслэн Улаанбаатар хот Баянзүрх дүүрэг, 26-р хороонд Дүнжингарав салбар нэгж нээв.<br>2017 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн Санхүүгийн зохицуулах хорооны 222 тоот тогтоолын дагуу компанийн дүрмийн санг 4,096,873,000 төгрөгөөр нэмэгдүүлж "Эс Ай Би Жэй Капитал" ХХК-60.7%, Н.Нармандах-39.3% тус тус эзэмших болсон.<br><br>2017 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн Санхүүгийн зохицуулах хорооны 485 тоот тогтоолын дагуу компанийн хувьцааг 100 хувь "Эс Ай Би Жэй Капитал" ХХК эзэмших болсон.<br><br>2018 оны 10 дугаар сарын 01-ны өдрийн хувьцаа эзэмшигчийн А/24 тоот шийдвэрээр ТУЗ-ийн гишүүдийн орон тоог 5 болгон өөрчилсөн байна. |
| **Хувьцаа Эзэмшигчид** | "Эс Ай Би Жэй Капитал" ХХК **100%** |
| **Нэгтгэгдсэн охин компани** | Инвескор Эй Ай Лаб ХХК (Монгол Улсын хуулийн этгээд) – 90%-ийг бүрэн эзэмшдэг. |
| **Төлөөлөн Удирдах** | Б.Анхболд — *ТУЗ-ийн дарга*<br>Д.Баясгалан — *ТУЗ-ийн гишүүн*<br>Р.Мөнхтөр — *ТУЗ-ийн гишүүн*<br>Namiki Hirohito — *ТУЗ-ийн гишүүн*<br>Ч.Хашчулуун — *ТУЗ-ийн хараат бус гишүүн* |
| **Гол удирдах албан тушаалтнууд** | Гүйцэтгэх захирал — Д.Баясгалан<br>Дэд захирал — Р.Мөнхтөр<br>Санхүүгийн захирал — Р.Пүрэв |
| **Байнгын хаяг** | **"Инвескор ББСБ" ХХК**<br>Твин Тауэр-1 байр, 13-р давхар<br>Сөүлийн гудамж Сүхбаатар дүүрэг 2-р хороо,<br>Улаанбаатар хот, Монгол Улс |
| **Аудитор** | **"БДО Аудит" ХХК**<br>Юнион Бюлдинг B блок, 15-р давхар, 1502 тоот,<br>Юнескогийн гудамж, Нарны зам-62, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,<br>Улаанбаатар хот, Монгол Улс |

TDB CAPITAL LLC

155

"ИНВЕСКОР ББСБ" ХХК
Invescore
1116224289 6060854
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2019 .04 сар 24 өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2019 -03- 26
БҮРТГЭВ-02

## 2018 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн Нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэх болон батлах талаарх Удирдлагын Хариуцлагын Мэдэгдэл

Энэхүү тайлангийн 3-7 дахь хуудсанд тусгагдсан хараат бус аудиторын тайланд дурдсан хараат бус аудиторын дүгнэлттэй хамт уншигдах дараах мэдэгдэл нь "Инвескор ББСБ" Хязгаарлагдмал Хариуцлагатай Компанийн (Цаашид "Компани" гэх) 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн нэгтгэсэн санхүүгийн тайлантай холбоотой удирдлагын үүрэг хариуцлага болон аудиторын хариуцлагыг тусад нь илэрхийлэх үүднээс хийгдсэн болно.

"Компани"-ийн удирдлага нь эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт ("СТОУС")-ын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй болно. Бид эдгээр санхүүгийн тайлантай холбоотой үүрэг хариуцлагаа ухамсарлан, санхүүгийн тайлангаа Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт ("СТОУС"), Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох заавар журмын дагуу үнэн зөв бэлтгэсэн гэдгээ баталж байна.

"Компани"-ийн 2018 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн нэгтгэсэн санхүүгийн тайланг гаргахыг зөвшөөрч батлав.

"ИНВЕСКОР ББСБ" ХХК
InvesCore
NON-BANK FINANCIAL INSTITUTION
1116224289 6060854
УЛААНБААТАР ХОТ

**Д.БАЯСГАЛАН**
Гүйцэтгэх захирал

**Р.ПҮРЭВ**
Санхүүгийн захирал

Огноо: ____________________

Улаанбаатар хот

TDB CAPITAL LLC

156

"ИНВЕСКОР ББСБ" ХХК
InvesCore
1116224289 6060854
УЛААНБААТАР ХОТ

Tel: +976 77404040
Fax: +976 77404041
www.bdo.mn
Zip code: 14230-0059

Room 1502, Level 15
Union Building - B, Unesco Street
Namii Zam - 62, Khoroo - 1
Sukhbaatar District, Ulaanbaatar
Mongolia

Утас: +976 77404040
Факс: +976 77404041
www.bdo.mn
ШНК: 14230-0059

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
1-р хороо, Нарны зам - 62, ЮНЕСКО-гийн гудамж, ЮНИОН БЮЛДИНГ Б блок
15 - р давхар, 1502 тоот

# ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

## "ИНВЕСКОР ББСБ" ХХК -ийн Хувьцаа эзэмшигчдэд

## Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитын талаарх тайлан

### Санал дүгнэлт

"Инвескор ББСБ" ХХК болон түүний охин компанийг багтаасан групп (Цаашид "Инвескор ББСБ" ХХК-ийг дангаар нь 'Компани', "Инвескор ББСБ" болон түүний охин компанийг хамтад нь 'Групп' гэх)-ийн дараах тайлангуудаас бүрдсэн нэгтгэсэн санхүүгийн тайлангуудад аудит хийлээ:

- 2018 оны 12 сарын 31-нээрх нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан;
- Энэ өдрөөр тасалбар болсон жилийн нэгтгэсэн ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлангууд; болон
- Нягтлан бодох бүртгэлийн томоохон бодлогуудын хураангуйг агуулсан нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тэмдэглэлүүд.

Бидний дүгнэлтээр, хавсаргасан нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь компанийн 2018 оны 12 сарын 31-ний өдрийн нэгтгэсэн санхүүгийн байдал, нэгтгэсэн санхүүгийн гүйцэтгэл болон нэгтгэсэн мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаараа Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт ("СТОУС")-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт ('АОУС')-ын дагуу хийсэн. Эдгээр стандартын дагуу хүлээх үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага гэсэн хэсэгт харуулсан. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөл ('НБЁЗОУСЗ')-ийн Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Дүрэм болон Монгол улсад мөрдүүлэхээр шаарддаг нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагуудын дагуу Компаниас хараат бус байсан бөгөөд НБЁЗОУСЗ-ийн дүрэм болон эдгээр ёс зүйн шаардлагын дагуу бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан санал дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай бөгөөд зохистой гэж бид найдаж байна.

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант жилийн Группийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй гэж мэргэжлийн шийдлээр бидний авч үзсэн асуудлууд болно. Гол асуудлуудыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд аудитын дүгнэлтээ илэрхийлэхдээ авч үзсэн бөгөөд эдгээр гол асуудлуудын талаар тусад нь дүгнэлт илэрхийлэхгүй.

BDO AUDIT LLC, a Mongolian Limited Liability Company, is a member of BDO International Limited, a UK company limited by guarantee, and forms part of the international BDO network of independent member firms.
Монгол Улсын хязгаарлагдмал хариуцлагатай компани болох БДО АУДИТ ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн гишүүн, олон улсын БДО сүлжээнии бие даасан гишүүн байгууллагуудын нэг юм.

# ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (үргэлжлэл)

## Аудитын гол асуудал (үргэлжлэл)

**Харилцагчдад олгосон зээлийн үнэ цэнийн бууралт**

Группийн нийт хөрөнгийн 89.35% (2017:90.92%)-ийг харилцагчдад олгосон зээл эзэлж байна. Зээлийн үнэ цэнэ бууралтыг тодорхойлохдоо өнгөрсөн хугацаанд тохиолдсон алдагдалын түүхэн мэдээлэл дээр үндэслэн магадлалаар таамагласан ирээдүйн мөнгөн урсгалын талаарх удирдлагын төсөөлөлд үндэслэн тооцоолдог. Тайлант жилийн эцэс дэх зээлийн үнэ цэнийн бууралтын гарзыг удирдлагаас бүлгийн үнэлгээний загвар ашиглан тодорхойлсон.

Ашигласан таамаглалууд зохисгүй байж болзошгүй учраас бид энэхүү удирдлагын тооцооллыг аудитын гол асуудалд оруулсан.

Эдгээр зүйлсийн тодруулгыг тэмдэглэл 12 болон 16-д тусгасан болно.

**Аудитын хариу**

Зээлийн үнэ цэнийн бууралтын нөөцийг үнэлэхдээ бид дараах горимууд гүйцэтгэсэн. Үүнд:

- Группийн зээлийн үнэ цэнийн бууралт, хүлээн зөвшөөрөлт, хяналтуудыг бид үнэлсэн.
- Группийн зээлийн үнэ цэнийн бууралтын тооцоололд ашигласан зээлийн өгөгдлийн иж бүрэн байдал, ашигласан орц мэдээллийн найдвартай байдлыг нарийвчлан шалгасан.
- Зээлийн бүлгийн ангилалд багтсан зээлийг холбогдох зөв ангилалд хамруулж, насжилтыг зөв гаргасан эсэхийг шалгаж зохих журмын дагуу дахин ангилсан.
- Зээлийн үнэ цэнийн бууралтыг тодорхойлоход удирдлагын зүгээс ашигласан магадлалуудыг бид группийн зээлийн бодлогод тулгуурлан үнэлж, холбогдох зах зээлийн мэдээлэлтэй тулгасан.
- Хүлээгдэж буй зээлийн алдагдалтай холбоотой нэмэлт тодруулгууд нь хангалттай эсэхийг үнэлсэн.

## Бусад мэдээлэл

Удирдлага нь бусад мэдээлэлд үүрэг хариуцлага хүлээдэг. Бусад мэдээлэл нь жилийн тайланд орсон мэдээллээс бүрддэг боловч түүнд нэгтгэсэн санхүүгийн тайлан болон бидний аудиторын тайлан ордоггүй. Нэгтгэсэн санхүүгийн тайланд гаргасан бидний дүгнэлт нь бусад мэдээллийг хамардаггүй бөгөөд бид бусад мэдээллийн талаар аливаа баталгаажилтын дүгнэлт гаргахгүй.

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудиттайгаа холбогдуулан бидний хүлээх үүрэг хариуцлага бол бусад мэдээллийг уншиж, ингэснээр бусад мэдээлэл нь нэгтгэсэн санхүүгийн тайлан эсвэл аудитаар олж авсан бидний мэдлэг эсвэл өөр хэлбэрээр материаллагаар буруу илэрхийлэгдсэн байж болох эсэх тухай материаллаг үл нийцэлтийг авч үзэхэд оршдог.

Бид өөрсдийн гүйцэтгэсэн ажил дээрээ суурилан энэхүү бусад мэдээлэл нь материаллаг буруу илэрхийлэлтэй байна гэж дүгнэвэл тухайн бодит байдлыг тайлагнахыг биднээс шаарддаг. Бидэнд ингэж тайлагнах зүйл байхгүй болно.

## Нэгтгэсэн санхүүгийн тайланд Удирдлага ба Засаглах удирдлагын хүлээх үүрэг хариуцлага

Нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт ("СТОУС")-ын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах, болон алдаа юмуу заль мэхнээс үүдэлтэй материаллаг буруу илэрхийллээс ангид нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэх боломж бүрдүүлэхэд зайлшгүй шаардлагатай тийм дотоод хяналтыг тодорхойлох нь удирдлагын үүрэг хариуцлага юм.

Нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэж байхдаа удирдлага нь группийг татан буулгах юмуу үйл ажиллагааг нь зогсоох эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд удирдлага өөдрөг төсөөллөөр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх группийн чадамжийг үнэлж, шаардлагатай бол өөдрөг төсөөлөлтэй холбоотой асуудлуудын талаар тодруулга хийх, нягтлан бодох бүртгэлийн өөдрөг төсөөллийн суурийг ашиглах үүрэг хариуцлага хүлээнэ.

Засаглах удирдлага нь группийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

BDO AUDIT LLC, a Mongolian Limited Liability Company, is a member of BDO International Limited, a UK company limited by guarantee, and forms part of the international BDO network of independent member firms.
Монгол Улсын хязгаарлагдмал хариуцлагатай компани болох БДО АУДИТ ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн гишүүн, олон улсын БДО сүлжээний бие даасан гишүүн байгууллагуудын нэг юм.

# ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (үргэлжлэл)

## Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Заль мэх эсвэл алдаанаас үүдсэн материаллаг буруу илэрхийллээс нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь бүхэлдээ ангид эсэх талаарх үл үндэслэлтэй баталгаажилтыг олж авч, өөрийн санал дүгнэлтийг багтаасан аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй баталгаажилт нь баталгаажилтын өндөр түвшин боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар оршин байгаа материаллаг алдаа зөрчлийг цаг ямагт илрүүлж байна гэж амласан баталгаа гаргадаггүй.

Алдаа зөрчил нь заль мэхнээс эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд хэрэв тэр нь дангаараа эсвэл нийлэхээрээ нэгтгэсэн санхүүгийн тайланд үндэслэн түүнийг хэрэглэгчдийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

АОУС-ын дагуу хийсэн аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шийдэл гарган, аудитын туршид мэргэжлийн үл итгэх үзлийг баримтлан ажилладаг. Бид мөн:

- Заль мэх эсвэл алдааны улмаас нэгтгэсэн санхүүгийн тайлан материаллаг алдаатай илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирох аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж,өөрсдийн санал дүгнэлтийн үндэслэл болохуйц хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоог олж авдаг. Заль мэхнээс үүссэн материаллаг алдааг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн материаллаг алдааг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангүй их байдаг. Учир нь заль мэхэнд хуйвалдаан, баримт бичгийг хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу тайлагнах, дотоод хяналтыг үл ойшоох явдлууд орсон байж болно.
- Компанийн дотоод хяналтын үр ашигт байдлын талаар санал дүгнэлт гаргах зорилгоор биш харин тухай нөхцөл байдалд тохирох аудитын горимыг боловсруулах зорилгоор аудитад хамаарах дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогын тохиромжтой байдал, хийсэн нягтлан бодох бүртгэлийн тооцоолол болон холбогдох тодруулгын үл үндэслэлтэй байдлыг үнэлдэг.
- Мөн олж авсан аудитын нотолгоо дээр үндэслэн компанийн тасралтгүйгээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ төрүүлэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг тодорхойлж, нягтлан бодох бүртгэлийн өөдрөг төсөөллийн суурийг удирдлага зохистойгоор хэрэглэсэн эсэхийг дүгнэдэг. Хэрэв бид материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа түүнтэй холбоотой санхүүгийн тайлангийн тодруулгад анхаарал хандуулах эсвэл хийсэн тодруулга нь хангалтгүй байна гэж үзвэл аудитын санал дүгнэлтээ өөрчилдөг. Бидний дүгнэлт нь аудиторын тайлан гаргах өдөр хүртэлх олж авсан аудитын нотолгоонд суурилдаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөлүүд нь компанийг өөдрөг төсөөллөө үргэлжлүүлэхээ зогсооход хүргэх нөлөө үзүүлж болно.
- Тодруулгыг багтаагаад санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулга ба санхүүгийн тайлангууд нь үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц хэмжээнд гол гол ажил гүйлгээ ба үйл явдлыг илэрхийлсэн эсэхийг үнэлдэг.

Бид аудитын төлөвлөсөн цар хүрээ ба хугацаа, аудитынхаа явцад олж илрүүлсэн дотоод хяналт дахь томоохон зөрчил дутагдлыг оруулаад нөлөө бүхий аудитын илрүүлэлтүүд, бусад асуудлуудаар засаглах эрх бүхий удирдлагатай харилцдаг.

BDO AUDIT LLC, a Mongolian Limited Liability Company, is a member of BDO International Limited, a UK company limited by guarantee, and forms part of the international BDO network of independent member firms.
Монгол Улсын хязгаарлагдмал хариуцлагатай компани болох БДО АУДИТ ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн гишүүн, олон улсын БДО сүлжээний бие даасан гишүүн байгууллагуудын нэг юм.

BDO

# ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (үргэлжлэл)

## Тайлангийн хэрэглээ

**Энэхүү тайланг Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 95.1-р зүйлд заасан хуулийн этгээд болох "Инвескор" Группийн хувьцаа эзэмшигчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй.**

**Л. БАЯРБОЛГОЗОЛ**
**"БДО Аудит" ХХК**
**Монгол улс, Улаанбаатар хот**
**Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,**
**Юнескогийн гудамж, Нарны зам-62**
**Юнион Бюлдинг B блок, 1502 тоот өрөө**

**Огноо:** 2019 . 01 . 31

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2019 -03- 26

"ИНВЕСКОР ББСБ" ХХК
InvesCore
NON BANK FINANCIAL INSTITUTION
1116224289
УЛААНБААТАР ХОТ

БДО АУДИТ ХХК
УЛААНБААТАР ХОТ

160

2019 .04. 24

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2019 -03- 26
БҮРТГЭВ-02

# ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН – үргэлжлэл

## Хууль тогтоомж, зохицуулалтын шаардлагын талаарх тайлан

**Бид "Инвескор ББСБ" ХХК-ийн 2018 оны 12-р дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр тасалбар болсон жилийн нэгтгэсэн ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж дүгнэлтээ гаргасан.**

**Бид санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгэх явцдаа санхүүгийн тайлагналтай холбоотойгоор банк бус санхүүгийн байгууллагад мөрдүүлэхээр зохицуулагч байгууллагаас гаргасан дүрэм, журмын мөрдөлтийн талаар тест гүйцэтгэсэн бөгөөд Монгол Улсын хууль тогтоомж, Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм, журмыг мөрдөөгүй гэсэн ул үндэслэлтэй нотолгоо бидэнд мэдэгдээгүй.**

БДО АУДИТ ХХК

**Л. БАЯРЦОГЗОЛ**
**"БДО Аудит" ХХК**
**Монгол улс, Улаанбаатар хот**
**Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,**
**Юнескогийн гудамж, Нарны зам-62**
**Юнион Бюлдинг В блок, 1502 тоот өрөө**

**Огноо:** 2019 .01. 31



"ИНВЕСКОР ББСБ" ХХК
InvesCore
NON-BANK FINANCIAL INSTITUTION
УЛААНБААТАР

2019.04.24 өдөр

# “ИНВЕСКОР” ГРУПП

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2019-03-26
БҮРТГЭВ-02

## 2018 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн НЭГТГЭСЭН АШИГ, АЛДАГДАЛ БОЛОН БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН

| | Тэм | 2018 он мян.төг | 2017 он мян.төг |
|---|---|---|---|
| Хүү болон түүнтэй адилтгах орлого | 6 | 10,793,828 | 4,476,418 |
| Хүү болон түүнтэй адилтгах зардал | 7 | (2,572,561) | (677,856) |
| **Хүүгийн цэвэр орлого** | | **8,221,267** | **3,798,562** |
| Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого | 8 | 324,140 | 166,320 |
| Хураамж ба ханшийн тэгшитгэлийн орлого/(зардал) | 9 | 77,927 | (16,588) |
| **Хүүгийн бус цэвэр орлого** | | **402,067** | **149,732** |
| **Үйл ажиллагааны орлого** | | **8,623,334** | **3,948,294** |
| Ажиллагсадтай холбогдолтой зардал | 10 | (902,020) | (329,064) |
| Үйл ажиллагааны бусад орлого/(зардал) | 11 | (572,104) | (244,470) |
| **Зээлийн үнэ цэнийн бууралтын өмнөх ашиг, (алдагдал)** | | **7,149,210** | **3,374,760** |
| Зээлийн үнэ цэнийн бууралтын зардал | 12 | (971,766) | (312,433) |
| **Татварын өмнөх ашиг** | | **6,177,444** | **3,062,327** |
| Орлогын албан татвар | 13 | (1,123,939) | (325,782) |
| **Тайлант үеийн цэвэр ашиг** | | **5,053,505** | **2,736,545** |
| **Бусад дэлгэрэнгүй орлого** | | | |
| Ирээдүйд ашиг алдагдлаар ангилагдаж болзошгүй эрсдэлийн сангийн нөөц | 21 | - | (108,752) |
| **Нийт дэлгэрэнгүй орлого** | | **5,053,505** | **2,627,793** |

*12-39-р хуудсан дахь тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.*

TDB CAPITAL LLC
“ИНВЕСКОР ББСБ” ХХК
InvesCore
УЛААНБААТАР ХОТ

2019.04.24

# “ИНВЕСКОР” ГРУПП

**2018 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн**
**НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2019-03-26

| | Тэм | 2018 оны 12-р сарын 31 мян.төг | 2017 оны 12-р сарын 31 мян.төг |
|---|---|---|---|
| **ХӨРӨНГӨ** | | | |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | 14 | 2,320,122 | 1,104,182 |
| Харилцагчдад олгосон зээл-цэвэр | 16 | 34,868,286 | 17,859,808 |
| Өмчлөх бусад хөрөнгө | 15 | 417,534 | 539,894 |
| Бусад санхүүгийн бус хөрөнгө | 17 | 811,214 | 39,620 |
| Өмч, барилга, тоног төхөөрөмж-цэвэр | 18 | 322,468 | 82,388 |
| Биет бус хөрөнгө-цэвэр | 19 | 286,107 | 17,639 |
| **НИЙТ ХӨРӨНГӨ** | | **39,025,731** | **19,643,531** |
| **ӨМЧ БА ӨР ТӨЛБӨР** | | | |
| **Өмч** | | | |
| Дүрмийн сан | 20 | 6,096,873 | 6,096,873 |
| Эрсдэлийн сангийн нөөц | 21 | - | 108,752 |
| Хуримтлагдсан ашиг / (алдагдал) | | 7,794,023 | 2,631,766 |
| Цөөнхийн хувь оролцоо | | 2,860 | - |
| **Өмчийн дүн** | | **13,893,756** | **8,837,391** |
| **Өр төлбөр** | | | |
| Итгэлцлийн үйлчилгээний өглөг | 22 | 10,374,108 | 2,507,692 |
| Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл | 23 | 13,867,446 | 7,897,149 |
| Бусад санхүүгийн өр төлбөр | 24 | 496,390 | 85,340 |
| Бусад санхүүгийн бус өр төлбөр | 25 | 394,031 | 315,960 |
| **Өр төлбөрийн дүн** | | **25,131,975** | **10,806,140** |
| **НИЙТ ӨМЧ БА ӨР ТӨЛБӨР** | | **39,025,731** | **19,643,531** |

*12-39-р хуудсан дахь тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.*

“ИНВЕСКОР ББСБ” ХХК
InvesCore
1116224289 6060854
УЛААНБААТАР ХОТ

## “ИНВЕСКОР” ГРУПП

### 2018 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн НЭГТГЭСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

| | Дүрмийн сан | Хуримтлагдсан ашиг | Зээлийн эрсдэлийн сангийн нөөц | Нийт хувьцаа эзэмшигчдэд хуваарилагдах | Хяналтын бус хувь оролцоонд хуваарилагдах | Нийт |
|---|---|---|---|---|---|---|
| | мян.төг | мян.төг | мян.төг | мян.төг | мян.төг | мян.төг |
| **2017 оны 01 сарын 01-ний үлдэгдэл** | **2,000,000** | **399,256** | - | **2,399,256** | - | **2,399,256** |
| Гаргасан хувьцаат капитал | 3,701,590 | - | - | 3,701,590 | - | 3,701,590 |
| Дүрмийн санд шилжүүлсэн ашиг | 395,283 | (395,283) | - | - | - | - |
| Тайлант жилийн ашиг/(алдагдал) | - | 2,736,545 | - | 2,736,545 | - | 2,736,545 |
| **Зээлийн эрсдэлийн сангийн нөөц** | - | (108,752) | 108,752 | - | - | - |
| **2017 оны 12 сарын 31-ний үлдэгдэл** | **6,096,873** | **2,631,766** | **108,752** | **8,837,391** | - | **8,837,391** |
| Гаргасан хувьцаат капитал | - | - | - | - | - | - |
| Дүрмийн санд шилжүүлсэн ашиг | - | - | - | - | - | - |
| Тайлант жилийн ашиг/(алдагдал) | - | 5,053,505 | - | 5,053,505 | 2,860 | 5,056,365 |
| Зээлийн эрсдэлийн сангийн нөөц | - | 108,752 | (108,752) | - | - | - |
| **2018 оны 12 сарын 31-ний үлдэгдэл** | **6,096,873** | **7,794,023** | - | **13,890,896** | **2,860** | **13,893,756** |

*12-39-р хуудсан дахь тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.*



СЗХ 2019.04.24 он сар өдөр БҮРТГЭВ
TDB CAPITAL LLC
164
“ИНВЕСКОР ББСБ” ХХК InvesCore NON BANK FINANCIAL INSTITUTION УЛААНБААТАР ХОТ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2019-03-26 БҮРТГЭВ-02

# "ИНВЕСКОР" ГРУПП

## 2018 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

| | Тэмдэглэл | 2018 оны 12 сарын 31 мян.төг | 2017 оны 12 сарын 31 мян.төг |
|---|---|---|---|
| **Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | | |
| **Тайлант жилийн ашиг/(алдагдал)** | | **6,177,443** | **3,062,327** |
| *Тохируулга:* | | | |
| Өмч, барилга, тоног төхөөрөмжийн элэгдэл | 18 | 34,040 | 10,540 |
| Биет бус хөрөнгийн хорогдуулга | 19 | 8,127 | 1,362 |
| Зээлийн үнэ цэнийн бууралт | | 880,264 | 312,427 |
| Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгийн үнэ цэнийн бууралт | | 21,976 | - |
| Өмч, барилга, тоног төхөөрөмж борлуулалтын (олз)/гарз | | 84 | - |
| Биет бус хөрөнгө борлуулалтын (олз)/гарз | | 4,008 | - |
| Хүүгийн орлого | 6 | (10,780,916) | (4,476,502) |
| Хүүгийн зардал | 7 | 2,572,561 | 605,666 |
| **Ажлын капиталын өөрчлөлтийн өмнөх үндсэн үйл ажиллагааны ашиг/(алдагдал)** | | **(1,082,413)** | **(484,180)** |
| Харилцагчдад олгосон зээлийн (өсөлт)/бууралт | 16 | (18,102,293) | (13,859,820) |
| Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгийн өсөлт/(бууралт) | | 100,384 | - |
| Бусад санхүүгийн өр төлбөрийн өсөлт/(бууралт) | | 325,339 | - |
| Бусад санхүүгийн бус өр төлбөрийн өсөлт/(бууралт) | 25 | (330,084) | (29,654) |
| Бусад санхүүгийн бус хөрөнгийн (өсөлт)/бууралт | 17 | (50) | 6,235 |
| **Ажлын капиталын өөрчлөлт** | | **(19,089,117)** | **(14,367,419)** |
| Төлсөн орлогын татвар | | (761,000) | - |
| Хүлээн авсан хүү | | 10,247,900 | 3,913,413 |
| Төлсөн хүү | | (485,803) | (50,590) |
| **Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ** | | **(10,088,020)** | **(10,504,596)** |
| **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | | |
| Худалдан авсан өмч, барилга, тоног төхөөрөмж | 18 | (276,277) | (73,364) |
| Худалдан борлуулсан өмч, барилга, тоног төхөөрөмж | 18 | 2,073 | - |
| Худалдан авсан биет бус хөрөнгө | 19 | (282,602) | (9,626) |
| Худалдан борлуулсан биет бус хөрөнгө | 19 | 2,000 | - |
| **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ** | | **(554,806)** | **(82,990)** |
| **Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | | |
| Авсан зээл | 23 | 19,053,583 | 8,888,764 |
| Төлсөн зээл | 23 | (14,601,970) | - |
| Харилцагчдаас татсан итгэлцэл | 22 | 11,969,883 | 2,587,503 |
| Харилцагчидад төлсөн итгэлцэл | 22 | (4,946,383) | |
| Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн нөлөө | | 383,653 | (7,672) |
| **Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ** | | **11,858,766** | **11,468,595** |
| **Тайлант жилд бий болсон (зарцуулсан) нийт цэвэр мөнгөн гүйлгээ** | | **1,215,940** | **881,009** |
| **Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн оны эхний үлдэгдэл** | 14 | **1,104,182** | **223,173** |
| **Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн оны эцсийн үлдэгдэл** | 14 | **2,320,122** | **1,104,182** |

*12-39-р хуудсан дахь тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.*

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2019 -03- 26
2019 .04. 24
"ИНВЕСКОР ББСБ" ХХК
InvesCore
УЛААНБААТАР
165

2019 .04. 24
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2019 -03- 26
БҮРТГЭВ-02

**Санхүүгийн тайлангийн тэмдэглэлүүд**


1. ТАЙЛАГНАГЧ АЖ АХУЙН НЭГЖ ........ 13
2. ТАЙЛАН БЭЛТГЭСЭН ҮНДЭСЛЭЛ ........ 14
3. ШИНЭЭР БАТЛАГДСАН, НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛСАН СТАНДАРТ БОЛОН ТАЙЛБАРУУД ........ 15
4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ЧУХАЛ ТООЦООЛОЛ БА ШИЙДЭЛ ........ 17
5. САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР - ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА ........ 18
6. ХҮҮ БОЛОН ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ОРЛОГО ........ 21
7. ХҮҮ БОЛОН ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ЗАРДАЛ ........ 21
8. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖ, ШИМТГЭЛИЙН ОРЛОГО ........ 21
9. ГАДААД ВАЛЮТЫН АРИЛЖАА БОЛОН ХАНШИЙН ТЭГШИТГЭЛИЙН ОРЛОГО/(ЗАРДАЛ) ........ 21
10. АЖИЛЛАГСАДТАЙ ХОЛБООТОЙ ЗАРДАЛ ........ 22
11. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУСАД ЗАРДАЛ ........ 22
12. ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛИЙН САНГИЙН ЗАРДАЛ ........ 22
13. ОРЛОГЫН АЛБАН ТАТВАР ........ 23
14. МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ ........ 23
15. ӨМЧЛӨХ БУСАД ХӨРӨНГӨ ........ 24
16. ХАРИЛЦАГЧДАД ОЛГОСОН ЗЭЭЛ ........ 25
17. БУСАД САНХҮҮГИЙН БУС ХӨРӨНГӨ ........ 26
18. ӨМЧ, БАРИЛГА, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ- ЦЭВЭР ........ 27
19. БИЕТ БУС ХӨРӨНГӨ ........ 28
20. ДҮРМИЙН САН ........ 28
21. ЭРСДЛИЙН САНГИЙН НӨӨЦ ........ 28
22. ИТГЭЛЦЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨР ТӨЛБӨР ........ 29
23. БАНК САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГААС АВСАН ЗЭЭЛ ........ 29
24. БУСАД САНХҮҮГИЙН ӨР ТӨЛБӨР ........ 30
25. БУСАД САНХҮҮГИЙН БУС ӨР ТӨЛБӨР ........ 30
26. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ ........ 31
27. ХОЛБООТОЙ ТАЛУУДЫН АЖИЛ ГҮЙЛГЭЭ, ТООЦООНЫ ҮЛДЭГДЭЛ ........ 37
28. ТАЙЛАНТ ХУГАЦААНЫ ДАРААХ ҮЙЛ ЯВДЛУУД ........ 39
29. ЗЭРЭГЦҮҮЛЭХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД ........ 39
30. ТАЙЛАНГИЙН ОРЧУУЛГА ........ 39


TDB CAPITAL LLC

166

"ИНВЕСКОР ББСБ" ХХК
InvesCore
NON BANK FINANCIAL INSTITUTION
УЛААНБААТАР ХОТ

### 1. ТАЙЛАГНАГЧ АЖ АХУЙН НЭГЖ

“Инвескор ББСБ” ХХК (Цаашид “Компани” гэх) нь 2016 оны 03 дугаар сарын 29-ний өдөр компанийн дүрмийн дагуу Монгол улсын хуулийн этгээд болох Хязгаарлагдмал Хариуцлагатай Компанийн хэлбэрээр банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх чиглэлтэйгээр үүсгэн байгуулагдсан.

Компани нь 2016 оны 03 дугаар сарын 29-ний өдөр Улсын Бүртгэлийн Албанд бүртгүүлж 6060854 регистрийн дугаар бүхий 9015003118 тоот Улсын Бүртгэлийн Гэрчилгээ авсан.

“Инвескор ББСБ” ХХК нь 2018 оны 08 дугаар сарын 15-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн А/27-Т тоот тогтоолын дагуу “Инвескор Эй Ай Лаб” ХХК-ийг үүсгэн байгуулсан байна.

“Инвескор Эй Ай Лаб” ХХК нь 2018 оны 08 дугаар сарын 17-ний өдөр Улсын Бүртгэлийн Албанд бүртгүүлж 6339247 регистрийн дугаар бүхий 90117558119 тоот Улсын Бүртгэлийн Гэрчилгээ авсан байна.

2018 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх хүчин төгөлдөр компанийн дүрмийн дагуу хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүн болон хувьцаат капитал нь дараах байдалтай байна. Үүнд:

| Хувьцаа эзэмшигчдийн нэр | Эзэмшлийн хувь | 2018 оны 12 сарын 31-ний өдрөөр | | |
|---|---|---|---|---|
| | | Тоо хэмжээ | Нэгжийн үнэ | Нийт (мян.төг) |
| “Эс Ай Би Жэй Капитал” ХХК | 100% | 6,096,873 | 1,000 | 6,096,873 |
| | **100%** | **6,096,873** | | **6,096,873** |

“Групп” нь дараах үндсэн үйл ажиллагааны чиглэлүүдтэй байна.

1. Зээлийн үйл ажиллагаа
2. Факторингийн үйл ажиллагаа;
3. Итгэлцлийн үйлчилгээ;
4. Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх;
5. Хөрөнгө оруулалт санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх;
6. Төлбөрийн баталгаа гаргах
7. Бизнесийн зөвлөгөө өгөх
8. Үл хөдлөх хөрөнгийн зуучлал
9. Аялал зуучлал
10. Программ хангамжийн үйл ажиллагаа
11. Менежментийн зөвлөгөө өгөх

“Групп” нь 2018 оны 12 сарын 31-нээр 57 ажилтан (2017: 16)-тай байсан.

167

## 2. ТАЙЛАН БЭЛТГЭСЭН ҮНДЭСЛЭЛ

Санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд ашигласан нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудын хураангуйг Тэмдэглэл 29-д толилуулсан. Өөрөөр тусгайлан зааснаас бусад тохиолдолд уг бодлогуудыг толилуулж буй бүх тайлант үеүдэд тууштай баримталж мөрдсөн болно.

Компанийн нягтлан бодох бүртгэлийн болон тайлагнагч валют нь Монгол улсын мөнгөн тэмдэгт болох Төгрөг юм. Эдгээр санхүүгийн тайлангууд нь төгрөгөөр илэрхийлэгдэж, мянган төгрөгөөр нарийвчлан харуулж тайлагнагдсан.

Эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт, Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт болон тайлбарууд (хамтад нь “СТОУС” гэх)-ын дагуу бэлтгэсэн.

Санхүүгийн тайланг СТОУС-ын дагуу бэлтгэхэд тодорхой, чухал нягтлан бодох бүртгэлийн тооцоолол хийхийг шаарддаг. Мөн компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэглэхэд удирдлагаас шийдэл гаргахыг шаарддаг. Санхүүгийн тайлан бэлтгэхэд хийгдсэн нөлөө бухий шийдэл ба тооцоолол болон түүний нөлөөллийн талаар Тэмдэглэл 4-т нэмж тодруулсан.

**Хэмжилтийн үндэслэл**

Эдгээр санхүүгийн тайлангууд нь доорх зүйлсээс (дэлгэрэнгүй мэдээллийг зохих нягтлан бодох бүртгэлийн бодлогоос харна уу) бусад зүйлсийн хувьд түүхэн өртөгт суурилан бэлтгэгдсэн:

- Санхүүгийн хэрэглүүр – бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх
- Санхүүгийн хэрэглүүр – борлуулахад бэлэн
- Болзошгүй төлбөр
- Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө
- Дахин үнэлэгдсэн өмч, барилга, тоног төхөөрөмж
- Тогтоосон тэтгэмжийн цэвэр өр төлбөр
- Мөнгөөр төлөгдөх, хувьцаанд суурилсан төлбөрийн өглөг.

СЭХ
2019.04.24
БҮРТГЭВ



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2019-03-26
БҮРТГЭВ-02

## 3. ШИНЭЭР БАТЛАГДСАН, НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛСАН СТАНДАРТ БОЛОН ТАЙЛБАРУУД

**Нягтлан бодох бүртгэлийн бодлогод гарсан өөрчлөлт**

*(а) 2018 оны 01 сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөх шинэ стандартууд, түүний тайлбарууд болон нэмэлт өөрчлөлтүүд*

2018 оны 12 сарын 31-нээр тасалбар болсон жилийн санхүүгийн тайланд мөрдөгдөх, Компанид нөлөө үзүүлэх дараах шинэ стандартууд нь Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт оруулсан:

- СТОУС 9 Санхүүгийн хэрэглүүр; болон
- СТОУС 15 Харилцагчтай байгуулсан гэрээний орлого

Дараагийн санхүүгийн жилд анх удаа мөрдөгдөж эхлэх НББОУСЗ-өөс гаргасан бусад шинэ болон нэмэлт өөрчлөлт оруулсан стандарт болон тайлбарууд нь Компанид нөлөө үзүүлэхгүй гэж үзэж байна. Мөн түүнчлэн эдгээр нь Компанийн үйл ажиллагаа эсвэл Компанийн одоогийн нягтлан бодох бүртгэлийн бодлоготой нийцсэн нягтлан бодох бүртгэлийн хэрэгцээ шаардлагатай хамааралгүй болно.

*(б) Хараахан мөрдөгдөж эхлээгүй байгаа шинэ стандартууд, түүний тайлбарууд болон нэмэлт өөрчлөлтүүд*

Компани хугацаанаас нь өмнө хэрэгжүүлэхээр шийдээгүй буюу ирээдүйн нягтлан бодох бүртгэлийн үеүдэд хэрэгжих Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс батлан гаргасан хэд хэдэн стандартууд болон тайлбарууд байна. Тэдгээрээс гол нөлөө бүхий стандартууд нь:

- СТОУС 16 Түрээс
- СТОУТХ 23 Орлогын татварын байр суурьтай холбоотой тодорхой бус байдал

| [illegible] | [illegible] | [illegible] |
|---|---|---|
| СТОУС 16<br><br>2016 оны 01 дугаар сард гаргасан | СТОУС 16 нь НББОУС 17, Түрээс, СТСБХ 4, түрээс агуулсан хэлцэл эсэхийг тодорхойлох, ТБХ 15, Үйл ажиллагааны түрээс – Урамшуулал, ТБХ 27, Түрээсийн эрх зүйн хэлбэртэй холбоотой ажил гүйлгээний мөн чанарыг үнэлэх зэрэг стандарт, тайлбаруудыг орлоно.<br><br>СТОУС 16-ын гол томоохон өөрчлөлт нь үйл ажиллагааны болон санхүүгийн түрээсийн хоорондын ялгаа арилгах мөн санхүүгийн байдлын тайланд хөрөнгийн "ашиглах эрхийг" болон түрээсийн гэрээний өр төлбөрийг тусгах цор ганц загварыг тодорхойлсон. | 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр буюу түүнээс хойших хугацаанд заавал мөрдөнө. СТОУС 15 нь хүлээн зөвшөөрөгдсөн тохиолдолд хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. |
| СТОУТХ 23<br><br>2017 оны 06 дугаар сард гаргасан | СТОУТХ 23 нь орлогын татвартай холбоотой тодорхой бус байдал байгаа үед тайлант жилийн болон хойшлогдсон орлогын албан татварын хөрөнгө ба өр төлбөрийг хэрхэн хэмжиж хүлээн зөвшөөрөхийг илүү тодорхой болгож өгсөн. | 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр буюу түүнээс хойших хугацаанд мөрдөнө |

TDB CAPITAL LLC
"ИНВЕСКОР ББСБ" ХХК
InvesCore
УЛААНБААТАР ХОТ

169

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2019 -03- 26
БҮРТГЭВ-02

## 3. ШИНЭЭР БАТЛАГДСАН, НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛСАН СТАНДАРТ БОЛОН ТАЙЛБАРУУД (үргэлжлэл)

**Нягтлан бодох бүртгэлийн бодлогод гарсан өөрчлөлт (үргэлжлэл)**

*(б) Хараахан мөрдөгдөж эхлээгүй байгаа шинэ стандартууд, түүний тайлбарууд болон нэмэлт өөрчлөлтүүд (үргэлжлэл)*

***Бусад***

Компани Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс батлан гаргасан боловч хараахан мөрдөгдөж эхлээгүй байгаа дараах стандартууд нь компанид материаллаг нөлөө үзүүлэхгүй гэж үзэж байна.

- СТОУС 9 Сөрөг нөхөн төлбөр бүхий урьдчилгаа төлбөрийн онцлог дах нэмэлт өөрчлөлт (2019 оны 01 сарын 01-нээс мөрдөнө)
- НББОУС 28: Хараат болон хамтарсан үйлдвэр дэх урт хугацаат хувь оролцоо дах нэмэлт өөрчлөлт (2019 оны 01 сарын 01-нээс мөрдөнө)
- СТОУС-ын жилийн сайжруулалтууд – 2015-2017 оны цикл (СТОУС 3 Бизнесийн нэгдэл, СТОУС 11 Хамтын хэлэлцээр, НББОУС 12 Орлогын албан татвар болон НББОУС 23 Зээлийн өртөг) (2019 оны 01 сарын 01-нээс мөрдөнө)
- СТОУС 17 Даатгалын гэрээ (2021 оны 01 сарын 01-нээс мөрдөнө)

TDB CAPITAL LLC

170

"ИНВЭСКОР ББСБ" ХХК
InvesCore
NON-BANK FINANCIAL INSTITUTION

## 4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ЧУХАЛ ТООЦООЛОЛ БА ШИЙДЭЛ

Компани нь ирээдүйн үйл ажиллагаатай холбоотой тодорхой тооцоолол ба төсөөлөл ашигладаг. Түүхэн туршлага болон үүссэн нөхцөл байдалд тохиромжтой гэж үзсэн ирээдүйн үйл ажиллагааны тухай таамаглал гэх мэт бусад хүчин зүйлсэд үндэслэн тооцоолол ба шийдлийг тогтмол үнэлдэг. Ирээдүйд бодит үр дүн нь тооцоолол ба төсөөллөөс ялгаатай байж болно. Дараагийн санхүүгийн жилүүдэд хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэд материаллаг нөлөө үзүүлж болохуйц нөлөө бүхий эрсдэлтэй тооцоолол ба төсөөллийг доор дурдлаа.

***(a) Тасралтгүй үйл ажиллагаа***

Эдгээр санхүүгийн тайлангуудыг тасралтгүйгээр үйл ажиллагаагаа явуулна гэсэн өөдрөг төсөөллийн үндсэн дээр бэлтгэсэн.

***(b) Үнэ цэнийн бууралт***

Хөрөнгө эсвэл хөрөнгийн мөнгө бий болгогч нэгжийн дансны үнэ нь эргэн нөхөгдөх дүнгээсээ давбал үнэ цэнийн бууралтын алдагдлыг хүлээн зөвшөөрнө. Эргэн төлөгдөх дүнг тогтоохдоо удирдлага нь хөрөнгө тус бүрийн эсвэл мөнгө бий болгогч нэгжийн ирээдүйн хүлээгдэж буй мөнгөн урсгалыг тооцоолж, эдгээр мөнгөн урсгалын оноогийн үнэ цэнийг тодорхойлохын тулд тохирох хүүг сонгож ашигладаг. Ирээдүйн хүлээгдэж буй мөнгөн урсгалыг хэмжихдээ удирдлага нь ирээдүйн үйл ажиллагааны үр дүнгийн талаар төсөөлөл гаргадаг. Энэ төсөөлөл нь ирээдүйд болох тодорхой нөхцөл байдал болон үйл явдлуудтай холбоотой болно. Бодит үр дүн нь өөр байж болох ба энэ нь дараагийн санхүүгийн жилд багтаж компанийн хөрөнгүүдэд хийгдэх томоохон залруулгуудын шалтгаан байж болно.

Ихэнх тохиолдолд тохирох хөнгөлөлтийн түвшнийг тодорхойлохдоо зах зээлийн эрсдэл болон хөрөнгөтэй холбоотой эрсдэлийн хүчин зүйлийн тохируулгыг хийдэг.

***(c) Элэгдэх хөрөнгийн ашиглалтын хугацаа***

Компанийн удирдлага нь хүлээгдэж буй хөрөнгийн ашиглалтад суурилан тайлант үе бүрийн эцэст биет бус хөрөнгө болон өмч, барилга, тоног төхөөрөмж гэх мэт элэгдэх хөрөнгийн ашиглалтын хугацааг шалгадаг. Гарсан үр дүн нь техникийн хуучралтын улмаас тооцоолол ба төсөөллөөс ялгаатай байж болно. Тэмдэглэл 18, Өмч, барилга, тоног төхөөрөмж болон Тэмдэглэл 19, Биет бус хөрөнгө-д ашиглалтын хугацааны талаар тус тус дэлгэрэнгүй тусгасан.

***(d) Бодит үнэ цэнийн хэмжилт***

Компанийн санхүүгийн тайланд хэд хэдэн хөрөнгө, өр төлбөрийг бодит үнэ цэнээр нь хэмжиж, тодруулахыг шаарддаг. Компанийн санхүүгийн ба санхүүгийн бус хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэнийн хэмжилтэд ажиглагдахуйц өгөгдлийг аль болох их хэмжээгээр хэрэглэдэг. Бодит үнэ цэнийн хэмжилтэд хэрэглэгддэг өгөгдлийг ажиглагдахуйц байдлаар нь гурван түвшинд ангилдаг (‘бодит үнэ цэнийн шатлал’):

- *Түвшин 1*: Идэвхитэй зах зээл дэх ижил төстэй зүйлсийн жишиг үнэ (тохируулга хийгдээгүй)
- *Түвшин 2*: Түвшин 1-ээс бусад ажиглагдахуйц шууд эсвэл шууд бус өгөгдөл
- *Түвшин 3*: Үл ажиглагдахуйц өгөгдөл (зах зээлийн бус мэдээлэл).

Өгөгдсөн зүйлсийн бодит үнэ цэнийн хэмжилтэд томоохон нөлөө үзүүлэх хэрэглэсэн өгөгдлийн өгөгдлийн хамгийн бага түвшинд үндэслэн зүйлсийг дээрх түвшинд ангилдаг. Түвшин хооронд зүйлсийг шилжүүлэхдээ шилжүүлсэн үед нь хүлээн зөвшөөрнө.

Компани нь өөрийн бизнесийн аливаа бие даасан хөрөнгө болон хөрөнгийн бүлэг, эсвэл мөнгө үүсгэгч нэгжийн аль алины түвшинд бодит үнэ цэнийн хэмжилт хийдэггүй.

171

СЗХ 2019 .04. 24
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2019 -03- 26 БҮРТГЭВ-02

## 5. САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР - ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

“Инвескор ББСБ” ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл эрсдэлийн удирдлагын зорилго, бодлогыг тодорхойлж түүнд үндсэн үүрэг хариуцлагыг хүлээхийн зэрэгцээ ББСБ-ын санхүүгийн үйл ажиллагааны зорилго, бодлогыг үр дүнтэйгээр хэрэгжүүлэх процессыг боловсруулж, үйл ажиллагааг нь явуулах эрх мэдэлтэй байдаг. ББСБ-ын гүйцэтгэх удирдлага улирал бүр ТУЗ-д тайлагнадаг бөгөөд энэхүү тайланд хэрэгжиж буй процессын үр дүнтэй байдал болон тогтоосон зорилт, бодлогын тохиромжтой байдалд хийсэн шалгалт багтдаг. Үүнээс гадна ББСБ-ын дотоод аудиторууд эрсдэлийн удирдлагын бодлого ба процессыг хянан шалгаж, илрүүлсэн илрүүлэлтээ ТУЗ-д тайлагнадаг.

Банк бус санхүүгийн байгууллагын эрсдэлийн удирдлагад санхүүгийн, үйл ажиллагааны, хууль зүйн эрсдэлүүд хамаардаг ба эрсдэлийн хязгаар тогтоох, эрсдэлийн нөлөөлөлд дүн шинжилгээ хийх, хяналт тавих замаар эрсдэлийг удирдана. Энэхүү хэсэг нь ББСБ-д учирч болох эрсдэлийн талаар дэлгэрэнгүй авч үзэн, эрсдэлийг хянахад удирдлагын ашиглах аргыг доор харууллаа:

ББСБ нь үйл ажиллагаагаараа дамжуулж дараах эрсдэлүүдэд өртөж байдаг.

a) Зээлийн эрсдэл,
b) Зах зээлийн эрсдэл
   i) Бодит үнэ цэнийн болон
   ii) хүүгийн түвшний эрсдэл
   iii) Гадаад валютын эрсдэл
c) Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын эрсдэл

Эдгээр эрсдэлүүд болон тэдгээрийг удирдах арга замын талаар дор авч үзэв:

a) <u>Зээлийн эрсдэл</u>

Харилцагч ба хамтрагч тал нь гэрээгээр хүлээсэн төлбөрийн үүргээ хугацаанд нь биелүүлээгүйн улмаас ББСБ санхүүгийн алдагдал хүлээх эрсдэлийг зээлийн эрсдэл гэнэ. ББСБ –ын хувьд зээлийн эрсдэлтэй дүн нь санхүүгийн байдлын тайлан дах санхүүгийн хөрөнгийн дансны үнээр илэрхийлэгдэнэ.

Тус ББСБ нь нэг зээлдэгч буюу нэг бүлэг зээлдэгч болон нэг салбарт олгож болох зөвшөөрөгдсөн эрсдэлийн дүнгийн хязгаарыг тогтоох замаар зээлийн эрсдэлийн түвшнийг тодорхойлдог. Зээлийн эрсдэлд орж болох байдлаа ББСБ нь зээлдэгчид болон томоохон зээлдэгчийн хүүгийн төлбөр, зээлийн эргэн төлөлтийн хариуцлагаа биелүүлж чадах чадварын шинжилгээгээр удирддаг. Шаардлагатай үед зээлийн хязгаарыг өөрчилдөг. Зээлийн эрсдэлийг мөн барьцаа хөрөнгө болон байгууллага, хувь хүний гаргасан баталгаагаар удирддаг.

2017 онд ББСБ-ын хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, гүйцэтгэх захирал, ажилтнууд тэдгээртэй холбогдох этгээд болон тэдний эзэмшлийн нэгжид олгох зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны дээд хэмжээ нь өөрийн хөрөнгийн 10 хувь, тэдгээрийн нийлбэр дүн нь өөрийн хөрөнгийн 25 хувиас хэтрэхгүй гэсэн шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллаагүй боловч 2018 онд энэхүү үзүүлэлт хангагдсан байна. Дараах хүснэгтээс харна уу.

TDB CAPITAL LLC



“ИНВЕСКОР ББСБ” ХХК
InvesCore
NON BANKING FINANCIAL INSTITUTION

## 5. САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР - ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (үргэлжлэл)

| | 2018 он | | 2017 он | |
|---|---|---|---|---|
| | мян.төг | Өөрийн хөрөнгөд эзлэх хувь | мян.төг | Өөрийн хөрөнгөд эзлэх хувь |
| Том зээлдэгчид олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив (40 том зээлдэгчээр) | 15,503,368 | 111.58% | 10,136,206 | 113.18% |
| Том зээлдэгчид олгосон зээл, зээлтэй адилтгах тооцох бусад актив (Хамгийн том зээлдэгч) | 2,489,544 | 17.92% | 1,462,120 | 16.33% |
| Хувь нийлүүлэгч, өөрийн ажилтан, холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив | 2,818,927 | 20.29% | 1,302,123 | 14.54% |
| Хувь нийлүүлэгч, өөрийн ажилтан, холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив (Хамгийн том зээлдэгч-1) | 1,388,520 | 9.99% | 1,250,480 | 13.96% |

b) Зах зээлийн эрсдэл

Зах зээлийн эрсдэл нь Компани хүүтэй, худалдагдах, гадаад валютаарх санхүүгийн хэрэглүүрийн хэрэглээнээс үүсдэг. Энэ нь санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ эсвэл ирээдүйн мөнгөн гүйлгээ нь хүүгийн хувь (хүүгийн түвшний эрсдэл), гадаад валютын ханш (валютын эрсдэл) эсвэл зах зээлийн бусад хүчин зүйлс (бусад үнийн эрсдэл)-ийн улмаас хэлбэлзэх эрсдэл юм.

## 5. САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР - ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (үргэлжлэл)

Компани нь үйл ажиллагаагаараа дамжуулж дараах эрсдэлүүдэд өртөж байдаг:

***i. Бодит үнэ цэнийн болон хүүгийн түвшний эрсдэл***

Хүүгийн түвшний эрсдэл гэдэг нь зах зээл дэх зээлийн хүүгийн түвшний өөрчлөлтийн улмаас санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ эсвэл ирээдүйн мөнгөн гүйлгээ хэлбэлзэх эрсдэл юм.

Тайлант хугацааны эцсээрх санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөрт хийх хүүгийн хувь хэмжээний мэдрэмжийн шинжилгээнд тулгуурлан хүүгийн хувь хэмжээний боломжит өөрчлөлт нь орлогын тайлан болон өөрийн хөрөнгөнд томоохон нөлөө үзүүлэхээргүй гэж тус ББСБ-ын удирдлага үзэж байгаа болно.

Хүү бүхий авлага, өглөгийн дүн болон хүүгийн түвшнийг доорх хүснэгтэд харуулав.

| | Хүүгийн түвшин % | 2018 оны 12 сарын 31 мян.төг | Хүүгийн түвшин % | 2017 оны 12 сарын 31 мян.төг |
|---|---|---|---|---|
| **ХҮҮ БҮХИЙ АВЛАГА** | | | | |
| Том зээл | 1.20% | 2,509,237 | 2.5%-2.6% | 1,000,000 |
| Байгууллагын бизнесийн зээл | 1.7%-3.5% | 5,129,702 | 1.7%-3.8% | 3,502,419 |
| Хувь хүнд олгосон бизнесийн зээл | 1.6%-4.0% | 10,002,991 | 1.8%-4.0% | 7,185,445 |
| Хэрэглээний зээл | 1.6%-4.0% | 1,844,554 | 1.6%-4.2% | 4,670,519 |
| Автомашины зээл | 1.6%-3.7% | 14,033,108 | 3.2%-3.7% | 697,239 |
| Кредит картын зээл | 3.50% | 257,244 | | |
| | | **33,776,836** | | **17,055,622** |
| **ХҮҮ БҮХИЙ ӨГЛӨГ** | | | | |
| Толгой компаниас авсан зээл | 19% | 9,974,323 | | 7,288,764 |
| Худалдаа Хөгжлийн банкнаас авсан зээл | 1.9%-2.5% | 1,757,244 | | 100,000 |
| Иргэнээс татсан итгэлцэл | 7.5%-36% | 6,623,510 | 10%-21% | 539,157 |
| Хуулийн этгээдээс татсан итгэлцэл | 8%-36% | 3,224,477 | 8%-20% | 1,894,740 |
| | | **21,579,554** | | **9,822,661** |

***ii. Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн эрсдэл***

Валютын эрсдэл гэдэг нь гадаад валютын ханшийн өөрчлөлтийн улмаас санхүүгийн хэрэглүүрийн үнэ цэнэ хэлбэлзэх эрсдэл юм. Ирээдүйн ажил гүйлгээ, хүлээн зөвшөөрөгдсөн хөрөнгө, өр төлбөр Монгол Төгрөгөөс өөр валютаар илэрхийлэгдсэн тохиолдолд валютын эрсдэл үүсдэг. Тэнцлийн болон тэнцлийн гадуурх гадаад актив, пассивын зөрүү нь нэгж болон нийт валютын хувьд өөрийн хөрөнгийн 40%-иас хэтрэхгүй байхыг СЗХ-оос шаарддаг. ББСБ-ын хувьд позицийн удирдлагыг хангаж ажиллах тал дээр анхаарч ажилладаг бөгөөд энэхүү харьцаа нь 0.91% (2017 онд 2.2%) байна.

СЗХ 2019 .04. 24 өдөр



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2019 -03- 26
БҮРТГЭВ

## 6. ХҮҮ БОЛОН ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ОРЛОГО

| | 2018 он мян.төг | 2017 он мян.төг |
|---|---|---|
| Зээлийн хүүгийн орлого | 10,780,916 | 4,466,769 |
| Харилцах дансны хүүгийн орлого | 12,912 | 9,649 |
| | **10,793,828** | **4,476,418** |

## 7. ХҮҮ БОЛОН ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ЗАРДАЛ

| | 2018 он мян.төг | 2017 он мян.төг |
|---|---|---|
| Зээлийн хүүгийн зардал | (1,733,427) | (558,975) |
| Итгэлцлийн үйлчилгээний хүүгийн зардал | (839,134) | (118,881) |
| | **(2,572,561)** | **(677,856)** |

## 8. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖ, ШИМТГЭЛИЙН ОРЛОГО

| | 2018 он мян.төг | 2017 он мян.төг |
|---|---|---|
| Зээлийн үйлчилгээний шимтгэлийн орлого | 300,370 | 129,612 |
| 8%-ийн зээлийн шимтгэлийн орлого | 23,770 | 36,708 |
| | **324,140** | **166,320** |

## 9. ГАДААД ВАЛЮТЫН АРИЛЖАА БОЛОН ХАНШИЙН ТЭГШИТГЭЛИЙН ОРЛОГО/(ЗАРДАЛ)

| | 2018 он мян.төг | 2017 он мян.төг |
|---|---|---|
| Гадаад валютын арилжааны орлого | 2,236 | 85 |
| Ханшийн тэгшитгэлийн хэрэгжсэн олз | 549,596 | 67,710 |
| Ханшийн тэгшитгэлийн хэрэгжээгүй олз | 59,634 | 3,712 |
| Ханшийн тэгшитгэлийн хэрэгжсэн гарз | (516,179) | (86,653) |
| Ханшийн тэгшитгэлийн хэрэгжээгүй гарз | (17,360) | (1,442) |
| | **77,927** | **(16,588)** |

TDB CAPITAL LLC



"ИНВЕСКОР ББСБ" ХХК
InvesCore
NON-BANK FINANCIAL INSTITUTION
УЛААНБААТАР ХОТ

## 10. АЖИЛЛАГСАДТАЙ ХОЛБООТОЙ ЗАРДАЛ

| | 2018 он мян.төг | 2017 он мян.төг |
|---|---|---|
| Үндсэн цалин | (755,196) | (292,160) |
| Ажилчдад олгосон тэтгэмж | (1,000) | (2,000) |
| Албан томилолтын зардал | (50,534) | (1,869) |
| Сургалтын зардал | (4,736) | (960) |
| НДШ-ийн зардал | (90,554) | (32,075) |
| | **(902,020)** | **(329,064)** |

## 11. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУСАД ЗАРДАЛ

| | 2018 он мян.төг | 2017 он мян.төг |
|---|---|---|
| Итгэлцлийн үйлчилгээ болон түүнтэй холбогдон гарсан зардал | - | (84,640) |
| Аудитын төлбөр, мэргэжлийн үйлчилгээ | (45,534) | (2,208) |
| Түрээс | (142,323) | (51,388) |
| Ашиглалтын зардал | (8,002) | (4,859) |
| Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал | (41,284) | (11,902) |
| Харилцаа холбоо, интернэт | (43,055) | (13,678) |
| Шатахуун болон тээврийн зардал | (28,780) | (8,067) |
| Сэлбэг хэрэгсэл, засвар үйлчилгээ | (967) | (704) |
| Зохицуулалтын үйлчилгээний хураамж | (3,240) | (3,600) |
| Захиалгат хэвлэлийн зардал | - | (36) |
| Автоматжуулалттай холбоотой урсгал зардал | (20,242) | (1,200) |
| Зар сурталчилгаа, маркетингийн судалгаа | (108,256) | (15,830) |
| Бичиг хэргийн зардал | (15,609) | (9,379) |
| Ариун цэврийн зардал | (1,408) | (36) |
| Даатгалын төлбөр | - | (10,979) |
| Шимтгэл, хураамжийн зардал | (13,762) | - |
| Зочин төлөөлөгчийн зардал | (34,449) | (9,286) |
| Баяр ёслол | (28,438) | (5,592) |
| Бусад (Хандив) | (11,719) | (10,878) |
| Бусад | (25,036) | (208) |
| | **(572,104)** | **(244,470)** |

## 12. ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛИЙН САНГИЙН ЗАРДАЛ

Энэхүү дүн нь харилцагчдад олгосон зээлийг СТОУС-ын дагуу бүлгийн үнэлгээгээр байгуулсан эрсдэлийн сангийн зардлын дүнг илэрхийлнэ. Групп нь зээлийн багцад эрсдлийн сан байгуулах тухай СТОУС 9, Санхүүгийн хэрэглүүр: Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилтэнд заасан аргачлалыг ашигласан боловч тухайлсан зээлийн үлдэгдэлд тусгайлан тооцох боломжгүй үнэ цэнэ бууралтын гарзыг тайлант хугацааны эцэст багцын хэмжээнд үнэлж сан байгуулсан. Групп зээлийг хэрэглээний зээл, барилгын салбарын зээл, санхүү даатгалын салбар, бөөний болон жижиглэн худалдаа, үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагааны салбар зэрэг үндсэн 6 салбарт бүлэглэн үнэ цэнийн бууралт тооцсон.

176

## 13. ОРЛОГЫН АЛБАН ТАТВАР

***Татварын зардал болон санхүүгийн тайлагналын зорилгоор тооцсон ашгийн тооцооны тохируулга***

2018, 2017 онуудад Компани нь Монгол улсын Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн дагуу тайлант жилийн 3 тэрбум төгрөг хүртэлх татвар ногдуулах орлогоос 10 хувиар, 3 тэрбум төгрөгөөс дээших татвар ногдуулах орлогын дунд 25 хувиар орлогын албан татвар ногдуулж, төлөх үүрэгтэй.

Бодит татварын зардал болон хүлээгдэж (тооцоологдож) буй татварын зардлын зөрүүний тооцоо дараах байдалтай байна.

| | 2018 он мян.төг | 2017 он мян.төг |
|---|---|---|
| **Татварын өмнөх ашиг/(алдагдал)** | **6,177,444** | **3,062,327** |
| *Хүчин төгөлдөр татварын хувь хэмжээний тохируулга* | | |
| Тусгайлсан хувь хэмжээгээр татвар ногдох орлого | 12,912 | 9,649 |
| Татвараас хасагдахгүй зардал | 242,473 | 46,591 |
| **Нийтлэг хувь хэмжээгээр татвар ногдуулах орлого** | **6,407,005** | **3,099,269** |
| Татварын хувь хэмжээ | 10% | 10% |
| **Тайлант үеийн татвар** | | |
| Нийтлэг хувь хэмжээтэй татварын зардал | 303,464 | 300,000 |
| Шаталсан хувь хэмжээтэй татварын зардал | 828,489 | 24,817 |
| Тусгайлсан хувь хэмжээтэй татварын зардал - 10% | 1,291 | 964.9 |
| **Хойшлогдсон татварын зардал/(өгөөж)** | **(9,305)** | - |
| **Нийт татварын зардал** | **1,123,939** | **(325,782)** |

## 14. МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ

| | 2018 оны 12 сарын 31 мян.төг | 2017 оны 12 сарын 31 мян.төг |
|---|---|---|
| Бэлэн мөнгө /төгрөг/ | 80,135 | 144,243 |
| Банк дах харилцах | 2,103,987 | 959,939 |
| Банк дах хадгаламж | 136,000 | |
| | **2,320,122** | **1,104,182** |

12 сарын 31-ний өдрөөрх мөнгөн хөрөнгийн эрсдэлийн чанарыг Стандарт ба Пүүсийн рейтинг дээр үндэслэн нэгтгэн дор харуулаа.

СЗХ 2019 .04. 24 өдөр №01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2019 -03- 26

## 14. МӨНГӨ ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ (үргэлжлэл)

| | 2018 оны 12 сарын 31 мян.төг | 2017 оны 12 сарын 31 мян.төг |
|---|---|---|
| *Хугацаа хэтрээгүй ба үнэ цэнэ буураагүй* | | |
| - Касс дахь бэлэн мөнгө | 80,135 | 144,243 |
| - B- эсвэл B+ зэрэглэлтэй банкны үлдэгдэл | 2,239,987 | 959,939 |
| - Зэрэглэлгүй банкны үлдэгдэл | | - |
| | **2,320,122** | **1,104,182** |

12 сарын 31-ний өдрөөрх мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг үндсэн валютаар илэрхийлбэл:

| | 2018 оны 12 сарын 31 мян.төг | 2017 оны 12 сарын 31 мян.төг |
|---|---|---|
| Төгрөг | 522,580 | 1,052,073 |
| Ам.доллар | 131,390 | 52,067 |
| Иен | 1,666,152 | 42 |
| | **2,320,122** | **1,104,182** |

## 15. ӨМЧЛӨХ БУСАД ХӨРӨНГӨ

| | 2018 он мян.төг | 2017 он мян.төг |
|---|---|---|
| **01-р сарын 01-ээрх үлдэгдэл** | **539,894** | - |
| Нэмэгдсэн | 557,166 | 539,894 |
| Хасагдсан | (657,551) | |
| **12-р сарын 31-ээрх үлдэгдэл** | **439,509** | **539,894** |
| Хасах: Үнэ цэнийн бууралтын сан | (21,975) | |
| | **417,534*** | **539,894** |

* Энэхүү дүн нь "Инвескор ББСБ" ХХК-ийн 2018 онд олж эзэмшсэн өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгийн дүнг илэрхийлэх бөгөөд 417.5 сая төгрөгийн үнэ бүхий 2 ширхэг үл хөдлөх хөрөнгө, 2 ширхэг хөдлөх хөрөнгөөс бүрдэж байна. Өмчлөх бусад хөрөнгийн хувьд үнэ цэнийн бууралтыг СЗХ-ны журмын дагуу тооцож бүртгэсэн бөгөөд эдгээр хөрөнгийн дансны цэвэр үнэ нь эргэн нөхөгдөх дүнтэй ойролцоо илэрхийлэгдэж байна.

TDB CAPITAL LLC 5251494

"ИНВЕСКОР ББСБ" ХХК InvesCore NON-BANK FINANCIAL INSTITUTION 6060854 УЛААНБААТАР ХОТ

## 16. ХАРИЛЦАГЧДАД ОЛГОСОН ЗЭЭЛ

Зээлийн эрсдлийн сан

| | 2018 оны 12 сарын 31 | | | | | | 2017 оны 12 сарын 31 | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Зээл | | ЗЭС | | Цэвэр Зээл | | Зээл | | ЗЭС | | Цэвэр Зээл | |
| | мян.төг | % | мян.төг | % | мян.төг | % | мян.төг | % | мян.төг | % | мян.төг | % |
| Хэвийн | 31,227,816 | 89% | - | - | 31,227,816 | 92% | 14,201,770 | 81% | - | 0% | 14,201,770 | 83% |
| Хугацаа хэтэрсэн | 1,993,711 | 6% | (99,686) | 9% | 1,894,025 | 6% | 2,337,692 | 13% | (116,884) | 23% | 2,220,808 | 13% |
| Хэвийн бус | 613,602 | 2% | (153,400) | 14% | 460,202 | 1% | 502,427 | 3% | (125,607) | 25% | 376,820 | 2% |
| Эргэлзээтэй | 389,586 | 1% | (194,793) | 17% | 194,793 | 1% | 512,448 | 3% | (256,224) | 51% | 256,224 | 2% |
| Муу | 672,437 | 2% | (672,437) | 60% | - | 0% | - | 0% | - | 0% | - | 0% |
| **Нийт** | **34,897,152** | **100%** | **(1,120,316)** | **100%** | **33,776,836** | **100%** | **17,554,337** | **100%** | **(498,715)** | **100%** | **17,055,622** | **100%** |
| Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага | | | | | 1,241,362 | | | | | | 695,435 | |
| Зээлийн үнэ цэнийн бууралт болон эрсдэлийн сангийн зөрүү* | | | | | (149,912) | | | | | | - | |
| Ирээдүйд ашиг алдагдлаар ангилагдаж болзошгүй эрсдэлийн сангийн нөөц** | | | | | - | | | | | | 108,751 | |
| **Нийт цэвэр зээл** | | | | | **34,868,286** | | | | | | **17,859,808** | |

* Энэхүү дүн нь СТОУС9-ийн дагуу байгуулсан зээлийн үнэ цэнийн бууралт нь Санхүүгийн Зохицуулах Хорооны заавар журмын дагуу байгуулсан зээлийн эрсдлийн сангаас давсан дүнг илэрхийлнэ

** Энэхүү дүн нь НББОУС 39-ийн дагуу байгуулсан зээлийн үнэ цэнийн бууралтаас давсан Санхүүгийн Зохицуулах Хорооны заавар журмын дагуу байгуулсан зээлийн эрсдлийн сангийн дүнг илэрхийлнэ.

179

СЗХ 2019.04.24 БҮРТГЭВ №01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2019-03-26 БҮРТГЭВ-02

## 16. ХАРИЛЦАГЧДАД ОЛГОСОН ЗЭЭЛ (үргэлжлэл)

Зээлийн бүтээгдэхүүний ангиллаар

| | 2018 оны 12 сарын 31 | | 2017 оны 12 сарын 31 | |
|---|---|---|---|---|
| | мян.төг | % | мян.төг | % |
| Том зээл | 2,509,237 | 7% | 1,000,000 | 6% |
| Байгууллагын бизнесийн зээл | 5,165,349 | 15% | 3,568,984 | 20% |
| Хувь хүнд олгосон бизнесийн зээл | 10,896,859 | 31% | 7,578,597 | 43% |
| Хэрэглээний зээл | 1,963,860 | 6% | 4,709,517 | 27% |
| Автомашины зээл | 14,104,602 | 40% | 697,239 | 4% |
| Кредит картын зээл | 257,244 | 1% | - | - |
| **Нийт зээлийн үлдэгдэл** | **34,897,151** | **100%** | **17,554,337** | **100%** |
| Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага | 1,241,362 | | 695,435 | |
| Зээлийн эрсдэлийн сан | (1,120,316) | | (498,715) | |
| Зээлийн эрсдэлийн сангийн нөөц | - | | 108,751 | |
| Зээлийн үнэ цэнийн бууралт болон эрсдэлийн сангийн зөрүү | (149,911) | | - | |
| **Нийт цэвэр зээлийн үлдэгдэл:** | **34,868,286** | | **17,859,808** | |

- Зээлийн үнэ цэнийн бууралтын сангийн дүн нь бүлгийн үнэлгээгээр байгуулсан сан болно.

## 17. БУСАД САНХҮҮГИЙН БУС ХӨРӨНГӨ

| | 2018 оны 12 сарын 31 мян.төг | 2017 оны 12 сарын 31 мян.төг |
|---|---|---|
| Бараа материал | 50 | - |
| Түрээсийн барьцааны авлага | 3,218 | 3,644 |
| Томилолтын авлага | 971 | 971 |
| Урьдчилж төлсөн төлбөр | 59,515 | 34,537 |
| НДШ-ийн авлага | 1,556 | 220 |
| ХХОАТ авлага | 51,617 | - |
| Бусад авлага | 694,287 | 248 |
| | **811,214** | **39,620** |

TOB CAPITAL LLC 5251494
"ИНВЕСКОР ББСБ" ХХК InvesCore NON BANK FINANCIAL INSTITUTION 6080854 УЛААНБААТАР ХОТ

## 18. ӨМЧ, БАРИЛГА, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ- ЦЭВЭР

| | Барилга байгууламж | Тоног төхөөрөмж | Тээврийн хэрэгсэл | Тавилга эд хогшил | Компьютер, дагалдах хэрэгслүүд | Нийт |
|---|---|---|---|---|---|---|
| | мян.төг | мян.төг | мян.төг | мян.төг | мян.төг | мян.төг |
| **ӨРТӨГ** | | | | | | |
| **2017 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл** | - | 3,049 | - | 9,438 | 9,992 | 22,479 |
| Худалдан авсан | 18,491 | 8,718 | 14,040 | 11,113 | 21,002 | 73,364 |
| **2017 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | 18,491 | 11,767 | 14,040 | 20,551 | 30,994 | 95,843 |
| Худалдан авсан | - | 24,148 | - | 175,886 | 76,243 | 276,277 |
| Худалдан борлуулсан | - | - | - | (367) | (2,200) | (2,567) |
| **2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | 18,491 | 35,915 | 14,040 | 196,070 | 105,037 | 369,553 |
| **ХУРИМТЛАГДСАН ЭЛЭГДЭЛ** | | | | | | |
| **2017 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл** | - | (600) | - | (483) | (1,831) | (2,914) |
| Тайлант жилд байгуулсан элэгдэл | (135) | (1,872) | (1,058) | (1,420) | (6,056) | (10,541) |
| **2017 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | (135) | (2,472) | (1,058) | (1,903) | (7,887) | (13,455) |
| Тайлант жилд байгуулсан элэгдэл | (462) | (5,796) | (1,404) | (5,968) | (20,410) | (34,040) |
| Худалдан борлуулсан хөрөнгийн элэгдэл | - | - | - | 33 | 377 | 410 |
| **2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | (597) | (8,268) | (2,462) | (7,838) | (27,920) | (47,085) |
| **ДАНСНЫ ҮНЭ** | | | | | | |
| **2017 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл** | - | 2,449 | - | 8,955 | 8,161 | 19,565 |
| **2017 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | 18,356 | 9,295 | 12,982 | 18,648 | 23,107 | 82,388 |
| **2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | 17,894 | 27,647 | 11,578 | 188,232 | 77,118 | 322,468 |

2019.04.24

"ИНВЕСКОР ББСБ" ХХК
InvesCore
1110224259 ☎ 6060854
УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
-02

2019 .04. 24



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2019 -03- 26

## 19. БИЕТ БУС ХӨРӨНГӨ

| | Программ хангамж мян.төг | Түрээсийн сайжруулалт мян.төг | Нийт мян.төг |
|---|---|---|---|
| **2017 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл** | **2,947** | **6,428** | **9,375** |
| Нэмэгдсэн | 1,000 | 8,626 | 9,626 |
| Хасагдсан | | | |
| Тайлант жилд байгуулсан хорогдуулалт | (306) | (1,056) | (1,362) |
| **2017 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | **3,641** | **13,998** | **17,639** |
| Нэмэгдсэн | 86,660 | 195,943 | 282,603 |
| Хасагдсан | - | (7,555) | (7,555) |
| Тайлант жилд байгуулсан хорогдуулалт | (1,242) | (6,885) | (8,127) |
| Хасагдсан хөрөнгийн хорогдуулалт | - | 1,547 | 1,547 |
| **2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | **89,059** | **197,048** | **286,107** |

## 20. ДҮРМИЙН САН

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар "Инвескор ББСБ" ХХК-ийн дүрмийн сан нь 1,000 мянган төгрөгийн нэрлэсэн үнэтэй 6,096,873ширхэг энгийн хувьцаанаас бүрдэж байна.

Гаргасан бөгөөд бүрэн төлөгдсөн энгийн хувьцааны хувьцаа эзэмшигчдийн бүтэц дараах байдалтай байна. Үүнд:

| | 2018 оны 12-р сарын 31 | | | 2017 оны 12-р сарын 31 | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Тоо хэмжээ | Нэрлэсэн үнэ мян.төг | Нийт үнэ мян.төг | Тоо хэмжээ | Нэрлэсэн үнэ мян.төг | Нийт үнэ мян.төг |
| "Эс Ай Би Жэй Капитал" ХХК | 6,096,873 | 1,000 | 6,096,873 | 6,096,873 | 1,000 | 6,096,873 |
| | **6,096,873** | | **6,096,873** | **6,096,873** | | **6,096,873** |

## 21. ЭРСДЛИЙН САНГИЙН НӨӨЦ

Энэхүү дүн нь Санхүүгийн Зохицуулах Хорооны дарга, Сангийн сайдын 2015 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 144/125 тоот хамтарсан тушаалаар баталсан "Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам"-ын дагуу байгуулсан эрсдэлийн сангийн нөөц болон СТОУС-ын дагуу тооцоолсон зээлийн үнэ цэнийн бууралтын зөрүүгээр үүсгэсэн нөөц сангийн дүнг илэрхийлнэ.

TDB CAPITAL LLC
5251494



"ИНВЕСКОР ББСБ" ХХК
InvesCore
NON BANK FINANCIAL INSTITUTION
УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2019 -03- 26
БҮРТГЭВ-02

СЗХ 2019 .04. 24

## 22. ИТГЭЛЦЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨР ТӨЛБӨР

| | 2018 оны 12 сарын 31 мян.төг | 2017 оны 12 сарын 31 мян.төг |
|---|---|---|
| Итгэлцлийн үйлчилгээний өр төлбөр-иргэн | 6,638,510 | 539,157 |
| Итгэлцлийн үйлчилгээний өр төлбөр-Хуулийн этгээд | 3,224,477 | 1,894,740 |
| Итгэлцлийн үйлчилгээнд хуримтлуулж тооцсон хүүгийн өр төлбөр | 511,121 | 73,795 |
| | **10,374,108** | **2,507,692** |

## 23. БАНК САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГААС АВСАН ЗЭЭЛ

| | 2018 оны 12 сарын 31 мян.төг | 2017 оны 12 сарын 31 мян.төг |
|---|---|---|
| Хөрөнгө оруулагчийн зээл-1 | 9,974,323 | 7,288,764 |
| Худалдаа хөгжлийн банкны зээл-2 | 1,500,000 | 100,000 |
| Худалдаа хөгжлийн банкны зээл-3 | 257,244 | - |
| Зээлийн хуримтлагдсан хүүгийн өр төлбөр | 2,135,879 | 508,385 |
| | **13,867,446** | **7,897,149** |

**Зээл-1**

2017 оны 03 дугаар сарын 29-ний өдөр “Эс Ай Би Жэй Капитал” ХХК, “Инвескор ББСБ” ХХК-ийн хооронд байгуулагдсан “Инвескор” ББСБ ХХК-ийн бизнесийн эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэхэд зориулан 082601 тоот зээлийн гэрээний дагуу 79,000 ам.доллар болон 61 сая иений зээл авсан. Зээл нь жилийн 19%-ийн хүүтэй, хугацаагүй байна. 2018 оны байдлаар зээлийн хүүг хуримтлуулан тооцож байгаа бөгөөд зээлийн үндсэн болон хүүгийн төлөлт хийгдээгүй байна.

**Зээл-2**

2017 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр Худалдаа Хөгжлийн банк, , “Инвескор ББСБ” ХХК-ийн хооронд эргэлтийн хөрөнгийн санхүүжилтэд зориулан ЗГ/RCC170911005-1 тоот 250,000,000 төгрөгийн зээлийн шугамын гэрээ байгуулсан байна.Тайлант жилд нийт 100 сая төгрөгийн зээлийг ашигласан байна. Зээл нь ашигласан зээлийн үлдэгдэл сарын 2.1%-ийн хүүтэй, хөвөгч хүүгийн түвшин 2.5%, ашиглаагүй зээлийн үлдэгдэлд жилийн 4%-ийн хүүтэй 24 сарын хугацаатай байна. Хүүгийн төлбөрийг сар бүр, үндсэн зээлийн төлбөрийг хугацааны эцэст төлөх гэрээний үүрэгтэй. Уг зээлийн батлан даагчаар “Эс Ай Би Жэй Капитал” ХХК оролцсон бөгөөд зээлд “Эс Ай Би Жэй Капитал” ХХК-ийн эзэмшлийн 4 ширхэг 442.8 сая төгрөгийн үнэлгээ бүхий орон сууцны зориулалттай үл хөдлөх хөрөнгийг барьцаалсан байна.

2018 оны 07 дугаар сарын 09-ний өдөр Худалдаа Хөгжлийн банк, Инвескор ББСБ ХХК – ийн хооронд зээлийн эрх нэмэх нэмэлт гэрээ болох ЗЭНГ/RCC170911005-1-2 тоот 1,500,000,000 төгрөгийн зээлийн шугамын гэрээг нэмж байгуулсан байна. Уг зээл нь ашигласан зээлийн үлдэгдэлд жилийн 19,2%-ийн хүүтэй, зээлийн хэтэрсэн хугацааны хүү сарын 2.5% жилийн 30% болно. Тус гэрээний барьцаанд “Эс Ай Би Жэй Рийл Эстэйт” ХХК, “Эс Ай Би Жэй Про” ХХК, “Эс Ай Би Жэй Холдингс” ХХК болон гүйцэтгэх захирал Д.Баясгалан-ийн үл хөдлөх хөрөнгүүд мөн “Эс Ай Би Жэй Холдингс” ХХК болон “Инвескор ББСБ” ХХК-ийн хадгаламжийн дансыг барьцаалсан байна.

“ИНВЕСКОР ББСБ” ХХК
InvesCore

## 23. БАНК САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГААС АВСАН ЗЭЭЛ (үргэлжлэл)

| | |
|---|---|
| Зээл-3 | 2018 оны 04 дүгээр сарын 23-ний өдөр Худалдаа Хөгжлийн банк, Инвескор ББСБ ХХК –ийн хооронд кредит картны үйлчилгээг санхүүжүүлэх үндсэн зорилгоор зээлийн эрх нээх нэмэлт гэрээ болох ЗЭНГ/RCC170911005-1-1 тоот 500,000,000 төгрөгийн зээлийн шугамын гэрээг нэмж байгуулсан байна. Тус зээлийн үндсэн хүү сарын 1.9% бөгөөд хэтэрсэн хугацааны хүү сарын 2.3% байна. |

## 24. БУСАД САНХҮҮГИЙН ӨР ТӨЛБӨР

| | 2018 оны 12 сарын 31 мян.төг | 2017 оны 12 сарын 31 мян.төг |
|---|---|---|
| Толгой компанид өгөх шимтгэлийн өглөг | 294,850 | 78,946 |
| Холбоотой талд өгөх өглөг | 108,810 | - |
| Түрээсийн өглөг | 910 | 624 |
| Бусад санхүүгийн өр төлбөр | 91,820 | 5,770 |
| | **496,390** | **85,340** |

## 25. БУСАД САНХҮҮГИЙН БУС ӨР ТӨЛБӨР

| | 2018 оны 12 сарын 31 мян.төг | 2017 оны 12 сарын 31 мян.төг |
|---|---|---|
| Хойшлогдсон татварын өр төлбөр | 1,731 | 11,036 |
| ААНОАТ-ийн өглөг | 308,838 | 265,253 |
| ХХОАТ-ийн өглөг | 36,733 | 33,122 |
| Хойшлогдсон орлого | 29,334 | 6,235 |
| Цалингийн өглөг | 17,002 | 314 |
| Бусад санхүүгийн бус өр төлбөр | 393 | - |
| | **394,031** | **315,960** |

184

СЭХ 2019 .04. 24 өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2019 -03- 26 БҮРТГЭВ-02

## 26. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ

### a. *Гадаад валютаарх ажил гүйлгээ*

Компанийн тайлагнагч валют нь Монгол улсын Төгрөг юм. Компанийн үйл ажиллагааны үндсэн валют нь Монгол Улсын Төгрөг болно.

Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөөрх хөрөнгө, өр төлбөрийг тайлагнах валют (Төгрөг) рүү хөрвүүлэхдээ балансын өдрийн албан ханшаар, гадаад валютаар илэрхийлэгдсэн орлого, зарлагуудыг гүйлгээ гарсан өдрийн албан ханшаар хөрвүүлсэн. Эдгээр хөрвүүлэлтээс үүссэн ханшийн зөрүүний олз ба гарзыг дэлгэрэнгүй орлогын тайланд тусгасан.

Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн бус хөрөнгө, өр төлбөрийг түүхэн өртгөөр нь илэрхийлж гүйлгээ гарсан өдрийн албан ханшаар төгрөгт хөрвүүлсэн.

Тайлант жилийн явцад хэрэглэж байсан ханш дараах байдалтай байна:

| | Дундаж ханш | | Хаалтын ханш | |
|---|---|---|---|---|
| | 2018 он | 2017 он | 2018 он | 2017 он |
| Ам.доллар ба төгрөг | 2,472.64 | 2,439.78 | 2,642.92 | 2427.13 |
| Иен ба төгрөг | 22.39 | 21.76 | 23.94 | 21.53 |

### b. *Орлого хүлээн зөвшөөрөлт-Хүү болон түүнтэй адилтгах орлого ба зардал*

Хүүгийн орлого ба зардлыг үр ашигт хүүгийн түвшинг ашиглан бүх өрийн хэрэгслүүдийн хувьд ашиг, алдагдал болон дэлгэрэнгүй орлогын тайланд аккруэл сууриар бүртгэдэг. Үр ашигт хүүгийн арга нь санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийн хорогдуулсан өртгийг тооцож, хүүгийн орлого ба хүүгийн зардлыг холбогдох хугацаанд нь хуваарилдаг арга юм. Үр ашигт хүүгийн түвшин гэдэг нь санхүүгийн хэрэглүүрийн хүлээгдэж буй хугацааны турш хүлээн авах мөнгөн орлого болон төлөх мөнгөн төлбөрийг санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийн дансны цэвэр үнэ хүртэл нь хөнгөлөх түвшин юм. Үр ашигт хүүгийн түвшинг тооцоолохдоо санхүүгийн хэрэглүүрийн гэрээний бүх нөхцөлүүдийг харгалзан үзэж мөнгөн урсгалыг тооцоолох боловч ирээдүйн зээлийн алдагдлыг харгалзан үздэггүй. Энэхүү тооцоолол нь гэрээнд оролцогч талуудын төлсөн буюу хүлээн авсан бүх шимтгэл, хураамж, ажил гүйлгээний зардал бусад бүх хөнгөлөлт эсвэл урамшууллыг үр ашигт хүүгийн түвшний салшгүй хэсэгт болгон авч үздэг.

Хүү бүхий санхүүгийн хэрэглүүрүүдийн хүүгийн орлого, зардлыг холбогдох санхүүгийн хөрөнгө эсвэл өр төлбөрийн үр ашигт хүүгийн хувийг хэрэглэн ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд “Хүү болон түүнтэй адилтгах орлого” ба “Хүү болон түүнтэй адилтгах зардал” гэж хүлээн зөвшөөрнө. Үнэ цэнийн бууралтад орсон зээл, урьдчилгааны хүүгийн орлогоос бусад хүүгийн орлогыг аккруэл сууриар ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрнө. Үнэ цэнийн бууралтад орсон санхүүгийн хөрөнгийн хүүгийн орлогыг анхны үр ашигт хүүгийн хувь хэмжээгээр тооцож хүлээн зөвшөөрнө.

### c. *Орлого хүлээн зөвшөөрөлт- Хураамж шимтгэлийн орлого*

ББСБ нь өөрийн харилцагч нарт үзүүлдэг үйлчилгээнээс хураамж, шимтгэлийн орлого олдог. Хураамж, шимтгэлийн орлогыг үйлчилгээ үзүүлсэн тайлант хугацаанд нь орлогоор хүлээн зөвшөөрдөг.

TDB CAPITAL LLC

"ИНВЕСКОР ББСБ" ХХК InvesCore NON BANK FINANCIAL INSTITUTION УЛААНБААТАР ХОТ

185

## 26. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ (үргэлжлэл)

### *d. Хураамж шимтгэлийн зардал*

ББСБ-ын хураамж, шимтгэлийн зардал нь ихэвчлэн харилцах дансны шимтгэл, банкны зээлийн хураамж зэргээс бүрддэг. Хураамж, шимтгэлийн зардлыг үйлчилгээ үзүүлсэн хугацаанд нь хүлээн зөвшөөрдөг.

### *e. Зээлийн өртөг*

Хугацаа шаардсан хөрөнгийн худалдаж авах, барьж байгуулах, үйлдвэрлэхтэй шууд холбоотой зээлийн зардлыг тухайн хөрөнгө иж бүрэн, ашиглахад бэлэн болох хүртэлх хугацаанд капиталжуулдаг. Тухайн зорилгоор авсан зээлтэй холбоотой хүүгийн түвшин эсвэл Компанийн зээлийн ерөнхий эх үүсвэр нь ашиглагдаж буй бол жигнэсэн дундаж хүүгийн түвшнээр санхүүгийн зардлыг капиталжуулдаг.

Зээлийн өртгийн капиталжуулалт нь хөрөнгийн барьж босгох үйл явц зогссон үед дуусдаг. Бусад зээлийн өртөг нь тухайн зардал гарсан үеийн хугацаандаа "Санхүүгийн зардал"-д тайлагнагддаг.

### *f. Татварын зардал*

Татварын зардал нь тайлант жилийн болон хойшлуулсан татварын зардлын нийлбэрээс бүрдэх бөгөөд орлогын тайланд тусгагддаг. Компанийн татвар нь тайлант жилийн татвар ногдуулах орлогод ногдох балансын өдрөөр хүчинтэй байгаа татварын хувь хэмжээгээр тооцсон бөгөөд өмнөх үеийн татварын өглөг, хойшлуулсан татвар хөрөнгө ба өр төлбөрийг тохируулсан хүлээгдэж буй татварын хөрөнгө эсвэл өглөг юм.

Хойшлогдсон татвар нь санхүүгийн тайлагналын зорилгоор бүртгэсэн хөрөнгө болон өр төлбөрийн дансны үнэ ба татварын тайлагналын зорилгоор бүртгэсэн үнийн зөрүүнээс үүссэн түр зөрүү юм. Хойшлогдсон татварыг тайлагнах өдрөөрх болон цаашид хэрэгжих хуульд үндэслэн буцаалт хийгдэх түр зөрүүнд хэрэгжихээр хүлээгдэж байгаа татварын хувиар тооцдог. Хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийг татвар ногдуулах нэг аж ахуйн нэгжид хамаарах татварын байгууллагаас тогтоосон тайлант үеийн татвар ногдуулах хөрөнгө, өр төлбөрийн эсрэг хуулийн эрх үүргийн дагуу хооронд нь хааж болох бөгөөд гэхдээ эдгээр татвар ногдуулах хөрөнгө, өр төлбөр нь цэвэр дүнд суурилсан байх хэрэгтэй.

Ирээдүйн татвар ногдуулах ашиг нь татварын түр зөрүүг нөхөхүйц байх тохиолдолд хойшлогдсон татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрнө. Хойшлогдсон татварын хөрөнгийг тайлант үе бүрд хянаж холбогдох татварын өгөөжийг хэрэгжүүлэх буюу бууруулдаг.

### *g. Ажилчдын тэтгэмж*

*i) Түр хугацааны ажилчдын тэтгэмж*

Богино хугацаат ажилчдын тэтгэмж нь хөнгөлөлтгүй сууриар хэмжигддэг бөгөөд ажилчдын ажил гүйцэтгэсэн тайлант үед нь зардлаар бүртгэдэг.

Хэрэв ажилчдын гүйцэтгэсэн ажлын үр дүнгээс үүдэн компани хуулийн дагуу бонус өгөх хариуцлага хүлээх болон бонусын дүнг үндэслэлтэй тооцоолох боломжтой үед тооцоолсон дүнгээр богино хугацаат бонусын өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө.

*ii) Нийгмийн болон эрүүл мэндийн даатгал*

Монгол улсын хуулийн дагуу Монгол улсад үйл ажиллагаагаа явуулж байгаа компаниуд нь нийгмийн болон эрүүл мэндийн даатгалыг зохих ёсоор төлөх ёстой бөгөөд уг зардлыг гарсан тухайн үед нь орлогын тайланд зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

186

## 26. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ (үргэлжлэл)

### h. *Өмч, барилга, тоног төхөөрөмж*

*Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт*

Өмч, барилга, тоног төхөөрөмжийг анх өртгөөр нь хүлээн зөвшөөрөх бөгөөд анхны өртөгт худалдан авсан үнэ, тухайн хөрөнгийг Компанийн зориулалтын ажлын байршил, нөхцөлд бэлэн болгоход шаардагдах худалдан авалттай холбоотой зардлууд багтах бөгөөд үүнд мөн холбогдох зээлийн зардлыг оруулдаг.

Өмч, барилга, тоног төхөөрөмжийг анх хүлэн зөвшөөрсний дараа үеэс анхны өртгөөс хуримтлагдсан элэгдэл болон хуримтлагдсан үнийн бууралтын алдагдлыг хассан дүнгээр нь хэмжинэ. Өмч, барилга, тоног төхөөрөмжийн зүйлс нь ашиглалтын ялгаатай хугацаатай томоохон бүрэлдэхүүнээс бүрдэж буй тохиолдолд бүрэлдэхүүн хэсгүүдийг барилга, тоног төхөөрөмжийн тусдаа зүйл болгон бүртгэдэг.

*Олз болон гарз*

Өмч, барилга, тоног төхөөрөмжийн зүйлсийг худалдан борлуулснаас үүсэх олз буюу гарз нь дансны үнийг борлуулсан үнэтэй харьцуулж тодорхойлох бөгөөд бусад дэлгэрэнгүй орлогын тайланд өмч, барилга, тоног төхөөрөмж борлуулсны олз, гарзаар бүртгэгдэнэ.

*Элэгдэл*

Элэгдэл нь дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөх бөгөөд тухайн хөрөнгийг зориулалтын ажлын байршил, нөхцөлд авчирсан буюу ашиглахад бэлэн болсон үеэс эхлэн бүртгэж эхлэнэ.
Элэгдлийг шулуун шугамын аргаар, доорх тогтоосон ашиглалтын хугацааны турш байгуулдаг:

| | Ашиглалтын хугацаа |
|---|---|
| Барилга, байгууламж | 40 жил |
| Тавилга, эд хогшил | 10 жил |
| Тоног төхөөрөмж | 3 жил |
| Тээврийн хэрэгсэл | 3 жил |
| Компьютер, дагалдах хэрэгсэл | 3 жил |

Элэгдүүлэлтийн арга, ашиглах хугацаа, үлдэх өртгийг тайлагнах үе бүрд дахин тооцож үзнэ.

### i. *Биет бус хөрөнгө*

Олж бэлтгэсэн болон дотооддоо хөгжүүлсэн, үйлдвэрлэл болон удирдлагын түвшинд ашиглагдах программ хангамж нь Биет бус хөрөнгөнд багтана. Биет бус хөрөнгүүдийг өртгийн загвараар бүртгэх бөгөөд ашиглалтын хугацаа нь тодорхой хөрөнгүүдийн тогтоосон ашиглалтын хугацааны турш шулуун шугамын аргаар хорогдуулна. Үлдэгдэл өртөг болон ашиглалтын хугацааг санхүүгийн тайлангийн үе бүрд шалгадаг. Биет бус хөрөнгийн тогтоосон ашиглалтын хугацаа нь дараах байдалтай байна. Үүнд:

| | Ашиглалтын хугацаа |
|---|---|
| Программ хангамж | 3 жил |
| Түрээсийн сайжруулалт | 10 жил |

187

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2019 -03- 26 БҮРТГЭВ-02

## 26. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ (үргэлжлэл)

### j. *Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө*

Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгүүд нь бэлэн мөнгө болон бусад банкны байгууллагад байршуулсан мөнгөн хөрөнгө болон богино хугацаат хадгаламжаас бүрдэнэ.

### k. *Санхүүгийн хөрөнгө*

Хөрөнгө худалдан авсан зорилгоос хамаарч Компани нь санхүүгийн хөрөнгөө доор дурдсан байдлаар ангилдаг. Компани дуусах хугацаа хүртэл нь эзэмшсэн санхүүгийн хөрөнгөөр хөрөнгөө ангилаагүй.

Хейджийн харилцааны шаардлага хангасан санхүүгийн хөрөнгөөс бусад санхүүгийн хөрөнгийг Компани нь дараах нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын дагуу ангилна:

*Бодит Үнэ Цэнэ нь Ашиг, Алдагдлаар Хэмжигдэх*
Бодит үнэ цэнэ нь ашиг алдагдлаар хэмжигдэх санхүүгийн хөрөнгөд зөвхөн ашигтай үүсмэл хэрэглүүр багтана (алдагдалтай үүсмэл хэрэглүүрийн тухай “Санхүүгийн Өр Төлбөр” хэсгээс харна уу). Энэхүү ангилалд багтсан санхүүгийн хөрөнгийг Санхүүгийн Байдлын Тайланд бодит үнэ цэнээр нь тусгаж, бодит үнэ цэнийн өөрчлөлтийг Дэлгэрэнгүй Орлогын Тайлангийн санхүүгийн орлого эсвэл зардлын мөрөнд тусгана. Хейджийн хэрэгслийн зориулалтгүй үүсмэл санхүүгийн хэрэгслээс гадна арилжаалах зорилготой санхүүгийн хөрөнгө Компанид байхгүй бөгөөд Компани санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийг сайн дураараа ашиг, алдагдлаар хэмжигдэх ангилалд оруулдаггүй.

*Зээл ба Авлага*
Зээл ба авлага гэсэн ангилалд багтах санхүүгийн хөрөнгө нь идэвхтэй зах зээлд арилжаалагддаггүй, тогтмол эсвэл тодорхойлж болох төлбөртэй үүсмэл бус санхүүгийн хөрөнгө байдаг. Ийм төрлийн санхүүгийн хөрөнгө нь ихэвчлэн харилцагчдад өгсөн бүтээгдэхүүн, үйлчилгээний нөөцөөр (дансны авлага) дамжиж үүсэх бөгөөд мөн бусад төрлийн гэрээгээр хүлээсэн мөнгөөрх хөрөнгөөс бүрддэг байна. Зээл ба авлагыг бодит үнэ цэнэ дээр нь худалдан авалттай шууд хамааралтай ажил гүйлгээний зардлыг нэмсэн дүнгээр анх хүлээн зөвшөөрөх ба дараа үеудэд үр ашигт хүүгийн түвшин ашиглан хорогдуулсан өртгөөс үнэ цэнийн бууралтын нөөцийг хассан дүнгээр бүртгэнэ.

Компани авлагаа бүгдийг нь цуглуулж чадахгүй гэсэн бодит нотолгоотой (харилцагч санхүүгийн хүндрэлд орох, дампуурах, урт хугацаагаар хойшлуулах) бол үнэ цэнийн бууралтын нөөц үүсгэх ба тухайн нөөцийн үнийн дүнг үнэ цэнийн бууралт үүсгэж буй авлагын дансны цэвэр үнэ болон ирээдүйн таамагласан мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнийн зөрүүгээр тооцно. Цэвэр дүнгээр тайлагнагддаг дансны авлагын үнэ цэнийн бууралтыг тусад нь нөөцийн данс үүсгэж, гарзыг нь Дэлгэрэнгүй Орлогын Тайлангийн удирдлагын зардалд тусгана. Дансны авлагыг цуглуулж чадахгүй гэдгийг баталгаажуулснаар хөрөнгийн нийт дансны үнэ цэнийг холбогдох нөөцтэй нь цэвэрлэж данснаас хасна.

Компанийн зээл ба авлага нь Санхүүгийн Байдлын Тайлан дахь мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө болон худалдааны болон бусад авлагаас бүрддэг.

*Мөнгөн хөрөнгө*
Кассын үлдэгдэл, банкны хадгаламж, гурван сар ба түүнээс доош дуусах хугацаатай бусад богино хугацаат хөрвөгч хөрөнгө оруулалт болон банкны овердрафт (мөнгөн гүйлгээний тайлангийн зорилготой)-аас мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө бүрдэнэ. Банкны овердрафтыг Санхүүгийн Байдлын Тайлангийн богино хугацаат өр төлбөрийн зээл ба зээллэгт тусгадаг.

TDB CAPITAL LLC

"ИНВЕСКОР ББСБ" ХХК InvesCore NON-BANK FINANCIAL INSTITUTION УЛААНБААТАР ХОТ

188

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2019 -03- 26
БҮРТГЭВ-02

## 26. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ (үргэлжлэл)

### *k. Санхүүгийн хөрөнгө (үргэлжлэл)*

Гадаад валютаар илэрхийлэгдсэн бөгөөд хүүг нь үр ашигт хүүгийн түвшин ашиглан тооцдог хөрөнгө оруулалтын ханшийн зөрүүг ашиг, алдагдалд тусгана.

Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнэ их хэмжээгээр эсвэл удаан хугацааны турш буурсан бол (үнэ цэнийн бууралт үүссэн гэсэн бодит нотолгоо болно) тухайн үнэ цэнийн бууралтын нийт дүнг өмнө нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрсөн үнийн дүнгийн хамт ашиг, алдагдалд тусгана.

Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгийн худалдан авалт, борлуулалтыг төлбөр төлөгдөх өдрөөр хүлээн зөвшөөрнө. Арилжааны өдөр ба төлбөр хийгдэх өдрийн хооронд гарсан үнэ цэнийн бууралтын өөрчлөлтийг борлуулахад бэлэн нөөцөд бүртгэнэ.

Санхүүгийн хөрөнгө борлуулах үед борлуулахад бэлэн нөөцөд хуримтлагдсан олз, гарзыг ашиг, алдагдлаар дахин ангилна.

### *l. Санхүүгийн Өр Төлбөр*

Компани өр төлбөрийн зорилгоос хамаарч санхүүгийн өр төлбөрөө дараах хоёр ангиллын аль нэгээр нь ангилдаг. Хейджийн харилцааны шаардлага хангасан санхүүгийн өр төлбөрөөс бусад санхүүгийн өр төлбөрийг Компани нь дараах нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын дагуу ангилна:

*Бодит Үнэ Цэнэ нь Ашиг, Алдагдлаар Хэмжигдэх санхүүгийн өр төлбөр*
Бодит үнэ цэнэ нь ашиг алдагдлаар хэмжигдэх санхүүгийн өр төлбөрт зөвхөн алдагдалтай үүсмэл хэрэглүүр багтана (ашигтай үүсмэл хэрэглүүрийн тухай "Санхүүгийн Хөрөнгө" хэсгээс хар). Энэхүү ангилалд багтсан санхүүгийн өр төлбөрийг Санхүүгийн Байдлын Тайланд бодит үнэ цэнээр нь тусгаж, бодит үнэ цэнийн өөрчлөлтийг Дэлгэрэнгүй Орлогын Тайланд тусгана. Компани ашиг олох зорилгоор бус харин эрсдэлээс хамгаалах (хейдж) зорилгоор үүсмэл хэрэглүүр эзэмшиж, гаргадаг. Эдгээр үүсмэл санхүүгийн хэрэглүүрээс бусад тохиолдолд Компанид арилжаалагдах зорилготой эсвэл бодит үнэ цэнийг нь ашиг, алдагдлаар нь хэмжих зорилготой санхүүгийн өр төлбөр байхгүй болно.

*Бусад Санхүүгийн Өр Төлбөр*
Бусад санхүүгийн өр төлбөрт дараах зүйлс багтана:

- Банкны зээл болон Компанийн хугацаагүй давуу эрхтэй хувьцааг анх хүлээн зөвшөөрөхдөө тухайн хэрэглүүрийг гаргахтай шууд холбоотой гүйлгээний зардлыг бодит үнэ цэнээс хассан дүнгээр бүртгэнэ. Ийм төрлийн хүүтэй өр төлбөрийг дараа үеүдэд бүртгэхдээ үр ашигт хүүгийн түвшин хэрэглэн хорогдуулсан өртгөөр хэмждэг. Ингэснээр Санхүүгийн Байдлын Тайлангаарх өр төлбөрийн үлдэгдэлд хүүгийн зардлыг эргэн төлөлтийн хугацаанд тогтмол хувиар тооцоолох боломжийг олгодог. Санхүүгийн өр төлбөрийн хүүгийн зардалд анхны ажил гүйлгээний зардал, эргэлтээс гаргах өдөр төлөгдөх аливаа нэмүү өртөг болон төлөгдөөгүй өрийн хүү эсвэл купон багтана.

- Анх бодит үнэ цэнээр нь хүлээн зөвшөөрсөн дансны өглөг ба бусад богино хугацаат мөнгөөр өр төлбөрийг дараа үеүдэд үр ашигт хүүгийн түвшин хэрэглэн хорогдуулсан өртгөөр нь хэмжинэ.

TDB CAPITAL LLC
"ИНВЕСКОР ББСБ" ХХК
InvesCore
NON BANK FINANCIAL INSTITUTION
УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2019-03-26
БҮРТГЭЛ-02

## 26. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ (үргэлжлэл)

### m. Үнэ цэнийн бууралт

Гүүдвиллийн үнэ цэнийн бууралтын шалгалтыг жил бүр санхүүгийн жилийн эцэст гүйцэтгэдэг. Өмч, барилга, тоног төхөөрөмж, биет бус хөрөнгө зэрэг бусад санхүүгийн бус хөрөнгүүдийн дансны үнэ нь эргэн нөхөгдөхгүй байж болохыг илэрхийлсэн үйл явдал буюу өөрчлөлт тухайн нөхцөлд байгаа эсэхийг шалгаж үзэх ёстой. Хөрөнгийн дансны үнэ нь эргэн нөхөгдөх дүнгээс (ашиглалтын үнэ ба бодит үнээс борлуулахтай холбоотой зардлыг хассан дүнгээс их) давсан үед хөрөнгийг бууруулах бичилт хийдэг.

Тухайлсан хөрөнгийн нөхөгдөх үнийг тооцоолох боломжгүй байх тохиолдолд хөрөнгүүдийг бие даан тодорхой мөнгөн урсгал бий болгохгүй хөрөнгийн бүлгийн хамгийн бага нэгж болгох хөрөнгийн мөнгө бий болгогч нэгжийн хувьд үнийн бууралтыг шалгана.

Гүүдвиллийг холбогдох бизнесийн нэгдлээс өгөөж хүртэхээр хүлээгдэж буй мөнгө бий болгогч нэгжид хуваарилах бөгөөд гүүдвиллийг хянаж удирдах хамгийн доод түвшинг илэрхийлнэ. Гүүдвиллийн хуваарилагдсан мөнгө бий болгогч нэгжүүдийн хувьд жил бүр үнийн бууралтын тест гүйцэтгэнэ.

Мөнгө бий болгогч нэгжийн үнэ цэнийн бууралтын алдагдал нь мөнгө бий болгогч нэгжүүдэд хуваарилагдсан анхны дансны нийт үнийн дүнг бууруулна. Үнэ цэнийн бууралтын алдагдлын үлдэгдэл хэсэг нь бусад хөрөнгийн хамрах мөнгө бий болгогч нэгжүүдэд хувь тэнцүүлэн тооцоологдоно. Дараа үеүдэд бүх хөрөнгийн өмнө нь бүртгэгдсэн үнэ цэнийн бууралтын гарз байгаа эсэхийг дахин шалгах бөгөөд энэ магадгүй удаан хугацаанд оршин тогтнохгүй байж болно. Үнэ цэнийн бууралтын төлбөрийг хэрвээ мөнгө бий болгогч нэгжийн нөхөгдөх дүн нь үүний дансны үнээс давсан бол дахин өөрчлөгдөнө.

Үнэ цэнийн бууралтын гарзыг дэлгэрэнгүй орлогын тайлангийн ерөнхий удирдлагын зардалд багтаадаг.

### n. Хувьцаат капитал

Хувьцаат капитал нь компанийн гаргасан хувьцааг илэрхийлэх бөгөөд хүлээн авсан дүнгээс хувьцаа гаргахтай холбоотой шууд зардлыг хассан цэвэр дүнгээр хэмжигддэг.

Санхүүгийн хөрөнгө эсвэл санхүүгийн өр төлбөрийн тодорхойлолтыг хангаагүй тохиолдолд Компанийн гаргасан санхүүгийн хэрэгслүүдийг өмчөөр ангилж бүртгэнэ.

Компанийн энгийн хувьцаа нь өмчийн хэрэгслээр ангилагддаг.

### o. Ноогдол ашиг

Ногдол ашгийг түүнийг зарласан тайлангийн хугацаанд өр төлбөр гэж хүлээн зөвшөөрнө.

TDB CAPITAL LLC



"ИНВЕСКОР ББСБ" ХХК
InvesCore
УЛААНБААТАР ХОТ

2019 .04. 24
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2019 -03- 26
БҮРТГЭВ-02

## 27. ХОЛБООТОЙ ТАЛУУДЫН АЖИЛ ГҮЙЛГЭЭ, ТООЦООНЫ ҮЛДЭГДЭЛ

### *(а) Холбоотой талуудыг тодорхойлох*

Хэрвээ тухайн компани нь нөгөө этгээдийн санхүүгийн болон бусад үйл ажиллагаатай холбоотой шийдвэр гаргалтад шууд ба шууд бусаар нөлөө үзүүлэх буюу хянах чадвартай бол тухайн этгээд нь тухайн компанийн хувьд холбоотой тал болох ба хэрвээ тухайн компани өөр этгээдийн удирдлага хяналт дор байдаг эсвэл дээр дурдсан харьцаа нь эсрэгээрээ байх тохиолдолд санхүүгийн тайлан бэлтгэх зорилгоор холбоотой талууд гэж тодорхойлдог.

Холбоотой талууд нь хувь хүмүүс болон бусад аж ахуйн нэгжүүд байж болно. Тус компани нь доор дурдсан аж ахуйн нэгж, хувь хүмүүстэй холбоотой талууд юм:

| Холбоотой талуудын нэр | Харьяалал | Хамаарал |
|---|---|---|
| “Эс Ай Би Жэй Капитал” ХХК | МУ-ын хуулийн этгээд | Толгой компани |
| “Инвескор Холдинг” ХХК | МУ-ын хуулийн этгээд | Холбоо хамаарал бүхий компани |
| “Эс Ай Би Жэй Холдинг” ХХК | МУ-ын хуулийн этгээд | Холбоо хамаарал бүхий компани |
| “Эс Ай Би Жэй Рийл Эстэйтс” ХХК | МУ-ын хуулийн этгээд | Холбоо хамаарал бүхий компани |
| Б.Анхболд | МУ-ын иргэн | ТУЗ-ийн дарга |
| Д.Баясгалан | МУ-ын иргэн | Гүйцэтгэх захирал |
| Р.Мөнхтөр | МУ-ын иргэн | Дэд захирал |
| Р.Пүрэв | МУ-ын иргэн | Санхүүгийн захирал |
| Ш.Эрдэнэбилэг | МУ-ын иргэн | Салбарын захирал |
| М.Мижиддорж | МУ-ын иргэн | Салбарын захирал |
| Б.Онолбаяр | МУ-ын иргэн | Салбарын захирал |
| Н.Арсланбаатар | МУ-ын иргэн | Салбарын захирал |

### *(б) Холбоотой талуудын ажил гүйлгээ*

2018 болон 2017 оны 12 дугаар сарын 31-нээр тасалбар болсон жилд холбоотой талуудтай хийгдсэн ажил гүйлгээ дараах байдалтай байна:

| | Хувьцаа эзэмшигч | |
|---|---|---|
| | **2018 он** | **2017 он** |
| | **мян.төг** | **мян.төг** |
| Авсан зээл | 2,685,559 | 7,288,764 |
| Олгосон зээл | 2,720,178 | 1,248,740 |
| Зээлийн хүүгийн зардал | 1,627,494 | 555,076 |
| Зээлийн хүүгийн орлого | 10,453 | 36,983 |

TDB CAPITAL LLC
“ИНВЕСКОР ББСБ” ХХК
InvesCore
NON BANK FINANCIAL INSTITUTION
УЛААНБААТАР ХОТ

## 27. ХОЛБООТОЙ ТАЛУУДЫН АЖИЛ ГҮЙЛГЭЭ, ТООЦООНЫ ҮЛДЭГДЭЛ (үргэлжлэл)

***(б) Холбоотой талуудын ажил гүйлгээ (үргэлжлэл)***

Гол удирдах албан тушаалтнуудын цалин:

| | 2018 он | | 2017 он | |
|---|---|---|---|---|
| | **Зардал мян.төг** | **Өр төлбөр мян.төг** | **Зардал мян.төг** | **Өр төлбөр мян.төг** |
| Богино хугацаат тэтгэмж: | | | | |
| - Цалин | (127,239) | - | (96,217) | - |
| - Богино хугацаат урамшуулал | (38,825) | - | (23,651) | - |
| | **(166,064)** | **-** | **(119,868)** | **-** |

Удирдлага холбогдох үйлчилгээг үзүүлсэн тайлант хугацаа дууссанаас хойш 12 сарын дотор богино хугацаат урамшуулал, бонусыг бүрэн олгодог.

***(в) Холбоотой талуудтай хийсэн хоорондын ажил гүйлгээний тооцооны үлдэгдэл***

2018 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ, тооцооны үлдэгдлийн мэдээллийг дор харуулав.

| ***Холбоотой талаас авах авлага*** | **2018 оны 12 сарын 31 мян.төг** | **2017 оны 12 сарын 31 мян.төг** |
|---|---|---|
| "Эс Ай Би Жэй Холдинг" ХХК-д олгосон зээл | 1,388,520 | 1,248,740 |
| "Инвескор Холдинг" ХХК-д олгосон зээл | 288,579 | - |
| "Эс Ай Би Жэй Рийл Эстэйтс" ХХК-д олгосон зээл | 1,032,627 | - |
| "Инвескор Холдинг" ХХК-д олгосон зээлийн хүү | 1,129 | - |
| "Эс Ай Би Жэй Холдинг" ХХК-д олгосон зээлийн хүү | 2,328 | - |
| "Эс Ай Би Жэй Рийл Эстэйтс" ХХК-д олгосон зээлийн хүү | 6,995 | - |
| | **2,720,178** | **1,248,740** |
| ***Холбоотой талд өгөх өглөг*** | | |
| "Эс Ай Би Жэй Капитал" ХХК-с авсан зээл | 9,974,323 | 7,288,764 |
| "Эс Ай Би Жэй Капитал" ХХК-с авсан зээлийн хүү | 2,135,879 | 508,385 |
| "Эс Ай Би Жэй Холдинг" ХХК-с авсан өр | 108,810 | - |
| | **12,219,012** | **7,797,149** |

СЭХ 2019 04 24 БҮРТГЭВ №11

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2019 -03- 26 БҮРТГЭВ-02

## 28. ТАЙЛАНТ ХУГАЦААНЫ ДАРААХ ҮЙЛ ЯВДЛУУД

Компанийн удирдлага эдгээр санхүүгийн тайлангуудад нөлөө үзүүлэх өөр бусад үйл явдал тайлант хугацаа дуусгавар болсон өдрөөс хойш санхүүгийн тайланг нийтлэхийг зөвшөөрсөн өдрийг хүртэлх хугацаанд гараагүй гэж үзэж байна.

## 29. ЗЭРЭГЦҮҮЛЭХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тодорхой харьцуулах үзүүлэлтүүдийг тайлант жилийн тайлагналтай нийцүүлэх үүднээс дахин ангилсан болно.

## 30. ТАЙЛАНГИЙН ОРЧУУЛГА

Эдгээр санхүүгийн тайлангуудыг Монгол, Англи хэл дээр бэлтгэсэн бөгөөд тэдгээрийн хооронд ялгаа, зөрчилдөх зүйл гарвал Монгол хэл дээрх хувийг баримтална.

TÖB CAPITAL LLC 5751494

"ИНВЕСКОР ББСБ" ХХК InvesCore NON BANK FINANCIAL INSTITUTION 6060854 УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2019.04.24 өдөр
БҮРТГЭВ

ГЭРЭГЭ
ЭСТИМЭЙТ



ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ: ИНВЕСКОР ББСБ ХХК

ҮНЭЛГЭЭЧИН: ГЭРЭГЭ ЭСТИМЭЙТ ХХК

Монгол улс, Улаанбаатар хот
Сүхбаатар Дүүрэг, 6-р Хороо
Бага тойруу, 37Б байрны
Үйлчилгээний төв
Утас: +976 7000 5000
Цахим хуудас:
www.geregepartners.mn
Имэйл:
valuation@geregepartners.mn

# ИНВЕСКОР ББСБ ХХК

ХАРААТ БУС БИЗНЕСИЙН
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН
***“ҮОУС 2017, RICS олон улсын мэргэжлийн стандарт 2017-г баримтлав”***

2018.12.31-НИЙ ӨДРИЙН БАЙДЛААРХ ҮНЭЛГЭЭ

**Улаанбаатар хот**
**2019 оны 2-р сарын 5-ны өдөр** 184

"ИНВЕСКОР ББСБ" ХХК
InvesCore
NON BANK FINANCIAL INSTITUTION
УЛААНБААТАР ХОТ

Гүйцэтгэх захирал Д.Баясгалан танаа,

Инвескор ББСБ ХХК
Монгол Улс, Улаанбаатар хот
Сүхбаатар дүүрэг, 2-р хороо
Сөүлийн гудамж 10/1,
Твин тауэр 1-13-р давхар

2019 оны 2-р сарын 5-ны өдөр

**БИЗНЕСИЙН ҮНЭЛГЭЭ**

Та бүхний захиалгын дагуу бид Инвескор ББСБ ХХК-ийн бизнесийн өмчлөлийн үнэ цэнийг 2018 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн байдлаар тооцоолох үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэн үнэлгээний тайланг хүргүүлж байна.

Энэхүү тайланг зөвхөн Инвескор ББСБ ХХК-ийн хувьцааг Монголын Хөрөнгийн Бирж дээр анхлан гаргах (IPO) үйл ажиллагаанд Үйлчлүүлэгч түүнтэй холбоотой компаниудын хэрэгцээнд зориулан боловсруулсан бөгөөд үнэлгээний үр дүнг өөр зорилгоор эсхүл бусад этгээд өөр зорилгоор ашиглахад тохиромжгүй бөгөөд зориулалтгүй болохыг онцолж байна.

Бизнесийн өмчлөлийн үнэ цэнийг тооцоолоход Үйлчлүүлэгчээс авсан мэдээлэл болон өөрсдийн хийсэн шинжилгээ, дүгнэлтийг ашиглав.

Үнэлгээний үр дүн нь энэхүү тайланд үзүүлсэн шинжилгээ, орц мэдээлэл болон таамаглалууд, ашиглалт болон хязгаарлалтад тулгуурласан болно.

Та бүхэн энэхүү тайлантай холбоотой аливаа санал болон асуулт байвал бидэнтэй холбоо барина уу.

Хүндэтгэсэн,

Гэрэгэ Эстимэйт ХХК-г төлөөлж:

Д. Ганбаатар, МУМҮ
Монгол улсын мэргэшсэн үнэлгээчин
Гэрэгэ Эстимэйт ХХК-ийн гүйцэтгэх захирал

Д. Гантулга, MRICS
RICS-ийн гишүүн
Гэрэгэ Эстимэйт ХХК-ийн үнэлгээ хариуцсан захирал

2019 .04. 24

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
ГЭРЭГЭ ЭСТИМЭЙТ
2019 -03- 26
БҮРТГЭВ-02

## АГУУЛГА


1. ЕРӨНХИЙ ТОЙМ ....................4
2. ТОДОРХОЙЛОЛТ БА ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ ....................7
   Тодорхойлолтууд ....................7
   Бодит болон Зах зээлийн үнэ цэнийн тодорхойлолт ....................9
   Үнэлгээний арга зүй ....................10
   Банк бус санхүүгийн байгууллагын үнэлгээний онцлог ....................13
   Орц мэдээлэл болон таамаглалууд ....................14
3. АШИГЛАЛТЫН НӨХЦӨЛҮҮД ....................14
4. КОМПАНИЙН ТУХАЙ ....................15
   Компанийн товч танилцуулга ....................15
   Салбаруудын зураг ....................15
   Санхүүгийн үзүүлэлт ....................17
5. ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ ....................18
6. ҮНЭЛГЭЭ ....................21
   6.1 Хөрөнгөд суурилсан шинжилгээ ....................21
      Эргэлтийн бус хөрөнгө ....................21
      Эргэлтийн хөрөнгө ....................22
      Өр төлбөр ....................22
   6.2 Зах зээлийн харьцуулалтын үнэлгээ ....................23
   6.3 Орлогын хандлагын аргаар хийсэн үнэлгээ ....................25
      Загварын орц, төсөөллүүд ....................25
      Мөнгөн урсгалын төсөөлөл, Цэвэр өнөөгийн үнэ цэнийн тооцоолол ....................29
7. ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН ....................30
8. ХАВСРАЛТУУД ....................31


196



"ИНВЕСКОР ББСБ" ХХК
InvesCore
NON BANK FINANCIAL INSTITUTION
УЛААНБААТАР ХОТ

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ


Зураг 1: Инвескор ББСБ-ын санхүүгийн байдлын үндсэн үзүүлэлтүүд....17
Зураг 2: Инвескор ББСБ-ын ашигт ажиллагааны үндсэн үзүүлэлтүүд....17
Зураг 3: ББСБ-ын тоо болон харилцагчдын тоо....18
Зураг 4: ББСБ-уудын тоо, үйлчилгээний төрлөөр....18
Зураг 5: ББСБ-ын салбарын нийт хөрөнгө ба өөрийн хөрөнгө....19
Зураг 6: ББСБ-уудын орлого, зарлага, ашгийн динамик....19
Зураг 7: ББСБ-ын салбарын нийт болон өөрийн хөрөнгийн өгөөж....19


## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ


Хүснэгт 1: Инвескор ББСБ-ын санхүүгийн үндсэн харьцаанууд....18
Хүснэгт 2: Банк болон ББСБ-ын салбарын харьцуулалт....20
Хүснэгт 3: Инвескор ББСБ-ын нийт салбарт эзлэх хувь....20
Хүснэгт 4: Санхүү, ББСБ-ын салбарын ДНБ-д эзлэх хувь....20
Хүснэгт 5: Инвескор ББСБ-ын эргэлтийн бус хөрөнгийн үнэлгээ....21
Хүснэгт 6: Инвескор ББСБ-ын эргэлтийн хөрөнгө....22
Хүснэгт 7: Инвескор ББСБ-ын өр төлбөр....22
Хүснэгт 8: Инвескор ББСБ-ын цэвэр хөрөнгийн хэмжээ....22
Хүснэгт 9: Харьцуулсан үзүүлэлт-дотоод....23
Хүснэгт 10: Харьцуулсан үзүүлэлт-гадаад....24
Хүснэгт 11: Зах зээлийн харьцуулалтын үр дүн....25
Хүснэгт 12: Үнэлгээний загварын орц, тооцоолсон төсөөллүүд....28
Хүснэгт 13: 2023 он хүртлэх цэвэр мөнгөн урсгалын төсөөлөл (Post-IPO)....29
Хүснэгт 14: Үнэлгээний үр дүн....30
Хүснэгт 15: IPO хийсний дараа зах зээлд эзлэх хувийн төсөөлөл....30


197

2019 .04. 24

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
ГЭРЭГЭ ЭСТИМЭЙТ
2019 -03- 26
БҮРТГЭВ-02

## 1. ЕРӨНХИЙ ТОЙМ

| | |
|---|---|
| **Тайлангийн өдөр** | 2019 оны 2-р сарын 5-ны өдөр |
| **Үйлчлүүлэгч** | Инвескор ББСБ ХХК. Улсын бүртгэлийн гэрчилгээ болон Банк бус санхүүгийн байгууллагын тусгай зөвшөөрлийн хуулбарыг Хавсралт 1-д үзүүлэв. |
| **Үнэлгээнд хамрагдсан хөрөнгө** | Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 2-р хороо, Сөүлийн гудамж 10/1, Твин товер 1, 13 давхарт хаягтай Инвескор ББСБ ХХК-ийн бизнес өмчлөлийн үнэ цэнэ |
| **Үнэлгээний өдөр** | 2018 оны 12-р сарын 31-ны өдөр |
| **Үнэлгээний стандартын нийцэл** | • Үнэлгээний Олон Улсын Стандарт 2017 (ҮОУС 2017)<br>• RICS Олон Улсын Мэргэжлийн Стандарт 2017 (“Улаан ном”) |
| **Тайлангийн зорилго / Үнэлгээний ажлын заавар** | Инвескор ББСБ ХХК Монголын Хөрөнгийн Бирж дээр хувьцаагаа олон нийтэд анх удаа санал болгох (IPO) үйл ажиллагаанд зориулж тус компанийн 100 хувийн өмчлөлийн үнэ цэнийг үнэлгээний өдрийн байдлаар тооцоолох |
| **Ашигласан үнэ цэнийн суурь** | Зах зээлийн үнэ цэнэ |
| **Бизнес өмчлөлийн тооцоолсон нийт үнэ цэнэ** | Өөрийн хөрөнгийг 18.1 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсний дараах бизнес өмчлөлийн нийт үнэ цэнэ 120,031,357,479 (нэг зуун хорин тэрбум гучин нэгэн сая гурван зуун тавин долоон мянга дөрвөн зуун далан ес) төгрөг.<br><br>Бидний үнэлгээ нь дараах мэдээлэлд тулгуурласан болно. Үүнд:<br>• Санхүүгийн тайлан, бизнес төлөвлөгөө, санхүүгийн загвар гэх мэт үйлчлүүлэгчээс ирүүлсэн мэдээлэл;<br>• Зах зээлийн судалгаанаас боловсруулсан мэдээлэл;<br>• Бидний тооцоолол, таамаглал болон салбарын талаарх мэдлэг зэрэг багтана.<br><br>Бид Үйлчлүүлэгчээс өгсөн мэдээлэл болон бичиг баримтын буруу зөвд хариуцлага хүлээхгүй болно. |
| **Ерөнхий таамаглал** | Дансны бүрдэл: Инвескор ББСБ-ын үйл ажиллагааг бүхэлд нь эсвэл зарим үйл ажиллагааг хэсэгчлэн бусад компанийн үйл ажиллагаатай нэгтгэсэн, нийлүүлснээс |

"ИНВЕСКОР ББСБ" ХХК
InvesCore
NON BANK FINANCIAL INSTITUTION
УЛААНБААТАР ХОТ

198

2019.04.24

үүсэх үр дагаврыг энэхүү үнэлгээний ажилд тооцоолоогүй бөгөөд Инвескор ББСБ-ийн бизнесийг бие даасан байдлаар үнэлсэн болно.

Тасралтгүй байдал: Инвескор ББСБ нь цаашид бизнесийн үйл ажиллагаагаа төлөвлөлтийн дагуу тасралтгүй үргэлжлүүлнэ гэж үзэв.

**Газар дээрх үзлэг, шалгалт, баримтын хадгалалт**

Бид Үйлчлүүлэгчийн хөрөнгөд газар дээрх үзлэг болон удаа дараагийн уулзалт, ярилцлагуудыг 2018.11.20-2019.01.31-ний өдрийн хооронд хийсэн болно.

**Стандартаас гажсан эсэх**

Гажаагүй

**Үнэлгээчид**

Бидэнд өгсөн даалгаврын дагуу бид энэ төрлийн бизнесийн үнэлгээ хийх туршлагатай гэдгээ үүгээр баталж байна. Д. Гантулга нь Гэрэгэ Эстимэйт ХХК-ийн Үнэлгээ хариуцсан захирал бөгөөд тус компанийн бизнесийн болон хөрөнгийн үнэлгээний ажлуудыг удирдан ажилладаг. Д.Ганбаатар нь Гэрэгэ Эстимэйт ХХК-ийн Гүйцэтгэх захирал болно. Л.Халиун нь ACCA буюу олон улсын мэргэшсэн нягтлан бодогч бөгөөд Гэрэгэ Эстимэйт ХХК-ийн зөвлөх үнэлгээчнээр ажилладаг. Гантулга нь Мэргэшсэн Үнэлгээчдийн Рояал Институт (RICS)-ийн гишүүн бөгөөд, Гантулга, Ганбаатар, Халиун нар нь Монгол улсын мэргэшсэн үнэлгээчид болно. Үнэлгээчний сертификатын хуулбарыг Хавсралт 3-т үзүүлэв.

Энэхүү үнэлгээний ажлын багийг Гантулга удирдан ажилласан бөгөөд үнэлгээний тайланг бэлтгэсэн болно.

**Ашиг сонирхлын зөрчил**

Энэ ажлыг хийж гүйцэтгэхэд бидэнд аливаа сонирхлын зөрчил байхгүй болно.

**Тайлангийн хэрэглэгчид / Нууцлал**

Энэхүү тайлан нь зөвхөн Үйлчлүүлэгч болон түүнтэй холбоотой компанид зориулж дээр дурдсан зориулалтаар бэлтгэгдсэн бөгөөд гуравдагч этгээдийн өмнө нийт болон хэсэгчилсэн агуулгын талаар хариуцлага хүлээхгүй болно.

**Тайлангийн хэрэглээ**

Урьдчилсан зөвшилцөж, бичгээр тохиролцоогүй тохиолдолд энэхүү тайланг бүтнээр эсвэл хэсэгчлэн тараахыг хориглоно.

Урьдчилсан зөвшилцөж, бичгээр тохиролцоогүй тохиолдолд Үйлчлүүлэгч компани болон тус компанитай холбоотой бусад компани нь олон нийтэд гаргах аливаа баримт, мэдээлэл, мэдэгдэлд энэхүү

199

үнэлгээний ажилтай холбоотойгоор Гэрэгэ Эстимэйт ХХК-ийн нэрийг дурдахыг хориглоно.

Энэхүү тайланг бизнесийн үнэлгээний чиглэлээр тодорхой мэдлэг, мэдээлэлтэй хүмүүс ашиглахад зориулж бэлтгэв. Үнэлгээний үр дүнгийн талаар аливаа санал, дүгнэлт гаргахын өмнө энэхүү тайланг бүхлээр нь уншиж танилцахыг зөвлөж байна. Энэхүү тайлантай холбоотой тайлбар авах, тодруулга хийх шаардлага гарсан тохиолдолд бидэнтэй холбоо барихыг хүсч байна.

| | |
|---|---|
| **Мэргэжлийн хариуцлагын даатгал** | Үнэлгээчид нь Монгол Улсын Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 28-р зүйлд заасны дагуу Үнэлгээчний хариуцлагын даатгалд хамрагдсан болно. |
| **Бусад** | Тайланг зөвхөн Монгол хэл дээр бэлтгэсэн болно. |

## 2. ТОДОРХОЙЛОЛТ БА ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ

### Тодорхойлолтууд

Үнэлгээний зарим нэр томьёог өөр өөр утгаар ойлгож болох талтай байдаг. Ийм нөхцөл байдал үүсэхээс зайлсхийх зорилгоор үнэлгээнд хэрэглэсэн зарим нэр томьёог Үнэлгээний Олон Улсын Стандарт (ҮОУС), RICS мэргэжлийн олон улсын стандарт ("Улаан ном") болон Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-д тодорхойлсны дагуу дараах байдлаар үзүүлэв.

*Идэвхитэй зах зээл* [СТОУС 13] – Үнийн мэдээллээр тогтмол хангахад хүрэлцэхүйц давтамж, дүнгээр хөрөнгө, өр төлбөрийн арилжаа хийгддэг зах зээл.

*Үнэ цэнэ* [ҮОУС 17]– Бодит байдал гэхээс илүүтэй мэргэжилтний дүгнэлт гэж ойлговол зохино. Үүнд: (а) хөрөнгийг арилжаалахад төлөгдөж болох хамгийн их магадлал бүхий үнийн дүнгийн тооцоолол, эсвэл (б) хөрөнгийг өмчилснөөр хүртэх эдийн засгийн үр ашгийн дүнгийн тооцоолол багтана.

*Үнэ цэнийн суурь* [Улаан ном 17]– Үнэлгээний таамаглалын үндсэн хэмжүүрийн тодорхойлолт.

*Өртгийн хандлага* [ҮОУС 17] – Хөрөнгийн ашиглалтын хүчин чадлыг одоогийн байдлаар оруулахад шаардагдах дүн ( үүнийг ихэнхдээ өнөөгийн оруулалтын зардал гэж нэрлэдэг)-г тусгадаг үнэлгээний арга, хандлага.

*Хүлээгдэж буй мөнгөн гүйлгээ* [СТОУС 13] – Боломжит ирээдүйн мөнгөн гүйлгээг магадлалаар жинлэсэн дундаж (өөрөөр хэлбэл тархалтын дундаж дүн).

*Бодит үнэ цэнэ* [СТОУС 13] – Хэмжилт хийж буй өдөр зах зээлд оролцогчдын хооронд байнга хийгдэх ажил гүйлгээгээр хөрөнгийг худалдсанаар хүлээн авах буюу өр төлбөрөөр тооцох үнэ юм.

*Хамгийн сайн ашиглалт* [СТОУС 13] – Хөрөнгийг ашиглах хугацаанд хөрөнгө буюу бүлэг хөрөнгө, өр төлбөр (бизнесийн хувьд)-ийн үнэ цэнийг дээд түвшинд байлгах зах зээлд оролцогчдын санхүүгийн бус хөрөнгө ашиглалт.

*Орлогын хандлага* [СТОУС 13] – Ирээдүйн дүнгүүд (жишээлбэл: мөнгөн гүйлгээ, орлого, зардлын дүн)-ийг өнөөгийн ганц дүн (өөрөөр хэлбэл хорогдуулан)-д хөрвүүлдэг үнэлгээний арга, хандлага. Бодит үнэ цэнийг хэмжихдээ ирээдүйн дүнгүүдийн талаарх зах зээлийн өнөөгийн таамаглалаар илэрхийлсэн үнэ цэнэд суурилна.

*Орц-мэдээлэл* [СТОУС 13] – Энэ нь хөрөнгө, өр төлбөрийн үнийг тогтоохдоо зах зээлд оролцогчдын гаргасан таамаглалыг хэлэх бөгөөд үүнд дараах эрсдэлийн таамаглал багтана:

(a) Бодит үнэ цэнийг хэмжихэд хэрэглэсэн үнэлгээний тодорхой арга аргачлалаас шалтгаалан үүссэн эрсдэл (тухайлбал, үнэ тогтоох загвар); ба

(b) Үнэлгээний арга, аргачлалын дагуу ашиглагдаж буй орц мэдээллээс шалтгаалан үүссэн эрсдэл.

Орц мэдээлэл нь бэлэн олдоцтой буюу ажиглагдах эсвэл үл ажиглагдах байж болно.

201

*Хөрөнгө оруулалтын зориулалттай өмч* [Улаан ном 17] – Доорх (а), (б)-оос бусад зорилгоор капиталын үнэ цэнийг өсгөх, эсвэл түрээсийн орлого олох, эсвэл аль алиных нь зорилгоор эзэмшиж буй өмч (газар, барилга, эсвэл барилгын хэсэг, эсвэл аль аль нь

(a) бараа үйлчилгээний үйлдвэрлэлт, нийлүүлэлт болон захиргааны зорилгоор ашиглаж байгаа эсвэл

(b) бизнесийн хэвийн нөхцөлд худалдан борлуулах зориулалттай.

*Нэгдүгээр түвшний орц-мэдээлэл* [СТОУС 13] – Аж ахуйн нэгжийн хэмжилт хийж буй өдрөөр ашиглах боломжтой, ижил төстэй хөрөнгө, өр төлбөрийн идэвхтэй зах зээлийн жишиг (тохируулаагүй ) үнэ.

*Хоёрдугаар түвшний орц-мэдээлэл* [СТОУС 13] – Хөрөнгө, *өр төлбөртэй холбоотой шууд ба шууд бусаар гаргаж авах боломжтой бөгөөд нэгдүгээр түвшинд багтсан жишиг үнээс бусад орц мэдээлэл.*

*Гуравдугаар түвшний орц-мэдээлэл* [СТОУС 13] – Хөрөнгө ба өр төлбөрийн талаарх үл ажиглагдах орц мэдээлэл.

*Зах зээлийн хандлага* [СТОУС 13] – *Энэ нь ижил төстэй буюу зэрэгцүүлэгдэх хөрөнгө, өр төлбөр, эсвэл бизнес гэж үзэж болох хөрөнгө, өр төлбөрийн бүлэгт хамаарах зах зээлийн ажил гүйлгээний үнэ, бусад холбогдох мэдээллийг ашигладаг үнэлгээний арга хандлага юм.*

*Зах зээлээр баталгаажсан мэдээлэл* [СТОУС 13] – Корреляци болон бусад аргын тусламжтайгаар зах зээлд бэлэн байгаа мэдээллээр баталгаажсан буюу түүнээс гаргаж авсан орц мэдээлэл.

*Зах зээлийн түрээсийн төлбөр* [ҮОУС 17] – Үнэлгээний өдрөөр бэлэн байгаа түрээслүүлэгч, түрээслэгчийн хооронд аль ч тал нь хариуцлагатай, мэдээлэл тооцоотой, ямар нэгэн шахалтгүйгээр хандсан гэж үзсэнээр зүй зохистой маркетинг хийсний дараах холбоогүй талуудын үйл ажиллагаагаар өмчийг түрээслүүлэх төлбөрийн тооцоолсон дүн.

*Зах зээлийн үнэ цэнэ* [Улаан ном 17] – Хариуцлагатай, мэдээлэл тооцоотой, ямар нэг шахалтгүйгээр хандсан, арилжаанд бэлэн байгаа худалдагч, худалдан авагчийн хооронд зохих маркетинг хийсний дараах холбоогүй талуудын ажил гүйлгээгээр хөрөнгө болон өр төлбөрийг солилцож болох, тухайн үнэлгээний өдрөөр тооцоолсон дүн байна.

*Бэлэн олдох орц мэдээлэл* [СТОУС 13] – Тодорхой үйл явдал, ажил гүйлгээний талаар олон нийтэд нээлттэй байгаа мэдээлэл гэх мэт зах зээлийн тоон мэдээг ашиглан боловсруулсан орц мэдээллийг хэлэх бөгөөд үүнд хөрөнгө, өр төлбөрийн үнийг тогтоохын тулд зах зээлд оролцогчдын гаргасан таамаглалыг тусгана.

*Байнга хийгдэх ажил гүйлгээ* [СТОУС 13] – Аливаа хөрөнгө, өр төлбөрийг хамарсан ажил гүйлгээнд зориулан хэвийн бөгөөд байнгын маркетингийн үйл ажиллагаа явуулахтай холбогдуулан хэмжилтийн өдрөөс өмнөх хугацаанд зах зээлд хөрөнгө байршуулахаар таамагласан ажил гүйлгээ бөгөөд энэ нь хүчээр хийгдэж буй ажил гүйлгээ байж болохгүй (жишээлбэл: хүчээр татан буулгах буюу худалдан борлуулахыг шахах гэж мэт).

203

СЗХ
2019 .04. 24 өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
ГЭРЭГЭ ЭСТИМЭЙТ
2019 -03- 26
БҮРТГЭВ-02

*Үндсэн зах зээл* [СТОУС 13] – Хөрөнгө, өр төлбөрийг хамарсан хамгийн өндөр дүнтэй болон хамгийн олон арилжаа хийгдсэн зах зээл юм.

*Үл хөдлөх өмч* [ҮОУС 17] – Үл хөрөнгийн өмчлөлд хамаарах бүх эрх, эрх ашиг, үр ашгийг хэлнэ.

*Тусгай таамаглал* [Улаан ном 17] – Үнэлгээний өдрөөр бий болсон нөхцөл байдлаас ялгаатай нөхцөл байдлыг авч үзэж буй таамаглал эсвэл үнэлгээний өдөр зах зээлийн жирийн оролцогч хийхгүй байх үйлдэл.

*Тусгай үнэ цэнэ* [Улаан ном 17] – Хөрөнгийн хувийн шинж чанарыг тусгаж байдаг, зөвхөн тусгай худалдан авагчдад бий болох үнэ цэнэ.

*Нэгдсэн эрхийн үнэ цэнэ* [ҮОУС 17] – Хоёр эсвэл түүнээс дээш эрхийг нэгтгэсэн үнэ цэнэ. Нэгтгэсэн үнэ цэнэ нь дангаараа эрхүүдийн үнэ цэнийн нийлбэрээс ямагт их байна.

*Худалдах зориулалт бүхий өмч* [Улаан ном 17] – Тухайн бизнесийн арилжаалагдах боломжийг өмчийн үнэ цэнэ нь илэрхийлж байдаг тусгай бизнест зориулагдсан үл хөдлөх өмчийн аливаа төрөл.

*Эрсдэлийн шагнал* [СТОУС 13]– Зах зээлд оролцогчид хөрөнгө, өр төлбөрийн мөнгөн гүйлгээний тодорхой байдлаас шалтгаалан үүсэх эрсдэлийг хүлээсний эцэст хүртэх ашиг. Үүнийг мөн “эрсдэлийн залруулга” хэмээн нэрэлдэг.

*Тооцооны нэгж* [СТОУС 13 ] – Хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрөхийн тулд уг хөрөнгө, өр төлбөрийг нэгтгэх буюу задлан жижгирүүлэх СТОУС-ын хэмжүүр.

Үл ажиглагдах орц мэдээлэл [СТОУС 13] – Хөрөнгө, өр төлбөрийн үнийг тогтоохдоо зах зээлд оролцогчдын гаргасан таамаглалын талаарх боломжит хамгийн сайн мэдээллийг ашиглан боловсруулсан буюу зах зээлд бэлэн байдаггүй орц мэдээлэл.

*Үнэлгээний өдөр* [Улаан ном 17]– Үнэлгээчний үнэлгээний дүгнэлт гаргасан өдөр.

*Үнэлгээний тайлангийн өдөр* [Улаан ном 17] – Үнэлгээний тайланд гарын үсэг зурсан өдөр.

## Бодит болон Зах зээлийн үнэ цэнийн тодорхойлолт

*СТОУС 13 Бодит Үнэ Цэнийн Хэмжилт-д Бодит үнэ цэнэ* гэдэгт хэмжилт хийж буй өдөр зах зээлд оролцогчдын хооронд байнга хийгдэх ажил гүйлгээгээр хөрөнгийг худалдсанаар хүлээн авах буюу өр төлбөрөөр тооцох үнэ гэж тодорхойлсон. Энэхүү тодорхойлолт нь ҮОУС-ын Хамрах Хүрээнд *Бодит үнэ цэнэ*-ийг тодорхойлсноос ялгаатай бөгөөд тэрхүү тодорхойлолтыг санхүүгийн тайлагналаас бусад зорилгоор нийтлэг хэрэглэдэг.

СТОУС-д тодорхойлсон *бодит үнэ цэнэ* нь ҮОУС-д тодорхойлсон *зах зээлийн үнэ цэнэ*-ийн ойлголттой ерөнхийдөө нийцдэг. Иймд тооцооны нэгжийн тайлбар, эсвэл борлуулалтын хориг гэх мэт нягтлан бодох бүртгэлийн стандартын шаардлагад багтсан тусгайлсан таамаглалуудыг харгалзан авч үзсэн тохиолдолд ихэнх практик ажилд ҮОУС-ийн *зах зээлийн үнэ цэнэ* нь СТОУС 13-д тодорхойлсон *бодит үнэ цэнэ*-ийн шаардлагыг хангана гэж үздэг.



"ИНВЕСКОР ББСБ" ХХК
invesCore
УЛААНБААТАР ХОТ

*Зах зээлийн үнэ цэнэ* гэдэгт хариуцлагатай, мэдээлэл тооцоотой, ямар нэг шахалтгүйгээр хандсан, арилжаанд бэлэн байгаа худалдагч, худалдан авагчийн хооронд зохих маркетинг хийсний дараах холбоогүй талуудын ажил гүйлгээгээр хөрөнгө болон өр төлбөрийг солилцож болох, тухайн үнэлгээний өдрөөр тооцоолсон дүнг ойлгоно.

*Зах зээлийн үнэ цэнэ* нь хөрөнгийн хамгийн сайн ашиглалтыг тусгасан байна. Хамгийн сайн ашиглалт гэдэг нь тухайн хөрөнгийн хүчин чадал ашиглалтыг дээд хэмжээнд байлгах биет байдлаараа боломжтой, хууль ёсоор зөвшөөрөгдсөн, санхүүгийн хувьд биелэгдэх ашиглалтыг хэлнэ. Хөрөнгийн одоогийн ашиглалт эсвэл өөр хувилбарт ашиглалтын аль нь ч хамгийн сайн ашиглалт байж болно. Энэ нь зах зээлийн оролцогч хөрөнгийн үнийг тооцоолохдоо өөртөө төсөөлж байгаа тэр ашиглалтаар тодорхойлогдоно.

## Үнэлгээний арга зүй

Үнэлгээний ажлын зорилготой уялдуулан *Үнэ цэнийн суурь*-д нээлттэй чөлөөт зах зээл дээр төсөөлж буй арилжаагаар хүрч болох хамгийн их магадлалтай үнийн илэрхийллийг авав. Энэ ангилалд ҮОУС-д тодорхойлсон *зах зээлийн үнэ цэнэ* багтана.

Үнэлгээнд хэрэглэдэг үндсэн гурван хандлагын тодорхойлолт, тайлбарыг доор үзүүлэв. Эдгээр хандлагууд нь үнийн тэнцвэр, үр ашгийн хүлээлт, орлуулалт зэрэг эдийн засгийн зарчмуудад тулгуурладаг. Үнэлгээний үндсэн хандлагуудад:

(a) Зах зээлийн хандлага,
(b) Орлогын хандлага,
(c) Өртгийн хандлага.

Үнэлгээний эдгээр үндсэн хандлага бүр нь хэрэглээний өөр өөр нарийвчилсан аргуудтай байдаг.

Үнэлгээний хандлага болон аргуудаас сонголт хийхдээ тухайн нөхцөл байдалд хамгийн тохиромжтой аргыг олох зорилго тавина. Бүх нөхцөлд тохиромжтой нэг ч арга байхгүй. Сонголт хийхдээ хамгийн багадаа дараах хүчин зүйлсийг авч үзэх шаардлагатай. Үүнд:

(a) үнэлгээний ажлын нөхцөл болон зорилгоор тодорхойлогдсон тохиромжтой үнэ цэнийн суурь,
(b) боломжит үнэлгээний хандлага болон аргуудын давуу болон сул талууд,
(c) арга бүрийн хувьд тухайн хөрөнгийн үндсэн шинжтэй зохицолтой байдал, холбогдох зах зээлийн оролцогчид нь тухайн хандлага, аргуудыг хэр зэргээр хэрэглэдэг талаар,
(d) тухайн аргыг хэрэглэхэд шаардагдах найдвартай мэдээллийн олдоц ямар байгаа зэрэг орно.

Үнэлгээчин нь заавал нэгээс дээш тооны үнэлгээний аргыг хөрөнгийн үнэлгээнд ашиглах ёстой гэсэн шаардлага байхгүй. Ялангуяа үнэлгээчин нь аль нэг аргын нарийвчлал болон найдвартай байдалд итгэх итгэл өндөр байхад бусад аргуудыг ашиглахыг шаарддаггүй. Үнэлгээний аль нэг аргаар итгэлтэй үр дүн гаргахад үнэн зөв эсвэл ажиглагдах орц мэдээлэл хангалттай олдоцгүй үед үнэ цэнийн баримжаа дүр зураг авах зорилгоор нэгээс дээш тооны үнэлгээний хандлага эсвэл аргыг хэрэглэдэг. Хэрэв нэгээс дээш тооны үнэлгээний хандлага эсвэл арга хэрэглэсэн, түүнчлэн нэг хандлагад хамаарах олон тооны

аргуудыг хэрэглэсэн тохиолдолд эдгээр хандлага, аргуудад үндэслэн гаргасан үнэ цэнийн тооцоолол нь үндэслэл сайтай, олон аргаар гарсан өөр өөр үр дүнг хэрхэн нэг үнэ цэнэ болгосон талаар хийсэн шинжилгээг үнэлгээний тайланд тодорхой тайлбарлах шаардлагатай байдаг.

Хэрэв үнэлгээний хандлага, аргуудаар гарсан үнэ цэнийн баримжаанууд нь хоорондоо зөрүү ихтэй байвал үнэлгээчин нь яагаад ийм үр дүн гарч байгаа талаар олж мэдэж ойлгох шаардлагатай бөгөөд зөрүү өндөртэй үнэ цэнийн баримжаа дүнгүүдийг хялбараар жинлэн үнэ цэнийг тооцоолох нь тохиромжтой биш юм. Энэ тохиолдолд үнэлгээчин нь дээр дурдсан удирдамжийн дагуу үнэлгээний аль нэг хандлага/арга нь бусад авч үзсэн аргуудаас илүү сайн, илүү найдвартай үнэ цэнийн баримжаа дүр зураг өгөх эсэхийг дахин нягтлан судлах шаардлагатай.

Гурван хандлагын алийг нь ч хэрэглэсэн үнэлгээчин нь зах зээлийн бэлэн олдоцтой мэдээллийг боломжит дээд хэмжээнд хүргэж ашиглах ёстой. Үнэлгээнд ашигласан орц мэдээлэл болон төсөөлөл нь ямар эх сурвалжаас авснаас үл хамааран үнэлгээчин нь тэдгээр орц мэдээлэл, төсөөлөлд үнэлэлт дүгнэлт өгөх, үнэлгээний зорилгод хэр тохиромжтой байгааг дүгнэх шинжилгээг заавал хийх ёстой байдаг.

Үнэлгээний олон улсын стандартаас гадна Монгол Улсад бизнесийн үнэлгээ хийх аргачлалыг Сангийн сайд, Санхүүгийн Зохицуулах Хорооны даргын 2011 оны 12-р сарын 30-ны өдрийн 274/240 тоот хамтарсан тушаалаар баталсан байдаг. Энэ аргачлалд бизнесийн үнэлгээний арга, хандлагыг Үнэлгээний Олон Улсын Стандартын дагуу тайлбарлан оруулсан байна.

**Зах зээлийн хандлага**

*Зах зээлийн хандлага*-аар бизнесийн үнэ цэнийг тогтоохдоо үнийн мэдээлэл хангалттай олдох ижил төстэй болон орлуулагч бизнестэй харьцуулах аргыг хэрэглэнэ. Энэ хандлагаар үнэлэх эхний алхам нь зах зээл хувьцаа нь арилжаалагдаж байгаа эсвэл зах зээл дээр саяхан борлогдсон үнэлгээнд хамрагдсан бизнестэй ижил төстэй бизнесийн хувьцааны үнэ эсвэл борлуулалтын үнийг авч үзэх явдал юм.

Энэ хандлагаар бизнесийн үнэлгээ хийхэд түгээмэл ашигладаг мэдээллийн эх сурвалжид дараах мэдээллүүд орно. Үүнд:

1. Ижил төстэй бизнесийн нийтэд зориулан худалдсан бизнесийн өмчлөлийн эрхийн талаарх хөрөнгийн зах зээл буюу хувьцааны талаарх мэдээлэл
2. Ижил төстэй бизнесийг зах зээл дээр худалдсан ба худалдан авсан ажил гүйлгээний талаарх мэдээлэл
3. Тухайн субъектийн бизнесийн өмчлөл дэх өмнөх үеийн ажил гүйлгээний талаарх мэдээлэл
4. Эрх бүхий байгууллагын болон ижил төстэй бүтээгдэхүүний мэдээллийн сан
5. Үнэлгээчний хувийн мэдээллийн сан зэрэг орно.

Энэ хандлагаар бизнесийн үнэлгээ хийхэд харьцуулж байгаа бизнесийн үнэ цэнийн дүнг орлого, нийт хөрөнгө, цэвэр хөрөнгө зэрэг суурь үзүүлэлтүүдэд харьцуулан гаргасан нэг эсвэл хэд хэдэн үржүүлэгчийг тооцно. Тухайлбал:

*Үнэ, ашгийн харьцаа (PE Ratio) = Нэгж хувьцааны үнэ / Нэгж хувьцааны өгөөж*

*Үнэ, бүртгэлийн өртгийн харьцаа (Price/Book Ratio) = Нэгж хувьцааны үнэ / Нэгж хувьцааны бүртгэлийн өртөг*

СЗХ
2019 .04 р 24 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
ГЭРЭГЭ ЭСТИМЭЙТ
2019-03-26

*Үнэ, борлуулалтын харьцаа (Price to Sales Ratio) = Нэгж хувьцааны үнэ / Нэгж хувьцаанд ногдох борлуулалт*

*Өөрийн хөрөнгийн өгөөж (ROE) = Цэвэр орлого / Хувьцаа эзэмшигчдийн хөрөнгө*

Бизнесийн үнэлгээг хийхэд хэд хэдэн үржүүлэгчийг ашигласан эсвэл хэд хэдэн аргыг хослуулан хэрэглэсэн бол үнэлгээчин тэдгээрийг ач холбогдлын хувиар жинэлэж үнэлгээний дүнг тодорхойлж болно. Ижил төстэй ба тухайн бизнесийг харьцуулагдахуйц болгохын тулд шаардлагатай тохиолдолд боломжит тохируулгыг хийдэг.

Санхүүгийн бизнесийн онцлогтой холбоотойгоор үнэлгээнд ихэнх тохиолдолд Үнэ, ашгийн харьцааг ашиглан хувьцааг үнэлэх *(Price/Earnings multiple approach)* эсвэл Үнэ, бүртгэлийн өртгийн харьцааг ашиглан хувьцааг үнэлэх *(Price to Book Value multiple approach)* аргуудыг хэрэглэдэг.

**Орлогын хандлага**

*Орлогын хандлага* гэдэгт тухайн хөрөнгийн өмчлөлөөс олохоор тооцоолсон эсвэл олсон мөнгөн урсгалд үндэслэн үнэ цэнийг тогтоодог ерөнхий зарчимтай олон аргуудыг багтаан үзэж болно.

Орлогын хандлагаар бизнесийн үнэлгээг хийхэд орлого капиталжуулалтын арга ба хорогдуулсан мөнгөн гүйлгээний аргуудыг түгээмэл ашигладаг.

*Орлого капиталжуулалтын арга*

Бизнесийн тогтвортой байдал, үргэлжлэх цаг хугацаа болон өгөөжийг харгалзан үзсэний үндсэн дээр тогтвортой байх үйл ажиллагааны цэвэр орлого (элэгдэл хасаагүй дүн)-ын дүнг тодорхойлж түүнийг капиталжуулах хувьд хувааж эсвэл орлогын үржүүлэгчээр үржүүлж бизнесийн үнэ цэнийг тооцно.

Капиталжуулах хувийг тооцохдоо хөрөнгө оруулалтын өгөөжийн хувиас ирээдүйн ашгийн өсөлтийн хувийг хасаж тооцно. Энэ аргыг ирэх 5 – 10 жилийн хугацаанд бизнесийн үйл ажиллагааны цэвэр орлогын өсөлт тогтвортой байх үед хэрэглэхэд илүү тохиромжтой. Орлогын үржүүлэгчийг ижил төстэй компаниудын зах зээлийн мэдээллийн үндэслэн тодорхойлно.

*Хорогдуулсан мөнгөн гүйлгээний арга*

Ирээдүйн тодорхой үеүдэд ашиг, орлогын хэмжээ тогтвортой бус, хугацааны төгсгөлд бизнес үлдэх өртөгтэй байх үед хорогдуулах мөнгөн гүйлгээний аргыг ашиглах нь оновчтой байдаг. Энэ аргаар бизнесийн үнэ цэнийг тухайн бизнесийн цэвэр мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнэ ба хугацааны сүүлийн жилийн орлогын капиталжуулсан дүнгийн өнөөгийн үнэ цэнийн нийлбэрээр тооцно.

Хорогдуулах хувийг капиталын жинлэсэн дундаж өртгийн аргаар тооцоход өөрийн капиталын хувьд Капитал Хөрөнгө Үнэлгээний загвар (CAPM)-ыг, харин зээлийн капиталын хувьд татварын дараах байдлаар авсан хүүгийн хувиар тус бүрд нь капиталжуулах хувийг тооцож тэдгээрийн нийт санхүүжилтэд эзлэх хувийн жингээр жинлэж тооцно.

Хорогдуулах хувийг нийлбэрийн аргаар тооцоход эрсдэлгүй хүүгийн хувь дээр дараах эрсдэлийн хүчин зүйлүүдийн хувийг нэмэх замаар тооцно. Үүнд:

1. Бизнесийн макро, микро эдийн засгийн хүчин зүйлүүд
2. Салбар болон компанийн үйл ажиллагааны онцлог хүчин зүйлүүд
3. Хөрөнгө, санхүү, боловсон хүчний чадавх, хүчин зүйлүүд
4. Гадаад хүчин зүйлс, инфляцын нөлөөллийн хүчин зүйлүүд

206

"ИНВЕСКОР ББСБ" ХХК
InvesCore

5. Хөрөнгө оруулалтын бусад эрсдэлийн хүчин зүйлүүд орно.

Хорогдуулах хувийг бондын өгөөжтэй харьцуулах арга (Bond-Yield-Plus-Premium Approach)-аар тооцохдоо тухайн компанийн урт хугацааны бондын хүү дээр эрсдэлийн урамшууллын хувийг (ихэнхдээ 2-5%) нэмэх замаар тооцно.

**Өртгийн хандлага**

Өртгийн хандлагыг мөн "Хөрөнгөд суурилсан хандлага" гэж нэрлэдэг ба энэ нь худалдан авагч үнэлэгдэж буй хөрөнгөд төлөх үнэ нь (цаг хугацаа, тохиромжгүй байдал, эрсдэл болон бусад хүчин зүйлийг эс тооцвол) тэнцүү чанартай хөрөнгийг худалдан авах эсвэл барьж байгуулах зардлаас илүүгүй байна гэсэн зарчимд үндэслэнэ.

Өртгийн хандлагаар бизнесийг үнэлэхдээ тухайн бизнесийн биет ба биет бус бүх хөрөнгүүдийг үнэлж, үүнээс бүх өр төлбөрүүдийн зах зээлийн үнэ цэнийг хасах замаар тооцно.

Өртгийн хандлагын арга нь тухайн бизнесийн орлого олох чадварыг харуулж чаддаггүй учир тасралтгүй байх төсөөллөөр ажиллаж байгаа бизнесийн үнэлгээнд ашиглахад тохиромж муутай байх магадлалтай байдаг.

## Банк бус санхүүгийн байгууллагын үнэлгээний онцлог

Санхүүгийн байгууллагын үнэлгээ нь бусад салбарын бизнесийн үнэлгээнээс ихээхэн онцлогтой бөгөөд ялгаатай байдаг. Тухайлбал, АНУ-ын Нью Йоркийн их сургуулийн Штерн бизнесийн сургуулийн профессор Асват Дамадораны цуврал бүтээлүүдэд[1] дэлгэрэнгүй тайлбарласан байна. Энд зарим үндсэн онцлогуудыг тодотгон авч оруулав.

**Хөрөнгө оруулалтын онцлог**

Бусад бизнесийн хувьд нэмэлтээр татсан хөрөнгө нь бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадлаа нэмэгдүүлэх, түүхий эдийн таталтаа нэмэгдүүлэх, өсөлтөд шаардагдах бусад зардлыг санхүүжүүлэх зэргээр борлуулалтаа өсгөх боломжийг олгодог бол банк бус санхүүгийн байгууллагын хувьд нэмэлт хөрөнгө нь шууд зээлийн бүтээгдэхүүн болж хувирдаг онцлогтой. Жишээ нь банк бус санхүүгийн байгууллагад татсан нэмэлт өөрийн хөрөнгө нь талхны үйдвэртэй жишвэл шууд бэлэн бүтээгдэхүүн болох талхтай адилтган үзэж болно.

**Нэмэлт санхүүжилтэд үзүүлэх нөлөө**

Банк бус санхүүгийн байгууллагын өөрийн хөрөнгө нэмэгдсэнээр бусдаас татах санхүүгийн бусад эх үүсвэрийг зохицуулах байгууллагаас тавьдаг зохистой харьцаануудын хүрээнд нэмэгдүүлэх боломжтой болдог. Өөрөөр хэлбэл, нэмэлт өөрийн хөрөнгө нь тус санхүүгийн байгууллагын зээлийн хэмжээг нэмэлт хөрөнгийг тодорхой дүнгээр үржүүлсэн дүнгээр (leverage) нэмэгдэгдүүлэх боломжийг олгодог онцлогтой.

Дээрх онцлогуудаас хамаарч өөрийн хөрөнгөө нэмэгдүүлэхээс өмнөх болон дараах үеийн бизнесийн үнэ цэнэ нь ихээхэн ялгаатай гарах боломжтой болдог. Гагцхүү санхүүгийн нэмэлт эх үүсвэрээр гарах зээлийн эрэлт байгаа эсэх, тус нэмэлт эх үүсвэрийг бизнесийн эргэлтэд хэрхэн үр ашигтай оруулж чадах эсэх зэрэг нь үнэлгээнд нөлөөлөх хүчин зүйлс болно.

[1] *The Little Book of Valuation: How to Value a Company, Pick a Stock and Profit, Aswath Damodaran, 2011*



2019 .04. 24
2019 -03- 26
БҮРТГЭЛ-02
207

## Орц мэдээлэл болон таамаглалууд

Үнэлгээнд ашигласан үндсэн таамаглалуудыг доор үзүүлэв.

Тооцооны нэгж: Инвескор ББСБ-ын үйл ажиллагааг бүхэлд нь эсвэл зарим үйл ажиллагааг хэсэгчлэн бусад компанийн үйл ажиллагаатай нэгтгэсэн, нийлүүлснээс үүсэх үр дагаврыг энэхүү үнэлгээний ажилд тооцоолоогүй бөгөөд Инвескор ББСБ-ын бизнесийг бие даасан байдлаар үнэлсэн болно.

Тасралтгүй байдал: Үнэлгээнд хамрагдсан бизнесийн үйл ажиллагаа нь үргэлжилнэ, цаашид татан буугдах, эсвэл үйл ажиллагааны хамрах хүрээгээ багасгах шаардлагагүй гэж үзэв. Ингэснээр бизнесийн үнэ цэнэ нь татан буугдах үнэ цэнээс дээгүүр үнэлэгдэж зах зээлийн үнэ цэнийг тодорхойлох боломжтой болно.

## 3. АШИГЛАЛТЫН НӨХЦӨЛҮҮД

Мэдээллийн найдвартай байдал: Энэхүү үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхэд Үйлчлүүлэгч компаниас гарган өгсөн тоон болон чанарын мэдээллийг ашигласан болно. Бид эдгээр мэдээллийн үнэн зөв байдал болон дотоод зөрчилдөөнтэй эсэхэд тойм шинжилгээ хийсэн боловч аудитын эсвэл хараат бус шалгалт, дүгнэлт хийлгээгүй болно. Үнэлгээний үр дүнгийн нарийвчлал нь мэдээллийн чанар, бүрэн бүтэн байдалтай шууд хамааралтай. Иймд энэ тайланд алдаатай мэдээлэл орсон бол бидэнд мэдэгдэхийг хүсье. Нэмэлт мэдээлэлд үндэслэн тайланг засварлан өөрчлөх боломжтой.

Хөрөнгийн үнэлгээний аливаа тооцооллын нарийвчлал нь хязгаарлагдмал байдаг. Энэ нь худалдагч болон худалдан авагчийн хувийн сонирхол, сэтгэл ханамжаас хамаарч хөрөнгийн үнэ тогтдогтой холбоотой юм. Цаашилбал, хөрөнгийн үнэ нь ирээдүйд болох зарим үйл явдал, тухайлбал хууль хяналтын байгууллагын болон шүүхийн шийдвэр, инфляцын өөрчлөлт болон эдийн засгийн шийдвэрүүдээс хамаардаг онцлогтой болно.

Энэхүү ажилд хэрэглэсэн үнэлгээний аргачлал, таамаглалууд нь үнэлгээний ажлын зорилготой нийцэх ба үнэлгээний үр дүн нь үнэлгээнд ашигласан мэдээллүүдийн хүрээнд харьцангуй бодит тооцоолсон гэж үзэж байна.

Үнэлгээнд хамрагдсан хөрөнгөтэй холбоотой аливаа өр төлбөрийг, тухайлбал тухайн хөрөнгүүд нь зээлийн барьцаанд тавигдсан эсэх, үндсэн хөрөнгийн төлөгдөөгүй татвар байгаа эсэх талаар энэхүү тооцоонд оруулаагүй болно.

Тооцооны аргачлалаас хамаарч тайлангийн зарим үзүүлбэр болон хүснэгтэд орсон тоон үзүүлэлтүүд нь нарийвчлал өндөртэй гарсан болно. Иймд тайланд орсон үнэлгээний үзүүлэлтүүдийг бүхэлчилсэнтэй холбоотойгоор үр дүн бага хэмжээгээр зөрж болохыг анхаарна уу.

Бидний хэрэглэсэн нарийвчилсан таамаглалууд болон бусад хязгаарлалтууд нь тайлангийн зохих бүлгүүдэд дурдагдсан болно. Энэ бүлэг нь тайлангийн зөвхөн нэг бүрэлдэхүүн хэсэг ба аливаа бүлгийг дангаар авч үзэн дүгнэлт гаргах нь буруу зөрүүтэй ойлголтод хүргэх боломжтой тул тайланг бүхэлд нь үзэж судлахыг зөвлөж байна.

# 4. КОМПАНИЙН ТУХАЙ

## Компанийн товч танилцуулга

Инвескор ББСБ нь 2016 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд одоогийн байдлаар Улаанбаатар хотод 6 салбартай, үйл ажиллагаа нь өргөжин ажиллаж байна. Санхүүгийн зохицуулах хорооноос зээл, хөрөнгө оруулалт ба санхүүгийн зөвлөгөө, итгэлцэл, факторинг, төлбөрийн баталгаа гаргах, богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй.

Компани нь Монгол улсад бүртгэлтэй "Эс Ай Би Жэй Капитал" ХХК-ийн 100% хөрөнгө оруулалттай компани бөгөөд "Эс Ай Би Жэй Капитал" ХХК-ийн хувьцаа эзэмшигчид нь Кубо Такааки (24%), Б.Анхболд (45%), Б.Мөнх-Очир (31%) нар юм. Инвескор ББСБ нь Инвескор Эй Ай Лаб ХХК-ийн 90% - ийг эзэмшдэг.

Монголын тэргүүлэх банк, санхүүгийн байгууллагад ажилласан өндөр туршлага, чадвартай, зөв хандлагатай залуусыг эгнээндээ нэгтгэн, үүсгэн байгуулагдаад удаагүй боловч үйлчлүүлэгчид түргэн шуурхай, хариуцлагатай үйлчилж банк бус санхүүгийн зах зээлд өөрийн байр сууриа эзэлжээ. Тухайлбал, Монголын Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын 2017, 2018 оны "Оны онцлох Энтрепренер" шагнал, Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбооны 2017 оны шилдэг хөрөнгө оруулагч байгууллага, 2018 оны шилдэг байгууллагаар тус тус шалгарсан байна.

**Бизнесийн зорилго болон стратеги**

Инвескор ББСБ-ын эрхэм зорилго нь финтек, хиймэл оюун ухаанд суурилсан олон шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг Монголын болон Зүүн өмнөд болон Төв Азийн орнуудын бичил санхүүгийн зах зээлд нэвтрүүлж, шуурхай үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд үзүүлж, хариуцлагатай санхүүгийн дэмжигч нь байхад оршино.

**Бизнесийн шинэлэг ололтууд**

Хямд хүүтэй валютын зээл, зээлийн шугам, гүүрэн санхүүжилт, синдикат зээл зэрэг шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлэн ажиллаж байна. Жишээ нь 20 жил хүртэлх хугацаатай, 8 хувийн хүүтэй ам.долларын моргтейжийн зээлийг зах зээлд нэвтрүүлснээр гадаадад ажиллаж амьдарч буй монголчуудад эрэлт хэрэгцээ өндөр байна.

Төрийн мэдээлэл солилцооны ХУР системийг нэвтрүүлж, харилцагчийн хуруун хээг уншуулаад харилцагчийн мэдээллийг шууд татдаг болсноор түргэн шуурхай зээл олгох боломжтой болсон байна.

Хиймэл оюун ухаанд суурилсан кредит онооны систем, зээлийн судалгааны бүрэн автоматжуулсан системийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллаж байна.

Монголын ББСБ-уд дунд анх удаагаа олон улсад ашиглагдах боломжтой хоёр төрлийн VISA зээлийн картыг нэвтрүүлсэн байна.

## Салбаруудын зураг

**Төв оффис**








2019 .04. 24
БҮРТГЭВ
ГЭРЭГЭ ЭСТИМЭЙТ
2019 -03- 26

**Дазүрээ салбар**





**100 айл салбар**





**Дүнжингарав салбар**





**22-ын товчоо салбар**





**Бусад салбарууд**





## Санхүүгийн үзүүлэлт

Инвескор ББСБ-ын аудитоор баталгаажсан 2016 – 2018 оны санхүүгийн тайланд тойм шинжилгээ хийв.

Санхүүгийн байдлын үндсэн үзүүлэлт болох нийт хөрөнгө, өөрийн хөрөнгө, өр төлбөр нь 2016 оноос хойш огцом өсч 2018 оны эцсийн байдлаар нийт хөрөнгө 39.0 тэрбум төгрөг, өөрийн хөрөнгө 13.9 тэрбум төгрөг байна, өр төлбөр 25.1 тэрбум төгрөгт хүрсэн байна.

**Зураг 1: Инвескор ББСБ-ын санхүүгийн байдлын үндсэн үзүүлэлтүүд**




Үйл ажиллагааны цар хүрээг илтгэх зээлийн үлдэгдэл, нийт орлого, цэвэр ашгийн хувьд мөн огцом өсөлттэй ажиллаж 2018 онд нийт зээл 34.9 тэрбум төгрөг, нийт орлого 11.2 тэрбум төгрөг, цэвэр ашиг 5.1 тэрбум төгрөгт хүрчээ.

**Зураг 2: Инвескор ББСБ-ын ашигт ажиллагааны үндсэн үзүүлэлтүүд**




Өөрийн хөрөнгөд ногдох ашгийн үзүүлэлтээс харахад бизнесийн ашигт ажиллагаа нь 2016 оноос хойш тогтмол өсөж ирсэн байна.
Нийт хөрөнгө хөрөнгөд эзлэх өр төлбөрийн харьцаа 2016 оноос хойш тогтмол өссөнөөс харахад үйл ажиллагааны тэлэлтэд бусдаас татсан эх үүсвэр чухал нөлөө үзүүлсэн байна.
Инвескор ББСБ-ын санхүү, хөрөнгө оруулалтын үндсэн харьцаа үзүүлэлтүүдийг дараах хүснэгтэд үзүүлэв.

"ИНВЕСКОР ББСБ" ХХК
InvesCore NON-BANK FINANCIAL INSTITUTION
УЛААНБААТАР ХОТ
211

**Хүснэгт 1: Инвескор ББСБ-ын санхүүгийн үндсэн харьцаанууд**

| Санхүүгийн үндсэн харьцаанууд | 2016 | 2017 | 2018 |
|---|---|---|---|
| Хөрөнгийн өгөөж (ROA) | 8.8% | 13.9% | 13.0% |
| Өөрийн хөрөнгийн өгөөж (ROE) | 16.6% | 31.0% | 36.4% |
| Зээл/Хөрөнгө | 94.4% | 90.9% | 86.2% |
| Өөрийн хөрөнгө/Зээл | 55.9% | 49.5% | 41.3% |
| Өр төлбөр/Зээл | 50.1% | 60.5% | 74.7% |
| Өр төлбөр/Өөрийн хөрөнгө | 89.7% | 122.3% | 180.8% |
| Өр төлбөр/Нийт хөрөнгө | 47.3% | 55.0% | 64.4% |
| Бусад зардал/Нийт орлого | 7.2% | 7.1% | 23.6% |
| Ашиг/Зээл | 9.3% | 15.3% | 15.0% |
| Ашиг/Орлого | 49.9% | 59.2% | 43.1% |

# 5. ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

**Банк бус санхүүгийн байгууллагуудын өнөөгийн байдал**

Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ)-ны мэдээллээр[2] 2008 онд 131 ББСБ байсан бол 2018 оны 12-р сарын байдлаар нийт 541 тусгай зөвшөөрөлтэй ББСБ байна. ББСБ нь нийт 10 төрлийн үйлчилгээг тусгай зөвшөөрлийн дагуу эрхлэх боломжтой. Үүнээс зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй 491 байгууллага, итгэлцлийн үйл ажиллагаа эрхэлж буй 29 байгууллага байна.

**Зураг 3: ББСБ-ын тоо болон харилцагчдын тоо**




**Зураг 4: ББСБ-уудын тоо, үйлчилгээний төрлөөр**




[2] СЗХ, *"Санхүүгийн зах зээлийн тойм 2018 оны 3-р улирал"*

Салбарын нийт хөрөнгө болон өөрийн хөрөнгийн хэмжээ 2008-2018 онуудад тогтмол өсч 2018 оны 3-р улирлын байдлаар нийт хөрөнгө 1.2 их наяд төгрөг, өөрийн хөрөнгө 932 тэрбум төгрөг байна. Түүнчлэн нийт зээл тогтмол өсч тухайн улирлын байдлаар 811.6 тэрбум төгрөгт хүрсэн байна.

**Зураг 5: ББСБ-ын салбарын нийт хөрөнгө ба өөрийн хөрөнгө**




Салбарын хувьд 2017 оноос бусад үед нийт орлого, цэвэр ашиг байнга өсөлт үзүүлж 2018 оны 3-р улирлын байдлаар нийт орлого 183.9 тэрбум төгрөг, цэвэр ашиг 73.5 тэрбум төгрөгт хүрсэн байна.

**Зураг 6: ББСБ-уудын орлого, зарлага, ашгийн динамик**

*/тэрбум төгрөгөөр/*




Салбарийн нийт болон өөрийн хөрөнгийн өгөөж 2012-2014 онуудад хамгийн өндөр байсан бөгөөд 2015-2017 онуудад буурч 2018 оноос буцаад сэргэх хандлага ажиглагдаж байна.

**Зураг 7: ББСБ-ын салбарын нийт болон өөрийн хөрөнгийн өгөөж**



## Банк бус санхүүгийн салбарыг банкны салбартай харьцуулсан байдал

2018 оны 3-р улирлын байдлаар банкны салбар нь банк бус санхүүгийн салбараас нийт хөрөнгийн хэмжээгээр 26 дахин их, өөрийн хөрөнгийн хэмжээгээр 3.3 дахин их, зээлийн нийт үлдэгдэлийн хэмжээгээр 21 дахин их, харин цэвэр ашгийн хэмжээгээр 1.7 дахин бага байна[3]. Банкны салбарын хувьд нийт хөрөнгө, өөрийн хөрөнгө, нийт зээлийн үлдэгдэл өндөр боловч ашигт ажиллагааны хувьд банк бус санхүүгийн салбар өндөр байгаа нь банк бус санхүүгийн салбарын хүү өндөр, үйл ажиллагааны зардал харьцангуй бага байгаатай холбоотой.

**Хүснэгт 2: Банк болон ББСБ-ын салбарын харьцуулалт**

| Үндсэн үзүүлэлт | Банкны салбар | Банк бус санхүүгийн салбар |
|---|---|---|
| Нийт хөрөнгө | 31 их наяд төгрөг | 1.2 их наяд төгрөг |
| Өөрийн хөрөнгө | 3.1 их наяд төгрөг | 932 тэрбум төгрөг |
| Зээлийн нийт үлдэгдэл | 16.8 их наяд төгрөг | 811.6 тэрбум төгрөг |
| Цэвэр ашиг | 42.2 тэрбум төгрөг | 73.5 тэрбум төгрөг |
| Нийт хөрөнгийн өгөөж | 0.14% | 7.0% |
| Өөрийн хөрөнгийн өгөөж | 1.36% | 8.9% |

## Инвескор ББСБ-ын салбарт эзлэх хувь

Инвескор ББСБ-ын салбарт эзлэх хувь санхүүгийн үндсэн үзүүлэлт бүрээр байгуулагдсанаас хойш буюу 2016 оноос хойш өсөж байна. 2018 оны 3-р улирлын байдлаар цэвэр ашгийн үзүүлэлтээр салбарын нийт цэвэр ашгийн 4.9%-г эзэлж байна.

**Хүснэгт 3: Инвескор ББСБ-ын нийт салбарт эзлэх хувь**

| Үзүүлэлтүүд | 2016 | 2017 | 2018.III |
|---|---|---|---|
| Нийт хөрөнгө | 0.6% | 2.0% | 3.0% |
| Өөрийн хөрөнгө | 0.4% | 1.2% | 1.3% |
| Зээлийн үлдэгдэл | 1.0% | 3.1% | 3.8% |
| Нийт орлого | 0.4% | 2.4% | 4.4% |
| Цэвэр ашиг | 0.7% | 4.1% | 4.9% |

## Банк бус санхүүгийн салбарын өсөлтийг ДНБ-тэй харьцуулсан байдал

Санхүү болон даатгалын салбарын нийт ДНБ-д эзлэх хувь 2013 онд 4.1% байсан бөгөөд 2016, 2017 онуудад тогтмол 5.1% байсан байна. ББСБ-уудын нийт хөрөнгийн ДНБ-д эзлэх хувь 2%-иас 5% хүртэл жил бүр тодорхой хувиар тогтмол өссөн байна[4].

**Хүснэгт 4: Санхүү, ББСБ-ын салбарын ДНБ-д эзлэх хувь**

| Харьцаа үзүүлэлтүүд | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 | 2018 |
|---|---|---|---|---|---|---|
| Санхүүгийн салбар/ДНБ | 4.1% | 4.7% | 5.4% | 5.1% | 5.1% | n/a |
| ББСБ-ын нийт хөрөнгө/ДНБ | 2.0% | 2.3% | 2.7% | 3.3% | 3.5% | 5.1% |

[3] *Монголбанк, СЗХ-ны салбарын тойм 2018 III улирал*
[4] *http://1212.mn*



2019 .04. 24
2019 -03- 26
214
"ИНВЕСКОР ББСБ" ХХК
InvesCore
NON BANK FINANCIAL INSTITUTION
УЛААНБААТАР ХОТ

# 6. ҮНЭЛГЭЭ

## 6.1 Хөрөнгөд суурилсан шинжилгээ

Хөрөнгөд суурилсан хандлагыг үнэлгээнд хэрэглэхэд тухайн бизнесийн нийт хөрөнгөөс өр төлбөрүүдийг хасах замаар бизнесийн үнэ цэнийг тодорхойлдог. Энэ аргаар үнэлгээ хийхийн тулд Инвескор ББСБ-ын биет болон биет бус бүх хөрөнгүүд, мөн өр төлбөрийн үзүүлэлтүүдийн зах зээлийн үнэ цэнийг тогтоох замаар цэвэр хөрөнгийн хэмжээг тодорхойлох шаардлагатай болно.

Инвескор ББСБ-ын хөрөнгө болон өр төлбөрүүдийг үнэлгээний зориулалтаар дараах байдлаар хуваах авч үзэв. Үүнд:

1. Эргэлтийн бус хөрөнгө:
   - Тээврийн хэрэгсэл
   - Бусад хөрөнгө (Компьютер, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, түрээсийн сайжруулалт, биет бус хөрөнгө)
2. Эргэлтийн хөрөнгө:
   - Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө
   - Олгосон цэвэр зээл
   - Авлага
3. Өр төлбөр:
   - Өглөг, зээл, бусад зэрэг орно.

### Эргэлтийн бус хөрөнгө

Эргэлтийн бус хөрөнгүүдийн онцлог байдлагт уялдуулан ҮОУС-д тодорхойлсон дараах аргуудыг ашиглав. Үүнд, тээврийн хэрэгсэлд зах зээлийн хандлагын нийтэд арилжаалагддаг жиших зүйлсийн аргыг, бусад хөрөнгөд өртгийн хандлагын орлуулалтын өртгийн аргыг тус тус ашиглав.

Инвескор ББСБ-ын эргэлтийн бус хөрөнгийн үнэлгээнд 1 ширхэг тээврийн хэрэгсэл, бусад хөрөнгө ангилалд багтсан компьютер, тавилга зэрэг 38 төрлийн 45 ширхэг хөрөнгийг хамруулав. Инвескор ББСБ-ын нийт эргэлтийн бус хөрөнгийг үнэлгээний өдрийн байдлаар 651,026,181 төгрөг байхаар тооцоолов. Үнэлгээний үр дүнг дараах хүснэгтэд үзүүлсэн бөгөөд үнэлгээний дэлгэрэнгүй тооцооллыг Хавсралт 2-д үзүүлэв.

**Хүснэгт 5: Инвескор ББСБ-ын эргэлтийн бус хөрөнгийн үнэлгээ**

| Хөрөнгө | Тодорхойлолт | Тооцоолсон үнэ цэнэ, *сая төгрөгөөр* |
|---|---|---|
| Тээврийн хэрэгсэл | 2009 оны Toyota Prius 30 | 13.9 |
| Бусад хөрөнгө | Компьютер, тавилга гэх мэт 38 төрлийн 45 ширхэг хөрөнгө | 637.2 |
| **Нийт** | | **651.1** |

СЗХ
2019 .04. 24
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
ГЭРЭГЭ ЭСТИМЭЙТ
2019 -03- 26
БҮРТГЭВ-02

## Эргэлтийн хөрөнгө

2018 оны жил эцсийн санхүүгийн тайланд орсон дүнгээр тус компанийн нийт эргэлтийн хөрөнгө 38.4 тэрбум төгрөг байна. Үүнд:

**Хүснэгт 6: Инвескор ББСБ-ын эргэлтийн хөрөнгө**

| **Хөрөнгө** | **Дүн,** *сая төгрөгөөр* |
|---|---|
| Мөнгөн хөрөнгө | 2,320.1 |
| Зээл | 34,868.3 |
| Өмчлөх үл хөдлөх болон бусад | 417.5 |
| Бусад актив | 811.2 |
| **Нийт** | **38,417.2** |

## Өр төлбөр

2018 оны жил эцсийн санхүүгийн тайланд орсон дүнгээр тус компанийн нийт өр төлбөр 25.1 тэрбум төгрөг байна. Үүнд:

**Хүснэгт 7: Инвескор ББСБ-ын өр төлбөр**

| **Өр төлбөр** | **Дүн,** *сая төгрөгөөр* |
|---|---|
| Итгэлцлийн өглөг | 10,374.1 |
| Бусад банк, санхүүгийн байгууллагад төлөх | 13,867.4 |
| Бусад өр төлбөр | 890.4 |
| **Нийт** | **25,132.0** |

## Цэвэр хөрөнгө

Хөрөнгөд суурилсан аргаар бизнесийг үнэлэхэд нийт хөрөнгөөс өр төлбөрийг хассан цэвэр хөрөнгөд үндэслэн тооцоолдог.

**Хүснэгт 8: Инвескор ББСБ-ын цэвэр хөрөнгийн хэмжээ**

| **Үзүүлэлтүүд** | **Дүн,** *сая төгрөгөөр* |
|---|---|
| Эргэлтийн хөрөнгө | 38,417.2 |
| Эргэлтийн бус хөрөнгийн үнэ цэнэ | 651.1 |
| Өр төлбөр | 25,132.0 |
| **Цэвэр хөрөнгийн хэмжээ** | **12,634.1** |

Дээрх тооцооллоор Инвескор ББСБ-ын цэвэр хөрөнгө үнэлгээний өдрийн байдлаар 12,6 тэрбум төгрөг байна. Энэхүү тооцоололд тус компанийн гоодвилл, барааны тэмдэгт, менежментийн ур чадвар зэрэг биет бус хөрөнгүүд ороогүй болно. Харьцуулан судлах ижил төстэй бизнесийн зах зээлийн мэдээлэл хомс үед компанийн ирээдүйн ашигт ажиллагаанд чухал үүрэг гүйцэтгэх эдгээр биет бус хөрөнгийн үнэ цэнийг тооцоолоход бизнесийн нийт үнэ цэнээс бусад хөрөнгийн үнэ цэнийг хасах зарчим дээр тулгуурлан тооцоолол хийх нь оновчтой байдаг. Харин энэ аргачлал нь энэхүү үнэлгээний ажлын

"ИНВЕСКОР ББСБ" ХХК
InvesCore
NON-BANK FINANCIAL INSTITUTION
УЛААНБААТАР ХОТ

даалгаварт өгөгдсөн бизнесийн үнэ цэнийг тооцоолох ажилтай давхцаж байгаа тул хөрөнгөд суурилсан аргыг бизнес өмчлөлийн үнэ цэнийг тооцоолоход тохиромжгүй гэж үзэв.

### 6.2 Зах зээлийн харьцуулалтын үнэлгээ

**Дотоодын компаниудтай харьцуулах**

2018 оны эцсийн байдлаар нийт 540 орчим банк бус санхүүгийн байгууллага үйл ажиллагаа явуулж байгаагаас зөвхөн нэг компани буюу ЛэндМН ББСБ нь хувьцаагаа Монголын хөрөнгийн бирж дээр гаргасан хувьцаат компанийн хэлбэрээр бусад нь хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэрээр ажиллаж байна. Түүнчлэн, үнэлгээний тайлангийн өдрийн байдлаар Ард Кредит ББСБ нь хувьцаагаа олон нийтэд анхлан санал болгох ажиллагаа явуулж байна. ЛэндМН ББСБ болон Ард Кредит ББСБ-ын санхүүгийн болон хөрөнгө оруулалтын үндсэн үзүүлэлтийг доор үзүүлэв. Энд ЛэндМН ББСБ-ын мэдээллийг Монголын Хөрөнгийн Бирж болон тус компанийн олон нийтэд нээлттэй зарласан 2018 оны тайлангаас[5], Ард Кредит ББСБ-ын мэдээллийг тус компанийн Үнэт цаасны танилцуулгаас[6] тус тус авч ашиглав.

**Хүснэгт 9: Харьцуулсан үзүүлэлт-дотоод**

| **Санхүүгийн үзүүлэлтүүд** *сая төгрөгөөр* | **ЛэндМН** 2018 он | **Ард Кредит** 2018 он* | **Инвескор** 2018 он |
|---|---|---|---|
| Нийт орлого | 7,143.3 | 2,960.0 | 11,195.9 |
| Цэвэр ашиг | 2,518.1 | 716.0 | 5,053.5 |
| Эздийн өмч | 13,350.8 | 9,353.0 | 13,893.8 |
| Өр төлбөр | 11,036.2 | 10,813.0 | 25,132.0 |
| Үнэлгээ | 56,800.0 | 24,554.9 | n/a |
| **Харьцаа үзүүлэлтүүд** | | | |
| Өр төлбөр/Эздийн өмч (Leverage) | 82.7% | 115.6% | 180.9% |
| Нийт хөрөнгийн өгөөж (ROA) | 10.3% | 3.6% | 12.9% |
| Өөрийн хөрөнгийн өгөөж (ROE) | 18.9% | 7.7% | 36.4% |
| Үнэлгээ/Цэвэр ашиг (P/E) | 22.6 | 34.3 | |
| Үнэлгээ/Эздийн өмч (P/B) | 4.3 | 2.6 | |

**2018 оны төсөөлөл, Үнэт цаасны танилцуулгад орсон дүнгээр*

2018 онд ЛэндМН ББСБ-ийн эздийн өмч 13.3 тэрбум төгрөг, өр төлбөр 11.0 тэрбум төгрөгт хүрч, тус компани 7.1 тэрбум төгрөгийн орлого олж, үүнээс 2.5 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллажээ. Энэ компанийн Монголын Хөрөнгийн Бирж дээрх бизнес өмчлөлийн нийт үнэ цэнэ 56.8 тэрбум төгрөгөөр үнэлэгдэж байна.

2018 оны Ард Кредит ББСБ-ийн тооцоолсон (Post IPO) дүнгээр эздийн өмч 9.3 тэрбум төгрөг, өр төлбөр 10.8 тэрбум төгрөгт хүрч, тухайн онд тус компани 2.9 тэрбум төгрөгийн орлого олж, үүнээс 716.0 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллахаар төлөвлөжээ. Энэ компанийн Монголын Хөрөнгийн Бирж дээр хувьцаагаа анхлан гаргах зориулалтаар хийсэн бизнес өмчлөлийн үнэ цэнэ 24.6 тэрбум төгрөг байхаар тооцоолсон байна.

[5] https://lend.mn/ipo.html
[6] http://mse.mn/uploads/images/ard_tovch_taniltsuulga.pdf

2018 онд үнэлгээнд хамрагдсан Инвескор ББСБ-ийн эздийн өмч 13.9 тэрбум төгрөг, өр төлбөр 25.1 тэрбум төгрөгт хүрч, тухайн онд тус компани 11.2 тэрбум төгрөгийн нийт орлого олж, үүнээс 5.1 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллажээ.

Хүснэгт 9-ийн харьцаа үзүүлэлтийг доор тайлбарлав.

Тайлангийн Бүлэг 2, "Банк бус санхүүгийн байгууллагын үнэлгээний онцлог" хэсэгт тайлбарласнаар банк бус санхүүгийн байгууллагын бусдаас санхүүгийн эх үүсвэр татан төвлөрүүлэх чадвар нь бизнесийн үнэ цэнэд чухал нөлөө үзүүлдэг. Өр төлбөрийг эздийн өмчид харьцуулсан харьцаагаар ЛэндМН 82.7%, Ард Кредит 115.6%, Инвескор 180.9% буюу Инвескор компани нь харьцуулж буй компаниудаас өндөр үзүүлэлттэй байна.

Тухайлбал, Инвескор ББСБ нь ЛэндМН компанитай эздийн өмчийн хэмжээгээр ойролцоо боловч бусдаас эх үүсвэр татсан үзүүлэлтээр өндөр тул тайлант хугацаанд 2 дахин өндөр ашигтай ажиллах боломжийг олгосон байна. Иймд ашигт ажиллагааны үзүүлэлтүүдээр Инвескор ББСБ нь харьцуулж үзсэн компаниудаас хамгийн өндөр үзүүлэлттэй ажилласан байна.

2018 оны эцсийн байдлаар ЛэндМН ББСБ-ийн бизнес өмчлөлийн зах зээлийн үнэ цэнэ 56.8 тэрбум байгаа нь тухайн жилийн цэвэр ашигтай харьцуулбал 22.6 дахин их, эздийн өмчтэй харьцуулбал 4.3 дахин их байна. Эдгээр харьцааг Ард Кредит ББСБ-ийн тооцоолсон дүнгээр гаргаж харвал хөрөнгийн зах зээлд анхдагч хувьцаа гаргасны дараах бизнесийн үнэлгээ нь тухайн жилийн цэвэр ашигтай харьцуулахад 34.3 дахин их, эздийн өмчтэй харьцуулбал 2.6 дахин их гарч байна.

**Гадаадын компаниудтай харьцуулах**

Үнэлгээнд хамрагдсан компанитай ижил төстэй үйл ажиллгаа явуулдаг гадаадын санхүүгийн байгууллагын олон нийтэд нээлттэй мэдээлэл олдоц сайтай байна. Жишээ болгох үүднээс (бичил) санхүүгийн зах зээл харьцангуй сайн хөгжсөн Балба улсын хөрөнгийн бирж[7] дээр арилжаалагдаж буй Инвескор ББСБ-тай ойролцоо хэмжээтэй санхүүгийн байгууллагуудыг сонгон авч хөрөнгө оруулалтын үндсэн харьцааг доорх хүснэгтэд үзүүлэв.

**Хүснэгт 10: Харьцуулсан үзүүлэлт-гадаад**

| Company name | Nirdhan Utthan Bank Limited | Rural Microfinance Development Centre | First Micro Finance Development Bank Ltd | Rural Self-reliance Development Centre | Nerude Laghubital Bikas | Average |
|---|---|---|---|---|---|---|
| Stock Exchange | Nepal Stock Exchange (http://www.merolagani.com) | | | | | |
| Stock symbols | NUBL | RMDC | FMDBL | RSDC | NLBBL | |
| Market cap, usd mln | 81.20 | 42.11 | 22.55 | 23.27 | 16.42 | 37.1 |
| P/E | 13.86 | 16.31 | 22.78 | 50.80 | 24.47 | 25.64 |
| P/B | 3.93 | 2.07 | 3.06 | 3.25 | 2.29 | 2.92 |

Дээрх харьцуулалтаас үзэхэд дундажаар 37.1 сая ам.доллар буюу ойролцоогоор 95.1 тэрбум төгрөгийн зах зээлийн үнэлгээтэй бичил санхүүгийн байгууллагуудын хувьд санхүүгийн бизнесийн үнэлгээнд өргөн хэрэглэгддэг үнэ, ашгийн харьцаа (P/E ratio) 13.86

[7] http://merolagani.com

– 50.80 хооронд, дундаж нь 25.64, үнэ, өөрийн хөрөнгийн харьцаа (P/B ratio) 2.07-3.93-ийн хооронд, дундаж нь 2.92 байна.

Инвескор ББСБ-ын бизнесийн үнэлгээг олон улсын бичил санхүүгийн байгууллагуудын санхүүгийн үзүүлэлттэй харьцуулан хийх нь учир дутагдалтай. Учир нь:

1. Төсөөтэй компаниудын үржигдэхүүнүүд нь хоорондоо зөрүү өндөртэй тул дундаж утгыг авч үзэх нь учир дутагдалтай. Иймд харьцуулж судалж байгаа компани тус бүрийг Инвескор ББСБ-тай харьцуулж шаардагдах тохируулгыг хийх хэрэгтэй болно.
2. Олон улсын болон Монгол улсын бичил санхүүгийн зах зээлийн хэмжээ, хэрэглэгчийн тоо, хууль эрх зүйн орчин, хэрэглэгчдийн зан төлөв зэрэг нь ялгаатай бөгөөд хэрэв үнэлгээнд олон улсын бичил санхүүгийн компанийн үржүүлэгчийг ашиглахаар бол эдгээр ялгааг судалж, харгалзах тохируулгын коэффициентийг тодорхойлох шаардлагатай. Тохируулгын коэффициент тооцоолох ажил нь субьектив дүгнэлт ихтэй, цаг хугацаа ихээр шаардана.

**Зах зээлийн харьцуулалтын аргын үр дүн**

Хүснэгт 9-д үзүүлсэн харьцааг ашиглан Инвескор ББСБ-ын хөрөнгийн зах зээлд анхдагч хувьцаа гаргасны дараах бизнес өмчлөлийн 100%-ийн үнэ цэнийг дараах байдлаар баримжаалан тооцоолж болно.

**Хүснэгт 11: Зах зээлийн харьцуулалтын үр дүн**

*сая төгрөгөөр*

| Үзүүлэлтүүд | Жишиг бизнес 1_Лэнд МН | Жишиг бизнес 2_Ард Кредит |
|---|---|---|
| Үнэлгээ/Ашиг (P/E) | 113,992.4 | 173,307.6 |
| Үнэлгээ/Өөрийн хөрөнгө (P/B) | 136,239.4 | 84,071.5 |
| **Дундаж** | **125,115.9** | **128,689.6** |

Зах зээлийн харьцуулалтын аргаар Инвескор ББСБ-ын хөрөнгийн зах зээлд анхдагч хувьцаа гаргасны дараах бизнес өмчлөлийн 100%-ийн үнэ цэнэ 125.1 – 128.7 тэрбум төгрөг байх баримжаа тооцоолол гарч байна..

## 6.3 Орлогын хандлагын аргаар хийсэн үнэлгээ

Үйлчлүүлэгч компанийн бизнесийн болон санхүүгийн загварт дүн шинжилгээ хийсний үндсэн дээр орлогын хандлагаар хийсэн үнэлгээг Үйлчлүүлэгч компанийн ирэх 5 жилийн бизнес төлөвлөгөөнд үндэслэн хийж гүйцэтгэв. Үнэлгээний зорилго, үнэлгээнд хамрагдсан бизнесийн онцлогийг харгалзан энэхүү үнэлгээний ажилд *Ногдол ашиг хорогдуулах (Dividend Discount Model)*-ын аргыг ашиглав. Үнэлгээнд ашигласан орц, төсөөллүүдийг доор тайлбарлав.

### Загварын орц, төсөөллүүд

**Өсөлтийн хугацаа**

219

Инвескор ББСБ нь 2016 онд байгуулагдсан бөгөөд 2017 оноос хойш үйл ажиллагаа нь жигдрэн ажиллаж байна. Тус компанийн өсөлтийн хугацааг үнэлгээний өдрөөс хойш 5 жил буюу 2023 он байхаар төсөөлөв.

**Урт хугацааны өсөлт**

Урт хугацааны буюу 2023 оноос хойших жилийн дундаж бодит өсөлтийг 5%, Монгол Улсын урт хугацааны жилийн инфляцийг 6% байхаар тус тус авч үнэлгээнд ашиглав. Энэ төсөөллийг Монгол Улсын Сангийн яам, Монголбанк, олон улсын санхүүгийн байгууллагуудын төсөөлөлд санхүүгийн зөвлөх үйлчлгээний Гэрэгэ Партнерс компанийн эдийн засагчдын хийсэн шинжилгээнд үндэслэн авав.

**Бусдаас татах эх үүсвэр**

Инвескор ББСБ-ын өрсөлдөөний үндсэн давуу талуудын нэг нь гадаадын болон дотоодын байгууллагуудаас санхүүгийн эх үүсвэр татах чадвар гэж үзэж болно. Энэ үзүүлэлт нь тус компанийн өр төлбөрийг эздийн өмчид харьцуулсан харьцаагаар хэмжигдэнэ. Банк бус санхүүгийн байгууллагын салбарын хэмжээнд энэ харьцаа нь 2018 оны 3-р улирлын байдлаар 29% байсан[8] бол Инвескор компанийн хувьд 2018 онд 180.8% байна. Салбарын дундаж үзүүлэлт ийнхүү бага байгаа нь нийт 541 ББСБ-аас зөвхөн 29 ББСБ нь итгэлцлийн үйлчилгээ үзүүлдэгтэй холбоотой (**Зураг 4: ББСБ-уудын тоо, үйлчилгээний төрлөөр**) тул шууд харьцуулсан дүгнэлт хийх нь учир дутагдалтай. Харин, энэ бүлгийн 6.2 хэсэгт харьцуулан авч үзсэн ЛэндМН, Ард Кредит компаниудаас энэ үзүүлэлтээр өндөр байгаа (**Хүснэгт 9: Харьцуулсан үзүүлэлт-дотоод**) нь тус компанийн чадварыг илүүтэй харуулж байна.

Энэ үзүүлэлтийг *Өр төлбөр*$_t$ / *Эздийн өмч*$_{t-1}$ буюу тухайн жилийн өр төлбөрийг өмнөх жилийн эздийн өмчид харьцуулсан харьцаагаар тодорхойлж шинжилгээ хийв. Үнэлгээчдийн зүгээс энэ харьцаа үнэлгээний өдрийн байдлаар өндөр дүнтэй байгаа ч цаашид бизнесийн өрсөлдөөний улмаас буурна, ингэхдээ хэтийн төлөвт (10 жилийн хугацаанд) салбарын дундаж утга руу чиглэж буурах хандлага дагна гэх төсөөлөл авч компанийн бизнес төлөвлөгөөтэй харьцуулж судлав. Төсөөллийг харьцуулан үзүүлбэл:

| ***Өр төлбөр***$_t$ ***/ Эздийн өмч***$_{t-1}$ | **2017** | **2018** | **2019** | **2020** | **2021** | **2022** | **2023** |
|---|---|---|---|---|---|---|---|
| Үнэлгээчид | 4.50 | 2.84 | 2.61 | 2.38 | 2.14 | 1.91 | 1.68 |
| Менежмент | 4.50 | 2.84 | 2.80 | 1.82 | 1.44 | 0.99 | 0.68 |

| 277 | Интернэт төхөөрөмж | 4/17/18 | 1 | 280,000 | 1.00 | 1.00 | 3 | 280,000 |
| 278 | firewall | 4/18/18 | 1 | 400,000 | 1.00 | 1.00 | 3 | 400,000 |
| 279 | B7025 принтер | 5/1/18 | 1 | 4,800,000 | 1.00 | 1.00 | 3 | 4,800,000 |
| 280 | Сервер | 5/4/18 | 1 | 2,597,400 | 1.00 | 1.00 | 3 | 2,597,400 |
| 281 | усны диспенсер | 5/17/18 | 1 | 199,990 | 1.00 | 1.00 | 3 | 199,990 |
| 282 | мөнхсүлд Төр | 5/30/18 | 1 | 117,500 | 1.00 | 1.00 | 3 | 117,500 |
| 283 | Laptop | 5/31/18 | 1 | 2,600,000 | 1.00 | 1.00 | 3 | 2,600,000 |
| 284 | Печь/monel/ | 5/15/18 | 1 | 142,990 | 1.00 | 1.00 | 3 | 142,990 |
| 285 | Печь/monel/ | 5/15/18 | 1 | 142,990 | 1.00 | 1.00 | 3 | 142,990 |
| 286 | Печь/monel/ | 5/15/18 | 1 | 142,990 | 1.00 | 1.00 | 3 | 142,990 |
| 287 | Печь/monel/ | 5/15/18 | 1 | 142,990 | 1.00 | 1.00 | 3 | 142,990 |
| 288 | сэнс /monel / | 5/15/18 | 1 | 92,990 | 1.00 | 1.00 | 3 | 92,990 |
| 289 | сэнс /monel / | 5/15/18 | 1 | 92,990 | 1.00 | 1.00 | 3 | 92,990 |
| 290 | кофе чанагч /enjoy/ | 5/15/18 | 1 | 46,999 | 1.00 | 1.00 | 3 | 46,999 |
| 291 | кофе чанагч /enjoy/ | 5/15/18 | 1 | 46,999 | 1.00 | 1.00 | 3 | 46,999 |
| 292 | кофе чанагч /enjoy/ | 5/15/18 | 1 | 46,999 | 1.00 | 1.00 | 3 | 46,999 |
| 293 | Хөргөгч/meda/ | 5/16/18 | 1 | 339,900 | 1.00 | 1.00 | 3 | 339,900 |
| 294 | эйр кондишны үнэ | 6/15/18 | 1 | 1,160,500 | 1.00 | 1.00 | 3 | 1,160,500 |
| 295 | Laptop | 6/24/18 | 1 | 2,500,000 | 1.00 | 1.00 | 3 | 2,500,000 |

2019.04.24

**ХАВСРАЛТ 2**

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 296 | Laptop | 7/31/18 | 1 | 1,250,000 | 1.00 | 1.00 | 3 | 1,250,000 |
| 297 | Laptop | 7/31/18 | 1 | 1,250,000 | 1.00 | 1.00 | 3 | 1,250,000 |
| 298 | | 8/21/18 | 1 | 5,016,000 | 1.00 | 1.00 | 3 | 5,016,000 |
| 299 | Laptop | 8/22/18 | 1 | 1,250,000 | 1.00 | 1.00 | 3 | 1,250,000 |
| 300 | Laptop | 8/22/18 | 1 | 1,250,000 | 1.00 | 1.00 | 3 | 1,250,000 |
| 301 | Laptop | 8/22/18 | 1 | 1,250,000 | 1.00 | 1.00 | 3 | 1,250,000 |
| 302 | Laptop | 8/22/18 | 1 | 1,250,000 | 1.00 | 1.00 | 3 | 1,250,000 |
| 303 | Laptop | 8/22/18 | 1 | 1,250,000 | 1.00 | 1.00 | 3 | 1,250,000 |
| 304 | | 9/3/18 | 1 | 1,000,000 | 1.00 | 1.00 | 3 | 1,000,000 |
| 305 | 3025 принтер | 9/3/18 | 1 | 770,000 | 1.00 | 1.00 | 3 | 770,000 |
| 306 | Биде | 9/7/18 | 1 | 1,776,473 | 1.00 | 1.00 | 3 | 1,776,473 |
| 307 | проекторны үнэ | 9/16/18 | 1 | 1,461,900 | 1.00 | 1.00 | 3 | 1,461,900 |
| 308 | Дэлгэцний үнэ | 9/16/18 | 1 | 279,920 | 1.00 | 1.00 | 3 | 279,920 |
| 309 | coffee chanagch | 9/16/18 | 1 | 2,499,900 | 1.00 | 1.00 | 3 | 2,499,900 |
| 310 | Laptop | 9/18/18 | 1 | 1,330,000 | 1.00 | 1.00 | 3 | 1,330,000 |
| 311 | Laptop | 9/18/18 | 1 | 1,330,000 | 1.00 | 1.00 | 3 | 1,330,000 |
| 312 | Laptop | 9/18/18 | 1 | 1,330,000 | 1.00 | 1.00 | 3 | 1,330,000 |
| 313 | гар хатаагч | 9/19/18 | 1 | 803,000 | 1.00 | 1.00 | 10 | 803,000 |
| 314 | ус цэвэршүүлэгч | 9/20/18 | 1 | 1,852,500 | 1.00 | 1.00 | 3 | 1,852,500 |
| 315 | LT10000LBE бензин | 9/27/18 | 1 | 1,798,000 | 1.00 | 1.00 | 10 | 1,798,000 |
| 316 | Дэлгэц Dell E2216HV | 10/15/18 | 1 | 299,000 | 1.00 | 1.00 | 3 | 299,000 |
| 317 | Дэлгэц Dell E2216HV | 10/15/18 | 1 | 299,000 | 1.00 | 1.00 | 3 | 299,000 |
| 318 | Дэлгэц Dell E2216HV | 10/15/18 | 1 | 299,000 | 1.00 | 1.00 | 3 | 299,000 |
| 319 | Дэлгэц Dell SE2417H Full | 10/15/18 | 1 | 387,000 | 1.00 | 1.00 | 3 | 387,000 |
| 320 | BSB-LED-US55P17T2 | 10/27/18 | 1 | 1,139,905 | 1.00 | 1.00 | 3 | 1,139,905 |
| 321 | BSB-LED-D39P17T2 | 10/27/18 | 1 | 474,905 | 1.00 | 1.00 | 3 | 474,905 |
| 322 | BSB-LED-D39P17T2 | 10/27/18 | 1 | 474,905 | 1.00 | 1.00 | 3 | 474,905 |
| 323 | X-AD20-1809-52 сервэр | 10/31/18 | 1 | 7,018,000 | 1.00 | 1.00 | 3 | 7,018,000 |
| 324 | HP принтер MFP- | 11/3/18 | 1 | 902,405 | 1.00 | 1.00 | 3 | 902,405 |
| 325 | Дэлгэц Dell E2216H | 11/17/18 | 1 | 980,000 | 1.00 | 1.00 | 3 | 980,000 |
| 326 | Switch | 12/6/18 | 1 | 236,500 | 1.00 | 1.00 | 3 | 236,500 |
| 327 | 40 мкв зөөврийн сууц | 6/30/17 | 1 | 18,490,780 | 1.08 | 0.94 | 25 | 18,766,909 |

"ИНВЕСКОР ББСБ" ХХК

InvesCore

7

241

2019 .04. 24

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2019 -03- 26

**ХАВСРАЛТ 3: ҮНЭЛГЭЭЧДИЙН СЕРТИФИКАТЫН ХУУЛБАРУУД**

TDB CAPITAL LLC



"ИНВЕСКОР ББСБ" ХХК
InvesCore
NON-BANK FINANCIAL INSTITUTION
УЛААНБААТАР ХОТ

2019 .04. 24

**ХАВСРАЛТ 3**

САНГИЙН ЯАМ

## ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ
# ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

Дугаар ..................

Иргэний ургийн овог ..................

Иргэний овог нэр ..................

Иргэний үнэмлэхний дугаар ..................

Иргэний бүртгэлийн дугаар ..................

Үнэлгээчний гэрчилгээний дугаар ..................

Иргэний хаяг ..................

Зөвшөөрөл олгосон шийдвэр, огноо: ..................

**Энэхүү зөвшөөрөл нь олгосон эсвэл сунгасан өдрөөс хойш 3 жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.**

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэгт заасны дагуу энэхүү тусгай зөвшөөрлийг хуульд зааснаас бусад тохиолдолд бусдад худалдах, бэлэглэх, барьцаалах зэргээр шилжүүлж үл болно.

САНГИЙН САЙД ......................... / ........ /

УЛААНБААТАР ХОТ

### ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААНЫ СУНГАЛТ

Сангийн сайдын 20 15 оны 344 дугаар тушаалаар энэхүү тусгай зөвшөөрлийг 20 15 оны 12 -р сарын 18 -ны өдрөөс 3 жилийн хугацаагаар сунгав.

САНГИЙН САЙД / Б.БОЛОР /

### ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААНЫ СУНГАЛТ

Сангийн сайдын 20 18 оны 284 дугаар тушаалаар энэхүү тусгай зөвшөөрлийг 20 18 оны 12 -р сарын 19 -ны өдрөөс 3 жилийн хугацаагаар сунгав

САНГИЙН САЙД / Ч.ХҮРЭЛБААТАР /

### ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААНЫ СУНГАЛТ

Сангийн сайдын 20..... оны ..... дугаар тушаалаар энэхүү тусгай зөвшөөрлийг 20..... оны .....-р сарын .....-ны өдрөөс 3 жилийн хугацаагаар сунгав

САНГИЙН САЙД / /

243

"ИНВЕСКОР ББСБ" ХХК
InvesCore
NON BANK FINANCIAL INSTITUTION
1

УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2019 .04. 24
БҮРТГЭВ

**ХАВСРАЛТ 3**

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2019 -03- 26
БҮРТГЭВ-02

**САНГИЙН ЯАМ**

Сангийн сайдын 2010 оны 13 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

## ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ
# ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

**Дугаар** 121200001

Иргэний ургийн овог [illegible]

Иргэний овог нэр [illegible]

Иргэний үнэмлэхний дугаар [illegible]

Иргэний бүртгэлийн дугаар

Үнэлгээчний гэрчилгээний дугаар

Иргэний хаяг [illegible]

Зөвшөөрөл олгосон шийдвэр, огноо [illegible]

**Энэхүү зөвшөөрөл нь олгосон эсвэл сунгасан өдрөөс хойш 3 жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.**

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэгт заасны дагуу энэхүү тусгай зөвшөөрлийг хуульд заасанаас бусад тохиолдолд бусдад худалдах, бэлэглэх, барьцаалах зэргээр шилжүүлж үл болно.

САНГИЙН САЙД ........ / Ч.УЛААН /

**УЛААНБААТАР ХОТ**

**ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААНЫ СУНГАЛТ**

Сангийн сайдын 20 15 оны 344 дугаар тушаалаар энэхүү тусгай зөвшөөрлийг

20 15 оны 12 -р сарын 18 -ны өдрөөс 3 жилийн хугацаагаар сунгав

САНГИЙН САЙД / Б.БОЛОР /

**ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААНЫ СУНГАЛТ**

Сангийн сайдын 20 18 оны 284 дугаар тушаалаар энэхүү тусгай зөвшөөрлийг

20 18 оны 12 -р сарын 19 -ны өдрөөс 3 жилийн хугацаагаар сунгав

САНГИЙН САЙД / Ч.ХҮРЭЛБААТАР /

**ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААНЫ СУНГАЛТ**

Сангийн сайдын 20.... оны ..... дугаар тушаалаар энэхүү тусгай зөвшөөрлийг

20..... оны .....-р сарын .....-ны өдрөөс 3 жилийн хугацаагаар сунгав

САНГИЙН САЙД / /

TDB CAPITAL LLC

244

"ИНВЕСКОР ББСБ" ХХК
InvesCore
NON-BANK FINANCIAL INSTITUTION
1116224289 6060854
УЛААНБААТАР ХОТ

ХАВСРАЛТ 3

СЗХ 2019.04.24 БҮРТГЭВ №81

MONGOLIAN STOCK EXCHANGE 2019-03-26

САНГИЙН ЯАМ

Сангийн сайдын 2010 оны 19 дүгээр тушаалын 3 дугаар хавсралт

## ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ
# ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

**Дугаар** 101200188

Иргэний ургийн овог: Хошууд

Иргэний овог нэр: Доноров овогтой Ганбаатар

Иргэний үнэмлэхний дугаар:

Иргэний бүртгэлийн дугаар: ОО77112572

Үнэлгээчний гэрчилгээний дугаар:

Иргэний хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг 23-р хороо хужир булан А-111 тоот

Зөвшөөрөл олгосон шийдвэр, огноо: Сангийн сайдын 2017 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн 7 тоот тушаал

**Энэхүү зөвшөөрөл нь олгосон эсвэл сунгасан өдрөөс хойш 3 жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.**

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэгт заасны дагуу энэхүү тусгай зөвшөөрлийг хуульд зааснаас бусад тохиолдолд бусдад худалдах, бэлэглэх, барьцаалах зэргээр шилжүүлж үл болно.

САНГИЙН САЙД ........................ Б.ЧОЙЖИЛСҮРЭН

УЛААНБААТАР ХОТ

TDB CAPITAL LLC

245

"ИНВЕСКОР ББСБ" ХХК
InvesCore NON BANK FINANCIAL INSTITUTION
3
1116224280 6060854
УЛААНБААТАР ХОТ

2019 .04. 24
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2019 -03- 26
БҮРТГЭВ-02

2019 ОНЫ 2 ДУГААР САРЫН 28

# ХУУЛЬ ЗҮЙН ДҮГНЭЛТ

## "ИНВЕСКОР ББСБ" ХХК-ИАС ХУВЬЦААГАА АНХ УДАА НИЙТЭД САНАЛ БОЛГОХ ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГАД ТУСГАСАН МЭДЭЭЛЭЛ НЬ ҮНЭН ЗӨВ, ХУУЛЬ ЗҮЙН ХУВЬД ХҮЧИН ТӨГӨЛДӨР ЭСЭХ ТУХАЙ

TDB CAPITAL LLC

ӨМГӨӨЛЛИЙН "ЭМ ДИ ЭС ЭНД ХААНЛЕКС" ХХН

Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо,
Сэнтрал Тауэр, 13 давхар, 1301 тоот, и-мэйл хаяг: info@mdsa.mn

"ИНВЕСКОР ББСБ" ХХК
InvesCore
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2019 .04. 24
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2019 -03- 26
БҮРТГЭВ

MDS KhanLex

## Агуулга

0. Нийтлэг үндэслэл....2

1. Компани хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдаж бүртгэгдсэн эсэх талаар ......4

2. Компанийн Гүйцэтгэх удирдлага, Эрх бүхий албан тушаалтнууд нь хууль болон Компанийн засаглалын кодекст заасан шаардлагыг хангаж байгаа эсэх, тэдний компанийг удирдах чадвар, дадлага туршлагын байдлаар ....5

3. Компанийн дүрэм бусад дотоод журмууд нь хууль тогтоомж, Хорооноос баталсан “Монголын компанийн засаглалын кодекс”-т нийцсэн эсэх....10

4. Бусадтай байгуулсан худалдан авах, бэлтгэн нийлүүлэх, зээлийн зэрэг үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд голлох ач холбогдолтой гэрээ нь хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх ....17

5. Сүүлийн 3 жилийн дотор хийсэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл байгаа бол хуульд заасан журмын дагуу байгуулсан эсэх. ....22

6. Үйл ажиллагааны гол үндэслэл болсон аливаа тусгай зөвшөөрөл, лиценз, зохиогчийн эрх, патент, бараа, үйлчилгээний тэмдэг нь хүчин төгөлдөр эсэх, тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах, барьцаалагдах зэргээр үйл ажиллагаанд нь бодитой нөлөөлж болох нөхцөл байгаа эсэх....23

7. Үнэт цаас, үл хөдлөх болон бусад эд хөрөнгө өмчлөх эрх нь хүчин төгөлдөр эсэх, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээсэн эсэх ....24

8. Үнэт цаас бүртгүүлэх өргөдөл, танилцуулгад тусгагдсан мэдээлэл нь хүчин төгөлдөр баримтаар нотлогдож байгаа эсэх....26

9. Үнэт цаас гаргагч компанийн хяналтыг жинхэнэ хэрэгжүүлэгч этгээд нь хэн болох..27

10. Тухайн компанийн улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлтэй холбоотой зөрчил байгаа эсэх болон нэмэлт шинжилгээ, судалгаа....28

11. Тухайн компанийн эрхэлж буй үйл ажиллагааны нийцэл (complaince)-ийн талаар хийсэн зарим нэмэлт судалгаа шинжилгээ ....29

12. Гол дүгнэлт....30

13. Хязгаарлалт ....31

ТДБ КАПИТАЛ ҮЦК ХХК
TDB CAPITAL
TDB CAPITAL LLC



"ИНВЕСКОР ББСБ" ХХК
InvesCore
NON-BANK FINANCIAL INSTITUTION
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2019.04.24
он сар өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2019-03-26



Өмгөөллийн "Эм Ди Эс энд Хаан Лекс" ХХН (цаашид "Хуулийн фирм" гэх) нь Санхүүгийн зохицуулах хороо (цаашид "СЗХ" гэх)-ны 2014.01.29-ний өдрийн 25 дугаар тогтоолоор Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 33.2.1 дэх хэсэгт зааснаар Үнэт цаасны зах зээлд хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа эрхлэх бүхий этгээдээр анх бүртгэгдсэн ба СЗХ-ны 2016.02.24-ний өдрийн 42 дугаар тогтоолоор нэрээ шинэчлэн бүртгүүлсэн Үнэт цаасны зохицуулалттай этгээд (Хавсралт 0.1)-ийн хувьд энэхүү хууль зүйн үйлчилгээг үзүүлэх эрхтэй болно.

Монгол Улсын хуулийн этгээд болох "Инвескор ББСБ" ХХК (цаашид "Инвескор" гэх) нь хувьцаагаа анх удаа нийтэд санал болгох гэж буйтай холбогдуулан Хууль зүйн дүгнэлт гаргахыг биднээс хүсч, улмаар бид 2018.10.05-ны өдөр Д-18/380 тоот "Хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ" (Хавсралт 0.2) байгуулан, тус гэрээний дагуу энэхүү хууль зүйн дүгнэлтийг гаргаж байна.

Энэхүү хууль зүйн дүгнэлтийг зөвхөн Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомж, түүний дотор Компанийн тухай хуулийн 23.1-т "... хязгаарлагдмал хариуцлагатай компанийг хувьцаат компани болгох замаар компанийн хэлбэрийг өөрчилж болно", 4.3-т "Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол нээлттэй хувьцаат компани нь нээлттэй буюу хаалттай захиалгын үндсэн дээр хувьцаа болон бусад үнэт цаасыг гаргаж болно" гэж хуульчилсны дагуу Инвескор нь нэмж гаргах энгийн эрхийн хувьцаагаа олон нийтэд санал болгох замаар хувьцаат компани болж өөрчлөн байгуулагдах эрх зүйн [illegible] Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйл [illegible] дугаар зүйл (Үнэт цаас гаргах), 7 дугаар зүйл (Үнэт цаас гаргагч), 8 дугаар зүйл (Нийтэд санал болгон үнэт цаас гаргах журам), 9 дүгээр зүйл (Үнэт цаас бүртгэх, нийтэд санал болгохыг зөвшөөрөх), 11 дүгээр зүйл (Үнэт цаасыг нийтэд санал болгох)-д заасны дагуу хувьцаагаа Санхүүгийн зохицуулах хороо (цаашид "СЗХ" эсхүл "Хороо" гэх), Монголын хөрөнгийн бирж (цаашид "МХБ" гэх)-д бүртгүүлж, нийтэд санал болгон гаргахаар төлөвлөсөн байна.

Энэхүү хувьцааны бүртгэл болон арилжаа нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10.6, 10.7, СЗХ-ны 2015.11.23-ны өдрийн 408 дугаар тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам", МХБ-ийн ТУЗ-ийн 2018.01.25-ны өдрийн 2018/01 дугаар тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам" болон МХБ-ийн ТУЗ-ийн 2012.02.10-ны өдрийн 02 тоот тогтоолоор батлагдсан "МХБ" ТӨХК-ийн "Арилжааны журам"-ын дагуу явагдана.

Бид хууль зүйн дүгнэлт гаргах зорилгоор Инвескороос түүний Гэрчилгээ, Дүрэм, Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолууд болон бидний хувьд шаардлагатай гэж үзсэн бусад бичиг баримтыг эх хувиар болон хуулбарыг гаргуулан авч, хууль зүйн үндэслэл болон мэдээллийг тулган шалгаж, судалсан болно. Түүнчлэн компанийн үйл ажиллагааны талаар шууд төрийн эрх бүхий байгууллагуудаас шаардлагатай гэж үзсэн хэндлэнгийн мэдээллийг гаргуулж судалсан болно.

"Инвескор ББСБ" ХХК
InvesCore
1116224289 @ 6060854
УЛААНБААТАР ХОТ



247

Бид ийнхүү судалгаа шинжилгээ (due diligence) хийж, дүгнэлт гаргахдаа (а) үнэт цаасны танилцуулгад тусгасан андеррайтер, аудитор, хөрөнгийн үнэлгээчний хийсэн судалгаа, дүгнэлт, тайлан, санхүүгийн мэдээлэл нь үнэн зөв, (б) бидэнд ирүүлсэн бүх бичиг баримтад дурдсан мэдээлэл үнэн, зөв; (в) тэдгээр баримт бичигт зурагдсан гарын үсэг, дарагдсан тамга, тэмдэг бодит, зөв; (г) бидэнд ирүүлсэн бичиг баримтуудын хуулбар нь тэдгээрийн эх хувьтай нийцсэн, бүрэн; (д) бидний судалж ашигласан бичиг баримтыг бэлтгэсэн болон түүнд гарын үсэг зурсан этгээд нь тийнхүү уг баримт бичгийг бэлтгэх, гарын үсэг зурах бүрэн эрхтэй гэж үзсэний үндсэн дээр, дүгнэлт гаргах өдрийн байдлаар хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн дор дурдсан хууль зүйн дүгнэлт гаргаж байна.

СЭХ 2019.04.24 БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2019-03-26 БҮРТГ...

## 1. [illegible]

"Инвескор ББСБ" ХХК нь Компанийн тухай хуулийн дагуу нэг гишүүн (Монгол Улсын иргэн Н.Нармандах РД: А362022114)-тэйгээр үүсгэн байгуулагдаж, 2016.03.30-ны өдөр улсын бүртгэлд бүртгэгдсэн байна. (Улсын бүртгэлийн дугаар: 9015003118, Регистрийн дугаар: 6060854) (Хавсралт 1.1)

Инвескорын 2017.03.10-ны өдрийн А/11 дугаар Хувьцаа эзэмшигчийн шийдвэр, 2017.03.10-ны өдрийн М/01 дугаар "Эс Ай Би Жэй Капитал" ХХК-ийн хувьцаа эзэмшигчийн шийдвэр, 2017.03.10-ны өдрийн "Компанийн хувьцаа болон эрх шилжүүлэх гэрээ"-ний дагуу Н.Нармандах нь өөрийн эзэмшлийн хувьцааны 60.71 хувийг "Эй Би Жей Эй капитал" ХХК-д шилжүүлсэн. Мөн Инвескорын 2017.10.06-ны өдрийн А/16 дугаар хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол, "Эй Ай Би Жей капитал" ХХК-ийн 2017.10.06-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр, 2017.10.03-ны өдрийн "Компанийн хувьцаа болон эрх шилжүүлэх гэрээ"-ний дагуу Н.Нармандах нь өөрийн эзэмшлийн хувьцааны 39.29 хувийг "Эй Би Жей Эй капитал" ХХК-д шилжүүлснээр Инвескорын цорын ганц хувьцаа эзэмшигч нь "Эй Би Жей Эй капитал" ХХК болсон байна.

Инвескор нь 2019.02.26-ны өдрийн гэрчилгээ (Хавсралт 1.2), 2019.01.31-ний өдөр баталж, 2019.02.26-ны өдөр улсын бүртгэлд бүртгүүлсэн Инвескор ББСБ ХХК-ийн дүрэм (Хавсралт 1.3)-д тусгаснаар зээлийн үйл ажиллагаа, факторингийн үйлчилгээ үзүүлэх, богино хугацаат [illegible] эрхлэхээр заасан байна.

Инвескор нь "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай" хуулийн 10.1.1, 15, 15.3.1, "Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай" хуулийн 9.1-д заасны дагуу Санхүүгийн Зохицуулах Хорооны 2016.05.17-ны өдрийн 159 дугаар тогтоолоор Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх 1/554 дугаар тусгай зөвшөөрөл (Хавсралт 1.4), 2018.01.10-ны өдрийн 17 дугаар тогтоолоор Банк бус санхүүгийн төлбөрийн баталгаа гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл (Хавсралт 1.5), мөн Санхүүгийн Зохицуулах Хорооны 2016.05.17-ны өдрийн 159 дугаар тогтоолоор Зээлийн үйл ажиллагаа, Факторингийн үйл ажиллагаа, Итгэлцлийн үйл ажиллагаа, Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх, Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл (Хавсралт 1.6) авсан байна.

Компани нь Монгол улсын Компанийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдаж, бүртгэгдсэн байна.

... CAPITAL LLC

"ИНВЕСКОР ББСБ" ХХК InvesCore NON BANKING FINANCIAL INSTITUTION 1116224289 6060854 УЛААНБААТАР ХОТ



248

СЗХ
2019.04.24
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2019-03-26
БҮРТГЭВ-02



2. [illegible]

Дүгнэлт гаргах өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж буй Инвескорын дүрмийн 12.1-д тус компанийн эрх бүхий албан тушаалтанд (i) ТУЗ-ийн гишүүн, (ii) гүйцэтгэх захирал, (iii) дэд захирал, (iv) газрын захирал, (v) ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нарыг тодорхойлсон байна. Компанийн тухай хуулийн 84-р зүйлийн 84.2, 84.3 дахь заалт болон Инвескорын дүрэмд үндэслэн тус компанийн эрх бүхий албан тушаалтан гэдэгт тус компанийн Хувьцаа эзэмшигч, компанийн ТУЗ-ийн дарга, гишүүд, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, Гүйцэтгэх захирал, Дэд захирал, Санхүүгийн захирал нарыг хамруулан авч үзлээ.

Инвескор-ын цорын ганц хувьцаа эзэмшигч "Эс Ай Би Жэй Капитал" ХХК нь "Компанийн тухай" хуулийн дагуу гурван хувьцаа эзэмшигч (Япон Улсын иргэн Кавазоа Такааки Паспортын дугаар: TR8201699; Монгол Улсын иргэн Баянмөнхийн Анхболд РД: ЧК80011134; Монгол Улсын иргэн Батбаярын Мөнх-Очир РД:ВЮ90031832)-тэйгээр үүсгэн байгуулагдаж, 2016.03 21-ний өдөр улсын бүртгэлд бүртгэгдсэн (Улсын бүртгэлийн дугаар: 9011739005; РД: 6057209) Монгол Улсын хуулийн этгээд (Хавсралт 2.1) юм.

"Эс Ай Би Жэй Капитал" ХХК-ийн 2018.10.04-ний өдрийн А/22 дугаар хувьцаа эзэмшигчийн хурлын тогтоолоор Инвескорын хувьцаа эзэмшигчийн эрх үүргийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх, хувьцаа эзэмшигчийн бүх шийдвэрийг Компанийн хувьцаа эзэмшигчийн нэрийн өмнөөс дангаар баталгаажуулж гарын үсэг зурж, шийдвэр гаргах [illegible] Баянмөнхийн Анхболдыг [illegible] байна (Хавсралт 2.2 болон Хавсралт 2.3). [illegible] "Эс Ай Би Жэй Капитал" ХХК болон Инвескор [illegible] бүрдэх эсвэл Компанийн хувьцаа эзэмшигчийн хурлаас хүчингүй болгох шийдвэр гаргах өдөр хүртэлх хугацаанд хүчинтэй байхаар зохицуулсан байна.

Инвескор-ын Хувьцаа эзэмшигчийн 2018.10.04-ний өдрийн А/24 дугаартай шийдвэр (Хавсралт 2.3)-аар тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид "ТУЗ" гэх) нь дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулагдан ажиллаж байна:

1. ТУЗ-ийн дарга Баянмөнхийн Анхболд, 2004 онд Япон Улсын Рицумейкан Азиа Пасифик их сургуулийг бизнесийн удирдлага чиглэлээр төгссөн. 2006-2012 оны хооронд "Абим Консалтинг" ХХК-д бизнесийн ахлах зөвлөхөөр, 2012-2015 оны хооронд "Шунхлай групп"-д хүний нөөцийн карьер төлөвлөлт хариуцсан захирал, дэд ерөнхийлөгчөөр тус тус ажиллаж байсан туршлагатай бөгөөд 2016.05 сараас өдрөөс одоог хүртэл Инвескорын дэд захирлаар ажиллаж байна (Хавсралт 2.4).
2. ТУЗ-ийн гишүүн Далайжамцын Баясгалан, 2001 онд Монгол Улсын Их сургуулийг эдийн засагч, эдийн засгийн онолын багш чиглэлээр төгссөн. 2001-2010 оны хооронд Худалдаа Хөгжлийн банкинд хөрөнгө зохицуулалтын газарт дилер, эдийн засагч, санхүүгийн газрын ахлах мэргэжилтнээр, 2015 онд Монгол банкны төслийн менежерээр тус тус ажиллаж байсан туршлагатай бөгөөд 2016 оноос одоог хүртэл Инвескорын Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна (Хавсралт 2.5).



TDB CAPITAL LLC

Invescore

менежерээр тус тус ажиллаж байсан туршлагатай бөгөөд 2016 оноос одоог хүртэл Инвескорын Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна (Хавсралт 2.5).

3. ТУЗ-ийн гишүүн Равжирын Мөнхтөр, 2001 онд МУИС-ийн Эдийн засгийн их сургуулийг Эдийн засагч – эдийн засгийн онолын багшаар суралцаж төгссөн. 2001-2003 оны хооронд Сэрүүлэг дээд сургуульд багшаар, 2003-2005 оны хооронд Худалдаа Үйлдвэрлэлийн Дээд сургуульд багшаар, 2005-2016 оны хооронд Монгол Улсын Их сургуульд багшаар, 2011-2016 оны хооронд Монгол Улсын хөгжлийн банкинд багшаар тус тус ажиллаж байсан туршлагатай бөгөөд 2016 оноос одоог хүртэл Инвескорын байгууллагын банк хариуцсан захирлаар ажиллаж байна (Хавсралт 2.6).

4. ТУЗ-ийн хараат бус гишүүн Чулуундоржийн Хашчулуун, 1989 онд ОХУ-ын Ломоносовын нэрэмжит Москвагийн их сургуулийг эдийн засагч, улс төрийн эдийн засгийн онолын багш чиглэлээр бакалавр зэрэгтэйгээр, 1996 онд Япон Улсын Йокохома хотын их сургуулийг эдийн засгийн ухааны магистр зэрэгтэйгээр, 2003 онд Япон Улсын Кеио Их сургуулийг эдийн засгийн ухааны доктор зэрэгтэйгээр тус тус суралцаж төгссөн. 2004-2009 оны хооронд Монгол Улсын их сургуулийн Эдийн засгийн сургуулийн захирлаар, 2009-2012 оны хооронд Засгийн газрын тохируулагч агентлагийн Үндэсний хөгжлийн Шинэтгэлийн хорооны даргаар, 2013-2016 оны хооронд Бизнес Эдийн засгийн сургуулиудын консорциумын гүйцэтгэх захирлаар тус тус ажиллаж байсан туршлагатай бөгөөд 2016 оноос одоог хүртэл Монгол Улсын Их сургуулийн Эдийн засгийн тэнхмийн дэд профессороор болон Монгол банкны Мөнгөний бодлогын гишүүнээр ажиллаж байна (Хавсралт 2.7).

5. ТУЗ-ийн гишүүн Япон Улсын иргэн Намики Хирохито, 1992 онд Япон Улсын Кейо их сургуулийн эдийн засгийн ухааны бакалавр зэрэгтэйгээр, 2005 онд АНУ-ын Рочестар их сургуулийг эдийн засгийн болон бизнесийн удирдлагын магистр зэрэгтэйгээр тус тус суралцаж төгссөн. Мөн АНУ-ын Вашингтон хотын Нягтлан бодох бүртгэлийн CPA зэрэгтэй. 1992-2014 оны хооронд Мицубиши ЮФЖ Итгэлийн банкинд санхүүгийн зөвлөх, компанийн стратеги хариуцсан ажилтнаар ажиллаж байсан туршлагатай бөгөөд 2014 оноос одоог хүртэл "Эс Ай Би Эй ФЖ" ХХК-ийн үүсгэн байгуулагч, компанийн стратеги хууль эрх зүйн асуудлыг хариуцаж ажиллаж байна (Хавсралт 2.8).

6. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Отгонсүхийн Уянга, 2010 онд Шихихутуг Хууль зүйн их сургуулийг бизнесийн эрх зүйч мэргэжлээр бакалавр зэрэгтэйгээр, Монгол Улсын их сургуулийн хууль зүйн сургуулийг хууль зүйн ухааны магистр зэрэгтэйгээр төгссөн. 2011-2012 оны хооронд Чимид энд ассошэйтс ХХН-д хуульчаар, 2012-2018 оны хооронд "Шунхлай групп" ХХК-д хуулийн зөвлөхөөр тус тус ажиллаж байсан туршлагатай бөгөөд 2018 оноос одоог хүртэл Инвескорын ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар ажиллаж байна (Хавсралт 2.9).

Инвескорын Гүйцэтгэх захирал Д.Баясгалан нь 2016.03.29-ний өдрийн 01 дугаартай Хувьцаа эзэмшигчдийн шийдвэр (цаашид "ХЭХ" гэх) (Хавсралт 2.10)-ээр томилогдон ажиллаж байгаа бөгөөд Инвескорын хувьцаа эзэмшигч, тухай үеийн цорын ганц хувьцаа эзэмшигч, ТУЗ-ын дарга Н.Нармандах EA16032501 дугаар "Хөдөлмөрийн контракт"-г

2016.03.25-ны өдөр түүнтэй байгуулсан байна. 2019.01.02-ны өдрийн А/40-Т тоот ТУЗ-ийн хурлын тогтоолоор Гүйцэтгэх захирлыг дахин томилсон ба ТУЗ-ийн дарга Б.Анхболд гүйцэтгэх захиралтай 2019.01.02-ны өдөр Хөдөлмөрийн контракт (Хавсралт 2.10.1)-ыг шинэчлэн байгуулсан байна.

Санхүүгийн захирал Р.Пүрэв нь 2017.12.22-ны өдрийн В/66 дугаартай Гүйцэтгэх захирлын тушаал (Хавсралт 2.11)-аар томилогдон ажиллаж байна.

Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг хариуцан зохион байгуулж байгаа эрх бүхий албан тушаалтнуудын ур чадвар, дадлага туршлагын байдлыг авч үзвэл:

1. Гүйцэтгэх захирал Д.Баясгалан (*дээрхээс танилцана уу*).
2. Дэд захирал, Байгууллагын банк хариуцсан захирал Р.Мөнхтөр (*дээрхээс танилцана уу*).
3. Санхүүгийн захирал Ралгаагийн Пүрэв нь 2002 онд МУИС-ийг нягтлан бодох бүртгэл, эдийн засгийн чиглэлээр бакалавр зэрэгтэй, 2011 онд Япон Улсын Олон улсын их сургуулийг санхүүч мэргэжлээр магистр зэрэгтэй төгссөн. 2002 онд Голомт банкинд туслах дилерээр, 2003-2009 оны хооронд Сангийн яаманд мэргэжилтнээр, 2011-2016 оны хооронд Оюу толгой ХХК-д аудитороор ажиллаж байгаад 2017 оноос оноос одоог хүртэл Инвескорын Санхүү эрхэлсэн захирлаар ажиллаж байна (Хавсралт 2.13).

Компанийн Гүйцэтгэх захирал, эрх бүхий албан тушаалтнууд нь Компанийн тухай хууль болон Компанийн засаглалын кодекст заасан эрх бүхий албан тушаалтны шаардлагыг хангаж байгаа эсэхийг дараах хүснэгтээр авч үзвэл:

| КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАНД ТАВИГДАХ ШААРДЛАГА | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| **№** | **Нэрс/Шаардлага** | **Боловсролын зэрэг, Мэргэжил** | **Ял шийтгэл эдэлж байгаа эсэх (КтХ-ийн 84.3.2)*** | **Компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан эсэх (КтХ-ийн 75.8)** | **Хувь хүн байх (КтХ-ийн 77.3, 83.2, 83.3)** | **Нийт ажилласан жил/Үүнээс Инвескорад** |
| 1. | **Б.Анхболд** (ТУЗ-ийн дарга) | Бизнесийн удирдлага/ Магистр | Үгүй* | Тийм /2016.08.25-ны өдөр, Дугаар 0930282/ Хавсралт 2.14 | Тийм | 13/3 |
| 2. | **Р.Мөнхтөр** (ТУЗ-ийн гишүүн) | Эдийн засагч/ Магистр | Үгүй* | Тийм /2012.11.30-ны өдөр, Дугаар 0131037/ Хавсралт 2.15 | Тийм | 19/3 |
| 3. | **Д.Баясгалан** (Гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн гишүүн) | Эдийн засагч/ Бакалавр | Үгүй* | Тийм /2016.08.25-ны өдөр, Дугаар 0930283/ Хавсралт 2.16 | Тийм | 18/3 |
| 4. | **Ч.Хашчулуун** (ТУЗ-ийн хараат бус гишүүн) | Эдийн засагч/ Доктор | Үгүй* | Тийм /2014.09.06-ны өдөр, Дугаар 1030024/ | Тийм | 30/3 |

СЭХ 2019 .04. 24 өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2019 -03- 26 БҮРТГЭВ-02



| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | Хавсралт 2.17 | | |
| 5. | **Намико Хирохито** (ТУЗ-ийн гишүүн) | Эдийн засагч/ Бакалавр Бизнесийн удирдлага/ Магистр | Үгүй* | - | Тийм | 27/3 |
| 6. | **О.Уянга** (ТУЗ-ийн нарийн бичгийн дарга) | Эрх зүйч/ Магистр | Үгүй* | Тийм /2013.01.18-ны өдөр/ Хавсралт 2.18 | | 8/2 |
| 7. | **Р.Пүрэв** (Санхүүгийн захирал) | Эдийн засагч/ Магистр | Үгүй* | Тийм /2016.08.25-ны өдөр, Дугаар 0930284/ Хавсралт 2.19 | Тийм | 15/3 |

* Монгол Улсын Хууль зүйн сайдын 2013.01.31-ний өдрийн А/12 тоот тушаалын 4 дүгээр хавсралтад заасны дагуу Ял шийтгэлэй эсэх лавлагааг өмгөөллийн нөхөрлөлд олгодоггүй тул Компанийн тухай хуулийн 84.3.2-т заасан ял шийтгэлгүй эдлээгүй байх шаардлагыг ТУЗ-ийн гишүүд, нарин бичгийн дарга, гүйцэтгэх захирал хангаж байгаа эсэхийг тэдний гаргаж өгсөн мэдүүлэг, баталгааг үндэслэж дүгнэв.

Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүд нь Компанийн тухай хууль болон Компанийн засаглалын кодекст заасан ТУЗ-ийн хараат бус гишүүнд тавих нэмэлт шаардлагыг хангаж байгаа эсэхийнг дараа хүснэгтээр авч үзвэл:

| **ТУЗ-ийн хараат бус гишүүнд тавигдах нэмэлт шаардлага** | | |
|---|---|---|
| **№** | **Шаардлага** | **ТУЗ-ийн хараат бус гишүүдийн нэр** |
| | | **Ч.Хашчулуун** |
| 1. | Өөрөө эсхүл компанийн нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн энгийн хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшдэггүй байх (КтХ-ийн 79.1.1) | Тийм** |
| 2. | Өөрөө эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд нь компанид болон компани оролцогч нь болж байгаа компанийн нэгдлийн бусад оролцогчид ажил, албан тушаал эрхэлдэггүй, сүүлийн 3 жилийн хугацаанд аливаа ажил, албан тушаал эрхэлж байгаагүй байх (КтХ-ийн 79.1.2, КЗК-ийн 5.2.4) | Тийм** |
| 3. | Төрийн үйлчилгээнийхээс бусад төрийн алба хашдаггүй байх (КтХ-ийн 79.1.3) | Тийм** |
| 4. | Компанитай бизнесийн гэрээ хэлцэл байгуулаагүй байх, тийм холбоогүй байх (КтХ-ийн 79.1.4) | Тийм** |
| 5. | Сүүлийн 5 жилд компанид нэгдмэл сонирхолтой этгээд болж байгаагүй байх (КЗК-ийн 5.2.4) | Тийм** |
| 6. | Компани эсхүл түүний нэгдмэл сонирхолтой этгээдтэй зөвлөх үйлчилгээ үзүүлдэггүй байх (КЗК-ийн 5.2.4) | Тийм** |
| 7. | Компани эсхүл түүний нэгдмэл сонирхолтой этгээдтэй ханган нийлүүлэгч ба харилцагч биш байх (КЗК-ийн 5.2.4) | Тийм** |
| 8. | Компани эсхүл түүний нэгдмэл сонирхолтой этгээдтэй үйлчилгээ үзүүлэх гэрээ хийгээгүй байх (КЗК-ийн 5.2.4) | Тийм** |
| 9. | Компанийн ТУЗ, гүйцэтгэх захирал болон гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн, дотоод аудитын ажилтны нэгдмэл сонирхолтой этгээд биш байх (КЗК-ийн 5.2.4) | Тийм** |
| 10. | Хувьцаа эзэмшигч эсхүл түүний нэгдмэл сонирхолтой этгээдийн ойрын хамаатан биш байх (КЗК-ийн 5.2.4) | Тийм** |

**Компанийн тухай хуулийн 79.1.1-79.1.4 зүйл, Компанийн засаглалын кодексийн 5.2.4-т заасан ТУЗ-ийн хараат бус гишүүнд тавигдах шаардлагыг тус компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүд хангаж байгаа эсэхийг тэдний гаргаж өгсөн мэдүүлэг, баталгааг үндэслэж дүгнэв

TDB CAPITAL LLC

"ИНВЕСКОР ББСБ" ХХК InvesCore NON-BANK FINANCIAL INSTITUTION УЛААНБААТАР ХОТ

СЭХ
2019.04.24
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН
MONGOLIAN STOCK
2019-03-26
БҮРТГЭВ



Инвескорын гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтнууд нь хууль болон Компанийн засаглалын кодекст заасан шаардлага хангасан бөгөөд компанийг удирдах чадвар, дадлага туршлагатай гэж дүгнэв.



CAPITAL LLC

"ИНВЕСКОР ББСБ" ХХК
InvesCore
NON-BANK FINANCIAL INSTITUTION
1118224289 6060854
УЛААНБААТАР ХОТ

## 3. Компанийн дүрэм бусад дотоод журмууд нь хууль тогтоомж, Хорооноос баталсан "Монголын компанийн засаглалын кодекс"-т нийцсэн эсэх

***Инвескорын дүрэм.*** Компанийн хувьцаа эзэмшигчийн 2019.01.31-ний өдрийн А/01 дүгээр шийдвэрээр Компанийн одоогийн мөрдөгдөж буй дүрэм (цаашид "**Дүрэм**" гэх)-ийг (Хавсралт 3.1) шинэчлэн баталсан байна. Дүрэм нь нийт 16 бүлэгтэй бөгөөд Компанийн эрх зүйн байдал, эрхэм зорилго, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлох, хувьцаа эзэмшигчид, Компанийн удирдлага, эрх бүхий албан тушаалтныг тодорхойлж, тэдний эрх, үүрэг хариуцлагыг тодорхойлох, компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд тавих хяналт, Компанийг өөрчлөн байгуулах, татан буулгахтай холбогдсон харилцааг зохицуулж байна.

Инвескор хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрэмд Компанийн тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан тусгагдвал зохих мэдээлэл бүрэн тусгагдсан бөгөөд Дүрмийн 1.3-т Компанийн оноосон нэрийг тусгасан, 3.3-т Компанийн эрхлэх үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлсон нь Компанийн тухай хуулийн 16.2.1, 16.2.6-д тус тус нийцсэн байна.

**Компанийн засаглалын журмууд**

***Инвескор-ын ногдол ашгийн бодлого.***

Компанийн ХЭХ нь хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчдын эрх ашиг, санхүүгийн тогтвортой үйл ажиллагааг хангах, хөрөнгө оруулах сонирхлыг хамгаалахаар Компанийн тухай хууль, Компанийн засаглалын Кодекст нийцүүлэн Компанийн жилийн ашгийг зөв зохистой хуваарилах зорилгоор нийт 4 бүлэгтэй "Ногдол ашгийн бодлого"-ыг 2019.02.04-ны өдрийн А/057 дугаар тогтоолын Хавсралт 3-р баталсан (Хавсралт 3.2) байна. Тус журамд Компанийн ногдол ашиг хуваарилах бодлогыг тодорхойлсноос гадна ногдол ашиг хуваарилах нөхцөл, ногдол ашиг төлөх хэлбэр, ногдол ашиг хуваарилах шийдвэр гаргах хугацаа, түүнд тусгах мэдээлэл, ногдол ашиг хуваарилах шийдвэр гарсан тохиолдолд авч хэрэгжүүлэх арга хэмжээ зэргийг зохицуулсан байна.

Тус журам нь Компанийн тухай хуулийн 46, 47 дугаар зүйлд заасан ногдол ашиг хуваарилах нөхцөл, журамд нийцсэнээс гадна тус хуулийн 76.1.12, Компанийн засаглалын кодексийн 2.2.2-т заасан компани ногдол ашгийн бодлоготой байх, ногдол ашиг тодорхойлох журамтай байх зэрэг шаардлагыг хангаж байна.

***Дотоод хяналтын журам***

Инвескорын үйл ажиллагаа, үзүүлж байгаа ажил, үйлчилгээ нь холбогдох хууль, журамд нийцэж байгаа эсэхэд хяналт тавьж, зөрчил, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хяналтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, байгууллагын үйл ажиллагааг сайжруулах талаар зөвлөмж гаргаж, хэрэгжилтийг хангуулах, зөрчил дахин давтагдахаас сэргийлэх, гэм буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх зорилгоор нийт 5 бүлэгтэй "Дотоод хяналтын журам"-ыг 2019.02.04-ны өдрийн А/057 дугаар тогтоолын Хавсралт 4-р баталсан (Хавсралт 3.3) байна. Тус журамд Компанийн дотоод хяналт хариуцсан алба/ажилтны эрх,



251

үүрэг, дотоод хяналтын үйл ажиллагаа, дотоод хяналтаар илэрсэн зөрчилд буруутай этгээдэд холбогдох хууль тогтоомж, ББСБ-ын дотоод журамд заасан хариуцлага ногдуулах зэрэг асуудлыг зохицуулсан байна.

***ТУЗ-ийн үйл ажиллагааны журмууд***

***ТУЗ-ийн үйл ажиллагааны журам.*** ТУЗ-ийн үндсэн чиг үүрэг, бүрэн эрх, ТУЗ-ийн гишүүнд гэр дэвшүүлэх этгээдэд тавигдах шаардлага, гишүүдийг сонгох журам, дахин нэр дэвших болзол, хараат бус гишүүний шалгуур үзүүлэлт, ТУЗ-ийн хурлын зарыг хүргэх, хуралд оролцох, санал өгөх, ТУЗ-ийн гишүүдийг мэдээллээр хангах журам, үүргээ зохих түвшинд хэрэгжүүлээгүй гишүүнд хүлээлгэх хариуцлага зэрэг ТУЗ-ийн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор нийт 11 бүлгээс бүрдсэн ТУЗ-ийн үйл ажиллагааны дүрэм (Хавсралт 3.4)-ийг 2019.02.04-ний өдрийн хурлын А/07-Т тоот тогтоолоор баталсан байна.

***Аудитын хорооны журам.*** Инвескорын ТУЗ нь Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх, дотоод хяналт, үйл ажиллагаа болон эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, санхүү, эдийн засгийн байдалд хяналт тавих үйл ажиллагааг зохицуулах зорилгоор 2019.02.04-ний өдрийн хурлын А07-Т тоот тогтоолын Хавсралт 2-р Хавсралтаар нийт 7 бүлгээс бүрдсэн Аудитын хорооны журам (Хавсралт 3.5)-ыг баталсан байна. Мөн дээрх тогтоолоор тус хорооны даргаар ТУЗ-ийн гишүүн Хирохито Намики, хорооны гишүүдээр ТУЗ-ийн хараат бус гишүүн Ч.Хашчулуун, ТУЗ-ийн дарга Б.Анхболдыг нарыг тус тус томилсон байна.

***Эрсдэлийн удирдлагын хороо.*** Компанийн эрсдэлийн удирдлагыг тодорхойлох, эрсдэлийг тодорхойлох, эрсдэлийн хяналтын тогтолцоо, үйл ажиллагаанд хяналт тавих үйл ажиллагааг зохицуулах зорилгоор 2019.02.04-ний өдрийн хурлын А07-Т тоот тогтоолын 5-р Хавсралтаар нийт 7 бүлгээс бүрдсэн Эрсдэлийн бодлого (Хавсралт 3.6)-ыг баталсан байна. Дээрх тогтоолоор тус хорооны даргаар Б.Анхболдыг, хорооны гишүүдээр ТУЗ-ийн гишүүн Д.Баясгалан, Р.Мөнхтөр нарыг тус тус томилсон байна.

***Нэр дэвшүүлэх хорооны журам.*** ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүн болон Гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчид тавих шаардлагыг тодорхойлох, тухайн шаардлагад нийцэж байгаа эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгөх, ТУЗ болон гүйцэтгэх удирдлагыг сонгохтой холбоотой үйл ажиллагааг зохицуулах зорилгоор 2019.02.04-ний өдрийн хурлын А07-Т тоот тогтоолын 4-р Хавсралтаар нийт 7 бүлгээс бүрдсэн Нэр дэвшүүлэх хорооны журам (Хавсралт 3.7)-ыг баталсан байна. Дээрх тогтоолоор тус хорооны даргаар ТУЗ-ийн дарга Б.Анхболдыг, хорооны гишүүдээр ТУЗ-ийн гишүүн Хирохито Намики, Д.Баясгалан нарыг тус тус томилсон байна.

***Цалин урамшууллын хорооны журам.*** Компанийн ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх захирал, эрх бүхий албан тушаалтанд олгох цалин, урамшууллын дээд хязгаарыг тогтоох, тогтоосон хэмжээнд багтаан цалин урамшуулал олгох санал боловсруулах үйл ажиллагааг зохицуулах зорилгоор 2019.02.04-ний өдрийн хурлын А07-Т тоот тогтоолын 3-р Хавсралтаар нийт 7 бүлгээс бүрдсэн Цалин, урамшууллын хорооны журам (Хавсралт 3.8)-г баталсан байна. Дээрх тогтоолоор тус хорооны даргаар ТУЗ-ийн дарга Б.Анхболд,

2019.04.24
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ



хорооны гишүүдээр ТУЗ-ийн гишүүн Хирохито Намики, Д.Баясгалан нарыг тус тус томилсон байна.

Дээрх ТУЗ-ийн үйл ажиллагаатай холбоотой дүрэм, журмуудыг Компанийн ТУЗ баталсан нь Компанийн тухай хуулийн 76.1.13-т нийцэж байна. Мөн Компанийн тухай хууль болон Компанийн засаглалын кодекст нийцэж байна.

Түүнчлэн IPO амжилттай болсны дараа зохион байгуулагдах Хувьцаа эзэмшигчдийн анхны хурлаар хэлэлцэн батлуулах зорилгоор Инвескор нь Хувьцаат компанийн дүрэм (Хавсралт 3.9 болон Хавсралт 8.1)-ийн төслийг боловсруулж, Хувьцаа эзэмшигчийн шийдвэрээр сайшаасан байна. Мөн IPO амжилттай болсны дараа хийх ХК-ийн анхны ТУЗ сонгогдсоны дараа зохион байгуулагдах ТУЗ-ийн анхны хурлаар батлуулах зорилгоор "Сонирхлын зөрчлийг зохицуулах, сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл хийх журам" (Хавсралт 3.9.1), "Мэдээллийн үйл ажиллагааны журам" (Хавсралт 3.9.1.1)-ын төслийг боловсруулж, Инвескорын ТУЗ-ын хурлаар сайшаасан тогтоол гаргасан байна. Эдгээр дүрэм, журмын төслүүд нь цаашид энэхүү найруулгаараа батлагдана гэж үзвэл Компанийн тухай зэрэг Монгол Улсын хуулиуд, СЗХ-ны журам, Компанийн засаглалын кодекст нийцсэн байна.

**Хөдөлмөрийн дотоод журмууд**

***Хөдөлмөрийн дотоод журам.*** Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 2019.01.02-ны өдрийн А/01-Т тоот шийдвэрийн Хавсралт 1-ээр Инвескорын жигд үйл ажиллагааг хангах, нийт ажилтнуудын хөдөлмөрийн оновчтой, үр ашигтай зохион байгуулах, хөдөлмөрийн сахилга батыг бэхжүүлэх, ажлын цагийг үр ашигтай ашиглах, ажиллах нөхцөлийн хангах, ажил олгогч болон ажилтны эрх үүрэг, хариуцлагыг тодорхойлохтой холбогдох харилцааг зохицуулах зорилгоор нийт 13 бүлгээс бүрдсэн Хөдөлмөрийн дотоод журам (Хавсралт 3.10) батлан мөрдүүлж байна. Энэ журмаар хөдөлмөрийн удирдлага, зохион байгуулалт, хөдөлмөрийн гэрээ байгуулах нөхцөл, журам, ажил олгогч болон ажилтны эрх, үүрэг, ажлын цаг, амралтын хугацааны горим, чөлөө олгох, ажилтны цалин хөлс урамшууллын тогтолцоо, тэтгэмж дэмжлэг олгох нөхцөл журам, албан тушаал өөрчлөх нөхцөл, хөдөлмөрийн сахилгын шийтгэлийн төрөл, сахилга зөрчигсдөд хүлээлгэх хариуцлага, ажил хүлээлцэх үйл ажиллагаа, хөдөлмөрийн гэрээг цуцлах үндэслэл, журам, хөдөлмөрийн гэрээг ажил олгогчийн санаачилгаар цуцлах үйл ажиллагааг зохицуулсан байна.

Энэхүү журам нь Хөдөлмөрийн тухай хуулийн 80.2, 130.1-д заасан шаардлагад нийцсэн байна.

***Ажиллагсдын цалин, хангамж, урамшууллын журам.***

Инвескорын ТУЗ-ийн 2019.01.02-ны өдрийн хурлын А/01-Т тоот Тогтоолын Хавсралт 2-ээр Инвескорын хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр ажиллаж байгаа ажилтны цалин, хангамж, урамшуулал, тэтгэлэг, нийгмийн халамжтай холбоотой харилцааг зохицуулах зорилгоор нийт 8 бүлгээс бүрдсэн журмыг (Хавсралт 3.11) батлан мөрдүүлж байна. Энэхүү журам нь цалин, хангамж, бонус, тэтгэлэг, нийгмийн халамжийн тодорхойлолт



TDB CAPITAL LLC



"ИНВЕСКОР ББСБ" ХХК
InvesCore
1116224289 6060854
УЛААНБААТАР ХОТ

болон түүнийг олгох нөхцөл, журмыг зохицуулсан. Тус журамд ТУЗ-ийн 2019.01.02-ны өдрийн хурлын А/01-Т тоот тогтоолын Хавсралт 2-р нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Энэхүү журам нь Хөдөлмөрийн тухай хууль болон Компанийн тухай хуульд нийцэж байна.

***Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх үйлчилгээний журам.*** Инвескорын хувьцаа эзэмшигчдийн хурлын 2016.04.25-ны өдрийн А/02 тоот шийдвэрийн Хавсралт 9-өөр Инвескорын үзүүлэх хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх үйлчилгээтэй холбоотой харилцаа зохицуулах зорилгоор нийт 8 бүлгээс бүрдсэн журмыг (Хавсралт 3.12) батлан мөрдүүлж байна. Энэхүү журам нь хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээрх зөвлөгөө мэдээлэл өгөх үйлчилгээний төрөл, зөвлөгөө мэдээлэл өгөх үйлчилгээний зохион байгуулалт, мэдээллийн сан, ёс зүй ба сонирхлын зөрчил, мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах, хяналт хариуцлагын үйл ажиллагаа зохицуулсан.

Энэхүү журам нь Иргэний хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн хуульд нийцэж байна.

***Эрсдэлийн удирдлагын бодлого.*** Инвескорын хувьцаа эзэмшигчдийн хурлын 2016.04.25-ны өдрийн А/02 тоот шийдвэрийн Хавсралт 6-аар үндсэн үйл ажиллагаанд учирч болох эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, урьдчилан сэргийлэх, бууруулах, хянах замаар хүлээж болзошгүй алдагдлыг бууруулах, тогтвортой тасралтгүй ажиллагаа хангах эрсдэлийн удирдлагын тогтолцоог бий болгож хэрэгжүүлэх зорилгоор нийт 11 бүлгээс бүрдсэн бодлогыг (Хавсралт 3.13) батлан хэрэгжүүлж байна. Энэхүү журам нь эрсдэлийн удирдлагын бодлогын зорилт, зарчим, эрсдэлийн төрөл, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх үе шат, эрсдэлийн удирдлагын бүтэц, зохион байгуулалт, зээлийн эрсдэлийн удирдлага, зах зээлийн эрсдэлийн удирдлага, үйл ажиллагааны эрсдэлийн удирдлага, хөрвөх чадварын эрсдэлийн удирдлага, эрсдэлийн удирдлагын тайлагнал, түүний хяналт хариуцлагыг зохицуулсан байна.

Энэхүү журам нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн зарчимд нийцэж байна.

***Факторингийн үйл ажиллагааны журам.*** Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2019.02.18-ны өдрийн В/186 тоот шийдвэрийн Хавсралт 2-оор факторингийн үйл ажиллагааг удирдах, үр дүнтэй зохион байгуулах, хяналт тавих, факторингийн үйл ажиллагааны ерөнхий зарчмуудыг тодорхойлохтой холбоотой журмыг (Хавсралт 3.14) батлан мөрдүүлж байна. Энэхүү журам нь факторингийн үйл ажиллагаанд мөрдөх зарчим, ажилтны ёс зүй, хүлээх хариуцлага, факторингийн үйлчилгээний хүсэлт судлах ажиллагаа, факторингийн үйлчилгээ үзүүлэх авлагын шаардлага, авлагын үнэлгээ, факторингийн үйлчилгээний хүсэлт шийдвэрлэх, факторингийн үйлчилгээ үзүүлэх, харилцагч болон үүрэг гүйцэтгэгчийн бүрдүүлэх баримт бичиг, факторингийн үйл ажиллагааг ББСБ-ын нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт хариуцлагыг зохицуулсан байна.

***Итгэлцлийн үйлчилгээний журам.*** Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2019.02.18-ны өдрийн B/186 тоот шийдвэрийн Хавсралт 5-аар итгэлцлийн үйлчилгээний хэлбэрийг тодорхойлох, тус үйлчилгээнд оролцогчдын эрх ашгийг хамгаалах, тэдгээрийн хоорондын харилцааг зохицуулах, хяналт тавих, итгэлцлийн үйлчилгээ эрхлэхэд учирч болзошгүй санхүү, төлбөрийн чадварын эрсдэлээс сэргийлэх, үйлчилгээг боловсронгуй болгох зорилгоор нийт 7 бүлгээс бүрдсэн журмыг (Хавсралт 3.15) батлан мөрдүүлж байна. Энэхүү журам нь итгэлцлийн үйлчилгээний зарчим, итгэмжлэгч болон итгэмжлэгдэгчийн эрх, үүрэг, хяналт хариуцлагын талаар зохицуулсан байна.

Итгэлцлийн үйлчилгээний журам нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль болон СЗХ-ны 2016.03.11-ний өдрийн 71 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журамд заасан зарчимд нийцэж байна.

***Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай журам.*** Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2019.02.18-ны өдрийн B/186 тоот шийдвэрийн Хавсралт 1-ээр мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх хууль бус үйл ажиллагааны үүсч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хяналт тавих, энэхүү журмыг зөрчигсдөд ногдуулах, хариуцлагыг тодорхойлохтой холбоотой харилцааг зохицуулах зорилгоор нийт 3 бүлгээс бүрдсэн журмыг (Хавсралт 3.16) батлан мөрдүүлж байна. Энэхүү журам нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг зөрчөөгүй байна.

***Богино хугацааны санхүүгийн хэрэгслүүдэд хөрөнгө оруулах журам.*** Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2019.02.18-ны өдрийн B/186 тоот шийдвэрийн Хавсралт 3-аар ашиг олох, санхүүгийн эрсдэлийг бууруулах, хөрөнгийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх, ББСБ-ын мөнгөн урсгалыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор богино хугацааны санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх, түүнийг борлуулахтай холбоотой харилцааг зохицуулах зорилгоор нийт 6 бүлгээс бүрдсэн журмыг (Хавсралт 3.17) батлан мөрдүүлж байна. Энэхүү журам нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн тухай хуульд нийцэж байна.

***Зээлийн хорооны үйл ажиллагааны журам.*** Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2016.04.25-ны өдрийн A02 тоот шийдвэрийн Хавсралт 4-өөр зээлийн хорооны эрхлэх үйл ажиллагаа, бүтэц бүрэлдэхүүн, гишүүдийг сонгох, хорооны хуралдаан, гишүүдийн үүрэг хариуцлагатай холбоотой харилцааг зохицуулах зорилгоор нийт 9 бүлгээс бүрдсэн журмыг (Хавсралт 3.18) батлан мөрдүүлж байна. Энэхүү журам нь зээлийн хорооны үйл ажиллагаа, зээлийн хорооны эрх хэмжээ, тус хорооны бүтэц, бүрэлдэхүүн, хорооны гишүүдийг томилох, чөлөөлөх, хорооны даргын эрх үүрэг, хорооны хуралдааны үйл ажиллагааг зохицуулсан байна.

Энэхүү журам нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн зарчимд нийцэж байна.

***Байгууллагын автомашин ашиглах журам***

Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2017.02.01-ний өдрийн А/10 тоот шийдвэрийн Хавсралт 2-оор Инвескорын өмчлөлийн автомашиныг байгууллагын хэрэгцээнд ашиглах, өмчлөх, ашиглалттай холбоотой харилцааг зохицуулах зорилгоор нийт 5 бүлгээс бүрдсэн журмыг (Хавсралт 3.19) батлан мөрдүүлж байна. Энэхүү журам нь байгууллагын автомашин ашиглахад баримтлах зарчим, ажилтны автомашин ашиглахтай холбоотой үүрэг хариуцлага болон хориглох зүйл, хяналт хариуцлагыг зохицуулсан байна.

***Тамга, тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх журам***

Гүйцэтгэх захирлын 2017.09.06-ны өдрийн В/41 тоот тушаалын хавсралтаар Инвескорын тамга, тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, устгах, хадгалах болон ББСБ-ын салбарын тамга хэрэглэхтэй холбоотой харилцааг зохицуулах зорилгоор нийт 5 бүлгээс бүрдсэн журмыг (Хавсралт 3.20) батлан мөрдүүлж байна. Энэхүү журам нь тамга, тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, тамга, тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэх, тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудасны хадгалалт, хамгаалалттай холбоотой харилцааг зохицуулсан байна.

***Түлхүүр ажилтны хуримтлалын сангийн тухай журам***

ТУЗ-ийн 2018.07.01-ний өдрийн хурлын А/26 тоот тогтоолын хавсралт 1-ээр Инвескортой хөдөлмөрийн болон контракт гэрээний үндсэн дээр ажиллаж байгаа түлхүүр ажилтныг урт хугацаанд тогтвор суурьшилтай ажиллуулах, тэдгээрийн нийгмийн хангамжийн асуудлыг дэмжих зорилгоор ажиллагсдын хуримтлалын сан бий болгох, түүнтэй холбоотойгоор Инвескор болон ажиллагсдын хооронд үүсэх харилцааг зохицуулах зорилгоор нийт 11 бүлгээс бүрдсэн журмыг (Хавсралт 3.21) батлан мөрдүүлж байна. Энэхүү журам нь хуримтлалын сан үүсгэх, түүнийг тооцох нөхцөл журам, Инвескорын эрх, үүрэг, ажилтны эрх, үүрэг, хуримтлалын сангийн мөнгийг олгох журам, хуримтлалын сангаас гарах нөхцөлүүд зэргийг зохицуулсан байна.

***Инвескорын Ко-брэнд кредит картын үйл ажиллагааг зохицуулах журам***

Худалдаа хөгжлийн банк болон Инвескор нарын хооронд 2017.12.13-ны өдөр байгуулсан tdbm/333/2017 тоот Хамтарсан ко-брэнд кредит картын гэрээний хавсралт 4-өөр ХХБ болон Инвескор нарын хамтран гаргах “Инвескор кредит карт”, түүний бүртгэл, төлбөр тооцоо, карттай холбоотой хүү шимтгэл, хураамж, карт эзэмшигч болон кредит карт гаргахтай холбогдох талуудын харилцааг зохицуулах зорилгоор нийт 6 бүлгээс бүрдсэн журам (Хавсралт 3.23)-ыг батлан мөрдөж байна.

***Салбарын дүрэм.***

ТУЗ-ийн 2018.08.23-ны өдрийн А28 тогтоолоор батлагдсан, ТУЗ-ийн 2019.01.02-ны өдрийн А02-Т тоот тогтоолын хавсралтаар нэмэлт өөрчлөлт оруулсан Салбарын дүрэм (Хавсралт 3.24)-ийг загвар байдлаар хянасан. Уг дүрмээр салбарын эрхлэх үйл ажиллагааны чиглэл, салбарын оршин байгаа газар, салбарыг өөрчлөн байгуулах, татан буулгах, салбарын үйл ажиллагаа, удирдлага, зохион байгуулалт, тэдгээрийн бүрэн эрх, үүрэг, тэдгээрт тавигдах хяналттай холбоотой харилцааг зохицуулсан нь Компанийн тухай хууль, Иргэний хуульд нийцэж байна.

СЗХ
2019 04. 24
БҮРТГЭВ
№ 01

MDSKhanLex

***Тусгай активын үйл ажиллагааны журам.*** Байгууллагын балансад бүртгэлтэй эрсдэлд орж болзошгүй болон эрсдэлд орсон зээлийг Тусгай активын албанд шилжүүлэх, Зээлийн эрсдэлийн сангаас хаах, тусгай активын албанд шилжсэн болон Зээлийн эрсдэлийн сангаас хаасан зээлийг төлүүлэхтэй холбоотой үйл ажиллагааг зохицуулах зорилгоор 2019.02.18-ны өдрийн Гүйцэтгэх захирлын В186 тоот тушаалын 8-р Хавсралтаар нийт 10 бүлгээс бүрдсэн Тусгай активын үйл ажиллагааны журам (Хавсралт 3.25)-г баталсан байна.

***Төлбөрийн баталгаа гаргах үйл ажиллагааны журам.*** Монгол Улсын нутаг дэвсгэрт гуравдагч этгээдэд аливаа төлбөрийн баталгаа гаргахтай холбоотой харилцааг зохицуулах зорилгоор 2019.02.18-ны өдрийн Гүйцэтгэх захирлын В186 тоот тушаалын 6-р Хавсралтаар нийт 7 бүлгээс бүрдсэн Төлбөрийн баталгаа гаргах үйл ажиллагааны журам (Хавсралт 3.26)-г баталсан байна.

Компанийн дүрэм, дотооддоо батлан мөрдүүлж байгаа болон ХК болж өөрчлөн байгуулагдсаны дараа батлахаар боловсруулсан журмууд нь холбогдох хууль тогтоомж, Компанийн засаглалын кодекст нийцэж байна.

TDB CAPITAL LLC



254

"ИНВЕСКОР ББСБ" ХХК
InvesCore
NON BANK FINANCIAL INSTITUTION
УЛААНБААТАР ХОТ

## 4. Бусадтай байгуулсан худалдан авах, бэлтгэн нийлүүлэх, зээлийн зэрэг үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд голлох ач холбогдолтой гэрээ нь хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх

Бид тус компаниас ирүүлсэн Инвескорын үйл ажиллагаанд голлох ач холбогдол бүхий дор дурдсан гэрээг хянасан болно.

***Зээлийн гэрээнүүд***

Инвескор Худалдаа Хөгжлийн Банк нарын хооронд 2017.09.13-ны өдөр байгуулсан ЗГ/RCC170911005-1 тоот Зээлийн эрх нээх гэрээ (Хавсралт 4.1)-ний дагуу Инвескор нь 250,000,000.00 төгрөгийн зээлийн эрхийг дараах нөхцөлөөр нээсэн байна. Үүнд:

- Зээлийн үндсэн хүү - сарын 2.10 хувь
- Нэмэгдүүлсэн хүү - зээл, хүүний эргэн төлөх хуваарийн дагуу төлөгдөөгүй зээлд ногдох хүүний 20.0 хувьтай тэнцэх хэмжээний
- Ашиглагдаагүй зээлийн эрхийн үлдэгдэл тооцох шимтгэл – жилийн 40 хувь (шимтгэлийг зээлийн болон зээлийн барьцаа, батлан даалтын гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш ажлын 3 хоногийн дараа тооцно)
- Зээлийн эрхийн хугацаа – 24 сар (2 жил)
- Инвескор барьцааны зүйлийг гуравдагч этгээдэд давхар барьцаалсан тохиолдолд давхар барьцаанд бүртгэгдсэний дараагийн өдрөөс зээлийн хүүг дахин нэмэлт гэрээ байгуулахгүйгээр дараах хүүнд шилжүүлнэ. Үүнд:
    - Зээлийн хүү (үндсэн болон хэтэрсэн хугацааны хүү) – жилийн 30 хувь, сарын 2.50 хувь

Дээрх гэрээтэй холбоотойгоор Эс Ай Би Жэй Капитал ХХК нь баталгаа гаргаж Худалдаа Хөгжлийн Банктай 2017.09.14-ний өдөр БГ/RCC170911005-1 тоот Баталгааны гэрээ (Хавсралт 4.2)-г Зээлийн гэрээний үүргийн биелэлтийг хангахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулах зорилгоор байгуулсан байна.

Мөн Намхайн Нармандах нь баталгаа гаргаж Худалдаа Хөжглийн Банктай 2017.09.14-ний өдөр БГ/RCC170911005-2 тоот Баталгааны гэрээг Зээлийн гэрээний үүргийн биелэлтийг хангахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулах зорилгоор байгуулсан байна.

Инвескор нь Худалдаа Хөгжлийн банктай 2018.04.23-ний өдөр байгуулсан ЗЭНГ/RCC170911005-1-1 тоот (Хавсралт 4.3), мөн 2018.07.29-ний өдөр байгуулсан ЗЭНГ/RCC170911005-1-2 тоот Зээлийн эрх нээх нэмэлт гэрээ (Хавсралт 4.4)-г тус тус байгуулсан байна.

Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Худалдаа Хөгжлийн банктай 2018.07.29-ний өдөр байгуулсан ЗЭНГ/RCC170911005-1-2 тоот Зээлийн эрх нээх нэмэлт гэрээгээр:

- Зээлийн эрхийн хэмжээ – 1,500,000,000.00 төгрөг
- Зээлийн эрхийн үндсэн болон хэтэрсэн хугацааны хүү – сарын 1.6 хувь
- Инвескор барьцааны зүйлийг гуравдагч этгээдэд давхар барьцаалсан тохиолдолд давхар барьцаанд бүртгэгдсэний дараагийн өдрөөс зээлийн хүүг дахин нэмэлт гэрээ байгуулахгүйгээр Зээлийн хүү (үндсэн болон хэтэрсэн хугацааны хүү) – жилийн 30.0 хувь, сарын 2.50 хувь байна.

Гэрээнд зээлийн дүн, үндсэн хүү, нэмэгдүүлсэн хүүгийн хэмжээ, зээлийн хугацаа, зориулалт, зээл төлөх хэлбэр, эргэн төлөлтийн хуваарь, зээлдэгч болон зээлдүүлэгчийн эрх, үүрэг, талуудын хүлээх хариуцлага, баталгаа ба зөвшөөрөл, гэрээ дуусгавар болох цуцлах нөхцөл, журам, маргаан шийдвэрлэх заалтуудыг тусгасан байх ба эдгээр нөхцөлүүд нь Иргэний хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.

***Даатгалын гэрээ***

Инвескор нь итгэлцлийн үйл ажиллагааны хүрээнд хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний дагуу мөнгөн хөрөнгөө байршуулсан харилцагчийн ашиг сонирхлыг учирч болзошгүй эрсдэлээс хамгаалуулах зорилгоор Монгол Даатгал ХХК-тай 2017.11.09-ний өдөр 90A1720000040 дугаар Хамтын ажиллагааны гэрээ (Хавсралт 4.5)-г 2 жилийн хугацаатайгаар байгуулсан байна.

Түүнчлэн Инвескор нь зээлдэгчийн барьцаалуулсан эд хөрөнгийг Монгол Даатгал ХХК (цаашид "Даатгагч" гэх)-д даатгуулж, даатгалын хураамжийг шилжүүлэх ба даатгагч нь гэрээнд заасан даатгалын тохиолдол бий болсон тохиолдолд Инвескорын барьцаа хөрөнгийг хамгаалж, даатгалын нөхөн төлбөрийг Инвескорд төлөх, даатгагч талаас Инвескорын ажлын байранд брошур, стэнд байршуулах, маркетингийн үйл ажиллагаа явуулах, ажилтан байршуулан ажиллуулах, мэдээлэл өгөх зэргээр талбай ашигласны төлбөр төлөх болон тэдгээртэй холбогдон үүсэх харилцааг зохицуулах зорилгоор Даатгагчтай 02 тоот Хамтран ажиллах гэрээ (Хавсралт 4.5.1)-г 2 жилийн хугацаатайгаар байгуулсан байна.

Дээрх Даатгалын гэрээнүүд нь Иргэний хууль, Даатгалын тухай хууль тогтоомжид нийцсэн байна.

***Үндсэн үйл ажиллагаатай холбоотой гэрээний загварууд:***

***Зээлийн гэрээний загвар:*** Инвескорын харилцагчидтай байгуулдаг зээлийн гэрээ (Хавсралт 4.6)-ээр Зээлдэгчид зээл олгох, түүний хугацаа, хүүгийн хэмжээг тогтоох, Зээлдэгчийн зүгээс түүний зарцуулалтад хяналт тавих, зээлийг эргэн төлөх болон тэдгээртэй холбоотой харилцааг зохицуулж байна.

СЗХ 2019 .04. 24 БҮРТГЭВ № 11

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2019 -03- 26 БҮРТГЭВ 02

MDSKhanLex

***Зээлийн эрх нээх гэрээний загвар:*** Зээлдүүлэгч, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай болон бусад хууль, тогтоомжид нийцүүлэн Зээлдүүлэгч болон зээлдэгчийн хооронд зээлийн эрх нээх, зээл олгох, түүний хугацаа, хүүгийн хэмжээг тогтоох, зээлийн зарцуулалтад Зээлдүүлэгчийн зүгээс хяналт тавих, зээлийг буцаан төлөх болон уг зээлтэй холбогдсон бусад харилцааг зохицуулах зорилгоор Зээлийн эрх нээх гэрээ (Хавсралт 4.7)-ний загвараар үйлчлүүлэгчидтэй гэрээ байгуулдаг байна.

***Зээлийн барьцааны гэрээний загвар:*** Зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг Барьцаалагч нь Барьцааны Зүйлээр тэргүүн ээлжинд хангуулах, Барьцаалуулагч нь Зээлийн Гэрээний үүргийг биелүүлэхийг баталгаа болгон Барьцааны Зүйлийг барьцаалуулах, Барьцааны Зүйлийн үнэлгээ, чанарыг тодорхойлох, Барьцааны Зүйлийг ашиглах, хамгаалах болон Зээлийн Гэрээний үүргийг Барьцааны Зүйлээр хангуулахтай холбоотой харилцааг зохицуулах зорилгоор Зээлийн барьцааны гэрээ (Хавсралт 4.8)-ний загвараар үйлчлүүлэгчидтэй гэрээ байгуулж байна.

***Батлан даалтын гэрээний загвар:*** Зээл, зээлийн хүү, нэмэгдүүлсэн хүү (цаашид хамтад нь "Зээл" гэх)-г Зээлийн Гэрээнд заасан хугацаанд төлж барагдуулахыг баталж, Зээлдэгч Зээлийн Гэрээний үүргээ гүйцэтгээгүй тохиолдолд Батлан даагч нь Зээлдэгчийн нэрийн өмнөөс ББСБ-ийн өмнө түүний Зээлийн Гэрээний үүргийг өөрийн эдийн болон эдийн бус эд хөрөнгөөр гүйцэтгэх болохыг баталж байгаатай холбоотой харилцааг зохицуулах зорилгоор Батлан даалтын гэрээ (Хавсралт 4.9)-ний загвараар үйлчлүүлэгчидтэй гэрээ байгуулж байна.

***Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний загвар:*** Итгэмжлэгдэгч нь Итгэмжлэгчийн хүсэлтээр мөнгөн хөрөнгийг үнэгүйдлээс хамгаалж, ашиг /үр шим/ олж өгөх зорилгоор итгэмжлэгчээс итгэмжлэгдэгчид шилжүүлсэн хөрөнгийг хадгалах, хянах, ашиглах, захиран зарцуулахтай холбоотойгоор талуудын эрх, үүргийг тодорхойлох, холбогдох харилцааг зохицуулах зорилгоор Итгэлцлийн гэрээ (Хавсралт 4.10)-ний загвар боловсруулан үйлчлүүлэгчидтэй гэрээ байгуулж байна.

***Эд хөрөнгө эзэмшил, өмчлөлд шилжүүлэх гэрээний загвар:*** Гэрээнд заасан хөдлөх эд хөрөнгүүдийг Үүрэг Гүйцэтгүүлэгчийн эзэмшил, өмчлөлд шилжүүлэх, Үүрэг Гүйцэтгэгч нь Зээлийн Гэрээнд заасан үүргээ зохих ёсоор хугацаанд нь гүйцэтгэсэн тохиолдолд уг эд хөрөнгийг Үүрэг Гүйцэтгүүлэгчид буцаан шилжүүлэх үүрэг хүлээх, Үүрэг Гүйцэтгэгч нь Зээлийн Гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд Үүрэг Гүйцэтгүүлэгч нь өмчлөлдөө шилжүүлэн авсан эд хөрөнгийг бодитоор Үүрэг Гүйцэтгэгчээс гаргуулан авахтай холбоотой харилцааг зохицуулж байна. Фидуцийн гэрээ (Хавсралт 4.11)-ний загвар нь Иргэний хуульд нийцэж байна.

***Хөдөлмөрийн харилцаатай холбоотой гэрээний загварууд:***

***Хөдөлмөрийн гэрээний загвар:*** (Хавсралт 4.12) Хөдөлмөрийн тухай хуулийн 21-р зүйлд заасан гэрээнд тусгах гол нөхцөлүүд болох ажлын байрны буюу албан тушаалын нэр, ажлын байрны тодорхойлтод заасан ажил, үүрэг, үндсэн цалин буюу албан тушаалын



TDB CAPITAL LLC

InvesCore

2019 .04. 24
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
2019 -03- 21



цалингийн хэмжээ, хөдөлмөрийн нөхцөлийг тусгасан бөгөөд Хөдөлмөрийн тухай хуульд нийцсэн байна.

***Эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээ:*** (Хавсралт 4.13) Хөдөлмөрийн тухай хуулийн 132, 135-р зүйлд заасан зохицуулалттай нийцэж байна.

***Нууц хадгалах гэрээ:*** (Хавсралт 4.14) Байгууллагын нууцын тухай хууль болон Хувь хүний нууцын тухай хуульд нийцэж байна.

***Домэйн нэр ашиглах, эрх шилжүүлэх гэрээ.*** Инвескор нь invescore.mn домэйн нэрийг ашиглах, төлбөр тооцоотой холбогдох харилцааг 2018.09.03-ны өдөр Монгол Улсын иргэн Э.Энэрэлтэй байгуулсан гэрээ (Хавсралт 4.15)-ээр зохицуулдаг байна. Дээрх гэрээний дагуу Энэрэл Инвескорд өөрийн эзэмшлийн домэйн нэрийг шилжүүлэхийг зөвшөөрч, Инвескор нь Мэйжикнет ХХК-д уг домэйн нэрийг бүртгүүлэхээр харилцан тохиролцсон.

***Оффисын талбайн түрээсийн гэрээ.*** Инвескор нь Сүхбаатар дүүрэг, 2-р хороо, Сөүл гудамж 10 1, Твин Тауэр барилгын 15 давхар барилгын 13 давхарын нийт 474 м.кв. бүхий оффисын зориулалттай талбайг сар бүр нийт 13,983,000 төгрөгийн түрээсийн төлбөртэйгөөр "Хурган Мөнх" ХХК-тай байгуулсан 2018.07.06-ны өдрийн гэрээ (Хавсралт 4.16)-гээр түрээслэн үйл ажиллагаа явуулж байна. Түрээсийн гэрээг 3 жилийн хугацаатайгаар байгуулсан ба тус гэрээ нь Иргэний хуульд нийцэж байна.

***Андеррайтерийн үйлчилгээний гэрээ.*** Инвескорын энгийн хувьцааг Санхүүгийн Зохицуулах Хороо болон Хөрөнгийн биржид бүртгүүлж, олон нийтэд нээлттэй арилжаалах үйл ажиллагаанд Андеррайтерийн үйлчилгээг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 41.4.3-т заасан хөрөнгө оруулагчид тухайн үнэт цаасыг танилцуулах замаар түүнийг худалдахад шаардлагатай бүх хүчин чармайлт гаргах нөхцөлөөр үзүүлэх, Инвескор нь хүлээн авсан үйлчилгээний хөлсийг гэрээнд заасны дагуу төлөхтэй холбоотой харилцааг зохицуулсан АҮГ-2019/01 дугаар бүхий "Андеррайтерийн үйлчилгээний гэрээ" (Хавсралт 4.17)-г 2019.01.02-ны өдөр "Инвескор Капитал ҮЦК" ХХК-тай байгуулсан. Мөн 2019.01.23-ны өдөр байгуулсан санамж бичгийн үндсэн дээр 2019.03.01-ны өдөр TDBC 107/2019, АҮГ-2019/02 дугаартай "Андеррайтерийн үйлчилгээний гэрээ" (Хавсралт 4.17.1)-г Үндсэн андеррайтер болох "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК, Туслах андеррайтер болох "Инвескор Капитал ҮЦК" ХХК-тай тус тус байгуулсан нь Монголын Хөрөнгийн Биржийн Үнэт цаасны бүртгэлийн журмын 2.1-д заасан шаардлагад нийцсэн байна.

***Аудитын үйлчилгээний гэрээ.*** Инвескор, "Инвескор Эй Ай Лаб" ХХК-ийн санхүүгийн байдлын тайлан, тайлант орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан болон мөнгөн гүйлгээний тайлангуудыг багтаасан санхүүгийн тайлангууд, эдгээр санхүүгийн тайлангуудтай холбоотой нэмэлт тодруулга болон нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд нь Сангүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд аудит хийж, тайланд дүгнэлт гаргахтай холбоотой харилцааг Инвескорын "БДО Аудит" ХХК-тай 2018.12.05-ны өдөр байгуулсан "Аудитын үйлчилгээ үзүүлэх гэрээ" (Хавсралт 4.18)-ээр зохицуулсан байна. Уг гэрээнд талуудын харилцан хүлээх үүрэг, хариуцлага, ажлын хүрээ, гүйцэтгэх хугацаа, хөлс, үр дүнг хүлээлгэн өгөх,



TDB CAPITAL LLC



InvesCore
УЛААНБААТАР ХОТ

гэрээг дуусгавар болгох журмыг тусгасан нь Аудитын тухай хуулийн 13-т заасан шаардлагад нийцсэн байна.

***Хөрөнгө үнэлгээний ажлын гэрээ.*** Инвескорын бизнесийн үнэлгээг тус компанийн хувьцааг Монголын Хөрөнгийн Бирж дээр анхлан гаргах зориулалтаар тогтоохтой холбоотой харилцааг Инвескор болон “Гэрэгэ Эстимэйт” ХХК-тай 2018.11.27-ны өдөр байгуулсан A18112701 тоот Бизнесийн үнэлгээний ажил гүйцэтгэх гэрээ (Хавсралт 4.19)-ээр зохицуулсан байна. Уг гэрээнд хөрөнгийн үнэлгээний зориулалт, хөрөнгийн үнэлгээний зүйл, түүний шинж, талуудын эрх үүрэг, хөрөнгийн үнэлгээний хөлс, хөрөнгийн үнэлгээний тайланг хүлээлгэн өгөх журмыг тусгасан нь Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 6-д заасан шаардлад нийцсэн байна.

MDSKhanLex

## 5. Сүүлийн 3 жилийн дотор хийсэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл байгаа бол хуульд заасан журмын дагуу байгуулсан эсэх.

Инвескор нь өөрийн толгой компани болох "Эс Ай Би Жэй Капитал" ХХК-тай 2017 оны 03 дугаар сарын 30-ны өдөр 18033001 тоот Зээлийн эрх нээх үндсэн гэрээ /цаашид "Гэрээ" гэх/ байгуулж, 25,000,000,000 төгрөгийн зээлийн эрхийг дараах нөхцөлөөр нээсэн байна. Үүнд:

- Зээлийн хүү – жилийн 19 хувь
- Зээл олгох валют – зээл болон зээлийн эргэн төлөлтийг төгрөгөөр
- Зээлийн эрхийн хугацаа – 15 жил
- Зээлийн зориулалт – бизнесийн эргэлтийн зээл.

Энэхүү гэрээ нь Компанийн тухай хуулийн 87-р зүйлийн 87.1 дэх хэсэгт заасан их хэмжээний хэлцэлд, мөн Компанийн тухай хуулийн 89-р зүйлийн 89.1 дэх хэсэгт заасан сонирхлын зөрчилтэй хэлцэлд нэгэн зэрэг хамаарч байна. Компанийн тухай хуулийн 92.5-д: "Хэлцэл хийх сонирхол бүхий этгээд ... түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдээс зээл авах тухай сонирхлын зөрчилтэй хэлцлийг энэ хуулийн 92.3-т заасны дагуу батлуулах шаардлагагүй" гэж заасан байдаг.

Инвескорын Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн хурлын А/02-Т-01 дугаартай "Их хэмжээний хэлцэл хийх тухай" тогтоолоор уг зээлийн эрх нээх гэрээ байгуулахыг зөвшөөрч, гэрээнд гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал Д.Баясгаланд олгосон байна. Энэхүү тогтоол нь 88.1 дэх хэсэгт заасан их хэмжээний хэлцэл хийх журамд нийцсэн, Инвескор болон түүний толгой компани болох "Эс Ай Би Жэй Капитал" ХХК-ийн хооронд 2017 оны 03 дугаар сарын 30-ны өдөр байгуулсан 18033001 тоот Зээлийн эрх нээх гэрээ нь хүчин төгөлдөр байна.

Инвескорын Гүйцэтгэх захирлын 2019.02.28-ны өдрийн Б-19/814 тоот Баталгаа бичиг (Хавсралт 5.1) -т дурдсанаас үзвэл дүгнэлт гаргах өдрийн байдлаар сүүлийн 3 жилийн дотор энэхүү дүгнэлтэд дурдсанаас өөр их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулаагүй байна.



257

MDSKhanLex

## 6. Үйл ажиллагааны гол үндэслэл болсон аливаа тусгай зөвшөөрөл, лиценз, зохиогчийн эрх, патент, бараа, үйлчилгээний тэмдэг нь хүчин төгөлдөр эсэх, тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах, барьцаалагдах зэргээр үйл ажиллагаанд нь бодитой нөлөөлж болох нөхцөл байгаа эсэх

Инвескор нь Санхүүгийн Зохицуулах Хорооны 2016.05.17-ны өдрийн 159 дугаар тогтоолоор Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх 1/554 дугаар тусгай зөвшөөрөл (Хавсралт 1.4), 2018.01.10-ны өдрийн 17 дугаар тогтоолоор Банк бус санхүүгийн төлбөрийн баталгаа гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл (Хавсралт 1.5), мөн Санхүүгийн Зохицуулах Хорооны 2016.05.17-ны өдрийн 159 дугаар тогтоолоор Зээлийн үйл ажиллагаа, Факторингийн үйл ажиллагаа, Итгэлцлийн үйл ажиллагаа, Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх, Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг (Хавсралт 1.6) тус тус авсан бөгөөд эдгээр нь "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай" хуулийн 10.1.1, 15, 15.3.1, "Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай" хуулийн 9.1-д заасан шаардлагад нийцэж байна.

Инвескорын нэр дээр байх дээрх Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлүүд нь дүгнэлт гаргах өдрийн байдлаар хүчинтэй эсэх, тэдгээрийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох нөхцөл байдал үүссэн эсэх талаар бид СЗХ-оос лавлагаа хүссэн бөгөөд Санхүүгийн Зохицуулах Хорооноос 2018.12.26-ны өдөр гаргасан 9/4903 тоот албан бичиг (Хавсралт 6.1)-т: "Инвескорд захиргааны хариуцлага ногдуулсан талаар мэдээлэл бүртгэгдээгүй байна" гэжээ.

Инвескорын СЗХ-оос авсан дээр дурдсан Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлүүд нь дүгнэлт гаргах өдрийн байдлаар хүчин төгөлдөр, түдгэлзүүлэх, хүчингүй болгох нөхцөл байдал үүсээгүй байна (Хавсралт 5.1).

Инвескор нь дараах "INVESCORE" барааны тэмдгийг бүртгүүлэхээр Засгийн Газрын хэрэгжүүлэгч агентлаг Оюуны өмчийн газарт 2018.07.20-ны өдөр мэдүүлэг (Хавсралт 6.2) гаргасан бөгөөд ОӨГ-ын хяналтын шатанд байна. Үүнд:

Инвескор – санхүүгийн байгууллага

InvesCore
САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

Оюуны өмчийн газраас 2018.12.26-ны өдөр ирүүлсэн Тодорхойлолт №2/358 (Хавсралт 6.3)-д тусгаснаар Инвескорын нэр дээр эрхийн хамгаалалт хийгдсэн шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загвар, зохиогчийн эрхийн аливаа бүтээл байхгүй.

СЗХ
2019.04.24
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2019-03-26



## 7. Үнэт цаас, үл хөдлөх болон бусад эд хөрөнгө өмчлөх эрх нь хүчин төгөлдөр эсэх, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээсэн эсэх

***Үнэт цаас.*** Инвескор нь Эй Ай Лаб ХХК (РД: 633947, УБД: 9011758119)-ийн 90 хувийн хувьцааг эзэмшдэг (Хавсралт 7.1).

Инвескор Эй Ай Лаб ХХК-ийн 2018.08.17-ны өдрийн гэрчилгээ, дүрмийн дагуу хувьцаа эзэмшигч, тэдгээрийн хувь, эзэмшил дараах байдлаар тодорхойлогдож байна. Үүнд:

| № | Хувьцаа эзэмшигчдийн нэрс | Регистрийн дугаар | Эзэмших хувь | Эзэмших хувьцааны тоо /*ширхэгээр*/ | Оруулсан хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ /*төгрөгөөр*/ |
|---|---|---|---|---|---|
| 1 | Инвескор ББСБ ХХК | 6060854 | 90 | 90 | 90,0000 |
| 2 | Иргэн М.Баярпүрэв | ЧР76072911 | 4 | 4 | 4,000 |
| 3 | Иргэн М.Золжаргал | ВЭ87021874 | 3 | 3 | 3,000 |
| 4 | Иргэн Д.Нанзадрагчаа | ИЭ85010976 | 3 | 3 | 3,000 |
| **НИЙТ:** | | | **100%** | **100** | **100,000** |

Инвескор Эй Ай Лаб ХХК нь програм хангамжийн үйл ажиллагаа, менежментийн зөвлөх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, хиймэл оюун ухаанд суурилсан програм зохион бүтээгч залуу хамт олноос бүрдсэн, техник технологийн шинэ шилдэг шийдлийг нэвтрүүлэгч байгууллага юм.

***Газар эзэмших эрх.*** Инвескороос өгсөн мэдээллийн дагуу болон Нийслэлийн Газрын албаны 2018.12.26-ны өдрийн 01-09/6121 тоот лавлагаа (Хавсралт 7.2)-ны дагуу Инвескор нь аливаа газар эзэмшдэггүй болно.

***Үл хөдлөх эд хөрөнгө.*** Инвескороос өгсөн мэдээллийн дагуу болон Улсын бүртгэлийн Ерөнхий газрын Эд хөрөнгийн бүртгэлийн газрын 2018.12.19-ний өдрийн 336697 тоот лавлагаа (Хавсралт 7.3)-ны дагуу Инвескор нь доорх үл хөдлөх эд хөрөнгүүдийг эзэмшдэг болно. Үүнд:

TDB CAPITAL LLC



258

"ИНВЕСКОР ББСБ" ХХК
InvesCore
1116224283 6060854
УЛААНБААТАР ХОТ

| № | Улсын бүртгэлийн дугаар | Үл хөдлөх эд хөрөнгийн зориулалт | Байршил | Хэмжээ мкв-аар | Гэрчилгээний дугаар/ Хавсралт № | Зээлийн Гэрээний дагуу Барьцаалагдсан эсэх |
|---|---|---|---|---|---|---|
| 1. | Ү-2206057725 | Орон сууц | ХУД, 2-р хороо үйлдвэр, Чингисийн өргөн чөлөө гудамж, 110а байрны 1404 тоот | 65.5 м.кв | 000654851/ Хавсралт 7.4 | үгүй |
| 2. | Ү-2205055771 | Авто зогсоол | БГД, 17-р хороо, 4-р хороолол, Жалханз хутагт дамдинбазар гудамж, Г40 байр, 201 тоот | 22.5 м.кв | 000664962/ Хавсралт 7.5 | үгүй |
| 3. | Ү-2205055774 | Авто зогсоол | БГД, 17-р хороо, 4-р хороолол, Жалханз хутагт дамдинбазар гудамж, Г40 байр, 252 тоот | 22.5 м.кв | 000664963/ Хавсралт 7.6 | үгүй |
| 4. | Ү-2204052949 | Авто зогсоол | БЗД, 25-р хороо, 13-р хороолол, нарны зам гудамж, 166-р байр, 10 тоот | 87.65 м.кв | 000684970/ Хавсралт 7.7 | үгүй |
| 5. | Ү-2205004135 | Хувийн сууц | БГД, 7-р хороо, ааеч гудамж, 39-1 тоот | 91.2 м.кв | 000651624/ Хавсралт 7.8 | үгүй |
| 6. | Ү-2206022622 | Орон сууц | ХУД, 11-р хороо, Интернейшнл рент, Ар зайсан гудамж, 90/2 байр, 3 тоот | 91.72 м.кв | 000688440/ Хавсралт 7.9 | үгүй |

Инвескороос өгсөн мэдээллийн дагуу тус компани нь 7448УНГ улсын бүртгэлийн дугаартай, ZVW305102655 арлын дугаартай, Toyota Prius маркийн тээврийн хэрэгсэл (Хавсралт 7.10) эзэмшдэг болно. 2019.02.26-ны өдөр "Монгол даатгал" ХХК-тай байгуулсан 19044003002662 тоот гэрээ (Хавсралт 7.11)-гээр жолоочийн хариуцлагын даатгалд даатгуулсан байна.

Дүгнэлт гаргах өдрийн байдлаар Инвескор нь аливаа газар эзэмших эрхгүй бөгөөд Инвескор Эй Ай Лаб ХХК-ийн гаргасан энгийн хувьцааны 90 хувийн хувьцаа болон дээр дурдсан 6 үл хөдлөх эд хөрөнгийг хууль ёсоор өмчилж байна. Эдгээр үл хөдлөх эд хөрөнгийг бусдад барьцаалуулаагүй байна. Мөн Инвескор нь 1 тээврийн хэрэгсэл эзэмшдэг бөгөөд жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд хамруулсан ба дүгнэлт гаргах өдрийн байдлаар тус даатгалын гэрээ хүчин төгөлдөр байна.

СЗХ
2019.04.24
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2019-03-26



## 8. Үнэт цаас бүртгүүлэх өргөдөл, танилцуулгад тусгагдсан мэдээлэл нь хүчин төгөлдөр баримтаар нотлогдож байгаа эсэх

Инвескорын Хувьцаа эзэмшигчийн 2019.02.25-ны өдрийн Хувьцаа нэмж гаргах, хувьцаагаа анх удаа нийтэд санал болгох тухай А/03 дугаартай шийдвэр (Хавсралт 8.1)-ээр дараах шийдвэр гаргасан байна. Үүнд:

1. Компанийн **зарласан** энгийн хувьцааны тоог нийт 82,000,000 (наян хоёр сая) ширхэг болгон нэмэгдүүлэх;
2. Компанийн одоогийн гаргасан 60,968,730 (жаран сая есөн зуун жаран найман мянга долоон зуун гучин) ширхэг энгийн хувьцаан дээр нэмж, зарласан энгийн хувьцаанаас нэг бүр нь 227 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 10,759,188 (арван сая долоон зуун тавин есөн мянга нэг зуун наян найман) ширхэг энгийн хувьцааг анх удаа олон нийтэд нээлттэй арилжаалахаар нэмж гаргах;
3. Энэхүү шийдвэрийн дагуу нэмж гаргаж буй 10,759,188 (арван сая долоон зуун тавин есөн мянга нэг зуун наян найман) ширхэг энгийн хувьцаа нь Компанийн нийт гаргасан 71,727,918 ширхэг энгийн хувьцааны 15 хувьтай тэнцэх бөгөөд Нэмж гаргах хувьцааны олон нийтэд санал болгох зах зээлийн үнийг хараат бус бизнесийн үнэлгээний тайланг үндэслэн тогтоохыг Төлөөлөн удирдах зөвлөлд даалгах;
4. Компанийн одоогийн хувьцаа эзэмшигч нь нэмж гаргах хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах давуу эрхээ хэрэгжүүлэхээс бүрэн татгалзах;
5. Компанийн одоогийн хувьцаа эзэмшигч болон стратегийн хөрөнгө оруулагч нь хувьцааны хоёрдогч зах зээл нээгдсэнээс хойш 12 (арван хоёр) сарын хугацаанд хувьцаагаа арилжаанд оруулахгүй байх.

Энэхүү шийдвэр нь Компанийн тухай хуулийн 23 дугаар зүйл, 31 дүгээр зүйлийн 31.2.2 дахь заалт, 38 дугаар зүйлийн 38.8 дахь хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.3, 62.1.4 дэх заалт, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, Инвескорын дүрмийн 7.2.13 дахь заалтад нийцсэн байна.

Тус компанийн нийтэд ил болсон мэдээлэл, төрийн болон бусад эрх бүхий байгууллагаас гаргуулсан, компани, түүний гүйцэтгэх удирдлага, холбогдох этгээд болон гуравдагч этгээдээс гаргуулсан мэдээллүүдийг шинжилсний үндсэн дээр Үнэт цаасыг бүртгүүлэх өргөдөл, танилцуулгад тусгасан мэдээлэл нь үнэн зөв, хууль зүйн хувьд хүчин төгөлдөр байна гэж дүгнэв.



"ИНВЕСКОР ББСБ" ХХК
InvesCore
1115224289 5060854
УЛААНБААТАР ХОТ

MDSKhanLex

## 9. Үнэт цаас гаргагч компанийн хяналтын жинхэнэ хэрэгжүүлэгч эзэд нь хэн болох

Улсын бүртгэлийн Ерөнхий газрын Улсын бүртгэлийн нэгдсэн архивын газраас 2018.12.20-ны өдөр 003103762 тоот албан бичгээр ирүүлсэн Инвескорын улсын бүртгэлийн дэлгэрэнгүй лавлагаа (Хавсралт 9.1)-г тус өдрийн байдлаар гаргуулан судлав. Дүгнэлт гаргах өдрийн байдлаар Инвескорын бүх хувьцааг “Эс Ай Би Жэй Капитал” ХХК эзэмшиж байна.

Инвескорын толгой компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2018.03.24-ний өдрийн 18032401 тоот тогтоол (Хавсралт 9.2)-ын хавсралтаар батлагдсан дүрмийн 3.1-т зааснаар дээрх компанийн хувьцаа эзэмшигчид, тэдгээрийн хувь эзэмшлийн хэмжээ дараах бүтэцтэй байна. Үүнд:

| № | Хувьцаа эзэмшигчдийн нэрс | Эзэмшлийн хувь | Эзэмших хувьцааны тоо /ширхэгээр/ | Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ /төгрөгөөр/ |
|---|---|---|---|---|
| 1 | Япон Улсын иргэн Кавазоэ Такааки /паспортын дугаар: TR8201699/ | 24% | 1,528,385 | 1,528,385,520 |
| 2 | Монгол Улсын иргэн Баянмөнхийн Анхболд /РД: ЧК80011134/ | 45% | 2,865,723 | 2,865,722,850 |
| 3 | Монгол Улсын иргэн Батбаярын Мөнх-Очир /РД:ВЮ90031832/ | 31% | 1,974,165 | 1,974,164,630 |
| Нийт | | 100% | 6,368,273 | 6,368,273,000 |

Инвескорын ХЭХ-ын 2018.10.01-ний өдрийн А/24 тоот шийдвэрийн дагуу ТУЗ-ийн даргаар Б.Анхболдыг томилсон бөгөөд “Эс Ай Би Жэй Капитал” ХХК-ийн 2018.10.04-ний өдрийн А/22 хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор Инвескорын хувьцаа эзэмшигчийн эрх үүргийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх, хувьцаа эзэмшигчийн бүх шийдвэрийг Компанийн хувьцаа эзэмшигчдийн нэрийн өмнөөс дангаар баталгаажуулж гарын үсэг зурж, шийдвэр гаргах бүрэн эрхийг Хувьцаа эзэмшигч Б.Анхболдод мөн олгосон байна.

Дээрх мэдээллийн үндсэн дээр “Эс Ай Би Жэй Капитал” ХХК-ийн 45 хувийн хувьцаа эзэмшигч, Инвескорын ТУЗ-ийн дарга Баянмөнхийн Анхболд нь Япон Улсын иргэн Кавазоэ Такааки, Монгол Улсын иргэн Батбаярын Мөнх-Очир нарын хамт Инвескорын жинхэнэ хяналтыг хэрэгжүүлэгч хэмээн тодорхойлж байна. Энэхүү дүгнэлт нь бусад нөхцөл байдал, хүчин зүйлийн нөлөөгөөр өөрчлөгдөх боломжтойг дурдаж байна.

СЗХ 2019.04.24 өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ

MDSKhanLex

## 10. Тухайн компанийн улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлтэй холбоотой зөрчил байгаа эсэх болон нэмэлт шинжилгээ, судалгаа

Инвескор нь 2018.12.20-ны өдрийн байдлаар Гаалийн байгууллагад татварын өргүй (Хавсралт 10.1), 2019.02.01-ний өдрийн байдлаар Эрүүл мэнд, нийгмийн даатгалын байгууллагад нийгмийн даатгалын шимтгэлийн өргүй (Хавсралт 10.2), 2019.02.26-ны өдрийн байдлаар Татварын байгууллагад өр төлбөргүй (Хавсралт 10.3) ба 87,883,772.30 төгрөгийн илүү төлөлттэй байна.

Дүгнэлт гаргах өдрийн байдлаар Инвескорын хувьд улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлтэй холбоотой зөрчил тогтоогдоогүй болно.

TDB CAPITAL LLC



"ИНВЕСКОР ББСБ" ХХК

InvesCore

УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2019.04.24
БҮРТГЭВ
№01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2019-03-26
БҮРТГЭВ



## 11. Тухайн компанийн эрхэлж буй үйл ажиллагааны нийцэл (complaince)-ийн талаар хийсэн зарим нэмэлт судалгаа шинжилгээ

Бид Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, СЗХ-ны болон МХБ-ийн "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын зохицуулалтаас гадна хөрөнгө оруулагчид шийдвэр гаргахад ач холбогдолтой гэж үзэн хөндлөнгийн мэдээлэл (Хавсралт-11.1-11.14) цуглуулж, тус компанитай холбоотой дараах нөхцөл байдлуудыг тогтоосон болно.Үүнд:

- Хаан банк, Худалдаа Хөгжлийн банкнаас 2019.01.10-ны өдөр гаргасан Тулган баталгаажуулалтад тусгаснаар Инвескор нь тодорхойлолт өгсөн өдрийн байдлаар тус банкинд хугацаа хэтэрсэн зээл болон хүүгийн өр төлбөргүй байна;
- Монголын Олон Улсын ба Үндэсний Арбитрын 2018.12.19-ний өдөр гаргасан Тодорхойлолт №4/1105-д тусгаснаар Инвескор нь сүүлийн гурван жилийн байдлаар арбитраар хянан шийдвэрлэгдсэн болон арбитрын ажиллагаа явагдаж байгаа хэрэгт нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдээр оролцоогүй байна;
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх Ерөнхий Газрын Шийдвэр гүйцэтгэх албанаас 2018.12.19-ний өдөр гаргасан Тодорхойлолт №0044938-д Инвескор нь шүүхийн шийдвэрээр иргэн, хуулийн этгээдэд өр төлбөргүй байна;
- Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн Шүүхийн Төрөлжсөн Архиваас 2018.12.20-ны өдөр гаргасан Тодорхойлолт №15959 болон 2019.02.26-ны өдөр гаргасан Тодорхойлолт №2219-д тусгаснаар Инвескор нь Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй, Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргүүдийн иргэний хэргийн анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн иргэний хэрэгт хариуцагчаар оролцож байгаагүй болно. Гэвч Гүйцэтгэх захирлын мэдээлснээр Монгол Улсын иргэн Б.Дөлгөөний нэхэмжлэлтэй Инвескорд холбогдох шударга өмчлөгчөөр тогтоолгох, худалдах худалдан авах гэрээ, бэлэглэлийн гэрээг хүчин төгөлдөр бусад тооцуулах нэхэмжлэлийн шаардлага бүхий иргэний хэргийг Баянгол дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх хянаж байна;
- Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны Шүүхийн Тамгын Газраас 2018.12.24-ний өдөр гаргасан Тодорхойлолт №2/17-д тусгаснаар Инвескор нь захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нэхэмжлэгч болон гуравдагч этгээдээр сүүлийн 3 жилд оролцож байгаагүй болно;
- Шударга Өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газраас 2018.12.26-ны өдөр гаргасан Тодорхойлолт №1/1675-д тусгаснаар Инвескор нь тодорхойлолт өгсөн өдрийн байдлаар Өрсөлдөөний тухай хууль тогтоомжийг зөрчөөгүй байгаагүй бөгөөд Өрсөлдөөний тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д заасны дагуу давамгай байдалтай аж ахуйн нэгжээр тогтоогдоогүй байна;
- Оюуны өмч, улсын бүртгэлийн Ерөнхий газраас 2018.12.26-ны өдөр гаргасан Тодорхойлолт №2/358-д тусгаснаар Инвескорын нэр дээр эрхийн хамгаалалт хийгдсэн шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загвар, зохиогчийн эрхийн аливаа бүтээл байхгүй болно. 2018.07.20-ны өдөр "INVESCORE" барааны тэмдгийг бүртгүүлэхээр мэдүүлэг гаргасан байна;
- Санхүүгийн Зохицуулах Хорооноос 2018.12.26-ны өдөр гаргасан 9/4903 тоот албан бичигт тусгаснаар Инвескорд захиргааны хариуцлага ногдуулсан талаар мэдээлэл бүртгэгдээгүй байна.



TDB CAPITAL LLC

InvesCor

2019 .04. 24

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2019 -03- 26

MDSKhanLex

## 12. Гол дүгнэлт

“Инвескор ББСБ” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Үнэт цаасны танилцуулгад дурдсан мэдээлэл үнэн зөв, хуульд нийцсэн байна. Энэ тухай Хавсралт 12–оос үзнэ үү.

TDB CAPITAL LLC
5251194

"ИНВЕСКОР ББСБ" ХХК
InvesCore
УЛААНБААТАР ХОТ

2019 .04. 24

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2019 -03- 26

MDSKhanLex

## 13. Хязгаарлалт

Бидний үйлдсэн хууль зүйн дүгнэлтэд дор дурдсан хязгаарлалт хамаарна. Үүнд:

a) Бид Монгол Улсын хууль тогтоомжоос бусад улсын хууль тогтоомжийг хэрэглээгүй болно.

b) "хүчин төгөлдөр", "дагаж мөрдөнө", "хэрэгжинэ" гэдэг нь Монгол Улсын шүүх хэрэгжүүлж болох үүрэг болон нөхцөлүүдийг илэрхийлнэ. Гэхдээ энэ нь бүхий л нөхцөл байдалд хэрэгжих боломжтой гэсэн ойлголт биш болно. Тухайлбал:

   (i) Гэм хор арилгах, хориг тавих, тусгай гүйцэтгэл, дур зоргоор хандах;

   (ii) Татан буулгахтай холбоотой хууль болон санхүүжүүлэгчид нөлөөлж болох бусад хуулиудын нөлөөлөл;

   (iii) залилан, хууран мэхлэх, алдаа, албадлагын, шударга бус үйл явдал, хууль бус үйлдлийн эсрэг хуулийн нөлөөл.

c) Энэхүү хууль зүйн дүгнэлт нь Баримт бичгүүд дээр тусгагдсан асуудлуудтай холбоотой бөгөөд тухайн Баримт бичиг дээр тусгагдсан хууль зүйн факт, үйл явдалд хамаарна. Тухайн Баримт бичиг дээр тусгагдсан аливаа үүргийг нэмэгдүүлэх эсхүл бизнесийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхгүй болно.

Бид энэхүү хууль зүйн дүгнэлтийг гаргахдаа гагцхүү Монгол Улсын хууль тогтоомжид холбогдуулан өөрсдийн туршлага, мэргэжлийн ур чадвараа ашигласан бөгөөд Монгол Улсын хууль тогтоомжид үндэслэсэн болно. Хуулийн фирм нь бусад аливаа улсын хууль тогтоомжийн хүрээнд аливаа үйл явдлын талаар саналаа илэрхийлээгүй болно. Хуулийн фирм нь энэхүү дүгнэлтийг гаргахдаа санхүүгийн, статистикийн, нягтлан бодох бүртгэлийн, үйл ажиллагааны чиглэлийн ямар нэгэн ур чадвар, туршлага ашиглаагүй, эдгээрээс татгалздаг болно.

**ХҮНДЭТГЭСЭН,**

ПАРТНЕР Д.ДҮГЭРЖАВ

УЛААНБААТАР ХОТ

ТИ ДИ БИ КАПИТАЛ ҮЦК ХХК
5251494
TDB CAPITAL LLC

"ИНВЕСКОР ББСБ" ХХК
InvesCore
1116224289 6060854
УЛААНБААТАР ХОТ

2019.04.24

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2019-03-26

**“ИНВЕСКОР ББСБ” ХХК-ИЙН ҮНЭТ ЦААС НЭМЖ ГАРГАХ ТӨСЛИЙН АНДЕРРАЙТЕРИЙН ДҮГНЭЛТ**

**Ерөнхий мэдээлэл**

“Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК (цаашид “Үндсэн андеррайтер” гэх) нь андеррайтерийн тусгай зөвшөөрлийн хүрээнд Үнэт цаас гаргагч “Инвескор ББСБ” ХХК (цаашид “Компани эсвэл Үнэт цаас гаргагч” гэх)-тай “Андеррайтер болон зөвлөх үйлчилгээний гэрээ” байгуулж, Компанийн нэмж гаргаж буй хувьцааг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан нийтэд нээлттэй хүрээнд санал болгон арилжаалах үйл ажиллагаанд Үндсэн андеррайтераар оролцож байгаа болно.

Үнэт цаас гаргагч нь гаргасан нийт хувьцааныхаа 15 хувь буюу 10,759,188 ширхэг энгийн хувьцааг нийтэд санал болгон арилжих бөгөөд нэмж гаргах хувьцааны 85 хувийг стратегийн хөрөнгө оруулагчдад, 15 хувийг олон нийтэд санал болгох замаар нийт 17,591,272,400 төгрөгөөс 18,667,191,200 төгрөгийн санхүүжилт татахаар төлөвлөсөн байна.

Үнэт цаас гаргагч нь нээлттэй хувьцаат компани болж, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нэмэгдсэнээр Компанийн ашигт ажиллагаа, эрсдэл даах чадвар сайжрахын зэрэгцээ, төлөвлөж буй өсөлтийн стратегийг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэргэжлийн хөрөнгө оруулагчид болон санхүүгийн хямд эх үүсвэрийг дотоодын болон олон улсын санхүүгийн зах зээлээс татах боломжийг цаашид бий болгоно гэж үзэж байна.

**Үнэт цаас нэмж гаргах төслийн бэлтгэл ажил**

Энэхүү үнэт цаас нэмж гаргах төслийн бэлтгэл ажлын хүрээнд Үндсэн андеррайтер нь Туслах андеррайтер болох “Инвескор Капитал ҮЦК” ХХК-тай гэрээ байгуулан хамтран ажиллаж, Үнэт цаас гаргагчаас гаргаж өгсөн баримт, материал, мэдээллийн дагуу холбогдох судалгаа, шинжилгээг хийж гүйцэтгэсэн.

Үнэт цаас гаргагч нь бие даан “Эм Ди Эс энд Хаан Лекс” ХХН-тэй “Хууль зүйн үйлчилгээ үзүүлэх гэрээ” байгуулан үнэт цаасыг анхдагч зах зээлд санал болгох ажиллагаанд хуулийн зөвлөхөөр, “БДО Аудит” ХХК-тай Гэрээт ажлын захидал байгуулан үнэт цаасыг анхдагч зах зээлд санал болгох үйл ажиллагаанд аудитын байгууллагаар, “Гэрэгэ Эстимэйт” ХХК-тай “Бизнесийн үнэлгээний ажил гүйцэтгэх гэрээ” байгуулан үнэт цаасыг анхдагч зах зээлд санал болгох ажиллагаанд бизнесийн үнэлгээний байгууллагаар ажиллуулан холбогдох дүгнэлтүүдийг гаргуулсан байна.

Андеррайтер нь мэргэжлийн түвшинд хийгдсэн эдгээр судалгаа шинжилгээний үр дүнд тулгуурлан Үнэт цаасны танилцуулгыг боловсруулсан.

**Үнэт цаас гаргагчийн бизнес, үйл ажиллагаа**

Үнэт цаас гаргагч нь хэдийгээр 2016 онд Хорооноос банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан, үйл ажиллагаагаа явуулаад 2.9 жил болж буй хэдий ч дотоодын банк бус санхүүгийн байгууллагын салбартаа тэргүүлэгчдийн нэг болж, хөрөнгийн өсөлт, татан төвлөрүүлсэн хөрөнгө, өөрийн хөрөнгийн өсөлт, зээлийн багцын хэмжээ, чанаргүй зээлийн хувь, активын өгөөж зэргээр салбартаа тэргүүлэгчдийн нэг болсон байна.

Үнэт цаас гаргагч нь салбарын шилдэг, залуу удирдлагын баг, мэргэжилтнүүдээр багаа бүрдүүлсэн, хүний нөөцийн шилдэг удирдлагыг хэрэгжүүлэхээр зорин ажиллаж буй шилдэг хамт олонг бий болгож чадсанаас гадна уламжлалт банк бус санхүүгийн зах зээл болон финтект суурилсан санхүүгийн зах зээлийг хослуулан үйл ажиллагаа явуулдаг онцлогтой бөгөөд өөрийн охин компани

TDB CAPITAL LLC

“ИНВЕСКОР ББСБ” ХХК
InvesCore
УЛААНБААТАР ХОТ



262

2019.04.24
БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2019-03-26

болох “Инвескор Эй Ай Лаб” ХХК-аар дамжуулан хиймэл оюун ухаанд суурилсан финтек бүтээгдэхүүнүүдийг хөгжүүлж байна.

Үнэт цаас гаргагч нь бизнес эрхлэгч аж ахуйн нэгж, иргэдэд бага хүүтэй валютын зээл, зээлийн шугам, гүүрэн зээл, хамтын санхүүжилт, кредит карт зэрэг зээлийн үйлчилгээг үзүүлэхээс гадна финтек буюу технологид суурилсан шинэлэг бүтээгдэхүүн, түргэн шуурхай үйлчилгээг үйл ажиллагаандаа нэвтрүүлжээ.

Компанийн нийт зээлдэгчдийн тоо жилд дунджаар 3.4 дахин өссөн үзүүлэлттэй байна. 2016 онд Үнэт цаас гаргагчийн нийт зээлийн үлдэгдэл 4.2 тэрбум төгрөгтэй тэнцэж байсан бол жил бүр дунджаар 1.9 дахин өсч, 34.9 тэрбум төгрөгт хүрсэн. 2016-2018 онд компанийн нийт зээлийн багц 1.9 дахин өссөн үзүүлэлттэй байна. Компани дотоодын зах зээлд 100% автомат бичил зээлийн аппликейшн, цахим мөнгөний гүйлгээ, төлбөр тооцооны систем, хэрэглээний зээл олголтын бүрэн автоматжуулсан систем зэрэг хиймэл оюун ухаан, финтект суурилсан бүтээгдэхүүн болон санхүүгийн эх үүсвэрийн давуу талаа ашиглан, компанийн зээл олголтын хэмжээг ирэх 5 жилийн хугацаанд жилд дунджаар 43 хувиар нэмэгдүүлж, 2023 он гэхэд 205.4 тэрбум төгрөгт хүргэхээр зорьж байна.

Үнэт цаас гаргагчийн зээлийн эрсдэлийн сан 2018 онд 1.1 тэрбум төгрөгтэй тэнцэж байсан бол 2023 онд 7.6 тэрбум төгрөгт хүрэхээр төсөвлөгдсөн байна. Үнэт цаас гаргагчийн хувьд барьцаагүй зээлийн хувь хэмжээг маш анхааралтайгаар тооцон үйл ажиллагаагаа явуулдаг ба одоогийн байдлаар нийт зээлийн бүтээгдэхүүний 98 хувь нь барьцаа, батлан даалттай байна. Цаашид энэ харьцаа үзүүлэлтүүдийг ижил түвшинд хадгалах стратеги барин ажиллахаар төлөвлөжээ. Компани нь нийт зээлийн багцынхаа 50 хувийг бизнесийн зээл, 50 хувийг хэрэглээний зээлээр бүрдүүлэхийг зорьж ажилладаг.

2018 оны жилийн эцсийн байдлаар Үнэт цаас гаргагчийн зээлийн багцын 40 хувийг автомашины зээл, 31 хувийг хувь хүнд олгосон бизнесийн зээл буюу жижиг, дунд бизнесийн зээл, 22 хувийг бусад бизнесийн зээл, 6 хувийг хэрэглээний зээл тус тус эзэлж байна. 2019-2023 онд Үнэт цаас гаргагч нь автомашин барьцаалсан зээлийн багцын хэмжээг үе шаттайгаар бууруулж, 2023 он гэхэд 21 орчим хувьд хүргэх бол бичил зээлийг өөрийн аппликейшнээр олгож эхэлснээр хэрэглээний зээлийн хэмжээ нэмэгдэж 28 орчим хувьд хүрэхээр төлөвлөжээ. Үнэт цаас гаргагч нь жижиг, дунд бизнесийн зээлийг нийт багцын 30 орчим хувьд, том зээлийг 3.4 орчим хувьд, бусад бизнесийн зээлийг 16 орчим хувьд, кредит картын зээлийг 1.5 орчим хувьд барин ажиллахаар төлөвлөж байна.

Үнэт цаас гаргагч нь 2023 оныг хүртэлх бизнес төлөвлөгөөндөө уламжлалт зээлийн бүтээгдэхүүнийхээ хүүг аажмаар бууруулахаар төлөвлөсөн байна. 2019 оны 9 дүгээр сард зах зээлд нэвтрүүлэхээр төлөвлөж буй Финтекд суурилсан хэрэглээний бичил зээлийн бүтээгдэхүүний нийт багцад эзлэх хувь цаашид улам ихсэж, энэ нь зээлийн жигнэсэн дундаж хүүгийн өсөлтөнд нөлөөлж буй хэдий ч компанийн энэхүү бичил зээлийн хүүгийн түвшин нь зах зээлд нэвтэрсэн бусад ижил төстэй бүтээгдэхүүний дунджаас доогуур байхаар төлөвлөгджээ.

Одоогийн эдийн засаг, хууль эрхзүйн орчноос хамаарч банк бус санхүүгийн байгууллага нь дотоодын зах зээлээс эх үүсвэр татах боломж хязгаарлагдмал, гадаад хөрөнгө оруулагчдаас гадаад валютаар эх үүсвэр бүрдүүлдэг нөхцөлд, төгрөгийн голлох валютын эсрэг ханш тасралтгүй суларч байгаа нь зээлийн хүүг богино хугацаанд бууруулахад саад болж байна гэж Үнэт цаас гаргагч үзсэн байна. Компаний хувьд 2023 онд бичил зээлээс бусад зээлийн бүтээгдэхүүний төгрөгийн хүүг сарын 2.3%-2.8% хүртэл, валютаарх хүүг сарын 1.2%-1.5% хүртэл бууруулахаар тооцсон байна.

Үнэт цаас гаргагч нь хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний үндсэн дээр итгэмжлэгчээс мөнгөн хөрөнгийг гэрээнд заасан хугацаанд, тодорхой хүүтэйгээр авч ашигладаг бөгөөд энэхүү санхүүгийн эх үүсвэрийг өөрийн бизнесийн үйл ажиллагааг өргөжүүлэхэд буюу зээлийн эх үүсвэрийг нэмэгдүүлэхэд зарцуулдаг. 2018 оны жилийн эцсийн байдлаар Үнэт цаас гаргагч нь нийт 1.2 тэрбум төгрөгтэй тэнцэх иенийн, 2.5 тэрбум төгрөгтэй тэнцэх ам.долларын болоод 4.7 тэрбум төгрөгийн

TDB CAPITAL LLC
"ИНВЕСКОР ББСБ" ХХК
InvesCore
УЛААНБААТАР ХОТ

2019.04.24 он сар өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2019-03-26 БҮРТГЭВ

итгэлцлийн үйлчилгээ үзүүлжээ. Нийт итгэлцлийн үйлчилгээний жигнэсэн дундаж хүү 13.7 хувь, төгрөгийнх 19.1%, ам.долларынх 8.8%, иенийнх 8.9% байсан байна. Үнэт цаас гаргагчийн санхүүгийн тайланд заасан итгэлцлийн үйлчилгээний үлдэгдэл (өглөг) нь итгэлцлийн үйлчилгээний мөнгөн хөрөнгийн дүн болон хуримтлуулж тооцсон хүүгийн өр төлбөрийг багтаасан. 2018 онд Үнэт цаас гаргагчийн итгэлцлийн үйлчилгээний үлдэгдэл 10.4 тэрбум төгрөгтэй тэнцэж байна.

2016-2018 онд “Инвескор ББСБ” ХХК-ийн итгэлцлийн үйлчилгээний үлдэгдэл жилд дунджаар 1.2 дахин өссөн үзүүлэлттэй байна. Үнэт цаас гаргагч нь ирэх 5 жилийн хугацаанд итгэлцлийн үйлчилгээний үнийн дүнг жилд дунджаар 35 хувиар нэмэгдүүлж, 2023 он гэхэд 46.4 тэрбум төгрөгт хүргэхээр зорьж байна. Ингэхдээ эх үүсвэрийг гадаад зах зээлээс татан төвлөрүүлэх стратеги баримталжээ.

Үнэт цаас гаргагч нь үйл ажиллагаагаа хялбаршуулах зорилгоор зээлийн судалгаа, шийдвэр гаргалт, олголт, явцын хяналт, хаалт гэсэн үндсэн 5 үйл явцыг бүрэн автоматжуулсан SMART-LOS зээлийн үйл ажиллагааны дотоод системийг өөрийн охин компани болох “Инвескор Эй Ай Лаб” ХХК-иар дамжуулан хөгжүүлж үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн ба дараагийн шатны хөгжүүлэлтүүдийг хийлгэж буй талаар дурьдсан. Үнэт цаас гаргагчийн охин компани болох “Инвескор Эй Ай Лаб” ХХК нь Япон Улсын “Toyota” корпорацийн хүнгүй машины төслийг хэрэгжүүлэгч “Liberra” компанитай хамтран Үнэт цаас гаргагчийн SMART-LOS зээлийн үйл ажиллагааны системийн зээлийн судалгаа хэсгийн чухал үе шат болох зээлийн үнэлгээ (Credit Scoring) хэсгийн хөгжүүлэлтийг хийлгэж буй талаар мэдээлэлдээ тусгасан байна. Мөн Компани энэхүү системийн хяналтын үйл явцыг сайжруулах, бичил зээлийн аппликэйшн хөгжүүлэх ажлуудыг гүйцэтгэхээр төлөвлөсөн байна.

Үнэт цаас гаргагч нь компанийн дунд хугацааны бизнес төлөвлөгөөний зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд компанийн үйл ажиллагааг өргөжүүлэх, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх зорилгоор нээлттэй хүрээнд нэмж хувьцаа гаргах замаар татан төвлөрүүлэх хөрөнгийг Компанийн үндсэн бүтээгдэхүүн болох зээл олголт, зээлийн үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зарцуулахаар төлөвлөсөн.

**Үнэт цаас гаргагч компанийн бизнесийн үнэлгээ**

Үнэт цаас гаргагчийн бизнесийн үнэлгээг гүйцэтгэсэн “Гэрэгэ Эстимэйт” ХХК нь үнэлгээний хандлагууд дундаас орлогын хандлагын аргын Ногдол ашиг хорогдуулах загвараар тооцсон үр дүн нь бизнесийн зах зээлийн үнэ цэнийг илүү сайн төлөөлж чадна гэж үзжээ. Үнэлгээний байгууллага нь Үнэт цаас гаргагч нэмж хувьцаа гарган, өөрийн хөрөнгөө дунджаар 18.1 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсний дараах байдлаар тооцсон бизнесийн 100% өмчлөлийн үнэ цэнийг 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 120,031,357,479 төгрөг, хөрөнгө оруулалтын өгөөжийн дотоод хувийг 60.5% байхаар тооцоолсон байна.

Үнэлгээний байгууллагын тооцоолсон бизнесийн үнэлгээний үр дүнгээр нэгж хувьцааны зах зээлийн үнэ цэнэ 1,673.4 төгрөг байх боломжтой байна. Үнэт цаас гаргагч нь хөндлөнгийн үнэлгээний байгууллагын хараат бус бизнесийн үнэлгээний тайланд үндэслэн нэмж гаргах хувьцаанаас стратегийн хөрөнгө оруулагчид захиалгын бүртгэлийн аргаар санал болгох доод үнийг 1,650.0 төгрөг, дээд үнийг 1,750.0 төгрөгөөр, олон нийтэд санал болгох доод үнийг 1,550.0 төгрөг, дээд үнийг 1,650 төгрөг байхаар тус тус тогтоосон байна.

**Үнэт цаас гаргагчийн талаарх дүгнэлт**

Үнэт цаас гаргагч нь цаашид бичил зээл, төлбөр тооцооны аппликэйшн нэвтрүүлэн, SMB хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаагаас гадна Япон, Зүүн Өмнөд Ази, Төв Азийн зах зээлд нэвтрэх зорилго тавин ажиллаж байгаа нь үнэт цаас гаргагчийн ирээдүйн төлөв, чиг хандлагыг тодорхой харах боломжийг бий болгож байна.Түүнчлэн үр дүнтэй хөрөнгө оруулалт, бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх замаар дотоодын зах зээлд бага зардлаар, өндөр үр ашигтай ажиллах бүтцийг бий болгон, бизнесийн цар хүрээгээ улам тэлэхээр төлөвлөж байна.

TDB CAPITAL LLC

“ИНВЕСКОР ББСБ” ХХК InvesCore 1116224289 6060854 УЛААНБААТАР ХОТ

Дунд хугацаанд банк бус санхүүгийн байгууллагуудын өрсөлдөөн улам нэмэгдэж, банк бус санхүүгийн байгууллагуудын хэмжээ томорсноор тус салбар нь санхүүгийн зах зээлд эзлэх хувиа улам нэмэгдүүлэх хүлээлттэй байна. Зээлийн эрэлт талаас авч үзвэл хэрэглээний зээлийн болон жижиг дунд үйлдвэрлэлийн зээлийн хэрэгцээ тасралтгүй өсөн нэмэгдэхээс гадна, финтект суурилсан зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ улам идэвхжих хандлагатай байна. Үнэт цаас гаргагчийн нэр, брэнд олон нийтэд сайтар танигдаагүй боловч салбарын хэмжээнд аль хэдий нь хүлээн зөвшөөрөгдсөн топ банк бус санхүүгийн байгууллагуудын нэг болж чадсан байна.

Хэдийгээр улс төр, хууль эрхзүй, макро эдийн засаг болон салбарын эрсдэлүүд өндөр хэвээр байгаа боловч үнэт цаас гаргагч нь стратегийн зорилго, зорилтдоо хүрч ажилласнаар бизнес төлөвлөгөөнд тусгагдсан зорилтот түвшинг бүрэн биелүүлж, хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчиддаа өндөр өгөөжтэй, харилцагчиддаа хэрэгцээ, шаардлагыг нь хангасан бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэсэн, өндөр өсөлттэй компани болох бүрэн боломжтой байна.

Үндсэн андеррайтер нь андеррайтерийн үйлчилгээний хүрээнд судалгаа шинжилгээ болон хөндлөнгийн зөвлөх байгууллагуудын аудитын тайлан, бизнесийн үнэлгээний тайлан, хуулийн дүгнэлт, холбогдох бусад баримт материалд үндэслэн Үнэт цаас гаргагч "Инвескор ББСБ" ХХК-ийн нэмж гаргаж буй хувьцаа нь Монголын хөрөнгийн биржийн 3-р ангиллын шалгуурыг хангасан бөгөөд стратегийн хөрөнгө оруулагчид, мэргэжлийн хөрөнгө оруулагчид болон нийтэд нээлттэй хүрээнд санал болгох боломжтой гэж үзэн энэхүү дүгнэлтийг гаргалаа.

Энэхүү дүгнэлт нь Үнэт цаас гаргагчийн итгэл үнэмшилд тулгуурлан хийгдсэн ирээдүйн төсөөлөл, таамаглал, биелэлтийн баталгаа болохгүй бөгөөд хөрөнгө оруулагчид нь компанийн үйл ажиллагаа, үнэт цаасны танилцуулга, холбогдох эрсдэл, үнэт цаас гаргах ажиллагааг сайтар судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргахыг зөвлөж байна.

**ДҮГНЭЛТ ГАРГАСАН**

ҮНДСЭН АНДЕРРАЙТЕР
"ТИ ДИ БИ КАПИТАЛ ҮЦК" ХХК-ийг төлөөлж:

Т.ДАВААЖАВ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

С.БАТЧИМЭГ
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАНКНЫ
ГАЗРЫН ЗАХИРАЛ